



ШҮҮХИЙН АКАДЕМИ

МОНГОЛЫН ТӨР, ЭРХ ЗҮЙ

**ДОТООДЫН МЭРГЭЖЛИЙН, ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ
УЛИРАЛ ТУТМЫН СЭТГҮҮЛ**

2024 №3 (109)

СЭТГҮҮЛИЙН ЗӨВЛӨЛ

ЭРХЛЭГЧ

Д.ЭРДЭНЭЧИМЭГ

Хууль зүйн ухааны доктор /Ph.D./, дэд профессор,
Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн академийн захирал

ГИШҮҮД

Ж.АМАРСАНАА

Академич, Хууль зүйн шинжлэх ухааны доктор /Sc.D./, профессор

С.НАРАНГЭРЭЛ

Академич, Хууль зүйн шинжлэх ухааны доктор /Sc.D./, профессор

Ж.БЯМБАА

Хууль зүйн ухааны доктор /Ph.D./, профессор

Г.БАНЗРАГЧ

Хууль зүйн ухааны доктор /Ph.D./, Улсын дээд шүүхийн шүүгч

Д.ЦОЛМОН

Улсын дээд шүүхийн шүүгч

Н.БАЯРМАА

Хууль зүйн ухааны доктор /Ph.D./, Улсын дээд шүүхийн шүүгч

Д.ГАНГАБААТАР

Хууль зүйн ухааны доктор /Ph.D./, дэд профессор, Үндсэн хуулийн цэцийн гишүүн

Х.ЭРДЭМ-УНДРАХ

Хууль зүйн ухааны доктор /Dr.jur./, дэд профессор, Хууль зүйн үндэсний
хүрээлэнгийн захирал

Б.ӨЛЗИЙСАЙХАН

Хууль зүйн ухааны доктор /Ph.D./, дэд профессор

РУДОЛЬФ ХЭЛМХАГЕН

Холбооны Бүгд Найрамдах Герман улсын
Бавари мужийн Пассау хот дахь Мужийн шүүхийн Ерөнхий шүүгч

ТАКАХАШИ АКИО

Хууль зүйн ухааны доктор /Ph.D./, профессор

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Б.ДӨЛГӨӨН

Хууль зүйн ухааны доктор /Ph.D./,
Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн академийн
Шүүхийн судалгааны төвийн дарга

АГУУЛГА

I ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ӨГҮҮЛЭЛ, СУДАЛГААНЫ ТОЙМ

Б.Амарбаясгалан, Улсын дээд шүүхийн шүүгч

З.Янжинлхам, Улсын дээд шүүхийн дэргэдэх Шүүхийн академийн эрүүгийн эрх зүйн секторын судлаач

Э.Баасанбямба, Улсын дээд шүүхийн дэргэдэх Шүүхийн академийн эрүүгийн эрх зүйн секторын судлаач

**Давж заалдах журмаар хэрэг хянан шийдвэрлэх шүүхийн эрх хэмжээ:
"Non reformatio in peius" буюу шүүгдэгчийн давж заалдах эрхийг
хязгаарлахгүйгээр шүүхийн шийдвэрт өөрчлөлт оруулах зарчмын тухай** 5

Б.Батбаяр, Монголын Өмгөөлөгчдийн Холбооны гишүүн, өмгөөлөгч

Хэлцлийн хэлбэрийн шаардлагын үндэслэл, төрөл 27

Б.Цэндсүрэн, БНСУ-ын Күүкмин их сургуулийн Хууль зүйн сургуулийн докторант

Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө ба халшрах үр нөлөөний хамаарал 38

Б.Наранцэцэг, МУИС-ийн Хууль зүйн сургуулийн магистрант, хуульч, өмгөөлөгч

Г.Амаржаргал, Өмгөөллийн Фиделитас партнерс ХХН-ийн судлаач, эрх зүйч

**Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа дахь хэргийг боломжит
богино хугацаанд шийдвэрлэх зарчим** 52

Б.Одгэрэл, Дотоод хэргийн их сургуулийн докторант

Үндсэн хуулийн өмнөх (1992) патентын эрх зүйн зохицуулалт 65

Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн академи

Шүүхийн цахимжилт: харьцуулсан судалгаа 88

**ДАВЖ ЗААЛДАХ ЖУРМААР ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ШҮҮХИЙН
ЭРХ ХЭМЖЭЭ: “NON REFORMATIO IN PEIUS” БУЮУ ШҮҮГДЭГЧИЙН
ДАВЖ ЗААЛДАХ ЭРХИЙГ ХЯЗГААРЛАХГҮЙГЭЭР ШҮҮХИЙН
ШИЙДВЭРТ ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ЗАРЧМЫН ТУХАЙ**

**Б.Амарбаясгалан¹
З.Янжинлхам²
Э.Баасанбямба³**

- I. Оршил
- II. Non Reformatio in peius зарчмын тухай
- III. Гадаадын зарим орнуудын эрүүгийн процессын эрх зүйд уг зарчмыг хэрхэн тусгасан талаар
- IV. Монгол Улсын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль дахь non reformatio in peius зарчмын агуулга
- V. Хүндрүүлэхийг хориглох зарчмыг туйлын агуулгаар хуульчилсны сөрөг тал
- VI. Дүгнэлт
- VII. Ном зүй

¹ Улсын дээд шүүхийн шүүгч, хууль зүйн ухааны доктор (Ph.D.).

² Улсын дээд шүүхийн дэргэдэх Шүүхийн академийн эрүүгийн эрх зүйн секторын судлаач.

³ Улсын дээд шүүхийн дэргэдэх Шүүхийн академийн эрүүгийн эрх зүйн секторын судлаач.



ДАВЖ ЗААЛДАХ ЖУРМААР ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ШҮҮХИЙН ЭРХ ХЭМЖЭЭ: "NON REFORMATIO IN PEIUS" БУЮУ ШҮҮГДЭГЧИЙН ДАВЖ ЗААЛДАХ ЭРХИЙГ ХЯЗГААРЛАХГҮЙГЭЭР ШҮҮХИЙН ШИЙДВЭРТ ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ЗАРЧМЫН ТУХАЙ



Б.АМАРБАЯСГАЛАН, Улсын дээд шүүхийн шүүгч, хууль зүйн ухааны доктор (Ph.D.).

З.ЯНЖИНЛХАМ, Улсын дээд шүүхийн дэргэдэх Шүүхийн академийн эрүүгийн эрх зүйн секторын судлаач

Э.БААСАНБЯМБА, Улсын дээд шүүхийн дэргэдэх Шүүхийн академийн эрүүгийн эрх зүйн секторын судлаач

Түлхүүр үг

Эрүүгийн процессын эрх зүй, доод шатны шүүхийн шийдвэрийг хүндрүүлэхгүй байх зарчим, давж заалдах эрх, эрүүгийн хэргийн шүүхийн хяналт, сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн эрх зүйн хамгаалалт.

Хураангуй

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шүүгдэгч давж заалдах эрхээ баталгаатай эдлэх нөхцөлийг хангахын тулд дээд шатны шүүхээс анхан шатны шүүхийн шийдвэрт хүндрүүлсэн өөрчлөлт оруулж хориглохыг **non reformatio in peius** буюу хүндрүүлж өөрчлөхгүй байх зарчим гэнэ. Тус зарчмыг шүүхийн хяналтын тогтолцооны онцлогтой уялдуулан туйлын болон харьцангуй агуулгаар хуульчилж болдог. Манай улсын хувьд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 39.9 дүгээр зүйлийн 1.4, 40.8 дугаар зүйлийн 1.4 дэх заалтуудад уг зарчмыг туйлын агуулгаар тодорхойлон хуульчилжээ. Дээд шатны

шүүхээс доод шатны шүүхийн шийдвэрийг хянаж өөрчлөлт оруулах эрхийг зөвхөн шүүгдэгчид ашигтайгаар буюу хөнгөрүүлэн өөрчлөхөөр хязгаарласан нь шүүхийн хяналтын тогтолцооны ач холбогдлыг бууруулах, хууль ёсны зарчим зөрчигдөх сөрөг үр дагавартай. Мөн эрүүгийн хэргийг анхан шатны шүүхээр дахин хэлэлцэх тохиолдолд уг зарчмын үйлчлэлд хамаарахгүй байхаар зохицуулсан нь шүүгдэгчийн эрхийг бүрэн хамгаалах боломжгүй хийдэлтэй зохицуулалт болжээ. Энэхүү өгүүллээр дамжуулан уг зарчмын талаарх ойлголтыг онолын үндэслэлтэйгээр судлан хүргэх, түүний ач холбогдол, хэрэглээг харьцуулсан болон практик судалгаанд тулгуурлан тодруулах, цаашлаад өөрийн орны эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны онцлогт нийцүүлэн агуулгыг нь бүрэн зөв тодорхойлж, боловсронгуй болгох талаар санал дэвшүүлэхийг зорилоо.



I. Оршил

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогч талууд нь ямагт тэгш бус нөхцөлд байдаг. Ялангуяа, гэмт хэрэгт холбогдон шалгагдаж байгаа яллагдагчийн хувьд яллах талтай харьцуулахад эрх зүйн байдал нь харьцангуй сул оролцогч юм. Иймд талуудын эрх зүйн байдлыг “тэнцвэржүүлэх” зорилгоор эрүүгийн процессын эрх зүйд сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчид эрх зүйн хамгаалалтуудыг (анг. *favor defensionis*) бүрдүүлж өгдөг.

Эдгээр хамгаалалтын нэг нь өмнөх шүүхийн шийдвэрийг хүндрүүлэхгүй байх зарчим¹ бөгөөд уг зарчим нь шүүгдэгч анх гаргасан шүүхийн шийдвэр өөрт нь ашиггүйгээр өөрчлөгдөх айдасгүйгээр дараагийн шатны шүүхэд давж заалдах гомдолд гаргах хууль зүйн баталгааг хангах зорилготой.

II. Non Reformatio in peius зарчмын тухай

Non Reformatio in peius буюу доод шатны шүүхийн шийдвэрийг хүндрүүлж өөрчлөлт оруулахгүй байх зарчим нь Ромын эрх зүйгээс гаралтай иргэн, захиргаа, эрүүгийн процессын эрх зүйд нийтлэг үйлчилдэг зарчим (*ius commune*) юм. Уг зарчмын үүслийг XVIII дугаар зууны төгсгөл үед Францын эрх зүйн хувьсгалын нөлөөгөөр үүссэн ч гэж зарим эрдэмтэд үздэг.²

¹ Тухайлбал, ХБНГУ-ын Үндсэн хуулийн шүүхээс 1969 онд шүүгдэгч нь эрүүгийн процессын объект бус хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үйл явц, үр дүнд нөлөөлөх чадвартай, идэвхтэй эрхүүдээр хангагдсан субъект болохыг баталгаажуулжээ

² Verena Uran: Das Verschlechterungsverbot im österreichischen Strafprozess – Ausgestaltung und Entwicklung, Diplomarbeit, Rechtswissenschaften an der Rechtswissenschaftlichen Fakultät der Karl – Franzens – Universität Graz, 2013, S.72.

XIX дүгээр зууны төгсгөл үед Германы хуульч Сарториус (*Sartorius*) болон Австрийн хуульч Лохсинг (*Lohsing*) нар хүндрүүлэх буюу **reformatio in peius** гэх үгийг тайлбарлахыг оролдож байжээ. Тухайлбал, Сарториус **reformatio in peius** гэх үгийн утгыг хууль зүйн ухааны нийтлэг сургаалаар илэрхийлэхийг зорьж “хэргийн нэг тал эсвэл хэргийн талуудад өмнөх шийдвэрээс хохиролтой хоёр дахь эсвэл дараагийн шийдвэр”, Лохсинг “өөрийн ашиг сонирхолд нийцүүлэн шүүхийн шийдвэрийг өөрчлүүлэхээр чармайсан шүүгдэгчид хохиролтой байдлаар шүүхийн шийдвэрийг өөрчлөх гэсэн утгыг илэрхийлнэ” хэмээн тус тус бичиж байжээ³. Иймд шүүгдэгч өөрт нь хохиролтой байдлаар дараагийн шүүхийн шийдвэр гарна гэх айдаст автан давж заалдах гомдол гаргахгүй байх шийдвэрт хүрэхээс сэргийлэн эрүүгийн процессын ажиллагаанд **non reformatio in peius** буюу хүндрүүлэхийг хориглох ойлголтыг нэвтрүүлсэн бөгөөд улс орнуудын эрүүгийн процессын эрх зүйд анхан шатны шүүхийн шийдвэрт шүүгдэгчид ашигтай байдлаар гомдол гаргахад түүнд хохиролтой байдлаар шүүхийн шийдвэрийг өөрчлөхийг хориглоно гэсэн агуулгаар тусгалаа олсон байна.

Non reformatio in peius нь шүүгдэгч шүүхийн шийдвэрийг хянуулахаар дээд шатны шүүхэд гомдол гаргасан тохиолдолд өмнөхөөс хүнд ял оноож, эрх зүйн байдлыг нь дордуулахаас айх айдасгүйгээр давж заалдах эрхээ бүрэн эдлэх нөхцөлийг бүрдүүлэх зорилготой.

Тус зарчмыг хуульчлах хэрэгцээг хэд хэдэн үндэслэлүүдээр тайлбарладагийг

³ Verena Uran, S.72.



тоймлон авч үзвэл⁴:

- Шүүгдэгч өөрийгөө өмгөөлөх эрхээ бодитой эдлэх боломжийг хангахын тулд ямар нэг айдасгүйгээр шүүхийн шийдвэрийг хянуулахаар дээд шатны шүүхэд гомдол гаргах эрхтэй. Ийнхүү шүүгдэгчийн давж заалдах эрхээ эдлэх бололцоог хангах нь эрүүгийн процессын хуулиар баталгаажуулсан эрхийн хэрэгжилт, баталгаа юм. Иймд хууль дээдлэх, хүний эрхийн зарчмын үүднээс үүнийг зайлшгүй хуульчлах шаардлагатай юм.
- Прокурор эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хараат бусаар хуулийн хэрэгжилтэд хяналт тавих, хууль ёсны зарчмын биелэлтийг сахиулах, яллах эрх бүхий субъектийн хувьд чиг үүргийнхээ хүрээнд шүүхийн өмнөх шатнаас хэргийг шүүхэд шилжүүлэх хүртэл шүүгдэгчийн гэм бурууг нотлох ажиллагаанд идэвхтэй оролцож, оногдуулах ялын хэмжээнд дүгнэлт гаргаж оролцдог. Иймээс анхан шатны шүүхийн шийдвэрийн эсрэг прокурор эсэргүүцэл гаргаагүй тохиолдолд дээд шатны шүүх шүүгдэгчийн эрх

зүйн байдлыг дордуулж өөрчилж болохгүй.

- Эрх зүйт төрийн зарчмын дагуу шүүх хууль ёсыг чанд сахина. Шүүх энэ үүргээ биелүүлж чадаагүйн улмаас үүссэн үр дагаврыг шүүгдэгчид үүрүүлэх учиргүй.

Хэрэглээ нь **туйлын** ба **харьцангуй** хүрээнд тодорхойлогддог.⁵ **Туйлын агуулгаараа** дээд шатны шүүхээс ямар ч тохиолдолд шүүгдэгчийн эрх зүйн байдлыг дордуулсан шийдвэр гаргахыг хориглоно. Өөрөөр хэлбэл, давж заалдах гомдлын агуулгаас үл хамааран ямар нэгэн байдлаар шүүгдэгчийн эрх зүйн байдлыг дордуулах, цаашлаад анхан шатны шүүхээр дахин хэлэлцүүлэхдээ өмнөх шүүхийн шийдвэрээс хүнд гэмт хэргээр зүйлчлэх, хүндрүүлж ял оногдуулахыг хориглодог. **Харьцангуй хүрээнд гэдэг нь** давж заалдах гомдол гаргагчийн гомдлын агуулгаас хамааралтайгаар доод шатны шүүхийн шийдвэрийг хүндрүүлэх эсэх нь шийдвэрлэгддэг. Хэргийн оролцогчдоос, тухайлбал, хохирогч, түүний эрх ашгийг хамгаалагч этгээдээс, эсхүл прокуророос шүүгдэгчийн эсрэг агуулгаар гомдол, эсэргүүцэл гаргасан бол дээд шатны шүүх тухайн гомдлын дагуу шүүгдэгчид оногдуулсан ял, гэмт хэргийн зүйлчлэлийг хүндрүүлж болно. Эсрэгээрээ шүүгдэгч, түүний өмгөөлөгч, хохирогч болон прокуророос шүүгдэгчийн эрх ашгийг хамгаалсан агуулгаар гомдол, эсэргүүцэл гаргасан бол шүүхээс шүүгдэгчийн эрх зүйн байдлыг дордуулсан шийдвэр

⁴ Csongor Herke & Csenge D. Tyth, "Theoretical and Practical Issues of the Prohibition of Reformatio in Peius in Hungary", Business and Law Vol.3 (2011), 95-109;

Csongor Herke & Csenge D. Tyth, "The Prohibition of Reformatio in Peius in the light of the Principle of Fair Procedure", researchgate.net, 2021, 92-98. https://www.researchgate.net/publication/348187735_The_prohibition_of_reformatio_in_peius_in_the_light_of_the_principle_of_fair_procedure (Сүүл үзсэн: 2024.08.24).

⁵ Csongor Herke & Csenge D. Tyth, Theoretical and Practical Issues of the Prohibition of Reformatio in Peius in Hungary, Business and Law Vol.3 (2011), 95-109.



гаргаж болохгүй гэж үздэг байна.

Дээрхээс гадна нийтлэг ба хэсэгчлэн, заавал дагах болон онцгой тохиолдолд хэрэгжих хэлбэрээр хуульчилж болно. Нийтлэг гэдэг нь туйлын утгаар хэрэглэхтэй ижил бол хэсэгчлэн буюу онцгой тохиолдлууд гэдэг нь ямар төрлийн шүүгдэгчид хохиролтой шийдвэрүүдийг гаргаж болохгүй талаар хуульд тодорхой жагсааж тусгахыг хэлнэ.

Non reformatio in peius зарчмын үйлчлэх хүрээг туйлын болон харьцангуй аль агуулгаар нь хэрэглэж байгааг тодруулахаар Австри, Герман, Унгар, Монгол Улсын эрх зүйн зохицуулалтыг удаах хэсэгт судлав.

III. Гадаадын зарим орнуудын эрүүгийн процессын эрх зүйд уг зарчмыг хэрхэн тусгасан талаар

А. Бүгд Найрамдах Австри Улс (цаашид “Австри улс” гэх)

Тус улс 1803 оны Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх хууль (цаашид ЭХХШТХ гэх) хэрэгжиж эхэлсэн үеэс хүндрүүлэхийг хориглох тухай ойлголтыг эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны нэг хэсэг болгон хөгжүүлсэн байна.⁶ Тодруулбал, тус хуулийн 467 дугаар зүйлд “Давж заалдах гомдол гаргахад шүүхийн шийдвэрийг хүнд ял шийтгэлээр өөрчилж болохгүй” гэсэн агуулгаар тусгаснаас⁷ үзвэл эхэндээ уг зарчмыг туйлын байдлаар хуульчлагдсан байв. Үүний дараа 1850 оны ЭХХШТХ-д “Шүүгдэгч давж заалдах гомдол гаргасан тохиолдолд дээд шатны шүүх түүнд хохиролтойгоор өмнөх шүүхийн шийдвэрийг өөрчилж болохгүй” гэх агуулгаар хуульчилсан нь уг хориглолт

зөвхөн шүүгдэгч давж заалдах гомдол гаргасан тохиолдолд хамааралтай болох талаар нэг мөр хуульчилсан байна.

Харин 2004 оны ЭХХШТХ-ийн нэмэлт, өөрчлөлтөөр “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа болон зарчмууд” гэсэн бүлгийн 16 дугаар зүйлд⁸ “хүндрүүлэхийг хориглох” хэмээн зааснаар уг хориглолтыг эрүүгийн процессын зарчим хэлбэрээр хуульчилжээ.

Үйлчлэх хүрээ: ЭХХШТХ-ийн 16 дугаар зүйлд “мөрдөн шалгах ажиллагааны үе шат болон ялын асуудлын талаарх шүүхийн шийдвэрийн агуулгыг” хүндрүүлэхийг хориглоно хэмээн хуульчилжээ. Үүнээс үзвэл уг зарчим нь мөрдөн шалгах, хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаа болон давж заалдах журмаар хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаанд үйлчлэхээр байна.

Урьдчилсан нөхцөл: Давж заалдах гомдол гаргасан байх, уг гомдол нь сэжигтэнд (*rep. Beschuldigter*)⁹ ашигтай байх гэсэн урьдчилсан нөхцөлийг хуульд заасан байна. Сэжигтэнд ашигтай байдлаар гомдол гаргах эрхтэй этгээдэд шүүгдэгч, түүний өмгөөлөгч, эсвэл хууль ёсны төлөөлөгч, прокурор байх боломжтой. Гэхдээ тус улсын Авлигын гэмт хэргийн тухай хуульд 2009 онд нэмэлт, өөрчлөлт оруулж, шүүгдэгчийн төрөл, садан, гэр бүлийн гишүүн нь шүүгдэгчид ашигтай байдлаар гомдол гаргах эрхийг нь хассан байна.¹⁰

⁸ Strafprozeßordnung 1975, <https://www.ris.bka.gv.at/GeltendeFassung.wxe?Abfrage=Bundesnormen&Gesetzesnummer=10002326>, (Сүүлд үзсэн: 2024.08.11).

⁹ Сэжигтэн, Ханнс-Зайделийн сан, Эрүүгийн эрх зүйн нэр томъёоны толь, 2006, 14 дэх тал.

¹⁰ Verena Uran, S.25.

⁶ Verena Uran, S.76.

⁷ Verena Uran, S.77.



Хүндрүүлэхийг хориглох зарчмын хязгаарлалт: ЭХХШТХ-ийн 16 дугаар зүйлд мөрдөн шалгах ажиллагаа болон ялын асуудлаар гаргасан шүүхийн шийдвэрийн агуулгыг хүндрүүлэхийг хориглоно хэмээн заажээ. Хуулийн бичвэрт шүүхийн шийдвэрийн агуулгатай хамааралтай хэмээн заасан бөгөөд уг “агуулга” нь зөвхөн оногдуулсан ял шийтгэлийн хүрээнд хамаарах уу, эсвэл хэргийн үйл баримтад тулгуурлан шүүхээс өгсөн хууль зүйн дүгнэлттэй холбоотой юу гэх асуудал гардаг байна. Уг асуудалд судлаачид болон шүүхийн практикт хоёр үзлийг сөргүүлэн тавьдаг. Нэг хэсэгт нь зөвхөн оногдуулсан ялын хүрээнд уг хориглолт үйлчилнэ гэдэг бол нөгөө хэсэг нь шүүхийн хууль ёсны дүгнэлтэд уг зарчим мөн үйлчилнэ хэмээн үзжээ.

Хүндрүүлэхийг хориглох зарчмын үйлчлэлийг ял шийтгэлийн хүрээнд хязгаарлагдахгүйгээр хэргийн зүйлчлэлийг тогтоох асуудалд хэрэглэх нь шүүх хэргийг буруу шийдвэрлэсэн тохиолдолд давж заалдах шатны шүүхээс яллагдагчийг цагаатгах үр дагаварт хүргэдэг. Жишээлбэл, анхан шатны шүүхээс шүүгдэгчийг хөрөнгө завших гэмт хэрэгт гэм буруутай хэмээн ял шийтгэл оногдуулсан бөгөөд уг шүүхийн шийдвэрт шүүгдэгч гомдол гаргасан байна. Давж заалдах шатны шүүхээс хэргийг хянаад анхан шатны шүүх нотлох баримтад тулгуурлан хэргийн үйл баримтыг тогтоохдоо хуулийг буруу хэрэглэсэн тул шүүгдэгч нь хөрөнгө завших гэмт хэрэгт бус хулгайлах гэмт хэрэгт гэм буруутай хэмээн үзжээ. Гэвч шүүхээс зүйлчлэл хүндрүүлэхийг хориглосон учраас шүүгдэгчийг цагаатгахад хүрнэ. Гэм буруугийн асуудалд хүндрүүлэхийг

хориглох зарчим нь ийм үр дагаварт хүрэх аюултай тул **уг хориглолт нь зөвхөн анхан шатны шүүхээс оногдуулсан ялын асуудалд үйлчилнэ** гэх утгаар ойлгоно хэмээн тус улсын Дээд шүүхээс үзжээ.¹¹

Ийнхүү хүндрүүлэхийг хориглох зарчим анхан шатны шүүхийн оногдуулсан ялын асуудлаар л хязгаарлагддаг. Харин анхан шатны шүүхийн эрх зүйн дүгнэлтэд уг зарчим хамаардаггүй. Давж заалдах шатны шүүхээс хэргийг хянаад анхан шатны шүүхээс оногдуулсан хорих ял, торгох ял, урьдчилан сэргийлэх арга хэмжээнд хүндрүүлэхийг хориглох зарчим тус тус үйлчилдэг байна.

Б. Холбооны Бүгд Найрамдах Герман Улс (цаашид “ХБНГУ” гэх)

Хүндрүүлэхийг хориглох тухай ойлголтыг Герман улс 1877 оны ЭХХШТХ-даа *“Зөвхөн шүүгдэгч, шүүгдэгчид ашигтай байдлаар прокурор, шүүгдэгчийн хууль ёсны төлөөлөгч гомдол гаргасан тохиолдолд анхан шатны шүүхийн шийдвэрийг шүүгдэгчид хохиролтойгоор өөрчилж болохгүй”* хэмээн тусгаж байжээ. Герман улсын ЭХХШТХ-д **non reformatio in peius**-ийг өнөөг хүртэл тогтвортой хуульчилж ирээгүй бөгөөд түүхэндээ уг зохицуулалтыг хүчингүй болгож байсан удаатай. Тухайлбал, национал-социализмын үед¹² буюу 1935 онд ЭХХШТХ-ийн болон Шүүхийн тухай хуулийг өөрчлөн найруулахдаа уг зохицуулалтыг халж *“Шүүхийн шийдвэрт шүүгдэгч, түүний хууль ёсны төлөөлөгч, түүнд ашигтай байдлаар прокурор гомдол гаргасан бол шүүгдэгчид*

¹¹ Verena Uran, S.33

¹² 1933-1945 оны хооронд.



хохиролтой байдлаар өөрчилж болно”¹³ гэсэн бол 1950 оны ЭХХШТХ-д “шүүгдэгч, түүнд ашигтай байдлаар прокурор, эсвэл шүүгдэгчийн хууль ёсны төлөөлөгч давж заалдах гомдол (гер.Berufung) гаргасан тохиолдолд шүүгдэгчид хохиролтой байдлаар ял шийтгэлийн төрөл болон хэмжээнд өөрчлөлт оруулахыг хориглоно” хэмээн хуульчилжээ. Дээрх зохицуулалт нь ял болон албадлагын арга хэмжээ гэсэн ялын 2 шатлалын зөвхөн ялд хүндрүүлэхийг хориглох талаар заасан хэмээн эрдэмтэд шүүмжилж, улмаар 1975 оны ЭХХШТХ-ийн нэмэлт, өөрчлөлтөөр “шүүгдэгч, түүнд ашигтай байдлаар прокурор, эсвэл шүүгдэгчийн хууль ёсны төлөөлөгч давж заалдах гомдол гаргасан тохиолдолд шүүгдэгчид хохиролтой байдлаар **хууль зүйн үр дагаврын төрөл болон хэмжээнд өөрчлөлт оруулахыг хориглоно**” хэмээн тусгажээ.

Үйлчлэх хүрээ: Одоо хүчин төгөлдөр үйлчилж буй ЭХХШТХ-д¹⁴ давж заалдах гомдол гаргах, хяналтын гомдол гаргах болон дээд шатны шүүхээс шийдвэрийг хүчингүй болгож эрүүгийн хэргийг анхан шатны шүүхээр дахин хэлэлцүүлэхэд¹⁵

¹³ Joachim Kretschmer: Das Strafprozessuale Verbot der reformatio in peius und die MayRegeln der Besserung und Sicherung, 1999, S.56

¹⁴ Strafprozeßordnung (StPO), 1950, <https://www.gesetze-im-internet.de/stpo/BjNR006290950.htm> |#BJNR006290950BJNG000102311, (Сүүлд үзсэн: 2023.11.29).

¹⁵ ХБНГУ-ын давж заалдах журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа /Berufung/-д шинээр нотлох баримт хүлээн авах, доод шатны шүүхийн шийдвэрт өөрчлөлт оруулах эрх хэмжээ эдэлдэг. Харин давж заалдах шатны шүүхээс хэргийг буцаахгүй бөгөөд зөвхөн харьяалал зөрчсөн үндэслэлээр анхан шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгон харьяаллын шүүх рүү шилжүүлэх шийдвэр гаргадаг (ХБНГУ-ын Эрүүгийн процесс хуулийн 349 дүгээр зүйл). Ийнхүү шилжүүлсэн тохиолдолд хэргийг хүлээн авсан шүүх шийдвэр гаргахад non reformatio in peius зарчмыг баримталдаг байна. Хяналтын журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад /Revision/ гомдол үндэслэлтэй гэж үзвэл

хүндрүүлэхийг хориглодог байна.

Эрүүгийн процесс хуулийн 331 дүгээр зүйл.

1. Прокурор болон шүүгдэгчийн хууль ёсны төлөөлөгч шүүгдэгчид ашигтай байдлаар давж заалдах гомдол гаргасан тохиолдолд шүүхийн шийдвэрийг шүүгдэгчид хохиролтойгоор хууль зүйн үр дагаврын төрөл болон хэмжээг өөрчлөхийг хориглоно.
2. Дээрх зохицуулалт нь сэтгэцийн эмнэлэгт болон тусгаарлах байранд хорих зохицуулалтад хамаарахгүй.

Уг хориглолт нь яллагдагч өөрт нь сөрөг үр дагавартай хэмээн айж давж заалдах гомдол гаргахгүй байхаас сэргийлдэг бөгөөд эрх зүйт төрийн шударгаар шүүлгэх эрхэд үндэслэн гарж ирсэн гэж зарим эрдэмтэн дурджээ.¹⁶ Гомдол гаргасан шүүхийн шийдвэрийг давж заалдах шатны шүүх шийдвэрлэхдээ шүүгдэгчид хохиролтой байдлаар ялын төрөл болон хэмжээг өөрчлөх боломжтой хэмээн үзэж гомдол гаргахаас татгалзах явдлаас шүүгдэгчийг хамгаалдаг. Шүүгдэгч давж заалдах гомдол гаргахдаа түүнд ямар нэгэн хохиролтой байдал үүснэ гэх дарамтаас ангид байж шийдвэр гаргадаг байх ёстой гэж үздэг байна.¹⁷

Урьдчилсан нөхцөл: Шүүгдэгчид ашигтай агуулгаар давж заалдах гомдол гаргах этгээдэд шүүгдэгч, түүний хууль

шүүхийн шийдвэрийг хүчингүй болгон, хэргийг өмнөх шатны шүүхэд буцаадаг (ХБНГУ-ын Эрүүгийн процесс хуулийн 354 зүгээр зүйлийн 2 дахь хэсэг). Ийнхүү буцсан хэргийг хүлээн авсан шүүх шинээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг явуулах ба хүндрүүлэхгүй байх зарчим мөн үйлчилдэг байна. Харин цагаатгах тогтоол гаргах, хөнгөн ял оногдуулахаар бол хяналтын журмаар хэргийг хянан шийдвэрлэж буй шүүх доод шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгож өөрөө шийдвэр гаргадаг байна.

¹⁶ Manfred Heinrich: Deutsches Strafverfahrensrecht, 2018, S.444

¹⁷ Gцssel, Karl Heinz, Ulrich Franke, Karl Heinz Gцssel, and Ulrich Franke: StPO §§ 312-373a, 26th, 2012, S.228



ёсны төлөөлөгч, прокурор хамаарна. Прокурор нь аль ч агуулгаар гомдол гаргах эрхтэй бол шүүгдэгчийн хууль ёсны төлөөлөгч зөвхөн шүүгдэгчид ашигтай байдлаар гомдол гаргах эрхтэй байна. Шүүгдэгчийн эсрэг гомдол гаргасан тохиолдолд **non reformatio in peius** зарчим ач холбогдолгүй болно.¹⁸

Хүндрүүлэхийг хориглох хязгаарлалт: Хүндрүүлэх хориглолт нь гэм буруугийн дүгнэлтэд хамааралгүй. ЭХХШТХ-ийн 331 дүгээр зүйлд заасны дагуу гэм буруугийн асуудлыг шинээр тогтоох, хүнд гэмт хэрэг хэмээн үзэх, тухайлбал, анхан шатны шүүхээс хулгайлах гэмт хэрэгт гэм буруутай хэмээн дүгнэснийг дээд шатны шүүхээс дээрэмдэх гэмт хэрэгт гэм буруутай хэмээн үзэх, эсвэл зөрчлийн хэргийг гэмт хэрэг хэмээн үзэх, эсвэл нэг үйлдэлтэй гэмт хэргийг нэгдмэл гэмт хэрэг хэмээн үзэж анхан шатны шүүхийн шийдвэрийг өөрчлөхөд саад болохгүй.

ЭХХШТХ-ийн 331 дүгээр зүйлд шүүгдэгч давж заалдах гомдол гаргасан бол давж заалдах шатны шүүхээс өмнөх шатны шүүхийн оногдуулсан **хууль зүйн үр дагаврыг хүндрүүлж шийдвэрлэхийг хориглодог**. Харин давж заалдах шатны шүүхээс анхан шатны шүүхийн орхигдуулсан хууль зүйн үр дагаврыг нөхөж оногдуулахад уг хориглолт үйлчилдэггүй байна.¹⁹ Тухайлбал, нийлмэл гэмт хэрэгт ял оногдуулах (§ 53 StGB), хэд хэдэн шийтгэх тогтоолоор ял оногдуулах (§ 53 StGB) гэх мэт. Мөн хэргийн зүйлчлэлийг хүндрүүлэн тогтоох, тухайлбал, болгоомжгүйгээр хүний бие махбодод гэмтэл учруулсан **гэж дүгнэснийг санаатай болгон өөрчлөх,**

¹⁸ Joachim Kretschmer, S.54

¹⁹ Sanchez-Hermosilla, Fernando, and Peter Schweikart: Die StPO in Fdllen. 1st ed, 2008, S6163

тэнсэх хугацааны шийдвэрт өөрчлөлт оруулах, жишээ нь, 3 жилийн оронд 4 жил хэмээн тогтооход уг хориглолт үйлчлэхгүй. Эдгээр тохиолдлуудад давж заалдах шатны шүүх өмнөх шатны шүүхээс оногдуулсан хууль зүйн үр дагаврыг хүндрүүлсэн гэж үзэхгүй.

Хүндрүүлэхийг хориглох ойлголт үйлчлэх тохиолдлуудад: анхан шатны шүүхээс хорих ялыг тэнсэснийг дээд шатны шүүхээс хүчингүй болгож хорих ял оногдуулах; анхан шатны шүүхээс торгох ял оногдуулсныг хорих ялаар солих; хорих ялын хэмжээг хүндрүүлэн өөрчлөх; торгох ялын хэмжээг нэмэгдүүлэх; зан үйлээ хянах албадлагын арга хэмжээг хамгаалах зорилгоор цагдан хорих албадлагын арга хэмжээгээр солих зэрэгт үйлчилдэг байна.

Зүйлчлэлийн хувьд илүү хүнд гэмт хэргээр зүйчлэхэд уг зарчим үйлчлэхгүй бөгөөд энэ талаар Холбооны дээд шүүхийн шийдвэрт бичсэн дүгнэлтийн дагуу практик нэг мөр тогтжээ.²⁰ Хэргийн зүйлчлэлийг өөрчлөхөд уг зарчим үйлчлэхгүй талаархи үндэслэлийг хүндрүүлэхийг хориглох зарчмын зорилготой холбон тайлбарладаг. Тодруулбал, уг зарчмын зорилго нь шүүгдэгч давж заалдах гомдол гаргавал түүнд **шүүхээс оногдуулсан ял шийтгэл нь илүү хүндэрч болзошгүй тул гомдол гаргахгүй байх шийдвэрт хүрэхээс сэргийлэх явдал юм**. Харин хэргийн зүйлчлэлийг өөрчилж байгаа нь илүү хүнд ял шийтгэл оногдуулж болзошгүй гэх шүүгдэгчийн айдаст хамааралгүй.²¹ Тиймээс давж заалдах

²⁰ BGHSt 21, 256, 259 f.

²¹ Jurajuchs, Verschlechterungsverbot (§ 331 StPO), https://www.jurafuchs.de/probeabo-faellern-lernen?utm_source=wissen.jurafuchs.de&utm_



шатны шүүх хэргийн зүйчлэлийг өөрчилж болох ч хууль зүйн үр дагавар буюу ялыг нь хүндрүүлэхийг хориглодог байна.

В. Унгар улс

Унгар улсад анх 1896 оны ЭХХШТХ-аар уг зарчмыг хуульчилж байсан боловч социалист дэглэмийн үед буюу 1949, 1950 оны хуулиудаас “*материаллаг шударга ёс бүхний дээгүүр засаглах ёстой*” гэсэн үндэслэлээр уг зарчмыг хасжээ. Харин 1954 онд батлагдсан ЭХХШТХ-аар хэргийг зөвхөн анхан шатны шүүхээр дахин хэлэлцүүлэхэд л шүүгдэгчийн эрх зүйн байдлыг дордуулж буюу өмнөхөөс хүндрүүлэн шийдвэрлэж болно хэмээн тусгажээ.²² Гэвч заавал анхан шатны шүүхэд буцаах замаар шүүхийн алдааг засварлуулах нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг удаашруулж байсан тул 1958 онд хуульд өөрчлөлт оруулж шүүгдэгчийн эсрэг агуулгатай гомдол гаргасан тохиолдолд давж заалдах шатны шүүх шүүхийн шийдвэрийг өмнөхөөс хүндрүүлж өөрчилж болохоор хуульчилжээ.²³

Үйлчлэх хүрээ: **Non reformatio in peius** зарчим эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны дараах үе шатуудад үйлчилнэ:

- а) Эрүүгийн хэргийг давж заалдах болон хяналтын шатны журмаар хянан шийдвэрлэх;
- б) Анхан шатны шүүхээр дахин хэлэлцүүлэх;
- в) Зарим төрлийн тусгай

medium=logo&utm_campaign=jqmeoogo, (Сүүлд үзсэн: 2024.08.27).

²² Csongor Herke & Csenge D. Tyth, *Theoretical and Practical Issues of the Prohibition of Reformatio in Peius in Hungary*, *Business and Law Vol.3* (2011), 97.

²³ *Ibid*, 97.

процессуудад;

- д) Шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас хэргийг шүүхээр дахин хэлэлцүүлэх.

Унгарын Эрүүгийн процесс хуулийн 595 дугаар зүйл.

Шүүгдэгчийн эсрэг давж заалдах гомдол гаргасан тохиолдолд анхан шатны шүүхээс цагаатгагдсан хүнийг гэм буруутайд тооцох, оногдуулсан ялыг хүндрүүлэх, албадлагын арга хэмжээг ялаар солих шийдвэр гаргаж болно.

Шүүгдэгчийн эсрэг агуулга бүхий гомдол гэдэгт:

- o Цагаатгагдсан хүнийг гэм буруутайд тооцуулах;
- o Гэмт хэргийн зүйлчлэлийг хүнд ангиллын гэмт хэргээр өөрчлүүлэх: Үүнд хүнд зүйл ангитай гэмт хэргээр зүйлчлэлийг өөрчлөх, гэмт хэрэгт хамтран оролцогчийн төрөл, хэлбэрийг өөрчилж хүндрүүлэх, гэмт хэрэгт завдсан гэж шийдвэрлэснийг гэмт хэрэг төгссөн гэж үзэх зэрэг шүүгдэгчид оногдуулах ялын хэмжээг шууд өсгөх үр дагавартай өөрчлөлтүүд;
- o Оногдуулсан ялыг хүндрүүлэх (албадлагын арга хэмжээг ялаар солих, бусад төрлийн ялыг хорих ялаар солих гэх мэт) зэрэг тохиолдлууд хамаарна.

Тус улсын давж заалдах болон хяналтын шатны шүүх доод шатны шүүхийн шийдвэрт өөрчлөлт оруулах, хүчингүй болгож хэргийг дахин хэлэлцүүлэхээр буцаах эрхтэй.²⁴ Өөрөөр хэлбэл, давж заалдах шатны шүүх **non reformatio in peius** зарчмыг зөрчихгүйгээр анхан

²⁴ Criminal Procedure Code of Hungary (2017), article 592-594.



шатны шүүхийн шийдвэр үндэслэлгүй гэж үзвэл үйл баримтыг өөрчлөн тогтоох, шинээр нотлох баримт хүлээн авах, зүйлчлэлийг өөрчлөх, ялыг хүндрүүлэх эрхийг ЭХХШТХ-аар олгосон.

Гэхдээ оногдуулсан ялыг эдлүүлэх нөхцөлийг хүндрүүлэх, эд хөрөнгө хураан авах гэх мэт арга хэмжээ авахад энэ үндэслэлд хамаардаггүй.²⁵ ХБНГУ болон Австри улстай харьцуулахад гэм буруу, хэргийн зүйлчлэлийг хамран өргөн хүрээнд хэрэгжих боловч гол анхаарлыг давж заалдах гомдлын агуулгад хандуулдаг буюу харьцангуй байдлаар тодорхойлох нийтлэг шинж байна.

IV. Монгол Улсын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль дахь *non reformatio in peius* зарчмын агуулга

Монгол Улсад 1949 оноос хойших эрүүгийн процессын эрх зүйн хэм хэмжээнүүдэд уг зарчмыг тусгаж иржээ.²⁶

Хүснэгт №1. Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хуулиудад non reformatio in peius зарчмыг хуульчилж ирсэн түүхэн уламжлал

1949 оны Эрүүгийн байцаан шийтгэх хууль	389 дүгээр зүйл. "... Эдгээр бүх шалтгаануудад шийтгэсэн тогтоолыг хүчингүй болгохдоо гагцхүү шүүхээс гаргасан алдаа нь хуулийг зөв зохистойгоор хэрэглэхэд ногдох байсан шийтгэлээс өөр шийтгэл оногдуулахад хүргэсэн байвал хүчингүй болгоно".
	392 дугаар зүйл. Анхан шатны шүүхийн тогтоолд хэргийн байдлыг тогтоохдоо хуулийг буруугаар хэрэглэсэн буюу уул тогтоолоор заасан шийтгэл нь тэрхүү шийтгэгдэгчийн өдүүлсэн хэрэгтэй үзтэл үл тохирсон гэж 2 дугаар шатны шүүхээс үзвэл уул хэргийг дахин хянуулахаар буцаалгүй тэрхүү тогтоолд зохих өөрчлөлтийг оруулж болох боловч тус шүүхээс тогтоосон шийтгэл нь анхан шатны шүүхийн тогтоолоор заагдсан шийтгэлээс хэтрэхгүй бөгөөд Эрүүгийн хуулийн зохих зүйлд заасан ялын доод хэмжээний шийтгэлээс бага үл болно.
	393 дугаар зүйл. Шийтгэсэн тогтоолыг хөнгөн болсон гэх шалтгаанаар хүчингүй болгох нь гагцхүү прокурор, дээд шүүхийн дарга, шүүх яамны сайд нарын эсэргүүцлээр гүйцэтгэгдэх бөгөөд үүнд уг хэргийг дахин хянуулахаар шилжүүлбэл зохино.
	398 дугаар зүйл. Хэрвээ анхны таслан шийтгэсэн тогтоолыг ялтан этгээдийн гомдолд дурдсан шалтгааныг баримтлан эсэргүүцэлгүйгээр хүчингүй болгосон байвал уг хэргийг шүүхээс дахин хянаж үзэхдээ урьд зааснаас хүнд шийтгэл оногдуулж үл болно.

²⁵ Csongor Herke, Criminal Procedure Law /lecture note/, (University of Pecs, 2018), 138.

²⁶ Хууль зүйн үндэсний хүрээлэн, Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хууль тогтоомжийн түүхэн уламжлал (1911-2009), 2012.



<p>1963 оны Эрүүгийн байцаан шийтгэх хууль</p>	<p>331 дүгээр зүйл. Давж заалдах шатны шүүх шийтгэгдэгчид оногдуулсан ялыг хүндрүүлэх буюу түүнд хүнд ялтай хуулийг хэрэглэж болохгүй Давж заалдах шатны шүүх хэргийг хэлэлцэхдээ анхан шатны шүүхээс өгсөн ялыг хөнгөрүүлэх буюу хөнгөн ялтай хуулийг хэрэглэж болох бөгөөд харин ялыг хүндрүүлэх буюу хүнд ялтай хуулийг хэрэглэх эрхгүй. Хүнд ялтай хуулийг хэрэглэх шаардлагатай буюу ял хөнгөдсөн тухай прокурор эсэргүүцэл бичсэн буюу хохирогчоос гомдол гаргасан байвал таслан шийдвэрлэх тогтоолыг хүчингүй болгож болно.</p> <p>371 дүгээр зүйл. Хяналтын шатны шүүхийн эрх хэмжээ ... Шүүх хэргийг шүүхийн хяналтын журмаар хянаж хэлэлцэхдээ шийтгэгдсэн этгээдэд оногдуулсан ялыг хөнгөтгөх буюу хөнгөн ялтай хуулийг хэрэглэж болох бөгөөд харин ялыг хүндрүүлэх буюу хүнд ялтай хуулийг хэрэглэх эрхгүй. ... Анхан шатны ба давж заалдах шатны шүүхээс шүүгдэгчийг цагаатгасан буюу хэргийг хэрэгсэхгүй болгосон явдал нь буруу болсон, түүнчлэн шийтгэгдсэн этгээдэд хөнгөн ял оногдуулсан нь хэргийн байдалд тохироогүй гэж үзвэл хяналтын шатны шүүх энэ хуулийн 346 дүгээр зүйлд дурдсан нөхцөлийг баримтлан таслан шийдвэрлэх тогтоол буюу магадлалыг хүчингүй болгож, хэргийг шинэчлэн хэлэлцүүлэхээр зохих анхан шатны буюу давж заалдах шатны шүүхэд буцаана ...</p>
<p>2002 оны Эрүүгийн байцаан шийтгэх хууль</p>	<p>324 дүгээр зүйл. Тогтоолыг өөрчлөх 324.1 Анхан шатны шүүх Эрүүгийн хуулийг буруу хэрэглэсэн, гэмт хэргийн хүнд, хөнгөн ба шийтгэгдсэн этгээдийн хувийн байдалд тохироогүй ял оногдуулсан нь тогтоогдвол давж заалдах шатны шүүх хөнгөн ялтай хууль хэрэглэх, эсхүл ялыг хөнгөрүүлэх өөрчилж болно. 324.2 Шүүх шүүгдэгчид оногдуулсан ялыг хэт хөнгөдсөн гэж үзвэл давж заалдах шатны шүүх тогтоолыг хүчингүй болгож, хэргийг дахин хэлэлцүүлэхээр анхан шатны шүүхэд буцаана.</p>

1949 оны Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 393 дугаар зүйлд зааснаас үзвэл ял хүндрүүлэхгүй байх зарчмыг хэрэглэх нөхцөлийг дээд шатны шүүхэд эсэргүүцэл гаргасан субъектүүдтэй уялдуулан харьцангуй байдлаар тодорхойлсон байв. Хэрэв шүүхээс оногдуулсан шийтгэл нь үйлдсэн гэмт хэрэгт нь үл тохирсон гэж дүгнэвэл доод шатны шүүхийн шийдвэрт өөрчлөлт оруулах, эсвэл хүчингүй болгож дахин хэлэлцүүлж болох хэдий ч анхны шийдвэрээс хүнд ял оногдуулахгүй байхаар дээд шатны шүүхийн эрх хэмжээг тогтоожээ.

Үүний дараа 1963 оны хуулиар дээд шатны шүүх ямар ч тохиолдолд хууль

зүйн дүгнэлт, үр дагаврыг хүндрүүлэх эрхгүй, харин шаардлагатай бол прокурорын эсэргүүцэл, хохирогчийн гомдлоор шийтгэх тогтоолыг хүчингүй болгох боломжийг хуульчилсан нь мөн харьцангуй шинжтэй зохицуулалт байв.

Харин 2002 оны Эрүүгийн байцаан шийтгэх хуулиас эхлэн гомдол, эсэргүүцэл гаргагч субьектээр ялгах явдлыг өөрчилж туйлын агуулгаар тодорхойлох болсон хэдий ч гомдол, эсэргүүцэл гаргасан субьектээс үл хамааран хүндрүүлэх шаардлагатай нөхцөлд анхан шатны шүүхээр дахин хэлэлцүүлж шийдвэрлэхээр хуульчилжээ. Өөрөөр хэлбэл, шүүгдэгчид ашигтайгаар



гомдол гаргасан эсэхээс үл хамааран гомдлын агуулгад дурдаагүй асуудлаар дүгнэлт хийн хэргийг буцаах, улмаар ял хүндрүүлэх нөхцөл байдлыг бүрдүүлсэн байна.

Үүний дараа 2017 онд батлагдсан Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 39.9 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1.4, 40.8 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.4 дэх заалтуудад "хэргийн зүйлчлэл, ялыг хүндрүүлэхгүйгээр анхан шатны шүүхийн шийдвэрт өөрчлөлт оруулах" хэмээн туйлын агуулгаар тодорхойлжээ.

V. Хүндрүүлэхийг хориглох зарчмыг туйлын агуулгаар хуульчилсны сөрөг тал

Манай улс хүндрүүлэхийг хориглох зарчмыг ийнхүү туйлын агуулгаар хуульчилсан нь дээд шатны шүүхийн эрх хэмжээг хумьж, хэргийн оролцогчдын эрх ашгийг хохироох, хууль ёсны зарчим алдагдахад хүргэх, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хүнд суртлыг нэмэгдүүлэх зэрэг сөрөг үр дагавруудыг бий болгох талтай.

2017 онд батлагдсан Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 39.9 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1.4, 40.8 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.4 дэх заалтуудад "хэргийн зүйлчлэл, ялыг хүндрүүлэхгүйгээр анхан шатны шүүхийн шийдвэрт өөрчлөлт оруулах" хэмээн дээд шатны шүүхийн эрх хэмжээг тодорхойлсон. Уг заалтыг²⁷ Монгол

Улсын иргэдээс гаргасан мэдээлэлд үндэслэн Үндсэн хуулийн цэц хянан үзээд 2019 оны 03 дугаар сарын 13-ны өдрийн №01 дүгнэлтээр Үндсэн хуулийн Арван зургаадугаар зүйлийн 14 дэх хэсэгт заасан "шүүхийн шийдвэрийг давж заалдах" эрхийг зөрчсөн хэмээн үзэж өмнөх шатны шүүхээс оногдуулсан ялыг хүндрүүлж шийдвэрлэх эрх хэмжээг хасжээ. Шийдвэрийнхээ үндэслэлийг дараах байдлаар тайлбарласан байна:

*"... анхан шатны шүүхийн шийдвэрээс шалтгаалж давж заалдах шатны болон хяналтын шатны шүүхийн ажиллагаа эхэлдэг. Өөрөөр хэлбэл, анхан шатны шүүхийн шийдвэрийг эс зөвшөөрч дээд шатны шүүхэд ханддаг бөгөөд гомдол, эсэргүүцлийн үндсэн дээр анхан шатны шүүх болон давж заалдах, хяналтын шатны шүүхийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа үүснэ. Иймд давж заалдах болон хяналтын шатны шүүхийн үйл ажиллагаа нь **анхан шатны шүүхийн шийдвэрийн хүрээнд асуудлыг шүүгдэгчид ашигтайгаар буюу хэргийн бодит байдлыг тогтоон хүний эрхийг хангаж**, анхан шатны шүүхийн шийдвэрийг эс зөвшөөрч дээд шатны шүүхэд гаргасан үндэслэл бүхий гомдлыг шийдвэрлэх ёстой. Гэтэл давж заалдах шатны шүүх болон хяналтын шатны шүүх шүүгдэгчид холбогдох эрүүгийн хэргийг гомдлоор хянан хэлэлцэхэд **гомдолд дурдаагүй асуудал**, тухайлбал, ялын*

²⁷ Монгол Улсын Их Хурлаас 2017 оны 05 дугаар сарын 18-ны өдөр баталсан Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 39.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт "Давж заалдах шатны шүүх шүүгдэгчид холбогдох хэргийн зүйлчлэлийг өөрчлөн ялыг хөнгөрүүлж, эсхүл шүүгдэгчид холбогдох хэргийн нөхцөл байдал, зүйлчлэлийг өөрчлөхгүйгээр ялыг хөнгөрүүлж, хүндрүүлж болно" гэж, 39.9 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1.4 дэх заалтад "шүүгдэгчид холбогдох хэргийн

нөхцөл байдал, зүйлчлэлийг өөрчлөхгүйгээр ялыг хөнгөрүүлж, эсхүл хүндрүүлж шүүхийн шийдвэрт өөрчлөлт оруулах;" гэж, 40.8 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.4 дэх заалтад "шүүгдэгчид холбогдох хэргийн нөхцөл байдал, зүйлчлэлийг өөрчлөхгүйгээр ялыг хөнгөрүүлж, эсхүл хүндрүүлж шүүхийн шийдвэрт өөрчлөлт оруулах;" гэж тус тус заасны "... хүндрүүлж ...", "... эсхүл хүндрүүлж ..." гэсэн заалт нь Үндсэн хууль зөрчсөн үндэслэлээр гомдол гаргажээ.



асуудлыг хөндөж анхан шатны шүүхийн шийдвэрээр оногдуулсан ялыг хүндрүүлэх боломжийг бий болгох зэргээр шүүгдэгч (бусад шүүгдэгч)-ийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг дордуулах хууль зүйн үндэслэлийг бүрдүүлсэн байна ..." гэжээ.

Үндсэн хуулийн цэцийн дээрх тайлбарыг ЭХХШТХ-ийн зохицуулалттай харьцуулан үзвэл **доод шатны шүүхийн шийдвэрт хяналт тавих дээд шатны шүүхийн хяналтын хүрээ зөвхөн шүүгдэгчид ашигтайгаар шийдвэр гаргах хүрээнд хязгаарлагдаж байна.** Тодруулбал, уг хуулийн дээд шатны шүүхийн эрх хэмжээг тодорхойлсон 39.9, 40.8 дугаар зүйлүүдэд заасны дагуу доод шатны шүүх Эрүүгийн хуулийг буруу хэрэглэсэн, процессын ноцтой зөрчил гаргасан нөхцөлд дээд шатны шүүх шийдвэрийг хүчингүй болгож буцаах эрхгүй. Дээд шатны шүүхэд хуулиар үүрэг болгосны дагуу эдгээр тохиолдлуудад шийдвэрийг хүчингүй болгох боловч энэ нь ямар нэгэн хууль зүйн үр дагаваргүй хяналт болж хувирна.

Энэ нь манай эрүүгийн процесст non reformation in peius зарчмыг туйлын агуулгаар тодорхойлж буйн илрэл юм. Энэ нөхцөлд ял хүндрүүлэх тухай ойлголт нь оногдуулсан ялын хэмжээг ихэсгэх, ялын төрөл, зүйлчлэлийг хүндрүүлэхээс гадна Эрүүгийн хуулийн ерөнхий ангид заасан тэнсэх арга хэмжээ авах болон нэмж нэгтгэх, ялаас чөлөөлөх, ял эдлүүлэх хугацааг хойшлуулах зэрэг ял оногдуулах журмуудыг буруу хэрэглэсэн нөхцөлд дээд шатны шүүх хууль хэрэглээг зөвтгөн дүгнэлт хийх, хууль ёсны зарчмыг хангуулах боломжгүй болгож байна.

Мөн уг заалтыг хэрэглэн хэрэг хянан шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрүүдийг судлан үзэхэд дараах тохиолдлуудад дээд шатны шүүхээс шүүгдэгчийн эрх зүйн байдлыг хүндрүүлэх үр дагавартай гэж үзжээ. Үүнд:

- Шүүгдэгчид оногдуулах ялын бодит хэмжээг шууд нэмэгдүүлэх үр дагавартай нөхцөлд тухайлбал, прокурор, хохирогчоос оногдуулсан ялын хэмжээг нэмэгдүүлэх агуулгатай гомдол, эсэргүүцэл гаргасан;
- Эрүүгийн хуулийн ерөнхий ангид заасан ялаас чөлөөлөх, хөнгөрүүлэх, тэнсэх зохицуулалтуудыг буруу хэрэглэсэн;
- Доод шатны шүүхийн хэргийн зүйлчлэлд холбогдох хууль зүйн дүгнэлт нь алдаатай бөгөөд илүү хүнд ялтай гэмт хэргээр өөрчлөн зүйлчлэхээр бол;
- Гэмт хэрэгт хамтран оролцогчийн хэлбэр, төрлийг өөрчлөн хүндрүүлэхээр бол;
- Гэмт хэргийг үгүйсгэх нөхцөл байдлыг буруу тогтоосон;
- Гэмт хэрэгт завдалтыг буруу тогтоосон буюу гэмт хэрэг төгссөн гэж үзэх нөхцөл байдал тогтоогдсон зэрэг болно.

Харин дараах тохиолдолд шүүгдэгчийн эдлэх ялын хэмжээ нэмэгдэхээр байсан ч түүний эрх зүйн байдал дордох нөхцөлд хамааруулахгүй байна. Үүнд:

- Эрүүгийн хуулийн ерөнхий ангид заасан хэд хэдэн гэмт хэрэг үйлдсэн хүнд ял оногдуулах, хэд



хэдэн шийтгэх тогтоолоор ял оногдуулах журмыг баримтлахад алдаа гаргасан;

- Өршөөл үзүүлэх тухай хуулийг буруу хэрэглэсэн;
- Зорчих эрхийг хязгаарлах ялыг эдлүүлэх нутаг дэвсгэрийн хүрээ хязгаарыг хумьсан гэх мэт.

Өмнөх бүлэгт дурдсан Унгар улсын зохицуулалтын түүхэн хөгжилд зарим талаараа манай улстай төсөөтэй байдал ажиглагдана. Монгол Улсын эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны тогтолцоонд дээд шатны шүүхээс эрүүгийн хэргийг шүүхийн өмнөх шатанд болон шүүхээр дахин хэлэлцүүлэхээр буцаах эрх байхгүй. Иймд шүүхийн практикт доод шатны шүүхийн гаргасан алдааг засахын тулд шүүгдэгчийн эрх зүйн байдал дордохоор байвал шийдвэрийг хүчингүй болгож анхан шатны шүүхээр *ex officio*²⁸ дахин хэлэлцүүлэх арга барил тогтсон. Үр дүнд нь 2002 оны Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн зохицуулалттай төсөөтэй практик хэрэгжсээр байгаа юм. Ингэснээр заавал дахин шүүх хуралдаан явуулах шаардлагагүйгээр эрүүгийн процессын цаг хугацаа, зардлыг хэмнэж дээд шатны шүүхээс шууд засварлах боломжтой алдаануудыг шүүхийн процессыг эхнээс нь дахин явуулах байдлаар сунжрах, улмаар хэргийн оролцогчдын эрх ашгийг хохироох нөхцөл байдал үүсгэж байна. Үүнийг шүүхийн шийдвэрүүдээр жишээ татаж тодруулъя.

Шийдвэр №1: Нийслэлийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн 2024 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн

²⁸ Ex officio хэмээх латин хэлц нь аливаа субъект өөрийн албаны чиг үүргийн хүрээнд ажиллагаа хийж гүйцэтгэхийг хэлнэ.

2024/ДШМ/646 дугаар магадлал.

Хэргийн тухай товч: Шүүгдэгч нь 2021 оны 08 дугаар сарын 01-ээс 02-нд шилжих шөнө Сонгинохайрхан дүүргийн нутаг дэвсгэрт нийтийн тээврийн хэрэгслээр зорчих үедээ хохирогчид “гар утсаар чинь ярья” гэж хэлээд гар утсыг нь авч, автобус зогсох үед эргүүлэн өгөхгүйгээр автобусаас буун зугтааж, улмаар хохирогч гар утсаа авахаар цүнхнээс нь зуурах үед цүнхнийхээ оосроор хохирогчийн хоолойг боосон гэмт хэрэгт холбогдуулан прокуророос Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.2 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар яллах дүгнэлт үйлдэж шүүхэд шилжүүлжээ. Анхан шатны шүүхээс шүүгдэгчид холбогдох хэргийн зүйлчлэлийг хөнгөрүүлж мөн хуулийн 17.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож, 1 жил 6 сарын хугацаагаар хорих ял оногдуулсан байна.

Шүүхийн шийдвэр: Давж заалдах шатны шүүхээс хэргийн зүйчлэлд холбогдуулан гаргасан прокурорын эсэргүүцэлд үндэслэн хэргийн хянан шийдвэрлэжээ. Хэргийн хүрээнд нотолбол зохих байдлуудыг хангалттай нотлон тогтоосон гэж үзсэн байна. Харин анхан шатны шүүхийн хийсэн хууль зүйн дүгнэлттэй холбогдуулан “... хохирогч өөрийн эд хөрөнгийг буцаан авах зорилгоор араас нь хөөхөд шүүгдэгч нь цүнхнийхээ оосроор хоолойг нь боож унаган гар утсыг авч явсан үйлдлийг бүхэлд нь авч үзэж дүгнэлт хийх нь зүйтэй ... Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.2 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “... бусдын эд хөрөнгийг хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлж



авахаар довтолсон ..." бол гэмт хэрэгт тооцохоор хуульчилсан байхад анхан шатны шүүх шүүгдэгчийг "... бусдын эд хөрөнгийг илээр, хүч хэрэглэхгүйгээр, хууль бусаар авсан ..." гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцсон нь үндэслэлгүй тул дээрэмдэх гэмт хэргийн хүндрүүлэх бүрэлдэхүүний объектив үндсэн шинжээр нь гэм буруутайд тооцох нь зүйтэй ...²⁹ хэмээн дүгнэж шийдвэрийг хүчингүй болгожээ.

Шийдвэр №2: Улсын дээд шүүхийн 2021 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн №61 дугаар тогтоол

Хэргийн тухай товч: Шүүгдэгч нь 2019 оны 05 дугаар сарын 24-өөс 25-нд шилжих шөнө Орхон аймгийн Баян-Өндөр сумын нутаг дэвсгэрт автомашины гражид хохирогчийн хэвлийн тус газарт хутгалж эрүүл мэндэд нь хүнд хохирол санаатай учруулсан гэмт хэрэгт холбогджээ. Анхан шатны шүүхээс шүүгдэгчийг Эрүүгийн хуулийн тусгай ангийн 11.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 2.4 дэх заалтад заасан гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож, мөн хуулийн ерөнхий ангийн 6.7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.4 дэх заалтад заасныг журамлан 3 жил 5 сарын хугацаагаар хорих ял шийтгэснийг давж заалдах шатны шүүх хэвээр үлдээсэн байна.

Шүүхийн шийдвэр: Хяналтын шатны шүүх шүүгдэгч, шүүгдэгчийн өмгөөлөгч нараас анхан болон давж заалдах шатны шүүхээс "зэвсгийн чанартай зүйл хэрэглэж" буюу хүндрүүлэх

²⁹ Нийслэлийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн 2024 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн 2024/ДШМ/646 дугаар магадлал, https://shuukh.mn/single_case/19680?daterange=2024-01-01%20-%202024-09-22&id=2&court_cat=2&bb=1 (Сүүлд үзсэн: 2024.08.29).

бүрэлдэхүүнтэйгээр гэмт хэрэг үйлдсэн хэмээн дүгнэсэнд холбогдуулан гаргасан гомдол болон прокуророос "шүүгдэгч анхан шатны шүүх хуралдаанд гэм буруугийн талаар маргаж оролцсон тул Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 6.7 дугаар зүйлийг хэрэглэж үндэслэлгүйгээр ялыг хөнгөрүүлэн шийдвэрлэсэн" гэсэн агуулга бүхий эсэргүүцэлд үндэслэн хэргийг хянан шийдвэрлэжээ. Шүүхээс анхан болон давж заалдах шатны шүүхийн дүгнэлт хэргийн жинхэнэ байдалд нийцсэн бөгөөд Эрүүгийн хуулийг зөв тайлбарлан хэрэглэж зүйлчилсэн гэж дүгнэсэн. Харин ял оногдуулах явцад Эрүүгийн хуульд заасан ял хөнгөрүүлэх журмыг буруу хэрэглэсэн талаарх прокурорын эсэргүүцлийг хүлээн авч "... анхан шатны шүүх ял шийтгэлийн хөнгөрүүлж шийдвэрлэсэн нь хууль зүйн үндэслэлгүй бөгөөд үнд давж заалдах шатны шүүх ямар ч хууль зүйн дүгнэлт хийгээгүй ..." ³⁰ тул шийтгэх тогтоол, магадлалыг хүчингүй болгож хэргийг анхан шатны шүүхээр дахин хэлэлцүүлэхээр буцаажээ.

Дээрх хоёр шийдвэрт хэргийн үйл баримтыг эргэлзээгүйгээр тогтооход хүрэлцэхүйц хэргийн нотлох баримтын бүрдүүлбэр хангагдсан, прокуророос шүүхэд шилжүүлсэн хэргийн хүрээнд хэргийг шийдвэрлэх боломжтой. **Зөвхөн доод шатны шүүхийн хууль хэрэглээний алдаатай холбоотой агуулгаар талууд гомдол гаргасан байна.** Ийм тохиолдолд шүүхийн шийдвэрийг хүчингүй болгож дахин

³⁰ Улсын дээд шүүхийн 2021 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн №61 дугаар тогтоол, https://shuukh.mn/single_case/2814?daterange=2021-01-01%20-%202021-02-01&id=3&court_cat=2&bb=1 (Сүүлд үзсэн: 2024.08.29).



хэлэлцүүлэх байдлаар эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны цаг хугацаа, зардлыг нэмэгдүүлж хүнд суртлыг даамжруулах сөрөг үр дагавартай буюу ЭХХШтХ-ийн 1 дүгээр зүйлд заасан эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зорилтуудыг алдагдуулах нөхцөл байдал үүснэ.

Үүний дээр ЭХХШтХ-ийн 39.9 дүгээр зүйлийн 1.4 дэх заалт, 40.8 дугаар зүйлийн 1.4 дэх заалтуудад зааснаар **non reformatio in peius** зарчим зөвхөн дээд

шатны шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хамааралтай. Харин хэргийг анхан шатны шүүхээр дахин хэлэлцүүлэхэд уг зарчим хамаарах талаар хуулийн зохицуулалтгүй. Шүүгдэгчийн гомдлоор хэргийг хянасан дээд шатны шүүхээс хэргийг хүчингүй болгож анхан шатны шүүхээр дахин хэлэлцүүлээд хууль зүйн дүгнэлт, үр дагаврыг анхны шийдвэрээс дордуулж өөрчилсөн тохиолдолд уг зарчмын ач холбогдол үндсэндээ алдагдаж байна.

Хүснэгт №2. Монгол, Австри, ХБНГУ болон Унгар улсын харьцуулалт

	Монгол	Австри	ХБНГУ	Унгар
Non reformatio in peius зарчмыг хуульчилсан эсэх	✓	✓	✓	✓
Туйлын эсхүл харьцангуй агуулгаар хуульчилсан	Туйлын	харьцангуй	харьцангуй	харьцангуй
Шүүхээс эрүүгийн хэргийг дахин хэлэлцүүлэхээр буцаах эрх хэмжээ бий эсэх	✗	✗	✓	✗
Дээд шатны шүүхээс доод шатны шүүхийн шийдвэрт хүндрүүлэн өөрчлөлт оруулах эрхтэй эсэх	✗	✓	✓	✓
Дүгнэлт	Дээд шатны шүүхээс доод шатны шүүхийн алдааг засах боломжгүй	Дээд шатны шүүхээс доод шатны шүүхийн алдааг засах боломжтой	Дээд шатны шүүхээс доод шатны шүүхийн алдааг засах боломжтой	Дээд шатны шүүхээс доод шатны шүүхийн алдааг засах боломжтой

Хүндрүүлэхийг хориглох зарчмыг туйлын агуулгаар тодорхойлох нь өмнөх бүлэгт дурдсанчлан хууль ёсны зарчим алдагдахад хүргэх, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хүнд суртлыг

нэмэгдүүлэх сөрөг нөлөөтэй учир улс орнууд тодорхой хязгаартайгаар хуульчилдаг байна. Ингэхдээ давж заалдах шатны шүүх эрүүгийн материаллаг хуулийг буруу хэрэглэсэн



үндэслэлээр шүүхийн шийдвэрийг хүчингүй болгож буцаах эрхгүй бол шинээр нотлох баримт хүлээн авах, үйл баримтад дүгнэлт өгөх, зүйлчлэлийг өөрчлөх эрхийг олгох зэргээр дээд шатны шүүхийн эрх хэмжээтэй хослуулан зохицуулж байна.

Монгол Улсын эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь уламжлалт мөрдөн шүүх тогтолцоонд хүний эрхийн баталгааг хангахад дэвшил болохуйц мэтгэлцээний элементүүдийг суулгасан зохицуулалттай билээ.³¹ Эх газрын эрх зүйн бүлийн сонгодог уламжлалаас ялгаатай нь шүүхийн болон шүүхийн өмнөх шатууд харьцангуй бие даасан шинжтэй. Үүнийг шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгээр холбож шүүхээс шүүхийн өмнөх шатанд хяналт тавих механизмыг нэг гэмт хэрэгт дахин яллагдахгүй байх, гэм буруугүйд тооцогдох эрхийн шаардлагад нийцүүлэн зохицуулахыг зорьжээ.³² Энэ нь шүүхээс өмнөх шатанд нотолгооны болон процессын хяналтыг хэрэгжүүлэхэд шүүхийн оролцоо, хариуцлагыг нэмэгдүүлэхэд чухал хүчин зүйл болсон.³³

Гэвч шүүхийн шатанд хяналтын механизмыг хэрхэн хангах нь тодорхойгүй үлджээ. Монгол Улсын шүүхийн тогтолцоо бол Үндсэн хууль, Олон улсын хүний эрхийн баримт бичгүүдэд заасан хүний эрхийг хамгаалахын тулд шүүхээр гомдлоо шийдвэрлүүлэх, давж заалдах

эрхийг хангах шүүхүүдийн шаталсан байгууламж бөгөөд шүүхийн тогтолцоо нэгдмэл байх зарчим нь Үндсэн хуульд ёсны нэг суурь зарчим³⁴ билээ. Давж заалдах шүүхийн тогтолцоо нь доод шатны шүүхийн шүүн таслах ажиллагаа дахь алдааг залруулах зорилготой³⁵ бөгөөд онцлог бүтцийн хувьд өөрийн гэсэн эрх хэмжээтэй байдаг. Шат шатны шүүхийн эрх хэмжээний уялдаа холбоо буюу шүүхийн тогтолцооны нэгдмэл байдлыг хадгалж шүүгдэгчийн эрхийн хамгаалалтыг баталгаатай эдлүүлэх, хууль ёс, шударга ёсонд нийцсэн зохицуулалтыг боловсруулах шаардлагатай байна.

Үүний тулд шүүгдэгчид оногдуулсан ялыг хүндрүүлэхгүй байх зарчмыг дотоодын шүүхийн тогтолцоо, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны онцлогтой уялдуулан агуулгыг нь зөв тодорхойлох, үүнд шүүхийн эрх хэмжээг хуульчлах нь зүйтэй. Энэ хүрээнд Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 09 дүгээр сард санаачилсан “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хуулийн төслийн 39.9 дүгээр зүйлийн 1.7 дахь хэсэгт давж заалдах шатны шүүх “... прокурорын эсэргүүцэл, хохирогч, хохирогчийн хууль ёсны төлөөлөгчийн гомдлыг үндэслэн прокуророос эрүүгийн хэрэг үүсгэж, яллагдагчаар татсан хэмжээ хязгаарын дотор хэргийн зүйлчлэл, ялыг хүндрүүлэх”³⁶ эрхтэй байхаар тусгасан нь

³¹ Ж.Эрхэсхулан, “Монголын эрүүгийн процессын амин сүнс ба сорилт бэрхшээл”, Эрх зүй сэтгүүл 61 (1), 2023, 326 дахь тал.

³² Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах судалгааны тайлан, parliament.mn, 2020 он.

³³ Д.Баярсайхан, Эрүүгийн эрх зүй, эрүүгийн процессын шинэтгэлийн асуудлууд, 2019, 242 дахь тал.

³⁴ Н.Лүндэндорж, Монгол Улсын Үндсэн хуулийн шинжлэх ухааны тайлбар, 2023, 752 дахь тал.

³⁵ Ц.Цогт, “Давж заалдах шатны шүүхийн үүсэл, хөгжил (1911-2015)”, legaldata.mn, 2016, 2 дахь тал.

³⁶ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, 2023.09.18, Монгол Улсын Засгийн газар <https://mojha.gov.mn:8085/core/files/6508165a99e06106c6370126> (Сүүлд үзсэн: 2024.09.02).



тохиромжтой зохицуулалт байж болох юм.

Ингэснээр **non reformation in peius** зарчмын агуулгыг харьцангуй хүрээнд тодорхойлох замаар нэг талаас шүүгдэгч айдасгүйгээр дээд шатны шүүхэд гомдол гаргах эрхээ эдлэх боломж бүрдэх, нөгөө талд доод шатны шүүхийн алдааг залруулах дээд шатны шүүхийн эрх хэмжээг бүрдүүлнэ. Шүүх эрүүгийн хэргийг прокурорын яллах дүгнэлтийн хүрээнд хянан шийдвэрлэх тул түүнээс хүндрүүлэн өөрчлөх тохиолдолд шүүгдэгч ямар хэрэгт яллагдаж байгаагаа мэдэх, өөрийгөө өмгөөлөх, өмгөөлүүлэх эрхээ эдлэх хангалттай хугацааг олгохын тулд дээд шатны шүүхийн эрх хэмжээг энэ хүрээнд хязгаарлах нь зүйтэй. Ингэснээр материаллаг хуулийг буруу хэрэглэсэн нөхцөлд шүүхийн хяналтын нэгдмэл тогтолцоо үйлчлэх, шүүгдэгчийн эрхийн баталгааг хангахад дөхөмтэй өөрчлөлт болж байна.

Харин “2021 оны Шүүхийн тухай хуулийн шинэтгэлийн хүрээнд Дээд шүүхийн хяналтын журмаар хэрэг хянан шийдвэрлэх чиг үүргийн зорилгыг “хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангах” гэж тодорхойлсноор Улсын дээд шүүх гагцхүү хуульд заасан шалгуур хангасан гомдлыг хэлэлцүүлж, хяналтын журмаар хянан шийдвэрлэх замаар Монгол Улсын шүүхийн үндсэн тогтолцоо дахь шүүхийн дээд байгууллагын хувиар хууль хэрэглээний нэгдмэл байдал төлөвшүүлэх”³⁷ үндсэн чиг үүрэгтэй болсон билээ. Үүний дагуу “ЭХШТХ-ийн ноцтой

зөрчсөнөөс” бусад нөхцөлд нэг бүрчилсэн (*private purpose*) хяналтыг тавихгүй байхаар хуульчилсан. Иймд зөвхөн хэргийн зүйлчлэл ба Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн бусад хэм хэмжээг хэрэглэхэд үүссэн зөрүүг арилгах, хуулийг албан ёсны тогтоол, тайлбараас өөрөөр хэрэглэсэн, эрх зүйн шинэ ойлголт, эсхүл хууль хэрэглээг тогтооход зарчмын хувьд нийтлэг ач холбогдолтой асуудлаар доод шатны шүүхийн шийдвэрт хяналт тавих эрхээр Улсын дээд шүүхийн хяналтын хүрээ хязгаарлагдана. Шүүгдэгчид оногдуулсан ялын хэмжээг өөрчлөхтэй холбоотой асуудал уг хяналтын хүрээнд хамаарахааргүй байна. Үүнтэй уялдуулан **non reformation in peius** зарчмын агуулгыг давж заалдах болон хяналтын шатны шүүхүүдэд өөр өөрөөр хуульчлах нь зүйтэй. Тодруулбал, хяналтын шатны шүүх зөвхөн хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангах зорилгоор хэргийн зүйлчлэлтэй холбоотой асуудлаар хүндрүүлэх болон хөнгөрүүлэх эрхтэй байхаар зохицуулах нь зүйтэй юм.

VI. Дүгнэлт

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хууль зөрчсөн эсэхийг хянах, шүүгдэгчийн эрхийг баталгаатай эдлүүлэх үүднээс шүүгдэгч болон хэргийн бусад оролцогчдоос давж заалдах гомдол, эсэргүүцэл гаргах эрхийг бодитой хангах, төрийн зүгээс үүнд саад тавихгүй байх зорилгоор **non reformation in peius** зарчим үйлчилдэг.

Уг зарчмын хэрэглээг харьцангуй болон туйлын агуулгаар тодорхойлж болох ба харьцуулсан судалгааны хүрээнд судалсан орнуудад харьцангуй агуулгаар хуульчилсан байна. Харьцангуй агуулгаар

³⁷ Ц.Цогт, С.Цэрэндолгор, “Монгол Улсын шүүхийн үндсэн тогтолцоон дахь Улсын дээд шүүхийн хяналтын журмаар хэрэг хянан шийдвэрлэх чиг үүрэг: Хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангах нь”, *legaldata.mn*, 2022, 9 дэх тал.



гэдэгт шүүгдэгч өөрт нь хохиролтойгоор шүүхийн шийдвэр хүндэрнэ гэх айдасгүйгээр гомдол гаргах боломжийг олгохын тулд гомдлын агуулгад гол анхаарал хандуулдаг ажээ. Шүүгдэгч, түүний өмгөөлөгч, хууль ёсны төлөөлөгч, прокуророос шүүгдэгчид ашигтай агуулгаар гомдол, эсэргүүцэл гаргасан тохиолдолд өмнөх шүүхийн шийдвэрийг хүндрүүлэн өөрчлөхийг хориглоно. Үүнээс гадна шүүхийн шийдвэрт ямар агуулгаар өөрчлөлт оруулах нь энэ зарчмын хүрээнд анхаарах асуудлын нэг мөн.

Ял болон зүйлчлэлийг хүндрүүлэхийг хориглох, зөвхөн ялыг хүндрүүлэхийг хориглох нь тухайн улсын шүүхийн тогтолцоо буюу шат шатны шүүхүүдийн эрх хэмжээтэй холбоотой. Жишээлбэл, ХБНГУ-д давж заалдах шатны шүүх шинээр нотлох баримт цуглуулах, үйл баримтыг шинэчлэн тогтоох эрхтэй учир зөвхөн ял хүндрүүлэх эсэх асуудалд уг зарчмыг баримталдаг. Харин Монгол Улсын хувьд хүндрүүлэхийг хориглох зарчмыг 1949, 1963 оны Эрүүгийн байцаан шийтгэх хуулиудад харьцангуй агуулгаар тодорхойлж байсан ч 2002 болон 2017 оны процесс хуулиудад туйлын агуулгаар хуульчилсан байна.

Давж заалдах болон хяналтын шатны шүүхийн эрх хэмжээ, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны тогтолцоотой уялдуулан үзвэл уг зарчмыг туйлын агуулгаар тогтоох буюу зөвхөн шүүгдэгчид ашигтайгаар шийдвэрлэх нь тохиромжгүй. Шүүхийн шаталсан хяналтын тогтолцоог бүрэн хөгжүүлээгүй нөхцөлд туйлын хандлагыг баримтлах нь хууль ёсны зарчим алдагдахад

хүргэнэ. Үүнд хуулийн хэд хэдэн хийдэл нөлөөлж байна. Нэгдүгээрт, дээд шатны шүүхээс доод шатны шүүхийн шийдвэрт өөрчлөлт оруулах эрх хэмжээ нь зөвхөн шүүгдэгчид ашигтай шийдвэр гаргахаар хязгаарлагдсан тул ЭХХШТХ-ийн дагуу доод шатны шүүхийн гаргасан алдааг хянаад хуульд нийцүүлэн өөрчлөлт оруулахад шүүгдэгчийн эрх зүйн байдлыг дордуулах үрдагавартай нөхцөлд эрүүгийн хэргийг эцэслэн шийдвэрлэх боломжгүй. Хоёрдугаарт, шүүхийн практикт тогтоод буй дарааллын дагуу дээд шатны шүүхээс хүчингүй болгосон шийдвэрийг гаргасан анхан шатны шүүх хэргийг өөрөө дахин хэлэлцүүлж шийдвэрлэхэд анхны шийдвэрээс дордуулан өөрчилсөн тохиолдолд шүүгдэгч давж заалдах эрхээ эдлэх баталгаа бүрэн хангагдаагүй байна. Иймд *non reformation in peius* зарчмын агуулгыг дахин тодорхойлж, үүнтэй уялдуулан эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны онцлогт нийцсэн шүүхийн хяналтыг зөв бүрдүүлэх шаардлага зайлшгүй тулгарч байна.

Ингэхдээ давж заалдах болон хяналтын шатны шүүхийн хяналтын онцлогийг харгалзан ялгаатай агуулгаар тодорхойлох шаардлагатай. Тодруулбал, давж заалдах шатны шүүх гомдлын агуулга, гомдол гаргасан субъектээс хамаарч хэргийн зүйлчлэл болон ялыг прокурорын яллах дүгнэлтийн хүрээнд хөнгөрүүлэх, эсхүл хүндрүүлэх; хяналтын шатны шүүх хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангах зорилгоор зөвхөн хэргийн зүйлчлэлийг яллах дүгнэлтийг хүрээнд хөнгөрүүлэх, эсхүл хүндрүүлэн өөрчлөх эрхтэй байхаар зохицуулах нь зүйтэй.



VII. Ном зүй

Монгол эх сурвалж:

1. Д.Баярсайхан, *Эрүүгийн эрх зүй, эрүүгийн процессын шинэтгэлийн асуудлууд*, 2019.
2. Н.Лүндэндорж, *Монгол Улсын Үндсэн хуулийн шинжлэх ухааны тайлбар*, 2023.
3. Ц.Цогт, С.Цэрэндолгор, "Монгол Улсын шүүхийн үндсэн тогтолцоон дахь Улсын дээд шүүхийн хяналтын журмаар хэрэг хянан шийдвэрлэх чиг үүрэг: Хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангах нь", *legaldata.mn*, 2022.
4. Ц.Цогт, "Давж заалдах шатны шүүхийн үүсэл, хөгжил (1911-2015)", *legaldata.mn*, 2016.
5. Ж.Эрхэсхулан, "Монголын эрүүгийн процессын амин сүнс ба сорилт бэрхшээл," *Эрх зүй сэтгүүл* 61 (1), 2023.
6. Ханнс-Зайделийн сан, *Эрүүгийн эрх зүйн нэр томъёоны толь*, 2006 он.
7. Хууль зүйн үндэсний хүрээлэн, *Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хууль тогтоомжийн түүхэн уламжлал (1911-2009)*, 2012.
8. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах судалгааны тайлан, *parliament.mn*, 2020 он.

Гадаад эх сурвалж:

1. Csongor Herke & Csenge D. Tyth, "Theoretical and Practical Issues of the Prohibition of Reformatio in

Peius in Hungary", *Business and Law* Vol.3 (2011).

2. Csongor Herke & Csenge D. Tyth, "The Prohibition of Reformatio in Peius in the light of the Principle of Fair Procedure", *researchgate.net*, 2021, 92-98.
3. Csongor Herke, *Criminal Procedure Law /lecture note/*, (University of Pács, 2018)
4. Heinrich, Manfred, *Deutsches Strafverfahrensrecht*, 2018.
5. Joachim Kretschmer, *Das strafprozessuale Verbot der reformatio in peius und die Maßregeln der Besserung und Sicherung*, 1999.
6. Beulke, Swoboda, *Strafprozessrecht*, 2022.
7. Verena Uran, *Das Verschlechterungsverbot im österreichischen Strafprozess – Ausgestaltung und Entwicklung* 2013.
8. Gцssel, Karl Heinz, Ulrich Franke, Karl Heinz Gцssel, and Ulrich Franke: *StPO §§ 312-373a*, 2012.
9. Sanchez-Hermosilla, Fernando, and Peter Schweikart: *Die StPO in Fдllen* 2008.

**Эрх зүйн эх сурвалж:**

1. Австри Улсын эрүүгийн процесс хууль (1803).
2. Австри Улсын эрүүгийн процесс хууль (1850).
3. Герман Улсын эрүүгийн процесс хууль (1877).
4. Унгар Улсын Эрүүгийн процесс хууль (2017).
5. Монгол Улсын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль (2017).
6. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, 2023.09.18.

Шүүхийн шийдвэр:

1. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2019 оны 03 дугаар сарын 13-ны өдрийн №1 дүгнэлт
2. Нийслэлийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн 2024 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн 2024/ДШМ/646 дугаар магадлал
3. Улсын дээд шүүхийн 2021 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн №61 дугаар тогтоол

**Abstract****THE SCOPE OF THE APPELLATE REVIEW REGARDING THE PRINCIPLE
OF NON REFORMATIO IN PEIUS****B.AMARBAYASGALAN***Doctor of Laws (Ph.D.)
Justice of the Supreme Court of Mongolia***Z.YANJINLKHAM***Researcher of the Criminal law sector, Judicial Academy
under the Supreme Court of Mongolia***E.BAASANBYAMBA***Researcher of the Criminal law sector, Judicial Academy
under the Supreme Court of Mongolia*

The principle of non reformation in peius was established to safeguard the defendant's right to appeal in criminal procedure. Its application can vary in scope, either in relative or absolute sense, depending on the legal framework of individual countries. In Mongolia, this principle is defined in an absolute sense under article 39.9-1.4 and 40.8-1.4 of Criminal Procedure Code of Mongolia. This limits the scope of judicial review by higher courts to decisions in favor of defendants thereby potentially undermining the overall effectiveness of judicial review, as there is no authority to remand cases for retrial or to lower court. Moreover, restrictive provisions of the principle do not apply in cases of retrial thereby resulting in a considerable legal void. This deficiency does not adequately safeguard the defendant's

rights, exposing them to potential inadequacies in legal protection during subsequent judicial reviews. Therefore, the primary objective of this article is to conduct a comprehensive theoretical analysis of the principle, elucidate its significance and application through an in-depth comparative and practical examination, and subsequently define and refine its integration within the framework of the Criminal Procedure Code of Mongolia. This approach aims to enhance understanding of the principle's role and effectiveness in the context of Mongolian criminal law.

Keywords

Criminal procedural law, the principle of non-reformation in peius, the right to appeal, judicial review of criminal matter, favor defensionis.

ХЭЛЦЛИЙН ХЭЛБЭРИЙН ШААРДЛАГЫН ҮНДЭСЛЭЛ, ТӨРӨЛ

Б.Батбаяр¹

- I. Удиртгал
- II. Хэлцлийн хэлбэрийн шаардлагын үндэслэлийн тухай ойлголт
- III. Хэлцлийн хэлбэрийн шаардлагын үндэслэлийн төрөл
- IV. Дүгнэлт
- V. Ном зүй

¹ Монголын Өмгөөлөгчдийн Холбооны гишүүн, өмгөөлөгч, хууль зүйн ухааны магистр (LL.M).



ХЭЛЦЛИЙН ХЭЛБЭРИЙН ШААРДЛАГЫН ҮНДЭСЛЭЛ, ТӨРӨЛ

Б.БАТБАЯР, Монголын Өмгөөлөгчдийн Холбооны гишүүн,
өмгөөлөгч, хууль зүйн ухааны магистр (LL.M).

Түлхүүр үг

Нотлох чиг үүрэг, анхааруулах чиг үүрэг, мэдээлэх чиг үүрэг, шилжүүлэх, хэлбэржүүлэх.

Хураангуй

Хэлцлийн хэлбэрийн шаардлагыг хамгийн оновчтойгоор тодорхойлохын тулд түүний бий болсон хийгээд байгаа шалтгаан буюу үндэслэлийг судлах шаардлагатай. Өдгөө хэлцлийн хэлбэрийн шаардлагын үндэслэлийг чиг үүргийнх нь хувьд авч үзэж, тодорхойлж байна. Үүнээс судлаачдын үзэж буйгаар үндсэн чиг үүргүүд нь нотлох, анхааруулах, мэдээлэх юм. Гэвч хэлцлийн хэлбэрийн шаардлагын үндэслэлийг зөвхөн түүний чиг үүргээр нь хязгаарлахгүйгээр хэлцлийн төрлөөс шалтгаалан тухайлсан шинжээр нь өргөн хүрээнд авч үзэх нь энэхүү ойлголтыг бүрэн дүүрэн тодорхойлоход үлэмж ач холбогдолтой юм.

I. Удиртгал

Хэлцлийн хэлбэрийн шаардлага нь зөрчигдсөн тохиолдолд хэлцлийн төрлөөс хамаарч янз бүрийн үр дагаварт хүрэхээр хуульчлагдсан байдаг. Тухайлбал тус хэлцэл байгуулагдаагүй, эсхүл хүчингүй гэж үзэх, тодорхой

хэсэг нь хүчингүй болох буюу хэлцлийн нэг хэсэг гэж үзэх боломжгүй болох, гэрчээр нотлох эрхээ алдах гэх мэт. Харин эдгээр хэлбэрийн шаардлагууд ийнхүү хуульчлагдах болсон шалтгааныг тодруулснаар хуульчлагдсан үр дагаврыг тохиолдол бүрд буюу хэлцлийн төрөл тус бүрд оновчтой зөв хэрэглэх нөхцөл бүрдэх юм. Энэ шалтгаанаар хэлцлийн хэлбэрийн шаардлага бий болсон буюу байгаа үндэслэлийг тодруулан судлах нь энэ төрлийн хууль тогтоомжийг боловсронгуй болгох хийгээд шүүхийн практикт зөв жишиг тогтооход чухал ач холбогдолтой хэмээн үзэж байна.

Энэ сэдвийн хүрээнд бичигдсэн бүтээлүүд нь хэлцлийн хэлбэрийн шаардлагыг гэрээний эрх чөлөөний зарчимтай сөргүүлэн авч үзэж, түүний хязгаарлагдмал шинжтэй болохыг дурдаж, зорилго нь гагцхүү хэлцлийг байгуулах, амжилттай хэрэгжүүлэхэд чиглэсэн, дэмжин туслах чиг үүрэгтэй болох талаар дурдсан байдаг. Харин энэхүү судалгаагаар энэ төрлийн сэдэвт ихээхэн жин дардаг гэрээний эрх чөлөөний зарчмыг дахин дурдахаас зайлсхийж, хэлцлийн хэлбэрийн шаардлагын бий болсон, байгаа шалтгаан нь чухам юу болох талаар түүхчлэн судалж, түүний



үндэслэл нь зөвхөн гүйцэтгэх чиг үүргээр нь тодорхойлогдох байдлаар хязгаарлагдахгүй бөгөөд хэлцлийн төрлөөс шалтгаалан тус хэлцлийн агуулгын салшгүй хэсэг байх боломжтой эсэх талаар өргөжүүлэн судалсан.

II. Хэлцлийн хэлбэрийн шаардлагын үндэслэлийн тухай ойлголт

Хэлцлийн хэлбэрийн шаардлага гэх ойлголтыг тодорхойлох хамгийн тохиромжтой арга нь түүний бий болсон буюу байх шалтгаан, үндэслэлийг оновчтой тогтоох явдал юм. Эрх зүйн тодорхой ойлголт нь түүхийн турш хувьсан өөрчлөгдөж, үүрэг, ач холбогдол нь цаг үеийн шаардлагаар тодорч, бүдгэрсээр ирсэн байдаг. Иймээс тухайн ойлголтыг бүрэн дүүрэн, алдаа мадаггүй тодорхойлохын тулд үүсэн бий болсон үеэс нь эхлээд хувьсал, хөгжлийг нь тасралтгүй судлах нь онцгой ач холбогдолтой билээ. Хэлцлийн хэлбэрийн шаардлагын үүслийг судалж үзэхэд бүхий л эх сурвалж Ромын эрх зүй рүү зааж байв. Европ тивд хамгийн анхны их сургуулиуд 11 дүгээр зуунд байгуулагдаж, хувийн эрх зүйн хичээл латин хэл дээр ордог байсан бөгөөд үүнд Ромын эрх зүйн чухал эх сурвалжууд болох *ius commune* (нийтлэг эрх зүй хэмээн латинаас англи хэлэнд буудаг боловч Английн эрх зүйд “эх газрын эрх зүй” хэмээн агуулгаар нь ойлгодог) болон Юстанианы гэгдэх *Corpus Iuris Civilis* (Иргэний эрх зүйн эмхэтгэл) зэргийг заадаг байсан¹. Харин 1758 онд Оксфордын их сургууль Английн эрх зүйн хичээлийг (шүүхийн жишиг судлал)

албан ёсоор зааж эхлэх хүртэл “эх газрын эрх зүй” буюу тухайн үеийн Ромын эрх зүйг судалдаг байв².

Ромын эрх зүйд тодорхой нөхцөл хангагдсан тохиолдолд л талуудын хийсэн хэлцэл заавал биелэх шинжтэй болдог байсан³. Эдгээр нөхцөлүүдийг одоо хэрэгжиж буй хэлбэрийн шаардлагуудтай шууд жиших замаар хэлбэрийн шаардлага мөн эсэхийг тодорхойлох нь учир дутагдалтай. Жишээ нь амаар байгуулж болох хэлцлийг өдгөө хэлбэрийн шаардлага шаарддаггүй хэлцэл гэж үздэг. Гэвч Ромын эрх зүйд энэ төрлийн хэлцлийг байгуулах арга нь маш тодорхой хэлбэржсэн бөгөөд үүнийг дагаж мөрдөөгүй нь хэлцлийг заавал биелэгдэх шинжгүй гэж үзэж, хэлцлийн тал үүргийг гүйцэтгүүлэхээр шаардах, албадан гүйцэтгүүлэх боломжгүй болох, нөгөөтээгүүр анхаарал болгоомжгүйгээр хэлбэржсэн нөхцөлийг биелүүлснээр заавал биелэгдэх шинжтэй үүргийг хүлээх үр дагавартай байсан. Тухайлбал, *contractus verbis* буюу аман хэлцэл байгуулахын тулд нэг тал нь албан ёсоор маш тодорхой асуулт тавих бөгөөд нөгөө тал нь үүнд ямар нэгэн болзол заахгүйгээр зөвшөөрсөн бол байгуулагдсанд тооцогддог бөгөөд үүнийг ердийн гэрээний санал ба саналын зөвшөөрсөн хариутай адилтгах боломжгүй.

Учир нь гэрээний үүргийг шаардах эрхийн хүрээ нь зөвхөн талуудын солилцсон албан ёсны асуултаар тодорхойлогдох бөгөөд нөхцөл байдлаас шалтгаалж, үгсээр илрээгүй боловч агуулгаараа багтсан болох нь илэрхий

² Мөн тэнд.

³ Mousourakis, G. (2015). Roman Law and the Origins of the Civil Law Tradition. Springer International Publishing. 128.

¹ Smits, J. M. (2017). Advanced Introduction to Private Law. Edward Elgar Publishing. 2-3.



зүйлсийг зөвхөн дурдагдаагүй гэх шалтгаанаар шаардах боломжгүй болдог⁴. Үүгээр ч зогсохгүй асуултад хариулж буй хэлцлийн талыг дарамталсан, хууран мэхэлсэн шинжтэй нөхцөл илэрсэн ч хэлцлийг заавал биелүүлэх үр дагавартай байсан⁵ тул үүнийг онцгой хатуу хэлбэрийн шаардлага гэж үзэхээс өөр аргагүй юм. Бурангуй гэж дүгнэж болох энэ шударга бус практикийг хожим нь Ромд бүгд найрамдах засаглал тогтох үед өөрчилж, хууран мэхэлсэн, дарамт шахалт үзүүлж хийсэн хэлцлийн эсрэг хэлцлийн нөгөө тал нь шаардлага гаргах эрхтэй болсон байна.⁶

Харин хэлцлийн зүйл нь хууль зөрчсөн, нийтээр хүлээн зөвшөөрсөн зан суртахуунд харш, бодитоор биелүүлэх боломжгүй бол анхнаасаа хүчин төгөлдөр бус гэж үздэг⁷ байснаас хүчин төгөлдөр хэлцэл байгуулсанд тооцоход дан ганц хэлбэрийн бус агуулгын хяналт тодорхой хэмжээнд байсан болохыг харж болно.

Өдгөө хамгийн түгээмэл хэлбэрийн шаардлагад тооцогдох болсон бичгээр үйлдэх хэлцэл буюу *contractus litteris* нь зөвхөн мөнгөн зээлийн харилцаанд хэрэглэгддэг байжээ⁸. Ингэхдээ зээлдүүлэгчийн өрийн бүртгэлийн дэвтэрт зээлдэгчийн зээлийн хэмжээ болон түүний мэдээлэл бичигдсэнээр байгуулагдсанд тооцогддог бөгөөд бусад төрлийн хэлцлээс ялгаатай нь өөр этгээд бусдын өмнөөс өрийг нь хариуцах хүсэл зоригоо илэрхийлсний хариуд зээлдүүлэгч зөвшөөрвөл түүнийг өрийн бүртгэлийн дэвтэртээ бүртгэсэнээр өмнөх

зээлдэгчийн үүрэг дуусгавар болдог байсан байна⁹.

Бодит гэрээ буюу *contractus re* (эртний нэршил нь *mutuum*) нь зээлийн харилцаанд түгээмэл хэрэглэгддэг байсан бөгөөд тодорхой эд зүйлийг тогтоосон хугацаа өнгөрөхөд буцааж өгнө гэсэн тохиролцооны дагуу бодитоор шилжүүлснээр хэлцэл байгуулагдсанд тооцогдож, шаардах эрх үүсдэг байсан¹⁰. Үүнээс хэлцлийн талууд тодорхой үйлдлийг бодитоор гүйцэтгэх нь хэлцэл байгуулагдах нэг төрлийн арга буюу хэлбэр болон тогтсон болохыг харж болно.

Ромын эрх зүйн үеийн дээрх зохицуулалтуудаас хэлцлийн хэлбэрийн шаардлага бий болох үндэслэл нь хэлцэл байгуулагдсан эсэхийг нотлохоос илүүтэй хэлцлээр тохирсон зүйл юу байсан эсэхийг тодорхойлоход чиглэсэн гэж үзэх боломжтой. Учир нь тухайн үед хэлцэл байгуулагдсан гэж үзэхэд *causa* буюу шалтгаан (үндэслэл) шаардлагатай гэж үздэг байсан бөгөөд ийм шалтгаантай хүмүүс л байгуулж буй хэлцэлдээ ач холбогдол өгч, дээр дурдсан хэлбэрийн шаардлагыг мөрддөг байсан тул тодорхой хэмжээнд хэлбэржсэн тохиролцоо нь тэр хэмжээгээрээ хэлцлийн зүйлийг тодорхойлж, маргаан шийдвэрлэлтийг хөнгөвчилж байсан байна.

Харин нийтлэг эрх зүйн тогтолцоот орнуудын хувьд хэлцлийн хэлбэрийн шаардлагыг 1677 онд Английн Эзэн хааны баталсан "Залилан мэхлэхээс сэргийлэх тухай хууль"-иас (Statute of Frauds 1677) эхтэй гэж үздэг¹¹. Тус хуулийн оршил

⁴ Mousourakis, G. (2015). 132.

⁵ Мөн тэнд.

⁶ Мөн тэнд.

⁷ Мөн тэнд.

⁸ Mousourakis, G. (2015). 133.

⁹ Мөн тэнд.

¹⁰ Mousourakis, G. (2015). 129.

¹¹ Seddon, N. C. and Bigwood, R. A. (2017). Cheshire and Fifoot's law of contract. Eleventh Australian



хэсэгт “Энэ хуулийн зорилго нь худал мэдүүлэг өгөх болон худал мэдүүлэг өгүүлэх зэргээр аливаа хууран мэхлэх зүй бус оролдлогуудаас сэргийлэхэд оршино” хэмээн заажээ¹². Тус зорилгыг биелүүлэх хүрээнд хуулиар тодорхой хэлцлийн хэлбэрийн шаардлагуудыг тогтоож, зөрчигдсөн тохиолдолд үүсэх үр дагаврыг тусгасан байдаг. Тухайлбал, тус хуулиар үндсэн таван төрлийн хэлцлийг бичгээр байгуулахаар заасан¹³. Үүнд:

- Батлан даалтын гэрээ: Батлан даасан этгээд нь өр төлбөрийн үүргээ гүйцэтгэж чадахгүй тохиолдолд тус этгээдийн өмнөөс өрийг хариуцахаар үүрэг гүйцэтгүүлэгчтэй тохиролцсон хэлцэл¹⁴.
- Гэрээслэл гүйцэтгэгчийн амлалтыг гэрчлэх хэлцэл: Нас барагчийн үүргийг биелүүлэх зорилгоор гэрээслэл гүйцэтгэгчийн үйлдсэн аливаа онцгой амлалт¹⁵. Энэхүү амлалтаар илэрхийлэгдэх хэлцэл нь нас барагчийн бус гэрээслэл гүйцэтгэгчийн өөрийн хөрөнгөөр нас барагчийн өр төлбөрийг барагдуулах агуулгатай байсан.
- Гэрлэх саналыг зөвшөөрсөн тохиолдолд хөрөнгө шилжүүлэх хэлцэл: Гэрлэх саналыг зөвшөөрвөл өөрийн хөрөнгийг шилжүүлэх тухай амлалт тухайн үед түгээмэл байснаас үүнийг бичгээр үйлдсэн тохиолдолд шаардах эрх үүсдэг байсан

Edition. Lexis Nexis Butterworths. 857.

¹² Thampapillai, D. et al., (2012). Contract law: text and cases. Oxford University Press. 164.

¹³ Emanuel, S. L. (2015). Contracts. Eleventh Edition. Wolters Kluwer. 537.

¹⁴ Мөн тэнд.

¹⁵ Emanuel, S. L. (2015). 538.

байна¹⁶.

- Газартай холбоотой хэлцлүүд: Нэн тэргүүнд газар худалдах, худалдан авах хэлцэл үүнд хамаардаг. Мөн нэг жил буюу түүнээс дээш хугацаагаар түрээслэх гэрээ, зээлийн барьцаа болгон ашиглах тухай газар барьцаалах гэрээ, бусдын газраар дайрч өнгөрөх сервитутын гэрээ, ургац хураах тухай гэрээ зэрэг болно¹⁷.
- Нэг жилээс дээш хугацаагаар байгуулагддаг хэлцэл: Үүнд нэг жилийн дотор тус хэлцлээр хүлээсэн үүргийг гүйцэтгэх боломжгүй хэлцлүүдийг багтаадаг¹⁸.

Үүнээс дүгнэвэл Нийтлэг эрх зүйн тогтолцоот орнуудын хувьд хэлбэрийн шаардлага үүсэн бий болох анхдагч хэрэгцээ, шаардлага нь хэлцэл байгуулагдсан эсэхийг нотлох явдал байсан. Өөрөөр хэлбэл хэлцлийн талууд хэлцэл байгуулагдсан эсэх дээр маргах тохиолдолд үүнийг нотлоход бэрхшээлтэй байдаг бөгөөд огт байгуулагдаагүй хэлцлийг гэрчийн мэдүүлэг ашиглаж байгуулагдсан мэтээр залилан мэхлэх тохиолдол их гарах болсон нь уг хуулийг батлах шалтгаан болсон байдаг.

Дээр дурдсан хэлцэл байгуулагдсан эсэх болон байгуулсан хэлцлийн зүйл юу байсан эсэх тухай маргаан одоо ч гарсаар байгаа тул хэлцлийн хэлбэрийн шаардлага бий болсон анхдагч шалтгаан өөрчлөгдөөгүй гэж үзэж болох бөгөөд илүү өргөжих хандлагатай байгаа юм.

¹⁶ Emanuel, S. L. (2015). 542.

¹⁷ Emanuel, S. L. (2015). 543.

¹⁸ Monahan, G. (2001). Essential Contract Law. Second Edition. Cavendish Publishing. 37.



Орчин үед хэлцлийн хэлбэрийн шаардлагыг биелүүлэхэд цаг хугацаа их шаардахаас гадна, хэлцлийн төслийг бэлдэх, зохих ёсоор бичиж буулгах, хянах, талууд гарын үсэг зурах, зарим тохиолдолд нотариатаар гэрчлүүлэх, төрийн эрх бүхий байгууллагад бүртгүүлэх зэрэг төвөг, чирэгдэл ихтэй гэж шүүмжлэх хандлага давамгайлах болсон тул ийм шаардлагыг хуульчлахад хангалттай сайн үндэслэл байх ёстой гэж үзэх болсон¹⁹.

III. Хэлцлийн хэлбэрийн шаардлагын үндэслэлийн төрөл

Хэлцлийн хэлбэрийн шаардлагын үндэслэлийг төрөлжүүлэн тодорхойлох оролдлогыг философийн үүднээс хийсэн судлаач нь Харвардын их сургуулийн профессор, эрх зүйн философич Лон Фуллер байсан юм. Тэрээр “Хэлцлийн хариу үүрэг ба хэлбэр” (Consideration and Form) хэмээх эрдэм шинжилгээний өгүүлэлдээ хууль зүйн буюу хэлцлийн хэлбэр байх үндэслэл нь тодорхой чиг үүргүүдийг хэрэгжүүлэхэд оршдог гэж үзсэн. Ийнхүү чиг үүргийг тодорхойлох байдлаар хэлцлийн хэлбэрийн шаардлагын үндэслэлийг төрөлжүүлж авч үзэх хандлага хожмын судлаачдын дунд давамгайлж байгааг Лон Фуллерийн нөлөөллийн үр дүн гэж үзэж болох юм. Тухайлбал, тэрээр “нотлох чиг үүргийг” хэлцэл байгуулагдсан эсэх болоод ямар нөхцөлийг тохирсон болохыг тодорхойлоход үйлчилнэ гэж үзсэн бөгөөд үүнийг хэрэгжүүлэх аргын хувьд бичгээр үйлдэх, нотариатаар гэрчлүүлэх²⁰ зэргээр тодорхойлсон. Үүнийг

Маастрихтын их сургуулийн Хуулийн факультетын Европын хувийн эрх зүйн тэнхимийн профессор Жан М. Смитс өөрийн “Гэрээний эрх зүй: Харьцуулсан удиртгал” (нэмж, засварласан 2 дахь хэвлэл) бүтээлдээ дараах байдлаар дэлгэрүүлэн авч үзсэн.

Гэрээ байгуулагдсан болохыг нотлохын тулд хэлбэрийн шаардлага тавигдах нь бий. Ялангуяа гэрээг бичгээр байгуулж нөхцөлүүдийг тодорхой тусгах нь тухайн гэрээ байгуулагдсан болохыг нотлоод зогсохгүй талуудын хүлээсэн үүргийн агуулгыг хялбархан тодорхойлох боломжийг олгодог. Энэ нь талуудын бодит хүсэл зоригийн талаар ирээдүйд үүсэх маргаанаас зайлсхийхэд тустай байдаг²¹ хэмээн ижил агуулгыг илэрхийлсэн.

Тэрээр жишээ болгож Английн 1677 оны Залилан мэхлэхээс сэргийлэх тухай хуулиар “батлан даал”-ын гэрээнд тавигдах хэлбэрийн шаардлагыг авч үзсэн. Тус хуульд “батлан даалтын гэрээ бичгээр нотлогдох ёстой” гэж заасан бөгөөд энэ нь гэрээг бичгээр хийгээгүй байсан ч нэхэмжлэгч нь бичгэн нотлох баримтыг ашиглан гэрээ байгуулагдсан болохыг нотлох боломжтой гэсэн үг юм. Тухайлбал хариуцагчийн гарын үсэгтэй захидал эсхүл батлан даалтын тухай дурдсан и-мэйл байгаа нөхцөлд эдгээрийг бичгэн нотлох баримтад тооцох боломжтой. Энгийн жишээ татвал томоохон компанийн захирал өдрийн цайны үеэр хэн нэгний өрийг батлан даах тухай мэдэгдсэн байсан ч бичгээр нотолгоо үйлдээгүй бол тус рестораны ширээнд өөр 3 гэрч байхгүй тохиолдолд

¹⁹ Kutz, H. (2017). European Contract Law. Second edition. Oxford University Press. 73.

²⁰ Fuller, L.L. (1941). Consideration and Form. Columbia Law Review 41, No.5, 799-824, 800.

²¹ Smits, J. M. (2017). Contract Law: A Comparative Introduction. Second edition. Edward Elgar Publishing. 140.



үүргийн харилцаа үүсээгүй гэж үзнэ²². Харин ХБНГУ, БНФУ-д арилжааны батлан даалтын гэрээг байгуулагдсан болохыг нотлох эсхүл гэрээ хүчин төгөлдөр байхын тулд бичгээр хийх хэлбэрийн шаардлага тавигддаггүй²³. Манай улсын тухайд энэ тал дээр иргэнлэг эрх зүйн тогтолцоот эдгээр орнуудтай адил байр суурийг баримталж буйг 2002 оны Иргэний хуулийн 459 дүгээр зүйлийн 459.2 дахь хэсгээс²⁴ харж болно.

Профессор Лон Фуллерын авч үзсэн удаах чиг үүрэг нь “анхааруулах буюу сэрэмжлүүлэх” юм. Тэрээр уг чиг үүргийг илэрхийлэхдээ нийтлэг эрх зүйн уламжлалд хамгийн алдартайд тооцогддог “лаван тамга” буюу лааны тосоор лацдах хэлбэрийн шаардлагыг энэ чиг үүргийг хэрэгжүүлэхэд үйлчилдэг хэмээн чухалчилсан байдаг. Тус хэлбэрийн шаардлагыг биелүүлэх нь ажиллагаа ихтэй ч энэ нь хэлцлийн талуудад чухал ач холбогдолтой шийдвэр гаргах гэж байгаа тухай сэрэмж, анхааруулга өгч байдаг²⁵ хэмээн тайлбарлажээ. Тус чиг үүргийн талаар хувийн эрх зүйн нэрт судлаач Хайн Коц өөрийн “Европын гэрээний эрх зүй” бүтээлдээ “хэлцлээр чухал үүрэг хүлээхээр болсон тохиолдолд хатуу тогтоосон, ажиллагаа ихтэй хэлбэрийн шаардлага нь оролцох гэж буй хэлцлийн талаар дахин нэг удаа нягтлах боломжийг түүнд олгодог²⁶” хэмээн ижил агуулгаар тодорхойлсон байна. Энгийн амьдралд тус чиг үүргийг хүлээдэг олон хэлцлийн хэлбэрийн шаардлагыг дурдаж болох

бөгөөд санхүүгийн өндөр эрсдэлтэйд тооцогддог хэрэглээний зээл, эсхүл хэн нэгний өр төлбөрийг батлан даахтай холбоотой харилцаанд оролцох гэж буй хэлцлийн талуудыг тохиролцоогоо бичгээр илэрхийлэх шаардлага дэлхийн ихэнх улс оронд хуулиар тавигддаг болно.

Нэрт эрх зүйн философичийн тодорхойлсон сүүлчийн чиг үүрэг нь “энгийн, ойлгомжтой байх” юм. Түүний үзэж буйгаар анх удаа хэлцлийн нэг тал болж буй туршлагагүй нэгнээс эхлээд асар өргөн туршлагатай этгээдийн хувьд тодорхой хэлбэрийн шаардлага нь түүнийг хуульд нийцсэн, заавал биелэгдэх шинжтэй эрх зүйн харилцаанд оролцож байна гэсэн ойлголтыг шууд төрүүлэхүйц байх ёстой²⁷ юм. Харин тус чиг үүргийг хувийн эрх зүйн судлаачид дэлгэрүүлэн судлалгүй орхигдуулсан бөгөөд оронд нь “мэдээлэх” чиг үүргийг санал нэгтгэйгээр хэлцлийн хэлбэрийн шаардлагын үндэслэлийг чиг үүргийнх нь хувьд төрөлжүүлэхдээ тодорхойлсон байдаг. Энэ нь гэрээ байгуулагдахаас өмнө нэг талыг мэдээлэл эсхүл хуулийн зөвлөгөөгөөр хангах хууль тогтоогчийн хүслээс үүдэлтэй. Жишээ нь үл хөдлөх хөрөнгийн өмчлөх эрхийг шилжүүлэхэд иргэнлэг эрх зүйн тогтолцоот улсуудад нотариатаар гэрчлүүлэхийг шаарддаг бөгөөд нотариатч нь талуудад тэдний үйлдлийн эрх зүйн үр дагаврын талаар тайлбарлаж өгөх ёстой байдаг²⁸.

Эдгээр чиг үүргүүд нь хэлцлийн хэлбэрийн шаардлагын үндэслэлийг төрөлжүүлэн тодорхойлох үйл явцын

²² Мөн тэнд.

²³ Мөн тэнд.

²⁴ Иргэний хуулийн 459.2 Ажил үүргийнхээ хүрээнд батлан даалт гаргасан бол батлан даалтын гэрээг бичгээр байгуулахгүй байж болно.

²⁵ Fuller, L.L. (1941). 800.

²⁶ Kutz, H. (2017). 75.

²⁷ Fuller, L.L. (1941). 801.

²⁸ Smits, J. M. (2017). Contract Law: A Comparative Introduction. Second edition. Edward Elgar Publishing. 139.



хүрээнд гүйцэтгэх чиг үүргийнх нь хувьд авч үзэж хөгжүүлсний үр дүн бөгөөд судлаачид өөрсдийн орны хууль тогтоомж, хэлцлийн онцлогт тохируулан өөр олон тооны чиг үүргийг дэлгэрүүлэн тодорхойлох нь бий. Тухайлбал, Тбилисийн Улсын их сургуулийн Хуулийн факультетын зочин судлаач Георги Амиранашвили “Хэлцлийн хэлбэрийн шаардлагын чиг үүрэг” гэх эрдэм шинжилгээний өгүүлэлдээ дээрх үндсэн гэж нэрлэж болохуйц хамгийн түгээмэл 3 чиг үүргийг дэлгэрүүлэн задалж, өөрийн орны хууль тогтоомж, хэлцэл байгуулах практикт суурилан “тодорхой байх, үнэн зөв байх, хяналтын, зөвлөх, баталгаажуулах, хэлцэл заавал биелэгдэх”²⁹ зэрэг 6 чиг үүргийг нэмж тодорхойлсон байна. Түүний энэхүү төрөлжүүлсэн байдалд дүн шинжилгээ хийж үзвэл “тодорхой байх, баталгаажуулах” чиг үүргүүд нь нотлох чиг үүргийн хүрээнд багтаж тодорхойлогдох боломжтой бол “үнэн зөв байх, хяналтын, зөвлөх” зэрэг чиг үүргүүд нь мэдээлэх чиг үүргийн хүрээнд багтах боломжтой буюу ялангуяа нотариатч мэдээлэх чиг үүргийг хэрэгжүүлснээр эдгээр чиг үүргийн агуулга бүрэн хангагдах боломж бүрдэж буй юм.

Харин “хэлцэл заавал биелэгдэх” чиг үүргийг судлаач Георги Амиранашвили тодорхойлохдоо Лон Фуллерын тодорхойлсон “энгийн, ойлгомжтой байх” чиг үүргийн хүрээнд хамаарна гэж үзсэн нь хувийн эрх зүйн бусад судлаачдаас ялгаатай санал байв. Учир нь дийлэнх судлаачдын бүтээлд уг чиг үүргийг орхигдуулсан байсныг өмнө нь

²⁹ Amiranashvili, G. (2016). Journal of Law. No. 1. 12. Retrieved view: Functions of the Form of Transaction by Giorgi Amiranashvili :: SSRN

дурдсан билээ. Ийнхүү тэрээр энэ тухайд дэлгэрүүлэн тайлбарлахдаа хэлцэлд оролцож буй талууд нь хуульд нийцсэн хэлцэлд оролцож буйгаа ойлгож, мэдэх боломжтой байна гэдэг нь түүнийг “заавал биелүүлэх буюу биелүүлэхгүй тохиолдолд шүүхэд хандах замаар албадан биелүүлэх боломжтой болохыг хэлцлийн талуудад харуулж буй”³⁰ гэх санааг гаргасан байв.

Дээрх чиг үүргүүд нь хэлцлийн хэлбэрийн шаардлагын үндэслэлийг хэлцэл байгуулагдсаныг нотлох хийгээд агуулгын зөрүүгүй амжилттай байгуулахад дэмжин туслах зорилго бүхий харьцангуй хязгаарлагдмал байдлаар авч үзсэн байна. Гэтэл зарим төрлийн хэлцлийн хувьд түүний хэлбэрийн шаардлага нь зөвхөн байгуулагдсанд тооцох эсхүл агуулгыг тодруулаад зогсохгүй салшгүй хэсэг нь байх боломжтой. Тухайлбал, үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөх эрхийг шилжүүлэх хэлцлийн тухайд энэ шинж нь тодорхой ажиглагддаг. Өмчлөх эрх нь бодитоор буюу материаллаг байдлаар оршдоггүй, хийсвэр шинжтэй эрх зүйн ойлголт тул түүнийг биежүүлж, хэлбэржүүлсэн нөхцөлд л нэг этгээдээс нөгөөд шилжүүлэх боломж бүрддэг. Гэвч бүртгэгддэггүй хөдлөх эд хөрөнгийн тухайд эд зүйлийг бодитоор шилжүүлэх үед өмчлөх эрх нь уг эд зүйлтэй хамт шилждэг гэж үздэг тул хэлцлийн хэлбэрийн шаардлага нь түүний салшгүй шинж болохгүй.

Харин бүртгэгддэг эд хөрөнгийн шилжилтийг хийхийн тулд хөрөнгийг бодитоор шилжүүлсэн нь хангалтгүй буюу шилжүүлэн авч буй талд өмчлөх эрхийг хууль ёсоор үүсгэхгүй тул

³⁰ Мөн тэнд.



шилжилтийг гэрчилж буй шинэчилсэн бүртгэл нь хийсвэр шинжтэй өмчлөх эрхийг биежүүлж, хэлбэржүүлж байдаг. Энэ нь аливаа бүртгэгддэг өмчлөх эрхийн бүртгэлийн ач холбогдлыг илтгэхийн сацуу аливаа шилжилт туйлын хийсвэр шинжтэйгээр явагдах боломжгүй тул ямар нэгэн байдлаар хэлбэржих нь шилжүүлэг хийгдэх бодит урьдчилсан нөхцөл болохыг харуулж буй юм. Бүртгэлийн байгууллагад бүртгүүлэх нь өмчлөх эрхийг үүсгэх, баталгаажуулах ач холбогдолтой байдаг бөгөөд үүнийг хууль тогтоогчийн зүгээс хэлцлийг бичгээр хийх, нотариатаар гэрчлүүлэх зэрэг хэлцлийн хэлбэрийн шаардлагуудтай адилгаж, түүний нэг төрөл болгон хуульчилсан. Үүнээс үзвэл тодорхой төрлийн хэлцлийн хувьд хуулиар тогтоосон хэлбэрийн шаардлага нь түүний агуулгыг илтгэх үндсэн зорилгыг биелүүлэхэд чиглэсэн хэлцлийн салшгүй шинж байх үр дагавар үүсэж байна.

IV. Дүгнэлт

Дээрдурдсанчлан хэлцлийн хэлбэрийн шаардлагын үндэслэл нь хэлцлийн үндсэн элементээс ангид зөвхөн түүнийг амжилттай хэрэгжүүлэхэд чиглэсэн туслах чиг үүргээр хязгаарлагдахгүй бөгөөд түүний бий болсон буюу байгаа шалтгаан, үндэслэлийг тодорхойлох үйл явцын хүрээнд өөр бусад байдлаар төрөлжүүлэн тодорхойлох боломжтой юм. Үүний хамгийн энгийн жишээ нь Ромын эрх зүйн *contractus re* буюу бодит гэрээний үндсэн шинж болох бодитоор үүргийг эхэлж гүйцэтгэх явдал нь тухайн үед албадан биелүүлэх боломжтой хэлцэл байгуулагдсанд тооцогдох урьдчилсан нөхцөл болж байсны хувьд хэлбэрийн

шаардлага гэж үзэх бүрэн үндэстэй.

Гэтэл ийнхүү бодитоор гүйцэтгэх явдал нь тухайн гэрээний төрлийн үндсэн шинж болж байдгаараа хэлцлийн хэлбэрийн шаардлага нь хэлцлийн өөрийнх нь үндсэн шинж байх боломжтойг харуулж буй юм. Одоо үед бодитоор гүйцэтгэх нь хэлцлийн хэлбэрийн шаардлагад тооцогдохгүй гэж үзэх хуульч олон байхыг үгүйсгэхгүй ч хэлцлийн хэлбэрийн шаардлагыг биелүүлсэнд тооцох үндэслэл болж буйгаараа түүнийг орлох өөр нэг сонголт буюу хэлбэрийн шаардлагын төрөлд хамруулан авч үзэх боломжтой байна. Үүнээс гадна үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөх эрхийг шилжүүлэх хэлцлийн хэлбэрийн шаардлага нь тус хэлцлийн үндсэн шинж байх боломжтой. Учир нь өмчлөх эрх нь өмчлөгчөөс бусад этгээдээс эд хөрөнгийг нь хамгаалахад чиглэдэг бөгөөд хийсвэр шинжтэй ойлголт тул түүнийг ямар нэгэн байдлаар биежүүлсэн тохиолдолд бусдын өмнө түүний өмчлөх эрхийг нь нотлох боломжтой болдог. Ихэнх судлаачид дээрх үндэслэлээр тус хэлцлийн хэлбэрийн шаардлагыг зөвхөн нотолгооны зориулалттай гэж үзэх нь бий.

Гэвч энэ хэлцэл нь байгаа зүйлийг эсхүл хэлцэл хийгдсэн болохыг нотлоход бус харин байгаа гэж үзэж буй тэр зүйлийг шилжүүлэхэд чиглэж буй юм. Энэ төрлийн хэлцлийн агуулга нь гагцхүү өмчлөх эрх гэх хийсвэр, биегүй зүйлийг шилжүүлэх үйл явцаар тодорхойлогддог. Иймээс уг хийсвэр ойлголтыг хэлбэржүүлж, биежүүлсэн тохиолдолд шилжилт хийгдэх боломж бүрдэх буюу хэлцлийн агуулгыг тодорхойлох үндсэн зорилго



биелнэ. Шилжилт хийгдэх боломж нь өмчлөх эрхийг хэлбэржүүлснээр бүрдэж, тус хэлбэржилт нь өмчлөх эрхийн агуулгыг тодорхойлдог. Энэ тохиолдолд хэлцлийн хэлбэрийн шаардлага нь нотлох, мэдээлэх, анхааруулах зэргээр хэлцэл хэрэгжихэд туслах чиг үүргээс хальж тухайн хэлцлээс салгах боломжгүй түүний нэг хэсэг болно хэмээн үзэж байна.

V. Ном зүй

Гадаад эх сурвалж:

1. Fuller, L.L. (1941). *Consideration and Form*. Columbia Law Review 41, No.5.
2. Monahan, G. (2001). *Essential Contract Law. Second Edition*. Cavendish Publishing.
3. Thampapillai, D. et al., (2012). *Contract law: text and cases*. Oxford University Press.
4. Mousourakis, G. (2015). *Roman Law and the Origins of the Civil Law Tradition*. Springer International Publishing.
5. Emanuel, S. L. (2015). *Contracts. Eleventh Edition*. Wolters Kluwer.
- Amiranashvili, G. (2016). *Journal of Law*. No. 1. 12. Retrieved view: Functions of the Form of Transaction by Giorgi Amiranashvili :: SSRN.
6. Kütz, H. (2017). *European Contract Law. Second edition*. Oxford University Press.
7. Seddon, N. C. and Bigwood, R. A. (2017). *Cheshire and Fifoot's law of contract. Eleventh Australian Edition*. Lexis Nexis Butterworths.
8. Smits, J. M. (2017). *Advanced Introduction to Private Law*. Edward Elgar Publishing.
9. Smits, J. M. (2017). *Contract Law: A Comparative Introduction. Second Edition*. Edward Elgar Publishing.



Abstract

REASONS FOR FORMALITY OF CONTRACTS, AND THEIR TYPES

B.BATBAYAR

Master of Laws (LL.M)

Attorney, member of the Mongolian Advocates' Association

To establish the formal requirements for a contract, it is necessary to examine the reasons for its creation and existence. Currently, we are exploring the basis for the contract's form requirement in terms of its purpose. Researchers have identified the primary functions of a contract as evidentiary, cautionary, and information. However, it is essential to thoroughly define this concept and consider the formal

requirements of a contract broadly, taking into account not only its function but also the nature of the formality of the specific type of contract.

Keywords

Evidentiary function, cautionary function, information function, transfer, formalization.

ҮЗЭЛ БОДЛОО ИЛЭРХИЙЛЭХ ЭРХ ЧӨЛӨӨ БА ХАЛШРАХ ҮР НӨЛӨӨНИЙ ХАМААРАЛ

Б.Цэндсүрэн¹

- I. Оршил
- II. Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг Монголын орчин үеийн эрх зүйн тогтолцоонд хуульчилсан байдал
- III. Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний үндсэн ойлголт, олон улсын эрх зүйн хөгжлийн үүднээс ойлгох нь
- IV. Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний хязгаарлалт, БНСУ-н эрх зүйн зохицуулалттай харьцуулан авч үзэх нь
- V. Халшрах үр нөлөөний ойлголт, жишиг шийдвэр дээр үндэслэн авч үзэх нь
- VI. Дүгнэлт
- VII. Ном зүй

¹ БНСУ-ын Күүкмин их сургуулийн Хууль зүйн сургуулийн докторант.



ҮЗЭЛ БОДЛОО ИЛЭРХИЙЛЭХ ЭРХ ЧӨЛӨӨ БА ХАЛШРАХ ҮР НӨЛӨӨНИЙ ХАМААРАЛ

Б.ЦЭНДСҮРЭН, БНСУ-ын Күүкмин их сургуулийн Хууль зүйн сургуулийн докторант.

Түлхүүр үг

Үзэл бодлоо илэрхийлэх эрх, халшрах үр нөлөө, үзэл бодлоо илэрхийлэх эрхийн хязгаарлалт, төрийн зохицуулалт.

Хураангуй

Энэхүү өгүүллээр Үндсэн хууль, олон улсын эрх зүйн хэм хэмжээгээр хамгаалагдсан үзэл бодлоо илэрхийлэх эрх хэрхэн хязгаарлагддаг болон үзэл бодлоо илэрхийлэх эрхийг хуулиар хязгаарлахад тавигдах шалгуурыг тодорхой болгох тухай асуудлыг хөндсөн. Түүнчлэн үзэл бодлоо илэрхийлэх эрхээ эдлэхээс зайлсхийх нөхцөлд хүргэх буюу халшрах үр нөлөөний талаар танилцуулж, олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, тэр дундаа интернэт орчинд үзэл бодлоо илэрхийлэхэд төрөөс зохицуулалт хийх шаардлагатай эсэхэд хариулт өгөхийг зорьсон болно.

I. Оршил

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургаадугаар зүйлийн 16-д “итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх, тайван жагсаал, цуглаан хийх эрх чөлөөтэй. Жагсаал, цуглаан хийх журмыг хуулиар тогтооно”, Арван есдүгээр зүйлийн 2-т “Онц болон дайны

байдал зарласан тохиолдолд Үндсэн хууль, бусад хуульд заасан хүний эрх, эрх чөлөөг гагцхүү хуулиар хязгаарлаж болно. Тийнхүү хязгаарласан хууль нь хүний амьд явах эрх, итгэл үнэмшилтэй байх, шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөө, түүнчлэн хэнд боловч эрүү шүүлт тулгах, хүнлэг бус, хэрцгий хандахыг хориглосон хуулийн заалтыг үл хөндөнө” гэж тус тус заасан нь үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх нь Монгол Улсад иргэний хуулиар хязгаарлуулах онцгой нөхцөл бүхий үндсэн эрх болохыг тодорхой илэрхийлдэг.

Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө бол ардчилсан улс орны зайлшгүй хуульчлагдан баталгаажуулах суурь шинжтэй эрх юм. Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөө гэдэгт үг хэлэх, хэвлэн нийтлэх, эвлэлдэн нэгдэх эрхүүдийг багтаан ойлгохоос гадна урлагийн бүтээл туурвих эрх ч хамаардаг. Энэ утгаараа үзэл бодлоо илэрхийлэх эрхийн хориглолтыг зөвхөн олон нийтийн ашиг сонирхлыг хувь хүний ашиг сонирхлоос дээгүүрт тавихаас өөр аргагүй тохиолдолд хатуу нөхцөлөөр зөвшөөрдөг. Учир нь үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хязгаарлах нь бусад эрхийг хязгаарлах суурийг



тавьдаг бөгөөд иргэдийн эрхийн талаарх мэдрэмжийг доройтуулах эрсдэлтэй байдаг. Иймээс үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хязгаарласан хуулийг боловсруулахдаа тус хязгаарлалтын цар хүрээг жирийн иргэн ердийн ухамсрын түвшинд ойлгож, хязгаарлалт үйлчлэхгүй нөхцөлд айж, эмээхгүйгээр эрхээ хэрэгжүүлж чадахуйц байдлаар энгийн тодорхой байх шалгуурыг хангах учиртай юм.

Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийн хязгаарлалтыг нухацтай авч үзэхгүйн улмаас үзэл бодлоо илэрхийлэх эрхийг хэрэгжүүлэхээс зайлсхийх буюу халшрах үр нөлөө (chilling effect) үүсдэг. Халшрах үр нөлөө гэдэг нь үзэл бодлоо илэрхийлэх эрхийг хязгаарласан төрийн зохицуулалтын улмаас хууль зүйн хариуцлага хүлээж болзошгүй гэж эмээж, сайн дураар үзэл бодлоо илэрхийлэхээс зайлсхийх үзэгдэл юм. Нэг хүний хязгааргүй эрх чөлөө бусдын эрх чөлөөнд халдаж болох тул иргэдийн үндсэн эрхийг хязгаарлах боломжийг хүлээн зөвшөөрөхийн зэрэгцээ үндсэн эрхийг зайлшгүй шаардлагатай хамгийн бага хэмжээнд хязгаарлах замаар баталгаажуулж ирсэн эрх зүйн хөгжлийн боловсронгуй аргыг шинэ түвшинд нарийвчлан боловсруулах бодит шаардлага Монгол улсад хийгээд бусад улсад тулгамдсан асуудал болсон тул үзэл бодлоо илэрхийлэх эрх ба халшрах үр нөлөөний харилцан хамаарлыг Бүгд Найрамдах Солонгос Улс (цаашид “БНСУ” гэх)-ийн жишиг шүүхийн шийдвэрүүдэд үндэслэн танилцуулахыг зорьсон болно.

Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийн халшрах үр нөлөөний өнөөгийн

нөхцөл байдлыг задлан шинжлэх болон нэгтгэн дүгнэх, Монгол Улсын эрх зүйн зохицуулалтыг бусад орны эрх зүйн зохицуулалттай харьцуулах, үзэл бодлоо илэрхийлэх эрхийн орчин цагийн эрх зүйн зохицуулалтыг түүхчлэн судлах аргаар тус өгүүллийг бичсэн болно.

II. Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг Монголын орчин үеийн эрх зүйн тогтолцоонд хуульчилсан байдал

Монголын улс төрийн бодлогод 1921 оны социалист хувьсгалаас үүдэлтэйгээр эрс өөрчлөлт гарсан байдаг. Тухайлбал, 1924 оны 11 дүгээр сарын 24-ний өдөр болсон Анхдугаар их хурлаас засаглалын шинэ хэлбэрийг тунхаглаж, 1924 оны 11 дүгээр сарын 26-ны өдөр хаант засгаас ардын засагт шилжүүлж, улсын нэрийг Бүгд Найрамдах Монгол Ард Улс хэмээн шинэчилж, анхдугаар Үндсэн хуулийг баталсан билээ.

Үүнээс хойш 1940 оноос социалист эрх зүйн тогтолцоо хөдөлбөргүй тогтсон байдаг. Ангийн шинж чанар бүхий тус Үндсэн хууль нь 1940 оны 06-р сарын 30-ны өдрөөс 1960 оны 07-р сарын 06-ны өдрийг хүртэл 20 жилийн хугацаанд хүчин төгөлдөр үйлчилсэн юм. Улмаар 1980-аад оны сүүл үед Зүүн Европт социализм уналтад орсны улмаас социалист Үндсэн хуульд төвлөрсөн БНМАУ-ын улс төрийн тогтолцоо өөрчлөгдөх нөхцөл бүрдэж, 1992 онд Монгол Улсын шинэ Үндсэн хууль батлагдсан. Тус Үндсэн хуулиар хүний эрхийг дээдлэн, зах зээлийн эдийн засгийн тогтолцоог нэвтрүүлсэн.

1992 онд шинэ Үндсэн хууль батлагдсан даруйдаа Монгол Улс эрх зүйн шинэчлэлийн ажлыг хоёр үе шаттайгаар эхлүүлсэн. Нэгдүгээр шатанд



Монгол Улсын Үндсэн хуульд хуулиар тодорхой заасан асуудлуудыг анхлан 1993 он хүртэл хуульчилж, хоёр дахь шатанд 1996 он гэхэд Монгол Улсын хууль тогтоомж, олон улсын гэрээг батлах, шинэчлэн найруулах ажлыг Үндсэн хуульд нийцүүлэн хийсэн байдаг¹.

1924 оны Үндсэн хуулийн 7 дугаар зүйлд “элдэв хэргийг жинхэнэ ард түмнээр шүүмжлэх эрхийг хүндэтгэж, тус улсаас аливаа хэвлэх, нийтлэх явдлыг бүртгэн гүйцэтгүүлбэл зохино” гэж, 1940 оны Үндсэн хуулийн 85 дугаар зүйлд “Хөдөлмөрчин ард түмний ашиг тусад нийлүүлэн мөн Бүгд Найрамдах Монгол Ард Улсын улсын байгуулалтыг бататган бэхжүүлэхийн төлөө, Бүгд Найрамдах Монгол Ард Улсын ард иргэдэд хуулиар батлан олгох эрх нь: 1.Чөлөөтэйгөөр үг хэлэх; 2.Чөлөөтэйгөөр хэвлэн нийтлэх; 3.Хурал ба индрийн хурлыг чөлөөтэйгөөр явуулах; 4.Гудамжаар жагсах явах нь тус тус чөлөөтэй болно” гэж, 1960 оны Үндсэн хуулийн 87 дугаар зүйлд “ БНМАУ-ын төрийн байгууллыг хөгжүүлэн бэхжүүлэх зорилгоор хөдөлмөрчдийн эрх ашигт нийцүүлэн БНМАУ-ын иргэдэд: 1.Үг хэлэх; 2.Хэвлэн нийтлэх; 3.Хурал, цуглаан хийх; 4.Жагсаал ёслол үйлдэх эрх чөлөөг хуулиар батлан олгосон болно. Эдгээр эрх чөлөөг эдлэхэд шаардагдах эд материалын нөхцөлийг хөдөлмөрчид ба тэдгээрийн байгууллагад хангаж өгнө” гэж, 1992 оны Үндсэн хуулийн Арван зургаадугаар зүйлийн 16-д “итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх, тайван жагсаал, цуглаан хийх

эрх чөлөөтэй. Жагсаал, цуглаан хийх журмыг хуулиар тогтооно” гэж тус тус үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний агуулгыг хуульчилсан байдаг.

III. Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний үндсэн ойлголт, олон улсын эрх зүйн хөгжлийн үүднээс ойлгох нь

1695 онд Их Британид Цензур тогтоох хуулийг цуцалснаар хэвлэн нийтлэх эрх чөлөө үүссэн бөгөөд 1776 оны Виржиниагийн эрхийн тухай Билл, 1789 оны Францын Хүний эрхийн тунхаглал, 1791 оны Америкийн нэгдсэн улс (цаашид “АНУ” гэх)-ийн Холбооны Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлт зэрэгт хэвлэлийн эрх чөлөөг тодорхойлсноос хойш дэлхийн бүх улсууд Үндсэн хуульдаа үүнийг хүлээн зөвшөөрсөн байдаг².

Тодруулбал, 1789 оны Францын “Хүний ба иргэний эрхийн тунхаглал”-ын 11-р зүйлд “Бодол санаа, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх нь хүний хамгийн нандин эрхийн нэг юм. Тиймээс иргэн бүр чөлөөтэй ярьж, бичиж, хэвлэн нийтлэх боломжтой. Харин энэ эрх чөлөөгөө урвуулан ашигласан тохиолдолд иргэн бүр хуульд заасан тохиолдолд хариуцлага хүлээнэ” гэж, 1776 оны Виржиниагийн эрхийн тунхаглалын 12 дугаар зүйлд “Үг хэлэх, хэвлэлийн эрх чөлөөг хязгаарлавал харгис төр гэж үзэж болно” гэж, АНУ-ыг үүсгэн байгуулсны дараа өөрчилсөн 1791 оны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөд “АНУ-ын Конгресс шашныг тогтоосон, шашны үйл ажиллагааг чөлөөтэй хэрэгжүүлэхийг хориглосон эсхүл үг хэлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөөг хумьсан, ард түмний

¹ С.Батчимэг, Монголын Үндсэн хуулийн судалгаа сэдэвт магистрын зэрэг хамгаалсан бүтээл, Сөүл хотын их сургуулийн Хууль зүйн сургууль, 2009학위논문(석사) 서울시립대학교 일반대학원 : 법학과 2009. 8.

² Ким Хаг Сон, Үндсэн хуулийн эрх зүйн онол, 2011, 452 дахь тал, 김학성, 「헌법학원론」, 2011.



тайван замаар цуглах болон бэрхшээлийг арилгахыг төрөөс шаардах эрхэнд халдсан хууль гаргаж болохгүй” (1791 оны 12-р сарын 15-д нийтэд зарласан)³ гэж тус тус зохицуулалт хийсэн нь орчин цагийн үзэл бодлоо илэрхийлэх эрхийг дэлхийн улс орнууд Үндсэн хуульдаа тусган, баталгаажуулах суурийг бүрдүүлсэн юм.

Бүгд Найрамдах Солонгос Улс (цаашид “БНСУ” гэх)-ийн Үндсэн хуулийн 21 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Бүх иргэд үг хэлэх, хэвлэн нийтлэх, цуглаан хийх, эвлэлдэн нэгдэх эрх чөлөөтэй” гэж үг хэлэх, хэвлэн нийтлэх, цуглаан хийх, эвлэлдэн нэгдэх эрх чөлөөг нэг зүйлд заасан байдаг. Үүний зэрэгцээ Үндсэн хуулийн 17 дугаар зүйлд заасан хувийн нууцтай байх эрх, 19 дүгээр зүйлд заасан ухамсрын эрх, 20 дугаар зүйлд заасан шашин шүтэх эрх, 22 дугаар зүйлд заасан боловсрол болон урлагийн эрх зэрэг нь үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөөтэй нягт холбоо хамааралтай⁴. Түүнчлэн Үндсэн хуулийн 21 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Үг хэлэх, хэвлэн нийтлэх, жагсаал, цуглаан хийх, эвлэлдэн нэгдэхэд зөвшөөрөл авахыг хүлээн зөвшөөрөхгүй” гэж урьдчилан зөвшөөрөл, цензур тогтоох замаар үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хязгаарлахыг хориглосон байдаг.

БНСУ-н Үндсэн хуулийн 21 дүгээр зүйлийн хэвлэн нийтлэх эрх чөлөө буюу үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний зохицуулалт нь уламжлалт утгаараа бодох эрх⁵, үзэл бодлоо чөлөөтэй

илэрхийлэн түгээх эрх (харилцах эрх чөлөө) гэж ойлгогддог болохын хувьд хүний эрхэм чанар, үнэ цэнийг хадгалах, аз жаргалыг эрэлхийлэх, үндэсний бүрэн эрхт байдлаа ухамсарлахад хувь хүнд зайлшгүй чухал эрх буюу өнөөгийн ардчилсан орнуудад иргэдийн хамгийн чухал үндсэн эрхийн нэг гэж хүлээн зөвшөөрөгдсөн. ⁶ Үг хэлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөө нь сонгодог утгаараа үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөнөөс гадна мэдэх эрх, хандах эрх, хэвлэл мэдээллийн байгууллагын эрх чөлөө (орчин үеийн үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө) гэсэн утгаар ашиглагддаг.⁷

IV. Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний хязгаарлалт, БНСУ-н эрх зүйн зохицуулалттай харьцуулан авч үзэх нь

1. Монгол Улс

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургаадугаар зүйлийн 16-д “итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх, тайван жагсаал, цуглаан хийх **эрх**

religion; this right includes freedom to change his religion or belief and freedom, either alone or in community with others and in public or private, to manifest his religion or belief, in worship, teaching practice and observance. 2. Freedom to manifest one's religion or beliefs shall be subject only to such limitations as are prescribed by law and are necessary in a democratic society in the interests of public safety, for the protection of public order, health or morals, or for the protection of the rights and freedoms of others.”

International Covenant on Civil and Political Rights Article 18: 1. “Everyone shall have the right to freedom of thought, conscience and religion. This right shall include freedom to have or to adopt a religion or belief of his choice, and freedom, either individually or in community with others and in public or private, to manifest his religion or belief in worship, observance, practice and teaching.”

³ Сон Наг Ин, Үндсэн хуулийн эрх зүй, 2021, 1263 дахь тал성낙인, 「헌법학」, 법문사, 2021, 1263면

⁴ Сон Наг Ин, Үндсэн хуулийн эрх зүй, 2021, 1261 дэх тал성낙인, 「헌법학」, 법문사

⁵ Human Rights Act (1998), Article 9 “Freedom of thought, conscience and religion, 1. Everyone has the right to freedom of thought, conscience and

⁶ БНСУ-н Үндсэн хуулийн шүүхийн шийдвэр, дугаар- Хонжэ 1992.2.25. 89 Хонга 104 현재 1992. 2. 25. 89헌가104.

⁷ Ким Хаг Сон, Үндсэн хуулийн эрх зүйн онол, 2011, 452 дахь тал김학성, 「헌법학원론」, 2011.



чөлөөтэй. Жагсаал, цуглаан хийх журмыг **хуулиар тогтооно**” гэж, Арван есдүгээр зүйлийн 2-т “Онц болон дайны байдал зарласан тохиолдолд Үндсэн хууль, бусад хуульд заасан хүний эрх, эрх чөлөөг гагцхүү хуулиар хязгаарлаж болно. Тийнхүү хязгаарласан хууль нь ... **итгэл үнэмшилтэй байх ... хуулийн заалтыг үл хөндөнө**” гэж, Эрүүгийн хуулийн 13.14 дүгээр зүйлийн 1-т “Хүний нэр төр, алдар хүнд, хуулийн этгээдийн ажил хэргийн нэр хүндэд халдсан илт худал мэдээллийг олон нийтэд тараасан бол ... ял шийтгэнэ” гэж, Эрүүгийн хуулийн 14.8 дугаар зүйлийн 1-т “Сонгуульд оролцогч улс төрийн нам, намуудын эвсэл, нэр дэвшигчийн нэр хүндэд халдаж, илт худал мэдээлэл тараасан бол ... ял шийтгэнэ” гэж, Эрүүгийн хуулийн олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг болох 20.1 дүгээр зүйлийн 1-т “Дэлбэлэх, галдан шатаах, олон хүнийг үхэлд хүргэх аюул бий болгох бусад үйлдэл, эд хөрөнгийн хор уршиг учруулах; нийгэмд аюултай өөр хор уршиг учруулахад бэлтгэж байгаа талаар зориуд худал мэдээлсэн бол ... ял шийтгэнэ” гэж зааснаас үзвэл Монгол дахь үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний хязгаарлалтын нөхцөл дараах байна. Үүнд:

1. Онц болон дайны байдал зарласан;
2. Нэр хүндэд халдах;
3. Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг;
4. Илт худал мэдээлэл;
5. Гагцхүү хуулиар тогтоох байна.

2. БНСУ

БНСУ-ийн Үндсэн хуулийн 21 дүгээр зүйлийн 4-т “Хэвлэх, нийтлэх нь бусдын нэр төр, эрх, нийтийн ёс суртахуун, нийгмийн ёс зүйд харшилж болохгүй. Хэвлэх, нийтлэх нь бусдын нэр төр, эрхэнд халдсан бол хохирогч хохирлоо нөхөн төлүүлэхээр шаардаж болно” гэж, Үндсэн хуулийн 37 дугаар зүйлийн 2-т “Иргэний бүх эрх чөлөө, эрхийг үндэсний аюулгүй байдал, хэв журам сахиулах, нийтийн сайн сайхны төлөө шаардлагатай тохиолдолд хуулиар хязгаарлаж болох бөгөөд хязгаарласан ч эрх чөлөө, эрхийн үндсэн агуулгыг зөрчиж болохгүй” гэж, Үндсэн хуулийн 77 дугаар зүйлийн 3-т “Онц байдал зарлахад хууль тогтоомжид заасан шүүхийн шийдвэр зайлшгүй байх тогтолцоо, үг хэлэх, хэвлэн нийтлэх, эвлэлдэн нэгдэх эрх чөлөөнд болон засгийн газар, шүүхийн эрх мэдэлд тусгай арга хэмжээ авч болно” гэж, Эрүүгийн хуулийн 307 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалтын 2-т “Илэрхий баримтаар хүний нэр хүндэд хохирол учруулсан бол хоёр хүртэл жилээр хорих эсхүл 5,000,000 хүртэлх воноор торгох ял шийтгэнэ” гэж, тус хэсгийн 2-т “Илэрхий худал баримтаар хүний нэр хүндэд хохирол учруулсан бол тав хүртэл жилээр хорих, 10 хүртэл жилээр эрх хасах эсхүл 10,000,000 хүртэлх воноор торгох ял шийтгэнэ” гэж тус тус зааснаас үзвэл БНСУ дахь үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний хязгаарлалтын нөхцөл дараах байна. Үүнд:

1. Онц байдал зарласан;
2. Бусдын нэр төр, эрх, нийтийн ёс суртахуун, нийгмийн ёс зүй, Үндэсний аюулгүй байдал, хэв



- журам сахиулах, нийтийн сайн сайхны төлөө;
3. Илэрхий баримт болон илэрхий худал баримт;
 4. Хуулиар тогтоох байна.

Монгол Улсын Их Хурлаас 2020 оны 01 дүгээр сарын 10-ний өдөр баталсан Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулиар Эрүүгийн хуулийн 13.14 дугаар зүйлээр илт худал мэдээлэл тарааж бусдын нэр төр, алдар хүндэд хохирол учруулсан тохиолдлыг гэмт хэрэг гэж үзсэнээр урьд нь зөрчилд тооцдог байсантай харьцуулбал халшрах үр нөлөө үүсгэх эрсдэл нэмэгдсэн байна. Гэхдээ үүнтэй харьцуулахад БНСУ-н Эрүүгийн хуулийн 307 дугаар зохицуулалт нь илүү хаалттай нийгмийг бүрдүүлж буй сонирхол татсан зохицуулалт байна. Тодруулбал:

Иргэн Ким гоо сайхны мэс заслын эмчийн буруугаас нүүрэндээ эдгэршгүй гүн сорвитой үлдсэн тухайгаа олон нийтийн мэдээллийн хэрэгсэлд илэрхийлж, нотлох баримттай илчилсэн гэж үзье. Энэ тохиолдолд магадлалаар тухайн эмчийн мэргэжлийн ур чадварт итгэх үйлчлүүлэгчдийн итгэл суларч, тухайн эмчээр хязгаарлагдахгүй эмнэлгээр үйлчлүүлэгчдийн тоо буурах эрсдэл нь өндөр байна. Үүний улмаас тус магадлал биелэх тохиолдолд тухайн мэс заслыг хийсэн эмч нь иргэн Кимийг мэргэжлийн нэр хүндэд нь халдаж хохирол учруулсан гэж маргах тохиолдолд иргэн Ким эрүүгийн хариуцлага хүлээх боломжтой зохицуулалтыг хуульчилжээ.

V. Халшрах үр нөлөөний ойлголт, жишиг шийдвэр дээр үндэслэн авч үзэх нь

Халшрах үр нөлөө гэж хууль зүйн хариуцлагаас эмээж, хууль ёсны эрхээ эдлэхээс зайлсхийх үзэгдэл гэж дээр дурдсан. Энэ утгаараа үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хязгаарласан зохицуулалттай хууль олноор батлагдах, зохицуулалтуудын холбоо хамаарлын тодорхойгүй болон хэт өргөжүүлсэн байдлаас үүдэн халшрах үр нөлөө ихэснэ гэж үзэж болно.

Энгийнээр тайлбарлавал, Монгол Улсад Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1-т “Гудамж, талбайд **жагсаал, цуглаан хийх тухай** мэдэгдлийг сум, дүүргийн Засаг даргад өгч **бүртгүүлнэ**. Жагсаал, цуглаан хийхээр төлөвлөсөн гудамж, талбай нь хоёр буюу түүнээс дээш сум, дүүргийн хилийн цэст хамаарах газар нутгийг хамарч байгаа бол мэдэгдлийг аймаг, нийслэлийн Засаг даргад өгч **бүртгүүлнэ**” гэж заажээ. Үндсэн хуулиар баталгаажсан эвлэлдэн нэгдэх эрхээ хэрэгжүүлэх талаар бусдад бүртгүүлж буй энэ журам нь эвлэлдэн нэгдэх эрхийг бусдаас хараат бусаар хэрэгжүүлэх боломжтой эрх мөн эсэхэд эргэлзээ үүсгэнэ. Энэ эргэлзээ нь тус зүйлийн 2-т “Жагсаал, цуглаан хийх тухай **мэдэгдэлд** түүний зорилго, эхлэх, дуусах хугацаа, оролцогчдын баримжаа тоо, хэрэглэх техник хэрэгсэл, цуглах, жагсан явах гудамж, талбай зэргийг **тодорхой заана**” гэснээр дарамт үүсгэх эрсдэлийг бий болгодог. Үүний улмаас жагсаал, цуглаан хийх эрх нь эвлэлдэн нэгдэх эрх буюу үзэл бодлоо чөлөөтэй



илэрхийлж буй аман бус хэлбэр гэдэг ИТГЭЛ ҮНЭМШИЛГИЙГ БАГАСГАХ нь тодорхой юм. Энэ үеэс үзэл бодлоо илэрхийлэх эрхтэй иргэн өөрийн эрхийн мэдрэмжээ аажмаар алдаж, хууль зүйн хариуцлагаас эмээж эхлэх бөгөөд хууль ёсны эрхээ эдлэхээс зайлсхийдэг. Үүнийг **халшрах үр нөлөө буюу өөрийн эрхийг эдлэхээс зайлсхийх** хэмээн тодорхойлдог.

1971 оны АНУ-ын Холбооны Дээд шүүхийн Коутс-Синсиннатигийн эсрэг (*Coates v. Cincinnati, 402 U.S. 611*) хэргийг шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрт халшрах үр нөлөө болон үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний хамаарлыг дүгнэсэн байдаг. Тус хэрэгт иргэн Коутс нь явган хүний зам дээр гурав ба түүнээс дээш хүн цугларч, хажуугаар өнгөрч буй хүмүүст саад учруулахуйц үйлдэл хийх нь эрүүгийн гэмт хэрэг болно гэх Синсиннати хотын захирамжийг зөрчсөн гэм буруутайд тооцогдож цагдан хоригдсон. Коутс нь жагсаалд оролцож явсан оюутан байсан тул тэрээр шүүхэд хотын захирамж нь Холбооны Үндсэн хуулийн 1-р зүйлийн үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний заалт болон 14-р зүйлийн хуульд нийцсэн журам тогтоох тухай заалтуудыг тус тус зөрчсөн гэж маргасан. Үүнийг Дээд шүүхийн шүүгч Стюарт үндэслэлтэй буюу Үндсэн хуулиар хамгаалагдсан үйлдлийг гэмт хэрэг гэж тооцсон хотын захирамж нь тодорхойгүй байдлыг үүсгэж, хэт өргөн хүрээг хамарсан нь Үндсэн хууль зөрчсөн гэж үзсэн байдаг.

Халшрах үр нөлөө болон үзэл бодлоо илэрхийлэх эрхийн талаар 2021 оны 01 дүгээр сарын 28-ний өдрийн шийдвэрээрээ БНСУ-ын Үндсэн хуулийн

шүүх нь Төрийн сонгуулийн тухай хуулийн 82.6 дугаар зүйлийн холбогдох хэсэг Үндсэн хууль зөрчсөн эсэх асуудалтай холбогдуулан дараах дүгнэлтийг хийжээ.

① Интернет мэдээллийн хэрэгсэл нь сонгуулийн сурталчилгааны үеэр цахим хуудсандаа самбар, чат өрөөнд улс төрийн нам, нэр дэвшигчийг **дэмжсэн эсхүл эсэргүүцсэн** бичвэр, дуу хоолой, зураг, видео зэрэг мэдээлэл (цаашид энэ зүйлд “мэдээлэл” гэх)-ийг **нийтлэхүйц боломжтой байх тохиолдолд** Төрийн захиргаа, аюулгүй байдлын сайд, эсвэл Зээлийн мэдээллийг ашиглах, хамгаалах тухай хуулийн 2 дугаар зүйлийн 5-д заасан хувийн зээлийн үнэлгээний компани (цаашид энэ зүйлд “хувийн зээлийн үнэлгээний компани” гэх)-аас боловсруулсан жинхэнэ нэрийг баталгаажуулах аргыг ашиглан **жинхэнэ нэрийг нь баталгаажуулахын тулд техникийн арга хэмжээ авах ёстой**. Харин Интернет мэдээллийн хэрэгсэл нь Мэдээлэл, харилцаа холбооны сүлжээний ашиглалт, мэдээллийн хамгаалалтыг дэмжих тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 5-д заасны дагуу иргэний хувийн байдлыг баталгаажуулах арга хэмжээ авсан бол тухайн хүний жинхэнэ нэрийг авах техникийн арга хэмжээ авсан гэж үзнэ.

④ Интернет мэдээллийн хэрэгсэл нь 1-д заасны дагуу жинхэнэ нэрийн баталгаажуулалт авсан этгээдийн мэдээллийг мэдээллийн самбар, чат өрөө зэрэгт **“жинхэнэ нэр баталгаажсан” тэмдэглэгээ**



харагдахуйц техникийн арга хэмжээ авна.

⑥Интернэт мэдээллийн хэрэгсэл нь тухайн интернэт мэдээллийн цахим хуудасны мэдээллийн самбар, чат өрөө зэрэгт **“жинхэнэ нэр баталгаажсан” тэмдэггүй** улс төрийн нам болон нэр дэвшигчийн талаарх дэмжсэн болон эсэргүүцсэн мэдээллийг **нэн даруй устгана.**

⑦ Хэрэв улс төрийн нам, нэр дэвшигч, сонгуулийн хорооноос б дахь хэсэгт заасны дагуу мэдээллийг **устгуулах хүсэлт гаргавал** интернэт мэдээллийн хэрэгсэл нь **нэн даруй биелүүлнэ.**

Дээрх зохицуулалттай агуулгын хувьд төстэй нэмэлтүүд үүнээс өмнө хэд хэдэн удаа Үндэсний Ассамблейгаас батлагдаж байсан байх ба тухай бүр Үндсэн хуулийн шүүхээс Үндсэн хуулийг зөрчсөн гэж үзэж байсан байна. Гэвч энэ удаагийн шийдвэртээ Төрийн сонгуулийн тухай хуулийн 82 дугаар зүйлийн “нэрээ нууцалсан улс төрийн шинжтэй илэрхийллийг” урьд гаргаж байсан шийдвэрүүдээсээ ялгаатай нь тодорхой байх зарчимд харшлагагүй гэж дүгнэсэн байна. Энэ маргааны хувьд аливаа этгээд интернэт мэдээллийн хэрэгсэлд улс төрийн нам болон нэр дэвшигчийн талаар дэмжсэн болон эсэргүүцсэн мэдээлэл оруулах тохиолдолд тухайн хүнийг хэн болохыг хэвлэлийн үйл ажиллагаа явуулагч этгээд баталгаажуулах үүрэг хүлээжээ. Нэг талаар иргэнд халгүй мэт боловч нөгөө талаараа иргэнээс жинхэнэ нэрийн баталгаажуулалт шаардаж байгаа нь иргэний үзэл бодлоо илэрхийлэхдээ чөлөөтэй байх, хараат бусаар илэрхийлэх

боломжийг хааж байна. “Жинхэнэ нэр баталгаажсан” тэмдэг авснаар өөрийгөө илчилсэн мэт мэдрэмж төрөх нь илт бөгөөд энэ тохиолдолд илэрхийлсэн илэрхийллийн хязгаар нь “дэмжсэн болон няцаасан” гэсэн 2 утгаар тодорхойлогдож байна. Гэтэл энэхүү “дэмжсэн болон няцаасан” гэх утга нь хэр хүрээнд, хэрхэн илэрхийлэгдэх нь тодорхойгүй гэж дүгнэлт хийх боломжтой буюу хэт өргөн хүрээгээр тодорхойлогдсон байгаа нь маргаан үүсэхэд хүргэжээ.

Үндсэн хуулийн шүүхээс дээрх маргаан бүхий заалтыг “Интернэт олон нийтийн мэдээллийн хэрэгсэл дэх нэрээ нууцалсан улс төрийн шинжтэй илэрхийллийн талаар зохицуулсан нь интернэтэд бий болсон “үзэл бодлоо илэрхийлэх орчин”-дох олон янзын санал бодлын солилцоог дарах, улмаар иргэний үзэл бодлоо илэрхийлэхэд нь **халшрах үр нөлөө үүсгэх (иргэний санаа бодлоо илэрхийлэхийг бууруулах)** бөгөөд ардчилсан нийгмийн суурь болсон үзэл бодлоо чөлөөтэйгөөр илэрхийлэх эрхийг алдагдуулж болзошгүй байна. Сонгуулийн сурталчилгааны явцад нэрээ нууцалсан улс төрийн шинжтэй илэрхийллийн сөрөг нөлөөлөл нь нэрээ нууцлахаас гадна улс төрийн илэрхийллийг зохицуулах тогтолцоо, улс төр, нийгмийн олон төрлийн нөхцөл байдлуудтай холбогдож үйлчилдэг тул нэргүй бүхий л илэрхийллийг урьдчилан цогцоор нь зохицуулж байгаа нь үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөнөөс илүүтэй төрийн үйл ажиллагааг амар, хялбар байдлаар явуулах нөхцөлийг эхэнд тавьснаараа нэрээ нууцлах эрх чөлөө, хувийн мэдээллийг өөрөө тодорхойлох эрхийг хэт хязгаарлаж



байна⁸ хэмээн дүгнэсэн юм.

Жинхэнэ нэрийг баталгаажуулах систем нь гэмт хэрэг, хууль бус үйлдлийг таслан зогсоох гэхээс илүүтэй хууль ёсны үзэл бодлоо илэрхийлэх эрхэд хяналт тавих нөлөөтэй болохыг харуулсан судалгааны үр дүн, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хэт хязгаарлаж байна гэж шүүмжилсэн саналууд ч байна (Чо Со-ёнг 2011). Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний дотроос сонгуультай холбоотой улс төрийн үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хамгийн өргөн хүрээнд хамгаалах ёстой ч гэмт хэрэг, хууль бус үйлдлүүд цөөнгүй байгаа учраас иргэдийн дийлэнх нь улс төрийн үг, үйлдлээ чөлөөтэй илэрхийлж чадахгүй байгаа талаар судлаачид ихээхэн шүүмжлэлтэй хандаж ирсэн. Дээрх шийдвэрээс өмнө БНСУ-ийн Үндсэн хуулийн шүүхээс 1998 онд халшрах үр нөлөөний талаар дараах дүгнэлтийг хийж байжээ. Үүнд:

Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг зохицуулсан хууль тогтоомжид тодорхой байх зарчим⁹ онцгой ач холбогдолтой. Ардчилсан нийгэм дэх үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний эзлэх байр суурь, хэрэгжилтийн үүднээс үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг тодорхой бус хэм

хэмжээгээр зохицуулах нь үндсэн хуулиар хамгаалагдсан үзэл бодлоо илэрхийлэхэд халшрах үр нөлөөг үзүүлдэг. Өөрөөр хэлбэл, илэрхийлэхийг хориглосон зүйл нь тодорхойгүй тохиолдолд илэрхийлэхийг хүсэж буй илэрхийлэл нь зохицуулалтад хамаарахгүй гэдэгт итгэлгүй байгаа үндсэн эрхтэй этгээд эрүүгийн хариуцлага хүлээх сул талтай байсан ч үзэл бодлоо илэрхийлэхдээ хатуу итгэл үнэмшилтэй байгаа тохиолдлыг эс тооцвол ерөнхийдөө хариуцлага хүлээхээс эмээж, илэрхийллийн үйлдлээ өөрөө дарах магадлал өндөр байдаг. Иймээс үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг зохицуулсан хуулиудад зохицуулалттай илэрхийллийн¹⁰ тухай ойлголтыг нарийвчлан, тодорхой тусгаж, бусад илэрхийлэлд халшрах үр нөлөө үзүүлэхгүй байхыг Үндсэн хуулиар шаарддаг.¹¹

Үндсэн хуулийн 21 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт заасан үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хязгаарлаж, гүтгэсэн, доромжилсон илэрхийллийг таслан зогсоох шаардлагатай байгаа нь үнэн. Гэсэн хэдий ч энэ хязгаарлалтыг бий болгохдоо арга хэрэгсэл нь үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хэт дарангуйлах арга байж болох эсэхийг нухацтай авч үзэх шаардлагатай. Манай Үндсэн хуулийн 21 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг, 37 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хязгаарлах аргыг тусгайлан заагаагүй. Эцэст нь Үндсэн хуулийн үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хязгаарлаж буйг Үндсэн хуулийн үзэл санааны дагуу тайлбарлахын тулд

8 БНСУ-н Үндсэн хуулийн шүүхийн шийдвэр. 2021.01.28. 憲法裁判所 2021. 1. 28. 선고 2018헌마 456, 2020헌마406, 2018헌가16 (병합) 전원재판부 결정 [공직선거법 제82조의6 제1항 등 위헌확인 등] [헌공292, 213]

9 Nulla poena sine lege "certa" буюу тодорхой хууль байхгүй бол ял үгүй гэх зарчмаас үүдэлтэй тус тодорхой байх зарчмын агуулга нь Үндсэн хуулийн эрх зүйд гүйцэтгэх болон шүүх засаглалд хэрэглэх хэм хэмжээний стандарт нь хууль өөрөө байдаг тул энэ хуульдаа нэр томъёог тодорхойлж, тухайн тодорхойлсон нэр томъёог энгийн ухамсарт хүний оюун дүгнэлтээр яг ижил утгаар ойлгогдох боломжтой байхыг шалгуураа болгож, энэ хуулийн заалт Үндсэн хуульд нийцнэ гэж үзэж ирсэн.

10 Хуулиар зохицуулах шаардлагатай гэж үзсэн илэрхийлэл

11 БНСУ-н Үндсэн хуулийн шүүхийн шийдвэр, дугаар – 95 Хонга 16헌재 1998.04.30., 95헌가16



үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөнд тавигдах бүх шаардлагыг цогцоор нь авч үзэх шаардлагатай байна. Үнэн хэрэгтээ, Үндсэн хуульд заасан үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хязгаарлахдаа халшрах үр нөлөөнөөс урьдчилан сэргийлэх асуудлыг авч үзэх нь үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний үндсэн агуулгад халдахыг хориглохтой нягт холбоотой гэж үзэж байна. Хүн төрөлхтний түүхийг эргэн харвал тоо томшгүй олон хавчлага, ялангуяа улс төрийн нөлөөнд өртөж байсан. Тиймээс төрөөс улс төрийн үзэл бодлоо илэрхийлэх хязгаарлалт нь үзэл бодлоо илэрхийлэхэд саад болох сэтгэл зүйн хувьд хумигдмал байдлыг үүсгэж, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг бодитоор хангахгүй байх нөхцөл байдлыг бий болгож болзошгүй юм. АНУ-ын Дээд шүүх үүнийг халшрах үр нөлөө гэж үзээд үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг зөрчсөн гэж үзэж эхэлсэн.¹²

Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хязгаарлах нь бусад эрхийг хязгаарлах суурийг тавьдаг бөгөөд иргэдийн эрхийн талаарх мэдрэмжийг доройтуулдаг эрсдэлтэй. Тиймээс үзэл бодлоо илэрхийлэх эрхийг хязгаарласан хууль нь халшрах үр нөлөө үүсгэхгүй байхаар тодорхой зохицуулах ёстой¹³ байдаг гэдгийг дээрх шүүхийн шийдвэрүүд бүрэн дүүрэн нотолж байна.

¹² “Им Ён Деок, Ким Хён Сон. (2009). “Халшрах үр нөлөө”-ийн талаарх эрх зүйн харьцуулсан дүгнэлт. Сунгкюнкван хуулийн сургууль, 21(2), 1-26.

¹³ Квон Хёон Дун, “Интернэтэд үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө ба түүний зохицуулалт-үзэн ядсан үг хэллэг, худал мэдээлэлд Германы хариу үйлдлийг авч үзэх нь,” Шүүх эрх зүй, 1(51), 3-34. 권형돈. (2020). 인터넷에서 표현의 자유와 그 규제법리 -혐오표현.거짓정보에 대한 독일의 대응을 중심으로. 사법, 1(51), 3-34.

VI. Дүгнэлт

Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хүн төрөлхтний хөгжил, дэвшилтэй салшгүй холбоотой гэж үзэх хандлага дэлхий дахинд түгээмэл байдаг. Учир нь тодорхой нэгэн цаг үеийнхээ танин мэдэхүйн дээд түвшинд хүрсэн эрдэмтэн, мэргэд, зохиолч, улс төрч, зохион бүтээгчдийн өөрсдийн үзэл бодлыг чөлөөтэй илэрхийлж, бодол санаагаа нээлттэйгээр шүүн хэлэлцүүлэх боломж гарсан нөхцөлд л тэдгээр дэвшилтэт үзэл санаа биеллээ олж, хүн төрөлхтнийг хөгжил, дэвшилд хөтөлж ирсэн түүхтэй билээ.

Энэ дагуу үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө нь орчин үеийн эрх зүйн хөгжлийн үр дүнд бэхжин тогтсон олон үнэт зүйлсийн тэргүүн эгнээнд бичигдэж, засаглалын ардчилсан хэлбэр бүхий улс орнуудын Үндсэн хуульд “үндсэн эрх” болж, хуульчлагдан баталгаажсан байдаг. Гэвч хувь хүний үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө нь зүй ёсоор хүлцэх хэмжээнээс хэтэрсэн тохиолдолд энэ нь бусдыг хохироох арга хэрэгсэл болж хувирах нь бий. Үүнээс сэргийлж, хууль тогтоогчийн зүгээс энэхүү үндсэн эрхэд аливаа хязгаарлалтыг тогтоохдоо бусдын эрхийг хамгаалахаас илүүтэй төрийн иргэдэд тавих хяналтыг нэмэгдүүлж, иргэний нийгмийн төрд тавих хяналтыг сулруулахад чиглэсэн хууль тогтоомжийг батлан гаргах явдал зөвхөн нэг улсаар хязгаарлагдахгүйгээр харьцангуй түгээмэл болж байна. Үүнээс гадна зөвхөн хууль тогтоогч төдийгүй шүүхээс бусдын эрхийг хамгаалах үүднээс төрийн хяналтыг нэмэгдүүлж, иргэний нийгмийн хяналтыг бууруулах үр дагавар



бүхий шийдвэрийг гаргаж, энэ салбарт хууль хэрэглээний жишиг тогтоож буйг дээр дурдсан БНСУ-ын Үндсэн хуулийн шүүхийн шийдвэрээс харж болно.

Үндсэн хуульд зааснаар үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө нь хүний эрхэм чанар, үнэт зүйлийг хүндэтгэхэд чиглэгдсэн үндсэн эрх бөгөөд бодит харилцаа, соёлын үнэт зүйл, ёс зүйн хүрээгээр хязгаарлагддаг. Гэвч тус хүрээний агуулгыг урьдчилан хянаж, хязгаарлах эсхүл зөвшөөрөх эсэхийг шийддэг төрийн цензур нь үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний суурь зарчимд нийцдэггүй гэдгийг анхаарах нь зүйтэй. Өдгөө хувь хүн өөрийн үзэл бодлоо олон нийтэд хандан илэрхийлэх хамгийн хүртээмжтэй үр дүнтэй арга хэрэгслийн нэг нь интернэт орчин дахь нийгмийн сүлжээний хэрэгслүүд болсон. Гэтэл төрөөс энэхүү иргэдийн үзэл бодлоо үр дүнтэй, хүртээмжтэйгээр илэрхийлэх боломжтой (цахим) талбарт тусгайлан хязгаарлалт тогтоож буй бол ингэх болсон шалтгааныг хангалттай тодорхой байдлаар тогтоосон байх шаардлагатай юм.

Учир нь Үндсэн хуулиар баталгаажсан эрхээ хувь хүн өөрт хамгийн тухтай, үр дүнтэйгээр чөлөөтэй эдлэх талбартаа өндөр хяналт тогтоолгох үед тэдний үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх сонирхол нь хуулийн хариуцлагаас эмээхээс эхлээд сөрөг буюу санал нийлэхгүй байгаагаа илэрхийлэх болон шүүмжлэх үед төрийн хяналтад орж, бүртгүүлж буй нь ирээдүйд энэ явдал өөрт нь сөргөөр нөлөөлөх вий гэсэн дарамтыг үүсгэж байдаг.

Ийм айдас, дарамт бүхий мэдрэмжийг мэдэрсэн хүн үзэл бодлоо “чөлөөтэй” илэрхийлэх сонирхолгүй болж, улмаар хязгаарлагдаагүй бусад талбарт ч үзэл бодлоо илэрхийлэх нь илэрхий буурдаг.

Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө нь бусдын эрхийг зөрчиж, хохироох үр дагаварт хүргэвэл хохирлыг нөхөн төлөх, залруулга хийх үүрэг хүлээлгэх замаар нэр төрийг нь сэргээх эрх зүйн механизм өдгөө дэлхийн олон улс оронд үйлчилсэн хэвээр байгаа юм. Өөрөөр хэлбэл бусдын нэр төрд халдсан тохиолдолд түүнд чиглэсэн эрх зүйн хамгаалалт нь хохирол барагдуулах болон эрх сэргээх юм. Үүний шалтгаан нь бусад руу чиглэсэн аливаа этгээдийн үзэл бодол санал шүүмжээс тэдгээрийн эрхийг урьдчилан хамгаална гэвэл зайлшгүй үзэл бодлоо “чөлөөтэй” илэрхийлэх эрх чөлөөг хязгаарлах шаардлага үүснэ. Гэтэл уг эрх нь үндсэн эрх тул түүнд халдахын тулд зайлшгүй хуулиар тогтоох ёстой бөгөөд тус хууль нь туйлын тодорхой үндэслэлтэй байх ёстой юм. Өөрийгөө нээлттэй зарлахгүйгээр илт худал мэдээлэл тарааж буй тохиолдолд түүнд итгэх олон нийтийн итгэл ямар хэмжээнд байгааг тодорхой судалж, үр дүнг нээлттэй мэдээлэхгүйгээр бусдын нэр төр онц ноцтойгоор хохирох эсэхийг тогтооход бэрхшээлтэй бөгөөд нөгөөтээгүүр хохирол барагдуулж, эрх сэргээхэд чиглэсэн ретроспектив шинжтэй эрх зүйн уламжлалт хамгаалалт үр дүнгүй болохыг эцэслэн тогтоосон байх шаардлагатай байна.



VII. Ном зүй

Гадаад эх сурвалж:

1. 권형돈. (2020). 인터넷에서 표현의 자유와 그 규제법리 -혐오표현·거짓정보에 대한 독일의 대응을 중심으로.
2. 임영덕, 김형성 (2009). '위축효과'에 대한 비교법적 고찰.
3. 김학성, 「헌법학원론」, 2011.
4. 학위논문(석사) 서울시립대학교 일반대학원 : 법학과 2009. 8.
5. 성낙인, 「헌법학」, 법문사, 2021.

Эрх зүйн эх сурвалж:

1. Үндсэн хууль (1924).
2. Үндсэн хууль (1940).
3. Үндсэн хууль (1960).
4. Үндсэн хууль (1992).
5. The Licensing Act (1695).

6. Virginia Declaration of Rights (1776).
7. Declaration of the Rights of Man and of the Citizen (1789).
8. First Amendment, Constitution of the United States (1791).
9. Human Rights Act (1998).
10. International Covenant on Civil and Political Rights (1966).
11. 2021.01.28. 憲法裁判所 2021. 1. 28. 선고 2018헌마456, 2020헌마406, 2018헌가16 (병합) 전원재판부 결정 [공직선거법 제82조의6 제1항 등 위헌확인 등] [헌공292, 213].
12. 공직선거법 (1994).
13. 대한민국헌법 (1948).
14. 헌재 1998.04.30., 95헌가16.
15. 헌재 1992. 2. 25. 89헌가104.

**Abstract****THE CORRELATION BETWEEN CHILLING EFFECT
AND FREEDOM OF EXPRESSION****B.TSENDSUREN***Ph.D. candidate of School of Law,
Kookmin University, Republic of Korea*

This article addresses the limitations placed on the right to freedom of speech by the Constitution and international legal norms. It seeks to clarify the criteria for legally restricting freedom of speech and aims to explore the chilling effect that deters individuals from exercising their right to express their opinions. Additionally, the article aims to answer whether the government should regulate non-traditional

forms of communication, such as social media and the internet, when it comes to expressing one's opinions.

Keywords

Freedom of expression, chilling effect, restrictions on freedom of expression and government regulation.

**ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ
АЖИЛЛАГАА ДАХЬ ХЭРГИЙГ БОЛОМЖИТ БОГИНО
ХУГАЦААНД ШИЙДВЭРЛЭХ ЗАРЧИМ**

**Б.Наранцэцэг¹
Г.Амаржаргал²**

- I. Удиртгал
- II. Хэргийг боломжит богино хугацаанд шийдвэрлэх зарчмын онолын агуулга
- III. Хэргийг боломжит богино хугацаанд шийдвэрлэх зарчмыг хэрэглэх нөхцөл: эрх зүйн зохицуулалт
- IV. Дүгнэлт
- V. Ном зүй

¹ МУИС-ийн Хууль зүйн сургуулийн магистрант, хуульч, өмгөөлөгч.

² Өмгөөллийн Фиделитас партнерс ХХН-ийн судлаач, эрх зүйч.



ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГАА ДАХЬ ХЭРГИЙГ БОЛОМЖИТ БОГИНО ХУГАЦААНД ШИЙДВЭРЛЭХ ЗАРЧИМ

Б.НАРАНЦЭЦЭГ, МУИС-ийн Хууль зүйн сургуулийн магистрант, хуульч, өмгөөлөгч.

Г.АМАРЖАРГАЛ, Өмгөөллийн Фиделитас партнерс ХХН-ийн судлаач, эрх зүйч.

Түлхүүр үг

Хэргийг боломжит богино хугацаанд шийдвэрлэх зарчим, зарчмын хэрэгжилт, хүний эрх, эрх чөлөө, боломжит богино хугацаа.

Хураангуй

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үндсэн зорилт нь гэмт хэргийг шуурхай, бүрэн илрүүлэх явдал бөгөөд хэргээ боломжит богино хугацаанд шийдвэрлүүлэх нь эрүүгийн хэргийн оролцогч буюу яллагдагч, шүүгдэгч төдийгүй хохирогчийн зүй ёсны эрх юм. Хэргийг боломжит богино хугацаанд шийдвэрлэх зарчим нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үндсэн зарчим болохын хувьд Монгол Улсын хууль тогтоомжоор уг зарчмыг баталгаажуулсан эсэх, зарчмын хэрэгжилтийн өнөөгийн нөхцөл байдал, ач холбогдол, мөн чанар, цаашид энэ зарчмыг зайлшгүй хэрэгжүүлэх хэрэгцээ шаардлагыг тодорхойлсон.

I. Удиртгал

Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 9 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт “Баривчлагдсан буюу эрүүгийн хэрэгт буруутгагдсан аль ч хүнийг шүүгч буюу хуулийн дагуу

шүүн таслах эрх хэмжээ олгогдсон бусад албан тушаалтанд даруй шилжүүлэх бөгөөд хүн **хэргээ боломжийн богино хугацаанд шүүхээр шийдвэрлүүлэх буюу суллагдах** эрхтэй...” хэмээн хэргийг боломжит богино хугацаанд шийдвэрлэх зарчмыг тодорхойлсон. Монгол Улсын Хүний эрхийн үндэсний комиссын “Монгол улс дахь Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 22 дахь тайланд¹ шүүхийн шатанд хэргээ шийдвэрлүүлэхээр хүлээж байгаа “шүүгдэгч”-ийн хувьд цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ хэрэглэх процессыг нарийвчлан хуульчлаагүй, хугацаа тоолох талаар яллагдагчид баримтлах хуулийн хэм хэмжээг баримтлахгүй байгаагаас шалтгаалан хэргээ богино хугацаанд шүүхээр шийдвэрлүүлэх, суллагдах эрх зөрчигдөж байгаа болохыг дүгнэсэн.

Манай Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд хэргийг боломжит богино хугацаанд шийдвэрлэх зарчмыг тусгайлан хуульчлаагүй боловч хүний халдашгүй байх эрхийг

¹ Хүний Эрхийн Үндэсний Комисс, *Монгол улс дахь Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 22 дахь илтгэл*, Улаанбаатар, 2023, 67 дахь тал. <https://nhrcm.gov.mn/assets/img/58c1302622c8c88d036544f656fdff5d.pdf>, (Сүүлд үзсэн: 2024.09.13).



хангах үүднээс хуульд зааснаас бусад тохиолдолд хойшлуулшгүйгээр, эсхүл шүүхийн шийдвэрт зааснаас илүү хугацаагаар баривчлагдсан, цагдан хоригдож байгаа хүнийг прокурор даруй суллана гэх зохицуулалтаар хэргийг нэн даруй, боломжит хугацаанд шийдвэрлэх зарчмын үзэл санааг бэхжүүлсэн гэж үзэж болно. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хэрэг бүртгэлтийн үндсэн хугацаа 30 хоног, мөрдөн байцаалтыг хөнгөн гэмт хэрэгт 14, хүнд гэмт хэрэгт 30 хоног, прокурор хянах 14 хоног гээд шүүхийн өмнөх шатан дахь үндсэн хугацаа нь 88 хоног буюу ойролцоогоор 3 сарын хугацаа байхаар хуульчилсан. Гэсэн хэдий ч практикт төдийгүй манай процессын хуульд хугацаа сунгах тухай зохицуулалт маш олон бөгөөд бодит байдал дээр нэг эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэхэд ихэнхдээ 2-3 жил, түүнээс ч олон сар, жилийн хугацаа өнгөрдөг байдал ажиглагдаад байна. Энэхүү үргэлжилсэн хугацаа нь эрүүгийн хэргийн холбогдогчийн эрх зүйн байдал зөрчигдөх болох суурь шалтгаан болдог. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа сунгагдаж байгаа нь нэг талаас цагдаа, прокурор дахь хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын хэргийн ачаалал, хэргийг шүүхээс мөрдөн байцаалтад буцаах зохицуулалтын хэрэгжилттэй салшгүй холбоотой. Нөгөө талаас, эрүүгийн процесс ажиллагаанд хэргийг боломжит богино хугацаанд шийдвэрлэх зарчим хэрэгждэг эсэх, хэрхэн зохистойгоор хэрэгжүүлэх талаарх асуудал нь судлаачдын анхаарлыг татаж байна.

Тиймээс энэ өгүүлэлд хэргийг боломжит богино хугацаанд шийдвэрлэх

зарчмын агуулга, тус зарчмыг хэрэгжүүлэх хэрэгцээг судлах замаар тус зарчмыг баримтлах, хэрэгжүүлэх нөхцөлийг тодорхойлсон болно.

II. Хэргийг боломжит богино хугацаанд шийдвэрлэх зарчмын онолын агуулга

Эрүүгийн процессын хууль тогтоомж нь нэгэнт үйлдэгдсэн гэмт хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулан нотлогдвол зохих байдлыг үндэслэлтэй шийтгэх тогтоол гаргах замаар Эрүүгийн хуулийг хэлбэрэлтгүй хэрэгжүүлэх бүхий л нөхцөл баталгааг бий болгоход чиглэгдсэн² бөгөөд хүний эрхийг хамгаалах төдийгүй хязгаарлах, халдахад хүргэх үр дагаврыг агуулдгаараа тодорхой хориглолт, зохицуулалт бүхий эрх зүйн зарчмуудыг өөртөө агуулж байдаг³. Хэргийг шуурхай, боломжит богино хугацаанд шийдвэрлэх, аливаа зүй бус хойшлуулалтгүйгээр шүүгдэх эрх нь үндсэндээ шударга шүүхээр шүүлгэх эрхийн хүрээнд багтах ойлголт юм. Хүн бүр хуулиар тогтоосон хараат бус, шударга шүүхээр үндэслэл бүхий хугацаанд шүүгдэх эрхийг Монгол Улсын Үндсэн хуулиар баталгаажуулсан. Хэрэг маргааныг шүүн таслах хугацааг эртний Ромын эрх зүйн XII Хүснэгтийн хуульд нэг өдрийн дүрэм буюу “нар жаргахаас өмнө хэргийг шалгаж, шийдвэр гаргана” гэж зохицуулснаас⁴ үзвэл, хэргийг аль болох боломжит богино хугацаанд шийдвэрлэх шаардлага нь эрүүгийн процессын эрх зүйн эртнээс уламжлагдан

² Б.Эрдэнэбат, Б.Эрдэнэбилэг, “Эрүүгийн хэргийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрийн дүн шинжилгээ”, *legaldata.mn*, 2022, 100 дахь тал.

³ Д.Баярсайхан, *Эрүүгийн процессын эрх зүй*, 2020, 199 дэх тал.

⁴ Raimundas Jurka, *New Insights into the Procedure within a Reasonable Time as a Legal Principle*, 2010, pg 300.



ирсэн суурь зарчим юм. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг боломжит богино хугацаанд явуулах шаардлагыг зарим судлаач “эрүүгийн процессын шуурхай байх зарчим” гэж нэрлэн, “Гэмт хэргийг бүрэн илрүүлэн нотолж, гэм буруутай хүн, хуулийн этгээдэд шударгаар ял ногдуулах, гэм буруугүй хэнийг ч гэм хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцохгүй байх, зөрчигдсэн эрхийг сэргээн эдлүүлэх зорилго бүхий эрүүгийн процессын боломжит хугацааны шалгуураар тодорхойлогдох үзэл баримтлалыг хэлнэ.” хэмээн томъёолжээ.⁵

Монгол Улсын 1963 оны Эрүүгийн байцаан шийтгэх хуульд эрүүгийн процесс шуурхай байх явдлыг бие даасан зарчим гэж тусгажээ.⁶ Харин Монгол Улсын гавьяат хуульч Г.Совд болон К.Тажбекед нар 1987 онд тус зарчмыг эрүүгийн процессын үндсэн 16 зарчмын нэг хэмээн тодорхойлсон байна.⁷ Одоо хүчин төгөлдөр үйлчилж буй Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд хэргийг боломжит богино хугацаанд шийдвэрлэх зарчим, эсхүл эрүүгийн процессыг шуурхай явуулах зарчмыг тусгайлан заагаагүй боловч хууль ёсны байх, хууль, шүүхийн өмнө тэгш байх, халдашгүй байх эрхийг хангах, эрүү шүүлт, хүнлэг бус харьцаанаас ангид байх хүрээнд зарчмын шинжтэй агуулга нь тусгагдсан гэж үзэж болохоор байна.

⁵ Б. Эрдэнэбат, Эрүүгийн процессын шуурхай байх зарчим, эрх зүйн орчин, хэрэгжилт, Хууль зүйн докторын зэрэг горилсон бүтээл, 2023, 33 дахь тал.

⁶ Б. Эрдэнэбат, Эрүүгийн процессын шуурхай байх зарчим, эрх зүйн орчин, хэрэгжилт, Хууль зүйн докторын зэрэг горилсон бүтээл, 2023. 34 дэх тал. Дам эшлэв.

⁷ Б. Эрдэнэбат, Эрүүгийн процессын шуурхай байх зарчим, эрх зүйн орчин, хэрэгжилт, Хууль зүйн докторын зэрэг горилсон бүтээл, 2023. 34 дэх тал. Дам эшлэв.

Зарчим гэдэг нь аливаа үйл явдалд заавал баримтлах чиглэл бөгөөд эрүүгийн процесст удирдамж болгон дагаж мөрдөх эрх зүйн үнэт зүйл юм. Тиймээс эрүүгийн процессын зарчмууд нь хоорондоо амин уялдаатай учраас нэг нь зөрчигдвөл нөгөө нь хэрэгжихгүйд хүрэх⁸ сөрөг үр дагавартай. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны шударга байдлыг бүрдүүлэх чухал хүчин зүйл нь хэргийг шуурхай шийдвэрлэхэд⁹ оршдог. Эрүүгийн процессын оролцогч нараас хэргээ шуурхай шийдүүлэх замаар шударга шүүхээр шүүлгэх эрхээ хэрэгжүүлэхэд эрүүгийн процесст “хэргийг боломжит богино хугацаанд шийдвэрлэх зарчим”-ыг зайлшгүй баримтлах нь зүй ёсны шаардлага болж байна.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд зааснаар “үндэслэл бүхий сэжиг” байх тохиолдолд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг явуулах бөгөөд ийнхүү эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь гэм буруугүй хүнийг баривчлах, цагдан хорих, ял эдлүүлэх эрсдэлийг өөртөө агуулж байдаг¹⁰ учраас эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд гэмт хэргийг **шуурхай бөгөөд бүрэн гүйцэт** явуулах зарчмыг харилцан тэнцвэртэй байлгах шаардлагатай. Яллагдагчид хэдий чинээ удаан эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулна, төдий чинээ хувь

⁸ Б. Эрдэнэбат, Эрүүгийн процессын шуурхай байх зарчим, эрх зүйн орчин, хэрэгжилт, Хууль зүйн докторын зэрэг горилсон бүтээл, 2023, 33 дахь тал.

⁹ МУИС-ийн Үндсэн хуулийн эрх зүйн хүрээлэн, Үндсэн хууль манай сургуульд, НУБ-ын Хүний эрхийн хороодын ерөнхий тайлбар, сургалтын хөтөлбөр, 2022, 116 дахь тал.

¹⁰ Нээлттэй Нийгэм Форум, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх явцад учирсан хохирлын нөхөн төлүүлэлт, шүүхийн шийдвэрийн дүн шинжилгээ, 2021, 6 дахь тал.



хүний халдашгүй байдал, эрх чөлөө, аюулгүй байдал, эрүүл мэнд, гэр бүл, ажил мэргэжил, нийгмийн харилцаанд сөргөөр нөлөөлдөг.¹¹ Нөгөөтээгүүр, гэмт хэрэг үйлдсэн хугацаа, ял шийтгэл оногдуулах хугацаа хэдий ойр байна, төдий чинээ ялын зорилгыг ач холбогдол бүхий байлгахад чиглэх¹² бөгөөд энэ нь ялын зорилго, түүний нийгэмд үзүүлэх нөлөөлөлтэй салшгүй холбоотой.

Эрүүгийн процессыг шуурхай явуулах нь зөрчигдсөн эрхийг түргэн шуурхай сэргээх, хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх, хохирлыг цаг тухайд нь барагдуулах, ял шийтгэлийг түргэн шуурхай эдлүүлэх, процессын зардал цаг хугацааг хэмнэх зэрэг цөөнгүй ач холбогдолтой. Мөн процессыг шуурхай явуулснаар гарсан гэмт хэрэг, үргэлжилсэн, бэлтгэгдэж буй гэмт хэргүүдийг цаг тухайд нь таслан зогсоох баталгаа болно. Хэргийг боломжит богино хугацаанд шийдвэрлэх нь зөвхөн яллагдагч, шүүгдэгчийн эрхэд хамаарах асуудал биш бөгөөд нөгөө талаас хохирогч, хэргийн бусад оролцогчдод ч мөн адил чирэгдэл учруулахгүйгээр түргэн, шуурхай шийдвэрлэж дуусгах тухай асуудал мөн хөндөгдөнө. Өөрөөр хэлбэл, эрүүгийн хэрэгт хэд хэдэн шалтгааны улмаас хохирогч ч мөн адил хэргээ шуурхай шийдүүлэх эрмэлзэлтэй байна. Тэдгээрийн нэг жишээ нь хөөн хэлэлцэх

хугацааны асуудал. Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд шалгагдаж байх хугацаанд эсвэл шүүхийн шатанд хөөн хэлэлцэх хугацаа дууссан гэх үндэслэлээр хэргийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэдэг тохиолдол цөөнгүй.

Хэргээ боломжит богино хугацаанд шийдвэрлүүлэх эрх нь Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактад заасан үндсэн эрх бөгөөд Европын Хүний эрхийн шүүхээс гишүүн улс орнуудад хэрэг хянан шийдвэрлэх хугацааг хурдасгах арга механизмыг бий болгохыг уриалсаар байна¹³. Түүнчлэн Америкийн Хүний эрхийн конвенц, Африкийн Хүний эрхийн тунхаглал зэрэг олон улсын хүний эрхийн баримт бичгүүдэд хэргээ “үндэслэл бүхий хугацаа (reasonable)”-нд шийдвэрлүүлэх эрхийг баталгаажуулсан нь эрүүгийн процесст энэ нь зайлшгүй хэрэгжүүлэх зарчим болохыг тодотгож байна. НҮБ-ийн Хүний эрхийн хорооноос хэргийг боломжит богино хугацаанд шийдвэрлэх шаардлага нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны “шүүхийн өмнөх шатнаас анхан шатны шүүхээр шүүгдэх хүртэл хугацаанд баривчлагдах хугацаанд” голчлон хамаарна¹⁴ гэж тайлбарлажээ. Өөрөөр хэлбэл, эрүүгийн

¹¹ Dr. Oudha yousif Salman., “Right of the accused to be tried within a reasonable period in the Iraqi and comparative criminal legislation”, 2022. “The longer the time taken for criminal proceedings, the higher the burden on the accused, Reconciliation, whether at the personal level, has been affected by freedom and security, their health at the family and social level, or the professional level.”

¹² Cesare Bonesana di Beccaria, *An Essay on Crimes and Punishments* (1764), http://files.libertyfund.org/files/2193/Beccaria_1476_EBk_v6.0.pdf, (Сүүлд үзсэн: 2024.09.13).

¹³ Miodrag Simovic, Marina Simovic, *Criteria for Assessing the Violation of the Right to a Trial Within a Reasonable Time*, 2021.07.10, <https://www.gfpn-au.com/sites/default/files/GFPN-11-11/Godisnjak-11-105-116.pdf>, (Сүүлд үзсэн: 2024.09.13).

¹⁴ UN, Human Rights Committee, *International covenant on civil and political rights, Article 9 (Liberty and security of person)*, *General Comment No.35*, dated December 16, 2014, para 37. “... That requirement applies specifically to periods of pretrial detention, that is, detention between the time of arrest and the time of judgment at first instance.” <https://www.ohchr.org/en/calls-for-input/general-comment-no-35-article-9-liberty-and-security-person>, (Сүүлд үзсэн: 2024.09.13).



хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ хэрэглэсэн тохиолдолд хугацаа нь аль болох богино хугацаанд, цагдан хоригдсон яллагдагчийн холбогдсон хэргийг хурдан шуурхай шийдвэрлэх, суллах талаар гарсан шүүхийн шийдвэрийг нэн даруй биелүүлэх хүрээнд уг зарчмын агуулга тодорхойлогдоно. Энэ хугацааг хэт уртасгах нь хүний гэм буруу нь хуулийн дагуу нотлогдох хүртэл гэм буруугийд тооцогдох эрхийг зөрчих эрсдэлтэй.¹⁵ Яллагдагчийн зүй бус хойшлуулалтгүйгээр шүүгдэх эрх нь зөвхөн түүнийг хувь заяаных нь талаар шийдвэрлэхдээ тодорхойгүй байдалд хэт удаахгүй байх зорилготой биш бөгөөд шүүн таслах ажиллагааны явцад цагдан хоригдсон бол тухайн хэргийн нөхцөл байдалд шаардлагатай хэмжээнээс удаан цагдан хорихгүй байх, шударгаар шүүлгэх ашиг сонирхолд нь нийцүүлэхэд чиглэнэ.¹⁶

Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа удааширч, хэт сунжрах нь олон хүчин зүйлээс шалтгаалдаг. Тухайлбал, (1) Хэргийн ээдрээ төвөгтэй байдлаас шалтгаалж хугацаа сунгах; (2) Хэрэг бүртгэх, мөрдөн шалгах ажиллагаа дахь нэг мөрдөгчид ногдох хэргийн ачаалал их; (3) Мөрдөгч бие даан ажиллагаа явуулах боломж хомс, дийлэнхдээ прокурорын зөвшөөрөл шаарддагаас хугацаа алдах; (4) Шүүхээс эрүүгийн хэргийг нэмэлт хэрэг бүртгэлт, мөрдөн

байцаалт хийлгэхээр прокурорт буцаах нөхцөл байдлууд хамаарч байна.

Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг шуурхай явуулах нөхцөл нь сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийг удаан хугацаагаар баривчлах, хуульд заасан хугацааг үндэслэлгүйгээр хойшлуулах явдлыг гаргахгүй байх, үүнээс урьдчилан сэргийлэх шаардлагаас үүдэлтэй.¹⁷ Аливаа этгээд гэмт хэрэг үйлдсэн эсэх нь нотлогдоогүй байхад олон сар, жилээр байцаагдах ёсгүй бөгөөд энэ нь Монгол Улсын Үндсэн хуулиар хамгаалагдсан эрх билээ. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хугацааг сунгах, хойшлуулахад хуулиар тодорхойлсон “*үндэслэл*” байх шаардлагатай.

Гадаад орнуудын эрүүгийн процессын зохицуулалтаас жишээ татан дурдвал эх газрын эрх зүйн систем бүхий ХБНГУ-ын эрүүгийн процесс ажиллагаа нь “*Nullum crimen sine lege*” зарчимд тулгуурлаж, хүний эрхийн наад захын стандартыг хангах, хуулийн зорилго, зарчим нь агуулга, журамтайгаа бүрэн уялдаж, баталгаатай, тогтвортой хэрэгжих нөхцөлийг бий болгосон байдаг. Эрүүгийн процессын хуульдаа тусгай зарчмуудыг тодорхойлсон бөгөөд үүнд ялах, албан ёсны байх, амаар мэдүүлэг авах, ил тод байх, нотлох баримтыг үнэ төлбөргүй үнэлэх, мөн хойшлуулшгүй шүүх хуралдааны зарчим багтдаг.¹⁸

¹⁵ *Ibis*.

¹⁶ UN, Human Rights Committee, International covenant on civil and political rights., Article 14: Right to equality before courts and tribunals and to a fair trial., General Comment No.32, dated August 23, 2007, para 35. https://tbinternet.ohchr.org/_layouts/15/TreatyBodyExternal/Download.aspx?symbolno=CCPR%2FC%2F32%2F32&Lang=en, (Сүүлд үзсэн: 2024.09.13).

¹⁷ Human Rights Institute, Southwest University of Political Science and Law, Estifanos Balew Liyew, *Accused person's speedy trial rights in Ethiopia's criminal proceedings: theory and practice*, May 21, 2024., https://www.researchgate.net/publication/380969380_Accused_persons'_speedy_trial_rights_in_Ethiopia's_criminal_proceedings_theory_and_practice, (Сүүлд үзсэн: 2024.09.13).

¹⁸ Д. Баярсайхан, *Гадаад орнуудын эрүүгийн процесс*, Улаанбаатар, 2015.



ХБНГУ-ын Эрүүгийн процессын хуулийн 202 дугаар зүйлд "...хэргийн бодит байдлыг сайтар судалж тогтоох зорилгоор шүүх нэмэлт нотлох баримт цуглуулахаар шийдвэрлэж болох ба түүнд хэн ч гомдол гаргах эрхгүй" гэж заасан. Үүний дараа шүүх хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэх эсэхээ шийдвэрлэдэг¹⁹. Өөрөөр хэлбэл, шүүх гэм бурууг шийдвэрлэх шүүх хуралдаанаас өмнө нотлох баримт бүрдүүлэх, нэмэлт ажиллагаа шаардлагатай эсэх бүхий л талаас нь шалгадаг нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хугацааг хангалттай хэмнэж буй явдал юм. Хэдийгээр яллах зарчимд тулгуурласан эрүүгийн процесс боловч энэ нь эрүү шүүлтийн арга, замаас огт ангид бөгөөд гэмт хэрэг нэг бүрийг бүрэн илрүүлэх, илэрсэн даруйд нь мөрдөн шалгах ажиллагааг шуурхай явуулах, бодит үнэнийг бүх талаас нь тогтоохын тулд нотолгооны процесс ажиллагаа явагддаг байна.

АНУ-ын Холбооны Хойшлуулшгүй Шүүх ажиллагааны тухай хууль (Speedy Trial Act)-д сэжигтнийг баривчлагдсанаас хойш 30 хоногийн дотор яллах дүгнэлт үйлдэж, яллах дүгнэлт үйлдсэнээс хойш 70 хоногийн дотор шүүх хуралдааныг явуулах ёстой гэж заасан.²⁰ Их Британи улсын Цагдаа ба Эрүүгийн нотлох баримтын тухай хууль (Police and Criminal Evidence Act)-д хоригдсон этгээдийг 24 цагийн дотор яллах эсхүл

суллах шийдвэрийг гаргах ёстой бөгөөд тодорхой нөхцөл байдалд 36-96 цаг хүртэл сунгаж болно гэж заасан²¹.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь шүүхийн өмнөх болон шүүхийн үе шатнаас бүрддэг. Процессын дийлэнх хугацаа мөрдөн шалгах ажиллагаанд зарцуулагдаж, удааширдаг боловч шүүхийн шатанд ч мөн адил хэргийг хуульд заасан хугацаанд шуурхай шүүн таслах нь эрүүгийн процессын шуурхай байх зарчмын нэг хэсэг юм. Шүүгч хүн олон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг явуулахгүй, шүүх хуралдааныг үндэслэлгүйгээр хойшлуулах, ажилдаа ирэхгүй байх нь шүүх хуралдаанд биечлэн оролцох эрхийг, мөн шударга шүүхээр шүүлгэх эрхийн нэг хэсэг болох боломжит хугацааны дотор хэргээ шуурхай шийдвэрлүүлэх эрхийг ноцтой зөрчдөг.

Эрүүгийн хэргийг боломжит богино хугацаанд шүүн таслах нь хэрэг хянан шийдвэрлэх хугацааг түргэсгэх, яаравчлах гэсэн үг огт биш бөгөөд тухайн хэргийн нөхцөл байдал, процессын онцлогт нийцүүлэн аль болох хамгийн боломжит богино хугацаанд, тодорхой бус хуульд заагаагүй үндэслэлээр хугацааг сунгахгүй, яллагдагчийн эрхийг зөрчиж, зовоохгүй, гэм буруу нь нотлогдох хүртэл хохирол учруулахгүйгээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг явуулах явдал бөгөөд эдгээр нь хүний шударга шүүхээр шүүлгэх үндсэн эрх, эрх чөлөөг хангах баталгаа юм.

¹⁹ Улсын дээд шүүх, Эрүүгийн хэргийг прокурорт буцаах шүүхийн эрх хэмжээ, Улаанбаатар, 2018, <http://old.supremecourt.mn/news/404>, (Сүүлд үзсэн: 2024.09.13).

²⁰ U.S.Department of Justice, Speedy Trial Act of 1974, Section A. <https://www.justice.gov/archives/jm/criminal-resource-manual-628-speedy-trial-act-1974>. (Сүүлд үзсэн: 2024.09.13).

²¹ UK, Police and Criminal Evidence Act 1984, Section 41 (1). <https://www.legislation.gov.uk/ukpga/1984/60/section/41>, (Сүүлд үзсэн: 2024.09.13).



III. Хэргийг боломжит богино хугацаанд шийдвэрлэх зарчмыг хэрэглэх нөхцөл: эрх зүйн зохицуулалт

Монгол Улсын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд гэмт хэргийг шуурхай илрүүлэх, ажиллагааг даруй явуулах зэргээр хэргийг боломжит богино хугацаанд шийдвэрлэх зарчмыг ерөнхий хүрээнд “даруй”²² гэх нөхцөлөөр хуульчилсан хэдий ч хуулийн зарим зүйл заалт ойлгомжгүй, олон шат дамжлага ихтэй, эрх зүйн хийдэлтэй, мөрдөгч, прокурорын хамтын ажиллагааны хэлбэр тодорхойгүйн улмаас хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг удаашруулах шалтгаан болж байна гэж үзэх үндэслэлтэй. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн шинэчилсэн найруулга батлагдсанаас хойш 7 жилийн хугацаанд хууль тогтоомжийг боловсронгуй болгохоор нийт 19 удаагийн нэмэлт өөрчлөлт орж байсан ч эрүүгийн хэргийг боломжит богино хугацаанд шийдвэрлэх зарчмыг хангахад чиглэсэн өөрчлөлт хараахан ороогүй байна.

Улсын Их Хурлаас 2017 онд шинэчлэн баталсан Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд хугацаатай холбоотой хэд хэдэн маргаан дагуулсан зохицуулалтууд байгааг Хууль зүйн үндэсний хүрээлэнгээс 2018 онд хийсэн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээний судалгааны тайланд онцолжээ. Тухайлбал, нэг талаас, цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авах үндэслэл учир дутагдалтай байдлаар

хуульчлагдсанаас эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа удаашрах нөхцөлийг үүсгэх, нөгөө талаас, мөрдөн шалгах ажиллагааны хугацааг өмнөх хуультай харьцуулахад богино хугацаанд хийж гүйцэтгэх боломжийг хангаж, хүний эрхийг хамгаалахад чиглэгдсэн хэмээн судлаачид өөр өөрийн байр суурийг илэрхийлж байна.²³ Судалгаанаас үзэхэд, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны практикт яллагдагч, шүүгдэгчид холбогдох хэргийг 12-48 сар хүртэл хугацаагаар шийдвэрлэж чадахгүй цагдан хорих тохиолдол гардаг.²⁴ Эрүүгийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 14.10 дугаар зүйлд цагдан хорих үндсэн хугацаа 1 сар, шаардлагатай тохиолдолд сунгах хугацаа хамгийн ихдээ 18 сараас хэтэрч болохгүй гэж заасан байтал дээрх байдлаар яллагдагч, шүүгдэгчийн эрхийг зөрчиж буй нь тулгамдсан асуудал болж байна. Энэ нь зөвхөн цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээний хугацааны хүрээнд яригдаж буй асуудал бөгөөд нийт эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд үүнээс их хугацааг үндэслэлтэй болон үндэслэлгүйгээр хойшлуулж байгаа нь Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 9 дүгээр зүйлийн 9.3-т заасан “хэргээ боломжит богино хугацаанд шийдүүлэх” эрх манай улсын эрүүгийн процессын системд огт хэрэгждэггүй болохыг илтгэж байна.

²² Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.4 дүгээр зүйлийн 1.7 дахь хэсэг. “Даруй” гэж боломжит богино хугацааг;

²³ Хууль зүйн үндэсний хүрээлэн, “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээ” (судалгааны тайлан), 2018, legaldata.mn, 7 дахь тал.

²⁴ Хүний Эрхийн Үндэсний Комисс, Монгол Улс дахь Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 22 дахь илтгэл, Улаанбаатар, 2023, <https://nhrcm.gov.mn/assets/img/d840600d288fcb74618e539b7331a142.pdf>, 64 дахь тал, (Сүүлд үзсэн: 2024.09.13).



Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 33.3 дугаар зүйлд зааснаар шүүх зөвхөн урьдчилсан хэлэлцүүлгээс хэргийг прокурорт буцаахаар хуульчилсан. Мөн хуулийн 2022 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн нэмэлт, өөрчлөлтөөр 33.1 дүгээр зүйлийн 12 дахь хэсэгт “Шүүхийн шатнаас урьдчилсан хэлэлцүүлэг рүү хэрэг буцаахгүй” болохыг тусгаж, хэргийг мөрдөн шалгах, хяналт тавих ажиллагааг чанаржуулах, тогтоосон хугацаанд бүрэн дүүрэн явуулах ач холбогдолтой зохицуулалтыг бий болгосон. Гэсэн хэдий ч практикт гэм буруугийн шүүх хурлаар хэргийг прокурорт буцаах тохиолдолд түгээмэл бөгөөд прокурор, шүүгчдийн хувьд энэ ойлголтыг өөр өөрөөр тайлбарлан хэрэглэж байна.

Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг шуурхай явуулахад мөрдөгчийн бие даасан ажиллагаа чухал үүрэг гүйцэтгэдэг. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 22.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасан 17 ажиллагааг прокурорын зөвшөөрлөөр явуулах, мөн хуулийн 22.4 дүгээр зүйлд зааснаар хойшлуулшгүй тохиолдолд прокурорын зөвшөөрөлгүй явуулсан тохиолдолд хүчинтэйд тооцуулах саналыг прокурорт 24 цагийн дотор гаргахаар заасан нь мөрдөгчийн бие даасан байдлыг багасгаж, зарим тохиолдолд мөрдөн шалгах ажиллагааг удаашруулах, процессын зөрчил, ажлын ачааллыг нэмэгдүүлэх сөрөг үр дагаврыг бий болгосон.²⁵ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хэт олон зөвшөөрөлтэй мөрдөн шалгах ажиллагаа

²⁵ Б.Дашням “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд мөрдөгчийн бие даасан байдлыг нэмэгдүүлэх нь” (2023), *legaldata.mn*, 2 дахь тал.

явуулж байгаа нь иргэн, хуулийн этгээдийн зөрчигдсөн эрхийг сэргээх, эрүүгийн процессын зорилтыг хангах нөхцөлд саад учруулж байна. Үүнээс гадна, мөрдөн шалгах ажиллагааг явуулж байгаа алба хаагчид хэт олон хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулж, ажлын ачаалал өндөртэй байгаа нь хуулийг нэг мөр хэлбэрэлтгүй хэрэгжүүлэх, бүхий л хэрэгт жигд мөрдөн шалгах ажиллагаа явуулах нөхцөл боломжийг олгох боломжгүй юм.

Мөрдөгч байцаагч, прокурор, шүүх нь эрүүгийн хэргийг өөр хоорондоо бөмбөг мэт шилжүүлж, хэргийн холбогдогч, хохирогчдыг шаналган зовоож, удаан хугацаагаар залхаан цээрлүүлдэг.²⁶ Хэргийн шийдвэрлэлт удааширнаас хоригдогч урт хугацаагаар буюу 30 сараас дээш хугацаагаар хоригдох явдал гарсаар байна. Хэргийг шүүхээс хэдэн ч удаа буцааж, шүүх дээр байсан хугацааг цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээний хугацаанд оруулахгүйгээр хорьж мөрдөх хугацааг хэтрүүлэх нь цөөнгүй байна.

IV. Дүгнэлт

Хэргийг боломжит богино хугацаанд шийдвэрлэх зарчим нь олон улсын төдийгүй манай улсын эрүүгийн процесс ажиллагаанд тусгагдсан, өмнө үеийн эрх зүйн эх сурвалжуудаас уламжлагдан ирсэн эрүүгийн процессын эрх зүйн тулгуур зарчим тул эрүүгийн процессын ажиллагаанд удирдамж болгон хэрэгжүүлэх шаардлагатай. Эрүүгийн

²⁶ Хүний Эрхийн Үндэсний Комисс, *Монгол Улс дахь Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 13 дахь илтгэл*, Улаанбаатар, 2014 он, 81 дэх тал, <https://nhrcm.gov.mn/assets/img/ff0238f01603f55cbb446ac72344eb8d.pdf>, (Сүүлд үзсэн: 2024.09.13).



хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь хүний эрх, эрх чөлөөг хязгаарлах, халдахад хүргэх үр дагаврыг агуулдаг тул төдий чинээ хүний эрхийг хамгаалах, хангах баталгааг нөхцөлдүүлж, харилцан тэнцвэртэй байлгах нь чухал ач холбогдолтой. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хэргийн бодит үнэнийг тогтоох нь нэн чухал зорилт боловч гэмт хэрэгт холбогдсон этгээдийг удаан хугацаагаар мөрдөн шалгах, хорьж саатуулах, хэргийг хэт сунжруулах нь зөвхөн яллагдагчийн төдийгүй хохирогчийн эрх, эрх чөлөөг зөрчиж буй явдал юм.

“Боломжит богино хугацаа” гэдгийг зөвхөн тодорхой цаг, өдрөөр тодорхойлж, зарчмын агуулгыг явцуу утгаар тайлбарлах нь өрөөсгөл юм. Судлаачийн зүгээс дэвшүүлж буй санаа нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь хүний эрх, эрх чөлөөг зөрчихөд хүргэх үр дагавартай байдаг тул тухайлсан процесс ажиллагааг байж болох хамгийн богино хугацаанд буюу аливаа үндэслэлгүйгээр хойшлуулалт, хэт ерөнхий зохицуулалтаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хугацааг сунгаж, удаашруулахгүй байх зохицуулалтыг Эрүүгийн процессын хуульд бэхжүүлэх шаардлагатай. Улмаар эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд “хугацаа сунгах” шийдвэр гаргахаас өмнө “боломжит богино хугацаанд хэргийг шийдвэрлэх зарчим”-ийг удирдамж болгон нэгдмэл агуулгаар хэрэглэх шаардлагатай гэж үзэж байна.

Монгол Улс хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, тодорхой төрлийн гэмт

хэрэгтэй тэмцэх олон улсын гэрээ, конвенцод нэгдэн орсон гишүүн орон болохын хувьд хүний “хэргээ боломжит богино хугацаанд шийдүүлэх” эрхийг хангах зарчмыг эрүүгийн процесстoo хэлбэрэлтгүй тусгаж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд нэг мөр хэрэглэх нөхцөлийг бүрдүүлэх замаар олон улсын гэрээгээр бусад улсын өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх нь зүйтэй.

Хэргийг боломжит богино хугацаанд шийдвэрлэх зарчмыг бэхжүүлэхийн тулд процессын үе шат бүрд тодорхой хугацаа заах бус харин процессын хугацаа сунгах, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа удаашруулж буй үндэслэлийг тодорхой бөгөөд зайлшгүй байх нөхцөлийг тодорхойлох явдал юм.

V. Ном зүй

Монгол эх сурвалж

1. Д.Баярсайхан, Эрүүгийн процессын эрх зүй, 2020.
2. Д. Баярсайхан, Гадаад орнуудын эрүүгийн процесс, 2015.
3. Хүний Эрхийн Үндэсний Комисс, Монгол улс дахь Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 13 дахь илтгэл, Улаанбаатар, 2014 он.
4. Хүний Эрхийн Үндэсний Комисс, Монгол улс дахь Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 22 дахь илтгэл, 2023,
5. МУИС-ийн Үндсэн хуулийн эрх зүй хүрээлэн, Үндсэн хууль манай сургууль, НҮБ-ын Хүний эрхийн хороодын ерөнхий тайлбар, сургалтын хөтөлбөр, 2022.



6. Нээлтэй Нийгэм Форум, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх явцад учирсан хохирлын нөхөн төлүүлэлт, шүүхийн шийдвэрийн дүн шинжилгээ, 2021.
7. Б.Эрдэнэбат, Б.Эрдэнэбилэг, Эрүүгийн хэргийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрийн дүн шинжилгээ, 2022.
8. Хууль зүйн үндэсний хүрээлэн, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээ (судалгааны тайлан), 2018.
9. Б.Эрдэнэбат, Эрүүгийн процессын шуурхай байх зарчим, эрх зүйн орчин, хэрэгжилт, хууль зүйн докторын зэрэг горилсон бүтээл, 2023.
10. Улсын Дээд Шүүх, Эрүүгийн хэргийг прокурорт буцаах шүүхийн эрх хэмжээ, Улаанбаатар, 2018, <http://old.supremecourt.mn/news/404>.
11. Б.Дашням "Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд мөрдөгчийн бие даасан байдлыг нэмэгдүүлэх нь" (2023), legaldata.mn.
5. UN, Human Rights Committee., International covenant on civil and political rights., Article 9 (Liberty and security of person)., General Comment No.35., dated December 16, 2014, <https://www.ohchr.org/en/calls-for-input/general-comment-no-35-article-9-liberty-and-security-person>.
6. UN, Human Rights Committee., International covenant on civil and political rights., Article 14: Right to equality before courts and tribunals and to a fair trial., General Comment No.32, dated August 23, 2007, https://tbinternet.ohchr.org/_layouts/15/TreatyBodyExternal/Download.aspx?symbolno=CCPR%2FC%2FGC%2F32&Lang=en.
7. Human Rights Institute, Southwest University of Political Science and Law, Estifanos Balew Liyew., Accused person's speedy trial rights in Ethiopia's criminal proceedings: theory and practice., May 21, 2024, https://www.researchgate.net/publication/380969380_Accused_persons'_speedy_trial_rights_in_Ethiopia's_criminal_proceedings_theory_and_practice.
8. Miodrag Simovic., Marina Simovic., Criteria for Assessing the Violation of the Right to a Trial Within a Reasonable Time., dated July 10, 2021, <https://www.gfpn-au.com/sites/default/files/GFPN-11-11/Godisnjak-11-105-116.pdf>.
9. Jiri Mulak., Principle of the Speed of proceedings and right to an

Гадаад эх сурвалж

1. International Covenant on Civil and Political Rights, 1976
2. U.S.Department of Justice, Speedy Trial Act, 1974
3. UK, Police and Criminal Evidence Act 1984
4. German, Code of Criminal Procedure, 1987
5. Jiri Mulak., Principle of the Speed of proceedings and right to an



adequate length of the criminal proceedings., 2021/II/4, https://papers.ssrn.com/sol3/papers.cfm?abstract_id=3849244.

10. Raimundas Jurka, New Insights into the Procedure within a Reasonable Time as a Legal Principle, 2010.
11. Dr. Oudha yousif Salman., "Right of the accused to be tried within a reasonable period in the Iraqi and comparative criminal legislation",

2022.

12. Cesare Bonesana di Beccaria, An Essay on Crimes and Punishments, 1764.

Эрх зүйн эх сурвалж

1. Монгол улсын Үндсэн хууль (1992)
2. Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт (1966/1976)
3. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль (2017)



Abstract

PRINCIPLE OF INVESTIGATING THE CASE WITHIN A REASONABLE SHORTEST TIME IN CRIMINAL PROCEDURE

B.NARANTSETSEG

*Master's student, School of Law, NUM
Lawyer, advocate*

G.AMARJARGAL

Researcher, Fidelitas Partners LLP

The main goal of the criminal procedure is to promptly and fully detect the crime, and investigating the case in the reasonable shortest time is the legitimate right of the participants of the criminal case, including not only the accused, the defendant, but also the victim. The principle of speedy investigation of the case in the reasonable shortest time in the criminal procedure is definitely one of the basic principles that must be present in the criminal procedure. Therefore, the importance and nature of

this principle was determined by studying whether this principle is reflected in the criminal procedure of Mongolia, how it is implemented, and the need for further implementation.

Keywords

principle of investigating the case within a reasonable shortest time, implementation of principle, human rights, reasonable time

**1992 ОНЫ ҮНДСЭН ХУУЛЬ БАТЛАГДАХААС ӨМНӨХ
МОНГОЛ УЛСЫН ПАТЕНТЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН
ТҮҮХЭН ХӨГЖИЛ**

Б.Одгэрэл¹

- I. Оршил
- II. Патентын эрх зүйн зохицуулалт (1944-1978)
- III. Патентын эрх зүйн зохицуулалт (1978-1992)
- IV. Дүгнэлт
- V. Ном зүй

¹ Дотоод хэргийн их сургуулийн докторант.



1992 ОНЫ ҮНДСЭН ХУУЛЬ БАТЛАГДАХААС ӨМНӨХ МОНГОЛ УЛСЫН ПАТЕНТЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ТҮҮХЭН ХӨГЖИЛ

Б.ОДГЭРЭЛ, Дотоод хэргийн их сургуулийн докторант.

Түлхүүр үг

Шинэ бүтээл, оновчтой санал, зохиогчийн гэрчилгээ, онцгой эрхийн бичиг, патент, эрх зүйн зохицуулалт.

Хураангуй

Дэлхий дахинаа патентын эрх зүйн тогтолцоо 1470 оноос үүсэж эхэлсэн гэж үздэг бөгөөд ингэхдээ шинээр үйлдвэрлэлд нэвтэрч байгаа шинэ мэдлэг нь эд баялгийг бий болгодог болохыг онцолж, энэ мэдлэгийг хамгаалснаар зохион бүтээсэн зүйлээ өөрөө захиран зарцуулах эрхийг олгож, зохион бүтээгчийн зөвшөөрөлгүй ашиглалтаас хамгаалах буюу шинэ санаа сэдэгчдийн эрхийг хамгаалж, шударга бус өрсөлдөөнөөс сэргийлэх шаардлагын улмаас хөгжиж ирсэн байна. Үндсэндээ патентын эрх зүйн тогтолцоогоор шинэ зүйлийг зохион бүтээсэн хүнд тодорхой хугацаанд түүнд олгосон эрхийн хүрээнд бүтээлээ ашиглах, түүний зөвшөөрөлтэй нийгмийн бусад этгээд ашиглах эрхийг олгодог. Манай улсын хувьд төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн үед буюу 1940-өөд онд энэхүү нийгмийн харилцааг зохицуулж эхэлсэн байх бөгөөд бүх материаллаг нөөц нь нийтийнх байсан үеийн зохицуулалтаас 1992 оны Үндсэн хуулиар хувийн өмчийг хүлээн зөвшөөрч,

оюуны бүтээлийг өмчлөх, хамгаалахад чиглэсэн зохиогч өөрийн туурвисан, зохион бүтээсэн бүтээлийнхээ үр шимийг чөлөөтэй хүртэх тогтолцоонд шилжих хүртэлх эрх зүйн тогтолцооны түүхэн хөгжлийг онол, практикийн хувьд судлах шаардлага тулгарч байна гэж үзэв. Социалист эрх зүйн тогтолцоотой, хувийн өмчийн эрхийг хүлээн зөвшөөрдөггүй нийгмийн тогтолцооны хувьд олон улсад хэдэн зуун жилийн өмнө тогтсон хувийн өмчид суурилсан патентын тогтолцооны үүсэл хөгжлөөс түүхэн хөгжлийн хувьд Монгол улсын патентын эрх зүйн зохицуулалт онцлогтой.

Энэхүү өгүүлэлд патентын эрх зүйн зохицуулалтын түүхэн хөгжлийг Монгол улсад шинэ бүтээл, оновчтой саналыг бүртгэж, зохиогчийн гэрчилгээ олгож эхэлсэн үеэс буюу 1944 оноос 1992 оны Үндсэн хууль батлагдах хүртэлх үеийг хамруулж, улмаар 1944-1978, 1978-1992 онуудад үечлэн судалсан. Цаашид 1992 оны Үндсэн хуулиар хувийн өмчийг хүлээн зөвшөөрсний дараа зохиогч өөрийн бүтээсэн, зохион бүтээсэн бүтээлийнхээ үр шимийг чөлөөтэй хүртэх тогтолцоонд шилжсэнээс хойших патентын эрх зүйн тогтолцооны түүхэн хөгжлийг үргэлжлүүлэн судлах шаардлагатай.



I. Оршил

Патентыг ерөнхийдөө оюуны өмч болохыг баталгаажуулж төрөөс олгодог баримт бичиг гэж тодорхойлох боломжтой. Нэр томъёоны хувьд патентыг шинэ бүтээлд шууд хамааруулдаг¹ ба энэ зүй тогтлыг 1883 оны Аж үйлдвэрийн өмчийг хамгаалах тухай Парисын конвенцод² аж үйлдвэрийн өмчийн эрхэд патентаар шинэ бүтээлийг төлөөлүүлэн заасантай холбож үзэх боломжтой юм. Энэ жишиг тогтолцоо олон улсад хэвшсэнийг харгалзан энэхүү судалгааны ажилд патентаар шинэ бүтээлийн патентыг төлөөлүүлэн авч үзсэн. Монгол улсад оюуны бүтээл туурвигчдын эрхийг хамгаалах харилцааг зохицуулсан анхны эрх зүйн баримт бичиг нь БНМАУ-ын Ардын Сайд нарын Зөвлөлийн 1944 оны 5 дугаар сарын 19-ны өдрийн 63 дугаар хурлын тогтоолоор батлагдсан “Шинэ юм зохион олох ба үйлдвэрт оновчтой сайн санал гаргагчдыг шагнаж урамшуулах тухай заавар” бөгөөд шинэ бүтээл, оновчтой санал (ШБОС) бүртгэх, ШБОС гаргагчдад эрхийн бичиг олгох, үйлдвэрлэлд нэвтрүүлэх болон мөнгөн шагнал олгох харилцааг зохицуулжээ.³ Энэхүү түүхэн зохицуулалтаас БНМАУ-ын 1963 оны Иргэний хууль үйлчлэх хүртэл ШБОС буюу аж үйлдвэрийн бүтээлд зохиогчийн гэрчилгээг дангаар олгож байсан бол хуулиар шинэ бүтээлд зохиогчийн гэрчилгээ олгохоос гадна “онцгой эрхийн бичиг”⁴ олгох

шинэ зохицуулалтыг хуульчилжээ. Тус хуулийн VI хэсгийн 358 дугаар зүйлийн нэг дэх хэсэгт “Шинэ бүтээл зохиогч нэг бол өөрийгөө зөвхөн шинэ бүтээлийн зохиогч гэж зөвшөөрөн хүлээх, эсхүл тийнхүү зохиогч гэж зөвшөөрөн хүлээж, уул шинэ бүтээлийн талаар онцгой эрхийн бичиг олгохыг өөрийн үзэмжээр шаардаж болно” хэмээн зохицуулжээ. Энэ заалтын дагуу шинэ бүтээлийн зохиогч хүсвэл зохиогчийн гэрчилгээ эсхүл онцгой эрхийн бичгийг эзэмших агуулгаар хуульчилжээ. Улмаар БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 1970 оны 415 дугаар тогтоолын хавсралт “Нээлт, шинэ бүтээл, оновчтой саналын дүрэм”⁵-д шинэ бүтээлийг хамгаалах хэлбэрийг гэрчилгээ эсхүл патент гэж зохицуулсан байна. Энд хувийн өмчийг хүлээн зөвшөөрөөгүй байсан нийгмийн харилцааны хувьд онцгой эрхийн бичиг буюу патент нь шинэ бүтээлээ чөлөөтэй захиран зарцуулах эрхийн хүрээнд олгогдсон эсэх нь эргэлзээтэй юм.

Төрөөс шинэ бүтээл болохыг тодорхойлж өмчлөх эрхийг баталгаажуулсны үндсэн дээр патентыг олгодог. Патент нь патент олгосон шинэ бүтээлийн бүтээгдэхүүн, арга ажиллагааг ашиглан үйлдвэрлэл эрхлэх, худалдаанд нэвтрүүлэх, худалдаалахаар санал болгох, импортлохыг таслан зогсоох, түүнээс сэргийлэх онцгой эрх олгодог байна.⁶ Нэр томъёоны хувьд патент нь “нээлттэй (opened)” гэсэн утгатай “Patens”

¹ Оюуны өмчийн газар, Оюуны өмчийн үндсэн асуудал, орч. Б.Одгэрэл, З.Гэрэлмаа, 2021, 21 дэх тал.

² Монгол Улс 1984 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр соёрхон баталсан, 1 дүгээр зүйл (2).

³ Оюуны өмчийн газар, Монгол улсын оюуны өмчийн байгууллагын үүсэл хөгжил, 2007, 4-5 дахь тал.

⁴ З.Сүхбаатар, Б.Батбаяр, П.Оюундэлгэр, Монгол

улсын иргэний хууль тогтоомж (Түүхэн эмхэтгэл) 1206-2012 он, 2012, 200 дэх тал.

⁵ БНМАУ-ын Үндэсний хөгжлийн яамны Патент, барааны тэмдгийн газар, Шинэ бүтээл, оновчтой саналын талаарх хууль тогтоомжийн эмхэтгэл (1960-1975), 1980, 14 дэх тал.

⁶ Оюуны өмчийн газар, Ирээдүйг бүтээхүй (Жижиг, дунд үйлдвэрлэлд зориулсан патентын танилцуулга), орч.Б.Одгэрэл, 2009, 3 дахь тал.



(патенс), “нээлтэй бичиг” буюу “Litterae Patents” гэдэг латин үгнээс гаралтай, монгол хэлэнд буулгавал “Онцгой эрхийн бичиг”⁷ гэх мэт гарал үүслийн хувьд ижил төстэй тодорхойлолтууд илэрч байна. Зохиогчийн гэрчилгээний талаар судлаачид бүтээлдээ дурдсан байдаг. З.Намжил⁸ патентын эрх зүйг шинэ тогтолцоо болохыг аж үйлдвэрийн өмчийн үндсэн объектод патент биш зохиогчийн гэрчилгээ олгож байсантай холбож тодорхойлсон бол, Д.Дэмбэрэл нар⁹ улсаас зохиогчийн гэрчилгээтэй шинэ бүтээлийн ашиглалт, нэвтрүүлэлтийг хариуцдаг байсан тухай тус тус бүтээлүүддээ дурджээ. С.Нарангэрэл нар¹⁰ 1993 он хүртэлх зохиогчийн эрх зүйн эх сурвалжаар иргэний хуулийг нэрлэсэн байна. ШБОС зохиогчийн эрхийг баталгаажуулж олгож байсан зохиогчийн гэрчилгээ зохиогчийн эрхийн хүрээнд үйлчилдэггүй, зөвхөн түүний нэг бүрэлдэхүүн хэсэг болох эд хөрөнгийн бус эрх буюу амины эрхийг хангаж байжээ. Онцгой эрхийн бичиг болохын хувьд патент нь шинэ бүтээлээ чөлөөтэй ашиглах эдийн засгийн агуулгаар ашиглагддаг, харин социалист өмчтэй нийгмийн харилцаанд энэ агуулгаар хэрэгжээгүй байна. Монгол улсын патентын эрх зүйн зохицуулалт социалист өмчтэй байсан нийгмийн тогтолцооны хувьд хэдэн зуун жилийн өмнө үүссэн дэлхий нийтийн патентын эрх зүйн тогтолцооны үүсэл хөгжлөөс түүхэн хөгжлийн хувьд онцлогтой байна.

⁷ Д.Дэмбэрэл, Г.Гомбо, Ц.Батжаргал, Шинэ бүтээлийн патент, 2000, 11 дэх тал.

⁸ З.Намжил, Патент-Эрх зүйн оньс, 2000, 8 дахь тал.

⁹ Д.Дэмбэрэл, Г.Гомбо, Ц.Батжаргал, Шинэ бүтээлийн патент, 2000, 31 дэх тал.

¹⁰ С.Нарангэрэл, Н.Тэмүүлэн, Зохиогчийн эрхийн тулгуур асуудал, 2008, 45 дахь тал.

Үндсэн хуулиар хувийн өмчийг хүлээн зөвшөөрч хуульчлан баталгаажуулахаас өмнөх түүхэн цаг үед аж үйлдвэрийн бүтээлд зохиогчийн гэрчилгээ, патентын аль нэгийг олгож¹¹ байсан эрх зүйн тогтолцооны талаар судалгаа илрэхгүй, шинэ дутмаг ойлголт байх тул патентын эрх зүйн тогтолцооны түүхэн хөгжлийн хүрээнд хамааруулан судалгааг хийхийг зорьсон.

II. Патентын эрх зүйн зохицуулалт (1944-1978)

Монгол улсад оюуны бүтээл туурвигчдын эрхийг хамгаалах харилцааг зохицуулсан анхны эрх зүйн баримт бичиг болохын хувьд БНМАУ-ын Ардын Сайд нарын Зөвлөлийн 1944 оны 5 дугаар сарын 19-ны өдрийн 63 дугаар хурлын тогтоолоор “Шинэ юм зохион олох ба үйлдвэрт оновчтой сайн санал гаргагчдыг шагнаж урамшуулах тухай заавар” нь шинэ юм зохион олсон, оновчтой санал гаргагчдад шагнал олгох, бүртгэх, зохиогчид эрхийн баримт бичиг олгох, үйлдвэрлэлд нэвтрүүлэлт, ашиглалтыг анхлан журамлажээ.¹² Шинэ юм гэдэг нь шинэ бүтээлийн хүрээнд журамлагдсан болохыг энд онцлон тэмдэглэжээ. БНМАУ-ын Ардын Сайд нарын Зөвлөлийн хурлын тогтоол хуулийн нэгэн адил хүчин чадалтай, заавал биелэгдэх шинжтэй хэм хэмжээ мөн. 1940 оны Үндсэн хуулийн хорин долдугаар зүйлд “Бүгд Найрамдах Монгол Ард Улсын засгийн гүйцэтгэх ба захирах дээд газар нь Бүгд Найрамдах

¹¹ БНМАУ-ын Үндэсний хөгжлийн яамны Патент, барааны тэмдгийн газар, Нээлт, шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, оновчтой саналын тухай БНМАУ-ын хуулийн төсөлд холбогдуулан хийсэн зарим тайлбар, судалгаа, 1991, 6 дахь тал.

¹² Оюуны өмчийн газар, Монгол улсын оюуны өмчийн байгууллагын үүсэл хөгжил, 2007, 4-5 дахь тал.



Ард Улсын Сайд нарын Зөвлөл болно”, гучдугаар зүйлд “Бүгд Найрамдах Ард Улсын Сайд нарын Зөвлөлөөс гаргасан тогтоол, тушаалуудыг Бүгд Найрамдах Ард Улсын бүх дэвсгэр дотор заавал дагаж гүйцэтгүүлбэл болно” гэж хуульчилсан байна. ШБОС гаргагчдын эрхийг хамгаалах, бүртгэлжүүлэх харилцааг уг тогтоолоор зохицуулснаас гадна ШБОС үйлдвэрлэлд нэвтрүүлэх, ашиглалтыг төр хариуцаж, зохицуулж байсан нь социалист эрх зүйн бүлд хамаарах төр засгийн бодлогын нийтлэг шинжийг илтгэж байна. Социалист эрх зүйн бүлд хамаарах төрийн үндсэн шинж социалист өмчийн тогтолцоогоор илэрдэг¹³ бөгөөд энэ түүхэн цаг үед төр засгаас хөдөлмөрийн хөдөлгөөнд шинийг санаачлах хөдөлгөөнийг зохион байгуулах, өрнүүлэх, техникийн бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэхэд чиглэсэн төр засгийн тогтоол шийдвэрүүд голлож, оюуны бүтээл туурвигчдын бүтээл нь нийтийн өмч болж, зохиогч өөрийн бүтээлтэй холбоотой эрх эдэлдэггүй байжээ.

Энэ түүхэн үед зохиогчид шагнал, урамшуулал өгч, улмаар зохиосон бүтээл нь нийтийн өмч болдог байсан, зохиогч өөрийн зохион бүтээсэн бүтээлтэй холбоотой ямар нэг эрх эдэлдэггүй байжээ. Энэхүү нийгмийн зүгээс хүний оюун ухаанаас гарсан бүтээлтэй хандах хандлагыг Н.Чинбат¹⁴ “нийгмийн буюу нийтийн мэдлийн” гэж тодорхойлсон байх бөгөөд 1930-1990 оны хооронд энэхүү үзэл баримтлалд тулгуурласан эрх зүйн зохицуулалт үйлчилж, бүтээлийн

үр шимийг нийгэм хүртэж, зохиогчийг урамшуулах, улмаар бүтээлийг ашиглах асуудал төр засгийн бодлогын үндэс болж хөгжиж, оюуны өмч сонгодог утгаараа энэ цаг үед оршин тогтоогүй гэж оновчтой тодорхойлсон байна. Энэ үед иргэдийн туурвисан оюуны бүтээл улсын мэдэлд байж, ашиглалтыг улс хариуцаж, зохиогчдод шан хөлс өгөх замаар шинэ санаачилгыг өрнүүлж, хөдөлмөрчдийн сэтгэн бүтээх урам зоригийг дэмжиж иржээ. Оюуны бүтээлийн ашиглалтыг улс хариуцах нь үйлдвэрлэлийн хувьд өрсөлдөөнд суурилагагүй улсын хэрэгцээг хангахад чиглэж, зах зээлийн хөгжлийг хангахад чиглэдэггүй. Оюуны бүтээл туурвигчдыг төр засгаас хөхүүлэн дэмжих, урамшуулах, алдаршуулах арга замыг өнөөг хүртэл сонгож ашигласаар байгаа хэдий ч оюуны бүтээл туурвигчдад бүтээлээ ашиглах эрх олгодог өрсөлдөөнд суурилсан тогтолцоотой харьцуулах боломжгүй нийгмийн тогтолцоо байжээ. Гэхдээ оюуны өмч бүтээгч нь шинэ санаачилга гаргагч болох тухай хэлэлцэж эхэлсэн цаг байсныг онцлох нь зүйтэй бөгөөд төрийн бодлогын хүрээнд “Шинийг санаачлагчдын хөдөлмөр бол нийгэмд оюуны өмчийн цаглашгүй ундраг болж байдаг билээ. Манай шинийг санаачлагчид бол тийм өвөрмөц өгөөжтэй онцгой үйлстэн”¹⁵ болохыг онцолж эхэлсэн цаг үе байв.

Түүхэн цаг үеийн нийгмийн харилцаанд шинийг санаачлах хөдөлгөөнийг өрнүүлэх, техникийн бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэхэд уралдаан, шагнал, урамшуулалд онцгойлон

¹³ Б.Буянхшиг, Монголын өмчийн тогтолцооны шилжилт, 2023, 37 дахь тал.

¹⁴ Н.Чинбат, Иргэний эрх зүй лекцийн товчоон (Ерөнхий анги), 2014, 208 дахь тал.

¹⁵ Монголын шинийг санаачлагчдын нийгэмлэгийн зөвлөл, Монголын шинийг санаачлагчдын нийгэмлэгийн III их хурлын материал, 1988, 113 дахь тал.



анхаарал хандуулж, тухайлбал БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 1946 оны 6 дугаар тогтоолоор “Чойбалсангийн нэрэмжит шагнал”¹⁶, 1963 оны 172 дугаар тогтоолоор “Шинийг санаачлагч” энгэрийн тэмдэг, 1986 оны 238 дугаар тогтоолоор “БНМАУ-ын Шилдэг зохион бүтээгч” цол тэмдэг,¹⁷ Монголын шинийг санаачлагчдын нийгэмлэгийн зөвлөлийн тэргүүлэгчдийн хурлын 1975 оны 4 дүгээр хурлын тогтоолоор “ШБОС” тэмдэг¹⁸ шагнах журам мөн социалист уралдаан зохион байгуулах, хоёр жил тутам шинэ бүтээл, оновчтой саналын ажлын улсын үзлэг явуулж, шалгарсан бүтээлээр шинэ санаачилгын үзэсгэлэн зохион байгуулах, хүүхэд залуучуудын бүтээлийн үзэсгэлэн гаргах, шинийг санаачлагчдын хөдөлгөөн өрнүүлэх, бага болон их хурал, улсын зөвлөгөөн зохион байгуулах, аймгийн аварга шинийг санаачлагч шалгаруулах зэргээр хөдөлмөрчдийн бүтээлч сэтгэлгээг дэмжиж байв. Шинийг санаачлагч, оюуны бүтээл туурвигчдын нийгмийн үйлдвэрлэлийн хөгжилд үзүүлэх үр нөлөөг чухалчлан, тэдгээрийн шинийг санаачлах урам зориг, идэвх зүтгэлийг өдөөн, урамшуулахад зохиогчийн гэрчилгээ олгох асуудал чухал үүрэг гүйцэтгэсэн байна.

Монгол Улсын анхдугаар Үндсэн хуульд (1924) “Бүгд Найрамдах Монгол Ард Улсын хязгаарын дотор бүхий газар ба уурхай хийгээд ой мод, ус ба мөн тэдгээрийн баялгууд бол эрт цагаас нааш

¹⁶ Оюуны өмчийн газар, Монгол улсын оюуны өмчийн байгууллагын үүсэл хөгжил, 2007, 5 дахь тал.

¹⁷ Патентын газар, Патентын тухай хууль тогтоомжийн эмхэтгэл, 1994, 22-23 дахь тал.

¹⁸ Монголын шинийг санаачлагчдын нийгэмлэгийн зөвлөл, Шинийг санаачлагчдын нийгэмлэгийн ажлын талаарх тогтоол дүрэм, зааврын эмхэтгэл 1972-1979, 1980, 63 дахь тал.

ард нийтийн хөрөнгө байсаар ирсэн зан суртал нь чухам одоогийн ард улсын ёсонд нийлэлцэх тул энэхүү хөрөнгө бүрнээс ардын мэдэлд байвал зохих бөгөөд энэ тухай хувийн өмч байгуулж үл болно”¹⁹, хоёрдугаар Үндсэн хуулийн (1940) тавдугаар зүйлд “Бүх газар шороо ба түүний хөрсөн доорх зүйлүүд, ой мод, ус ба тэдгээрийн баялаг, фабрик, завод, төмөрлөгийн уурхай, алт боловсруулах явдал, төмөр, авто тээврийн зам, усан ба агаарын тээвэр, холбоо харилцааны хэрэгсэл, банк, машинаар өвч хадах станц, улсын аж ахуйнууд нь улсын өмч буюу нийт ардын хөрөнгө мөн болно. Эдгээрийг өмчийн хөрөнгө болгож үл болно”, зургаадугаар зүйлд “Ард иргэнээс мал ба хөдөө аж ахуйн багаж зэвсэг хийгээд үйлдвэрлэлийн бусад багаж зэвсэг, түүхий эд, мөн боловсруулсан үйлдэхүүн, орон сууц, хашаа, барилга, гэр хогшил, орлого зэргийг өмчлөх эрх ба түүнчлэн хувийн өмчийг өмчлөх эрхийг хуулиар хамгаална”²⁰ хэмээн хуульчилжээ. Зохиогчийн эрхийн хууль тогтоомжийн зохицуулалт байхгүй байсан учир аж үйлдвэрийн бүтээлд зохиогчийн гэрчилгээ өгч байсныг БНМАУ-ын 1952 оны Иргэний хуулиар шийдвэрлэхийг зорьж, дэлхийн жишгийг дагаж оюуны бүтээлийг төрөлжүүлэн хөгжүүлэх эхлэлийг тавьжээ. Хуулийн арван наймдугаар бүлэгт “Зохиогчийн эрх”, арван есдүгээр бүлэгт “Зохион бүтээсэн зүйлийн эрх”-ийг тусад нь хуульчилсан нь зохиогчийн эрхийн гэрчилгээ олгож байсан шинэ бүтээлийн зохицуулалтыг зохиогчийн эрхийн бүтээлээс салгасан

¹⁹ 1924, 1940, 1960, 1992 оны Үндсэн хуулиуд, 2007, 8 дахь тал.

²⁰ 1924, 1940, 1960, 1992 оны Үндсэн хуулиуд, 2007, 25 дахь тал.



шинэ зохицуулалтыг бий болгож, зохиогчийн эрхийн бүтээлийн хүрээг дэлхий нийтийн хөгжлийн чиг хандлагад нийцүүлж журамласан гэж дүгнэх боломжтой байна. Энд зохиогчийн эрхийн харилцаанд “Утга зохиол, шинжлэх ухаан, урлагийн зүйлийг зохиосон хүн түүндээ эзэн болохыг зохиогчийн эрх гэж, бүтээл, (ном, өгүүлэл, утга зохиолын эмхэтгэл, бичсэн лекц, хэлсэн үг, илтгэл зэрэг) хөгжим, жүжгийн зохиол, киноны зохиол, уран зураг архитекторын бүтээл, баримал бүтээл, газар зүйн зураг, кино лент, гэрэг зургийн бүтээл, өөр хэл дээр оруулсан утга зохиолуудыг хамааруулж, зохиогчийн эрхийг тэрхүү зохиолыг бүтээсэн хүн эдэлнэ”²¹ гэж хуульчилжээ.

Зохион бүтээсэн зүйлийг “Аливаа нэгэн техникийн зорилтыг бүтээлч ёсоор шийдвэрлэснийг зохион бүтээсэн зүйл гэх ба заавал үйлдвэр дээр ашиглаж болох бөгөөд техникийн талаар биелэгдэх санал, БНМАУ-д буюу гадаад улсуудад бүрэн буюу үндсэн хэсгүүд нь урьд хэвлэгдэж нийтлэгдээгүй бөгөөд хүний мэддэг зүйлийг дуурилган үйлдээгүй, ил хэрэглээгүй байсан, заавал шинэ зүйл байх болно”²² гэж анхлан хуульчилжээ. Иргэний хуулийн эдгээр заалт шинэ бүтээлд патент олгоход тавигддаг олон улсын эрх зүйн хэм хэмжээн хүрээнд боловсруулагдсан байх бөгөөд үндсэндээ техникийн асуудлыг техник шийдлээр шийдсэн үйлдвэрлэлд ашиглагдах боломжтой зүйл байх бөгөөд өмнө нь дэлхийн хаа нэгтээ хэвлэгдэж нийтлэгдээгүй, өмнө байгаагаас ялгаатай

²¹ З.Сүхбаатар, Б.Батбаяр, П.Оюундэлгэр, Монгол улсын иргэний хууль тогтоомж (Түүхэн эмхэтгэл) 1206-2012 он, 2012, 114 дэх тал.

²² З.Сүхбаатар, Б.Батбаяр, П.Оюундэлгэр, Монгол улсын иргэний хууль тогтоомж (Түүхэн эмхэтгэл) 1206-2012 он, 2012, 116 дахь тал.

шинэ байх асуудлыг олон улсын патентын эрх зүйн хөгжлийн чиг хандлагад нийцүүлэн томъёолсон хэдий ч патент гэдэг үгийг хэрэглээгүй байна. Өмчийн төрлийн хувьд хуулийн 31 дүгээр зүйлд “улсын өмч, хоршооллын ба бусад олон нийтийн байгууллагын өмч, ард иргэдийн амины өмч” байхаар хуульчилсан нь патент гэж тодорхойлох нөхцөл бүрдээгүй нийгмийн харилцаа байжээ. Патент нь дээр дурдсанчлан хувийн өмч гэдэг утгаар ашиглагдах тул хувийн өмчийг хүлээн зөвшөөрөх нийгмийн харилцаанд шилжээгүй байсантай холбон тайлбарлах боломжтой юм. Харин “зохион бүтээгч” гэдэг нэр томъёог шинээр томъёолж хэрэглэсэн нь зохиогчийн эрхийн зохиогч гэдгээс ялгамжтай, оновчтой тогтоосон байна. Зохион бүтээсэн зүйлд зохиогчийн гэрчилгээ олгосон хэвээр зохицуулагдсан байх бөгөөд хуулийн арван есдүгээр бүлгийн 293-д “зохион бүтээгч нь зохион бүтээн гаргасан зүйлдээ өөрийн эрхийг, нотлон авахыг хүсвэл, тэрхүү шинэ бүтээлийн зургийг зохих яаманд мэдэгдэж, бүтээсэн зүйлдээ өргөдөл оруулах журмаар гүйцэтгэх ёстой” хэмээн зохиогчийн гэрчилгээ авах асуудлыг хуульчилжээ.

Зохиогчийн эрх эдлэх эрхийг “Өөрийн зохиолыг өөрийн нэрээр буюу зохиомол нэрээр гаргах; зохиолдоо засвар оруулах; өөрийн зохиолыг зохиомжтойгоор хэвлүүлэн нийтлүүлэхийн тулд санаачилга тавьж, энэ тухай хэвлэн нийтлэх ба тайзан дээр тоглохыг гүйцэтгэх тусгай газруудтай хэвлэн нийтлэх, тайзан дээр гаргах мөн утга зохиолын захиалга хийх гэрээ байгуулах; хэрэв зохиолоо эзэмшин мэдэх эрхийг зөрчсөн явдал гарвал уул эрхийг иргэний нэхэмжлэлийн журмаар



хамгаалуулж олж авах буюу эсхүл эрхийг зөрчсөн гэмт этгээдийг эрүүгийн журмаар мөрдүүлэн шийтгүүлэхээр шүүхэд мэдүүлэх эрхтэй болно²³ гэж зохицуулсан бол зохион бүтээгчийн эрхийг “хэн нэгэн этгээдээс зөрчвөл эрхээ олж авахаар иргэний журмаар шүүхэд мэдүүлэх буюу түүнчлэн түүний эрхийг зөрчсөн этгээдийг эрүүд татахыг шаардаж болно²⁴ гэж амины эрх эдлэхээс өргөн хүрээтэй зохицуулсан нь социалист өмчтэй байсан нийгмийн тогтолцооны үед онцлог зохицуулалт гэж үзэх үндэслэлтэй байна. Социалист өмчтэй нийгмийн тогтолцооны хувьд шинэ бүтээл зохиогчийг урамшуулан шагнах, зохиосон бүтээл нь нийгмийн өмч болдог байсан зохицуулалтад төвлөрч байсан хэдий ч шинэ бүтээлийг хамгаалах асуудлыг өрсөлдөөнд суурилсан байдлаар зохицуулсан нь агуулгын хувьд социалист өмчийг баримтлах нийгмийн бодлоготой зөрчилдсөн гэж тодорхойлж болох хэдий ч зүй тогтлын хувьд дэлхийн хөгжлийн нийтлэг чиг хандлагатай хөл нийлүүлэх том алхмыг хийжээ.

Улмаар “Нээлт, шинэ бүтээл, оновчтой саналын тухай дүрэм, заавар”-ыг шинэчлэн 1960 оны 5 дугаар сарын 17-ны 237 дугаар тогтоолоор баталж, нээлт, шинэ бүтээл, оновчтой саналын тухай дүрэм, тэдгээрийг гаргагчдыг шагнах журмын тухай зааврыг баталж шинэ бүтээл, оновчтой санаачилгын ажлыг удирдах улсын комиссын бүрэлдэхүүнийг томилсон байх бөгөөд шинэ бүтээлд зохиогчийн гэрчилгээ эсвэл патент олгох

²³ З.Сүхбаатар, Б.Батбаяр, П.Оюундэлгэр, Монгол улсын иргэний хууль тогтоомж (Түүхэн эмхэтгэл) 1206-2012 он, 2012, 115 дахь тал.

²⁴ З.Сүхбаатар, Б.Батбаяр, П.Оюундэлгэр, Монгол улсын иргэний хууль тогтоомж (Түүхэн эмхэтгэл) 1206-2012 он, 2012, 117 дахь тал.

асуудлыг хүсэлтийн дагуу шийдвэрлэхээр зохицуулжээ. Монгол улсад нэг дугаарын зохиогчийн эрхийн гэрчилгээг 1961 оны 01 дүгээр сарын 13-ны өдөр зохиогч Т.Аюурзаны “Орхон үүлдрийн нарийвтар хонины ноост хонь” нэртэй шинэ бүтээлд олгож байжээ.²⁵

Гуравдугаар Үндсэн хуульд (1960) “Бүгд Найрамдах Монгол Ард Улсын эдийн загийн үндэс бол хөдөлмөрчид олон жил шаргуу тэмцэн, үйлдвэрлэлийн хэрэгслийг хувьдаа өмчлөх журмыг халж, хүн хүнээ мөлжих ёсыг устгасны үрээр тогтсон социалист системийн аж ахуй, үйлдвэрлэлийн хэрэгслийг нийтээр өмчлөх социалист өмч мөн”, “Бүгд Найрамдах Монгол Ард Улсын социалист өмч бол улсын (бүх ард түмний хөрөнгө), хоршооллын (хөдөө аж ахуйн нэгдэл ба бусад төрлийн хоршооллын хөрөнгө) ийм хоёр хэлбэртэй байна²⁶ гэж тус тус хуульчлан бататгажээ. Түүнчлэн арван тавдугаар зүйлд “...Ардын Их Хурлаар батлагдсан БНМАУ-ын улс ардын аж ахуйн төлөвлөгөө бол хууль мөн...” гэж мөн арван долоодугаар зүйлд “...БНМАУ-ын ард нийтийн орлогоос социалист үйлдвэрлэлийг өргөтгөх нөөц байгуулах, эрүүлийг хамгаалах, соёл боловсролыг хөгжүүлэх, нас хөгширсөн, хөдөлмөрийн чадваргүй болсон хүмүүсийг тэтгэх, түүнчлэн нийгмийн гишүүдийн хамтын бусад хэрэгцээг хангах нийгмийн фондод зориулагдах хэсгийг хасаад үлдэх бүх хувийг нийгмийн бүх гишүүдэд хийсэн ажлын хэр хэмжээгээр “Хүн бүр чадлынхаа хирээр хийж, хийснийхээ хэрээр

²⁵ Оюуны өмчийн газар, Аж үйлдвэрийн өмчийн мэдээллийн сан, Патент, [https://publish.ipom.mn/wopublish-search/public/patents?3&query=*.*](https://publish.ipom.mn/wopublish-search/public/patents?3&query=*)

²⁶ 1924, 1940, 1960, 1992 оны Үндсэн хуулиуд, 2007, 98 дахь тал.



авах” социалист зарчмыг баримтлан хөдөлмөрийн хөлс олгож хуваарилна. Бүгд Найрамдах Монгол Ард Улсад хөдөлмөр бол социалист өргөтгөсөн нөхөн үйлдвэрлэлийг хэрэгжүүлэх чухал нөхцөл, үндэс мөн бөгөөд хөдөлмөрчин олны чинээлэг аж байдлыг дээшлүүлэхэд хэрэглэгдэх эд материалын ба оюуны баялгийг бүтээх эх сурвалж мөн” хэмээн хуульчилжээ. Т.Сэнгэдорж²⁷ манай улсын эрх зүйн салбаруудын хөгжлийг 1960 оны Үндсэн хуульд хамаатуулсан байх бөгөөд төрөлжсөн хуулиудын гол эх сурвалж болох талаар дурджээ.

Шинэ санаачилгыг өрнүүлэх хүрээнд тогтоол шийдвэрүүдийг хэрэгжүүлэхэд ихээхэн анхаарал хандуулж байсны зэрэгцээ нийгмийн үйлдвэрлэлийг дэмжих бодлогын хүрээнд тогтоол шийдвэрүүдийг гаргаж байжээ. БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 1961 оны 12 дугаар сарын 635 дугаар “Шинэ санаачилгыг нэвтрүүлэх ажлыг сайжруулах зарим арга хэмжээний тухай”²⁸ тогтоолыг баталж, Улсын төлөвлөгөөний комисс ба яам, тусгай газруудад Улс ардын аж ахуйг хөгжүүлэх төлөвлөгөөнд ШБОС-д тулгуурлан үр дүнг нь тооцсон бүтээлүүдийг оруулах төлөвлөгөө боловсруулж, нэвтрүүлэлтийг сайжруулахыг даалгасан байна. Шинэ санаачлагчийг өрнүүлж, хөдөлмөрчдийн сэтгэн бүтээх урам зоригийг дэмжихийн зэрэгцээ шинжлэх ухаан үйлдвэрлэлийн холбоог хөгжүүлэхэд ШБОС гаргагчдыг удирдан зохион байгуулах үйл ажиллагаанд өндөр ач холбогдол өгч,

цар хүрээтэй ажлыг төлөвлөж хэрэгжүүлж иржээ.

БНМАУ нь Хүний эрхийн түгээмэл тунхаглалд²⁹ 1961 оны 10 дугаар сарын 27-ны өдөр нэгдэн орсон байх бөгөөд энэхүү тунхаглалд “Хүн бүр нийгмийнхээ соёлын амьдралд чөлөөтэй оролцох, урлагийн цэнгэлийг эдлэх, шинжлэх ухааны дэвшилд оролцож үр шимийг нь хүртэх эрхтэй.”, мөн зүйлийн 2-т “Хүн бүр өөрийн туурвисан шинжлэх ухаан, утга зохиол, уран сайхны бүтээлийн материаллаг болон ёс суртахууны эрх ашгаа хамгаалуулах эрхтэй”³⁰ гэж тус тус тунхаглажээ. НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас 1948 оны 12 дугаар сарын 10-ны өдөр баталсан Хүний эрхийн тунхаглал нь хүний салшгүй эрхийг анх удаа бүрэн цогцоор нь баталгаажуулсан түүхэн ач холбогдолтой баримт бичиг юм. БНМАУ туурвисан бүтээлийнхээ үр шимийг хүртэх, эдийн болон эдийн бус эрхээ хангуулах эрхийг тунхагласан олон талт хүний эрхийн гэрээнд нэгдэж орж, иргэдийнхээ өмнө эрх ашгийг нь хангах үүрэг хүлээжээ. Энэхүү тунхаглал хүний эрхийн суурь баримт бичигт тооцогддог бөгөөд нэгдэн орсон улс гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийн тулд үндсэн хууль, салбар хууль тогтоомжийг гэрээнд нийцүүлэх зайлшгүй шаардлагатай тулгардаг байна.³¹

Улмаар БНМАУ-ыг Иргэний хуулийн (1963) Иргэний эрх, үүрэг үүсэх үндэслэлд “нээлт, шинэ бүтээл, оновчтой санал, шинжлэх ухаан, утга зохиол, урлагийн

²⁷ Т.Сэнгэдорж, Монгол улсын төр, эрх зүйн үндэс, 1998, 78 дахь тал.

²⁸ Оюуны өмчийн газар, Монгол улсын оюуны өмчийн байгууллагын үүсэл хөгжил, 2007, 9 дэх тал.

²⁹ Төрийн мэдээлэл тусгай дугаар 1-р боть, 2004.

³⁰ Хүний эрхийн түгээмэл тунхаглал, 1961, Төрийн мэдээлэл тусгай дугаар 1-р боть 2004, 27 дугаар зүйл.

³¹ Ж.Амарсанаа, Хүний эрх, Олон улсын ба үндэсний эрх зүйн асуудал, 2000, 59-60 дахь тал.



бүтээл гаргах³², “улсын бүх эд хөрөнгийг өмчлөгч нь улс мөн³³” гэж заажээ. Өмчийн төрлийг хуулийн 59 дүгээр зүйлд “социалист өмч, амины өмч гэж ялгана” хэмээн зохицуулсан байна. Шинэ бүтээлийг хуулийн 357 дугаар зүйлд “Улс ардын аж ахуй соёл, эрүүлийг хамгаалах буюу улс орны батлан хамгаалахын аль нэг техникийн зориулалтыг шийдвэрлэсэн цоо шинэ зүйл зохион бүтээснийг шинэ бүтээл гэнэ” хэмжээн хуульчилжээ. 1963 оны иргэний хуулиар шинэ бүтээл цоо шинэ байх шалгуурыг оруулж ирсэн байгаа нь 1952 оны иргэний хуулийн шинэ байхаас огт ялгаатай зохицуулалт байна. Цоо шинэ буюу “Absolute novelty” гэх нэр томъёоны хувьд тухайн шинэ бүтээл дэлхийн хаа ч байхгүй байх нөхцөлийг хамааруулж болно. Энэ зохицуулалт нь шинэ бүтээлийн хувьд хаа нэг газраас хуулбарлаагүй, нэвтрүүлээгүй, сайжруулаагүй ерөөсөө л огт байгаагүй шинэ байх нөхцөл юм. Хуулийн 358 дугаарт зүйлд “зохиогчийн гэрчилгээ ба онцгой эрхийн бичиг”-ийг шинэ бүтээл зохиогч нэг бол өөрийгөө зөвхөн шинэ бүтээлийн зохиогч гэж зөвшөөрөн хүлээх, эсхүл тийнхүү зохиогч гэж зөвшөөрөн хүлээж, уул шинэ бүтээлийн талаар онцгой эрхийн бичиг олгохыг өөрийн үзэмжээр шаардаж болно, шинэ бүтээл зохиогч гэж зөвшөөрөх хүлээсэн бол зохиогчийн гэрчилгээ олгоно, зохиогч гэж зөвшөөрч онцгой эрх олгож байгаа бол онцгой эрхийн бичиг олгоно гэж заажээ. Түүнчлэн 359 дүгээр зүйлд зөвхөн зохиогчийн гэрчилгээ олгогдох шинэ бүтээлийг тусад нь хуульчилжээ. Энд

химийн бус аргаар бүтээсэн эмийн зүйл, амтлаг ба тэжээлийн бодисын талаар гагцхүү зохиогчийн гэрчилгээ болгох ба онцгой эрхийн бичгийг зөвхөн дээр бодисыг хийх аргын талаар олгож болно гэж зааглан ялгаж зохицуулсан байна. Түүнчлэн хөдөө аж ахуйн амьтад ба шувууны шинэ үүлдэр, хөдөө аж ахуйн ургамлын шинэ сортыг бий болговол зөвхөн зохиогчийн гэрчилгээ олгох гэх зэргээр ялгамжтай хуульчилжээ.

Албан үүргийн дагуу буюу байгууллагын даалгавраар эсхүл мөнгөн ба эд материалын тусламжийг улс, хоршооллын, олоннийтийн байгууллагаас авч шинэ бүтээл гаргасан бол онцгой эрхийн бичиг олгохгүй, зохиогчийн гэрчилгээ олгохоор хуульчилжээ. Улсын хөрөнгөөр бүтээл туурвих тохиолдолд зохиогчийн гэрчилгээ олгох асуудал нь онцгой эрхийн бичгийн хууль зүйн хүчин чадал өндөр байсныг илтгэж байна гэж дүгнэх боломжтой байна. Учир нь хуулийн 361 дүгээр зүйлийн онцгой эрхийн бичиг эзэмшигчийн эрхэд “...онцгой эрхийн бичиг эзэмшигчийн зөвшөөрөлгүйгээр түүний шинэ бүтээлийг хэн ч ашиглах эрхгүй. Онцгой эрхийн бичиг эзэмшигч нь шинэ бүтээлээ бусдад түр ашиглуулах зөвшөөрөл өгөх буюу онцгой эрхийн бичгийг бүрмөсөн шилжүүлж болно” гэж хуульчилсан нь онцгой эрхийн бичиг эзэмшигчид шинэ бүтээлээ өөрөө захиран зарцуулах эрхийг олгосон нь шинэлэг зохицуулалт байна. 1962 оны БНМАУ-ын Иргэний хууль улсын өмч, эд хөрөнгө, түүнтэй холбогдсон эд хөрөнгийн бус харилцааны олон төрөл, чиглэлийг зохицуулж байв. БНМАУ-ын Үндэсний хөгжлийн яамны Патент, барааны тэмдгийн газраас гаргасан

³² 1924, 1940, 1960, 1992 оны Үндсэн хуулиуд, 2007, 121 дэх тал.

³³ 1924, 1940, 1960, 1992 оны Үндсэн хуулиуд, 2007, 135 дахь тал.



судалгаанд³⁴ 1963-1990 онуудад нийт гадаад, дотоодын 538 шинэ бүтээл улсын бүртгэлд авснаас 95%-д нь зохиогчийн гэрчилгээ, 15%-д патент олгосон байна. Улсын бүртгэлд авсан шинэ бүтээлүүдийн хувьд бүхэлдээ аж үйлдвэрийн бүтээлд тухайлбал тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, технологийн арга, бодис, бичил биетний омог, малын үүлдэр, ургамлын сорт гэсэн ангилалд багтсан бүтээлд хамаарч байжээ. Хэдийгээр зохиогчид шинэ бүтээлдээ зохиогчийн гэрчилгээ эсвэл патент авах сонголтыг олгосон ч патентаар хамгаалагдах шинэ бүтээлийн хувьд зохиогчийн гэрчилгээг ихэвчлэн сонгож байжээ. Үүнийг зохиогчийн гэрчилгээг хугацаагүй, патентыг шинэ бүтээлийн анхдагчийг тогтоосон өдрөөс 15 жилийн хугацаатай олгож байсантай холбож тайлбарлаж болох юм.

Түүнчлэн БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 1970 оны 415 дугаар тогтоолын хавсралт “Нээлт, шинэ бүтээл, оновчтой саналын дүрэм”-ийн 23 дугаарт зохиогчийн гэрчилгээ нь “...шагнал авах болон бусад эрх, хөнгөлөлт эдлэх эрхтэй болохыг гэрчилсэн...”, патент нь “... патент эзэмшигчийн зөвшөөрөлгүйгээр уг бүтээлийг ашиглаж болохгүй гэдгийг гэрчилсэн эрхийн бичиг мөн” хэмээн ялгамжтай зохицуулагдсан байна. Энд патентын хувьд шинэ бүтээлээ лицензээр ашиглуулах, бүр бүрмөсөн шилжүүлэх эрх олгосон боловч эдгээр эрхүүдийг хэрэгжүүлээгүй тохиолдолд патентаа зохиогчийн эрхийн гэрчилгээгээр солих боломжийг олгосон нь олон улсад

³⁴ БНМАУ-ын Үндэсний хөгжлийн яамны Патент, барааны тэмдгийн газар, Нээлт, шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, оновчтой саналын тухай БНМАУ-ын хуулийн төсөлд холбогдуулан хийсэн зарим тайлбар, судалгаа, 1991, 6 дахь тал.

тогтсон патентын эрх зүйн хэм хэмжээ бүрэн хэлбэршээгүй байсан гэж дүгнэх боломжтой байна. Патентын хувьд патент эзэмшигчийн эрхийг зөрчихгүй тохиолдолд үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллага патент олгохоос өмнө шинэ бүтээлийг ашиглаж байсан эсхүл ашиглах нөхцөл бүрдүүлсэн тохиолдлыг хамруулсан нь патент эзэмшигчийн эрхийг оновчтой хязгаарласан заалт оруулжээ. Мөн патентыг Сайд нарын Зөвлөлийн шийдвэрээр албадан худалдан авч улсын байгууллагад ашиглуулахаар хуульчилсан байна. Энэ тохиолдолд тогтоосон журмын дагуу патент эзэмшигчид шагнал олгохоор заажээ. Зохиогчийн гэрчилгээ, патентын аль нэгийг зохиогчийн хүсэлтээр шинэ бүтээлд олгож байгаа нь тэдгээрийг нэг зохицуулалтаар зохицуулж байгаа гэсэн үг биш байх бөгөөд оюуны бүтээлүүдийн хувьд ялгаатай байдлаар хуульчилж, ялгамжтай ангилсан байна.

Улмаар ажлын байран дээр хөдөлмөрчдийн зохион бүтээх эрх ашгийг хамгаалах асуудлыг төрөөс хуулиар зохицуулж эхэлжээ. Шинийг санаачлагчдын хөдөлгөөнийг өрнүүлэхэд МҮЭ-ийн байгууллагын үүргийг дээшлүүлэх тухай МАХН-ын Төв Хорооны 1972 оны 42 дугаар тогтоолоор³⁵ МҮЭ-ийн байгууллагад “Шинийг санаачлагчдын хөдөлгөөнийг зохион байгуулах, өрнүүлэх, үйлдвэрлэлд нэвтрүүлэх, судалж дүгнэх ажилд идэвхтэй оролцон, шинийг санаачлагчдын эрхийг хамгаалахад олон нийтийн хяналт тавьж байх”-ыг даалгажээ. Мөн уг тогтоолоор МҮЭ-

³⁵ Монголын шинийг санаачлагчдын нийгэмлэгийн зөвлөл, Шинийг санаачлагчдын нийгэмлэгийн ажлын талаарх тогтоол дүрэм, зааврын эмхэтгэл 1972-1979, 1980, 3 дахь тал.



ийн Төв Зөвлөлд шинийг санаачлагчдын нийгэмлэгийг (ШСН-ийг) байгуулахыг зөвшөөрчээ. Л.Баасан³⁶ БНМАУ-ын 1973 оны Хөдөлмөрийн хуулийг тухайн цаг үеийн аж үйлдвэржилтийн нийгмийн харилцааны хөгжлийн шаардлагад нийцсэн төдийгүй хөдөлмөрчдийн хөдөлмөрлөх эрх ашгийг хамгаалсан хууль гэж тодорхойлжээ. Хөдөлмөрийн хуулийн 185 дугаар зүйлд үйлдвэрчний эвлэлийн хорооны эдлэх эрх хэсэгт шинэ бүтээл, оновчтой санал өрнүүлэхэд бүх аргаар туслалцан, батлагдсан шинэ бүтээл, оновчтой саналыг цаг тухайд нь нэвтрүүлж байгаа эсэхийг хянаж, оновчтой саналыг хэрэгсэхгүй байгаа тухай ажилчин, албан хаагчдын гомдол, түүнчлэн нэгэнт баталсан шинэ бүтээл, оновчтой саналын шагналыг бодох журам, гарсан гомдлыг үйлдвэр, албан газар, байгууллагын захиргаатай хамтран хянан үзэж байх эрхийг бүх шатны байгууллагын үйлдвэрчний эвлэлийн хороодод олгож байсан байна. Монголын ШСН-ийн дүрэмд ШСН нь МҮЭ-ийн удирдлагын дор үйл ажиллагааг явуулдаг, сайн дурын байгууллага бөгөөд үйл ажиллагааг ШСН-ийн зөвлөлөөс удирдахаар зохион байгуулахаар журамласан байна.³⁷ Манай улсын хувьд аж ахуйн салбарт ажиллагсдын дөнгөж 1 хувь нь шинэ санаачлаг гаргаж байхад шинэ санаачилгын хөдөлгөөнд ЗХУ-д 15 хувь, БНАГУ-д 7 хүний 1 нь оролцдог байна.³⁸ Шинэ санаачилгын

хөдөлгөөнийг өрнүүлэх үйл хэрэгт МҮЭ-ийн бүх шатны байгууллагуудыг хамруулах хүрээнд ШСН-ийн анхдугаар их хурлын тогтоолоор ШБОС-ыг улс ардын аж ахуйн салбарын хэмжээнд төлөвлөгөөтэй хөгжүүлэх, хөдөлгөөнийг өрнүүлэх, үйлдвэрлэлийн нөөц бололцоог илрүүлэх, ашиглах, арвилан хэмнэлтийг хангах, техник эдийн засгийн үр ашигтай ШБОС, тэргүүн туршлага сурталчлах, ашиглалт, нэвтрүүлэлтийг хянах, холбогдох хууль, дүрэм, тогтоол, шийдвэрийн биелэлтэд хяналт тавих зэргийг даалгасан байна.³⁹ МҮЭ-ийн Төв Зөвлөлийн тэргүүлэгчдийн хурлын 1973 оны 1 сарын 17-ны өдрийн 6 дугаар тогтоолоор “Шинийг санаачлагчдын нэгдсэн бүтээлч бригадын заавар”-ыг баталж, бригадын гишүүд шинэ санаачилгын хөдөлгөөнийг өрнүүлж зохион байгуулах практик ажлыг хариуцан ажиллахаар зохицуулжээ. Г.Баасан “үйлдвэрчний эвлэлүүдээр дамжуулан хөдөлмөрчдийн хамт олон, төр, төрийн зохих байгууллагуудтай харилцах өөрсдийн хөдөлмөрлөх эрх ашгаа тууштай хамгаалах, түүнчлэн төр түүний байгууллагууд үйлдвэрчний эвлэлүүдээр дамжуулан удирдлагын болон төрийн бусад чиг үүргийг хэрэгжүүлэх зэргээр төр-үйлдвэрчний эвлэл-хөдөлмөрчид, эсхүл хөдөлмөрчид-үйлдвэрчний эвлэл-төр харьцаа, хэлхээ холбоо үүснэ”⁴⁰ гэж тодорхойлсон нь хөдөлмөрчдийн ШБОС гаргах үйл ажиллагааг дэмжих асуудлыг үйлдвэрчний эвлэлийн байгууллагаар дамжуулан төрөөс зохицуулсан гэж

³⁶ Л.Баасан, Монгол Улсын Хөдөлмөрийн эрхзүй, 2000, 129 дэх тал.

³⁷ Монголын шинийг санаачлагчдын нийгэмлэгийн зөвлөл, Шинийг санаачлагчдын нийгэмлэгийн ажлын талаарх тогтоол дүрэм, зааврын эмхэтгэл 1972-1979, 1980, 25-27 дахь тал.

³⁸ Ц.Гүрбадам, БНМАУ-д шинжлэх ухаан-техникийн дэвшлийг хурдасгах асуудал, 1974, 354 дэх тал

³⁹ Монголын шинийг санаачлагчдын нийгэмлэгийн зөвлөл, Шинийг санаачлагчдын нийгэмлэгийн ажлын талаарх тогтоол дүрэм, зааврын эмхэтгэл 1972-1979, 1980, 5-6 дахь тал.

⁴⁰ Л.Баасан, Монгол Улсын Хөдөлмөрийн эрхзүй, 2000, 83 дахь тал.



дүгнэх боломжийг олгож байна.

БНМАУ-ын Сайд нарын Зөвлөл 1970 оны 6 дугаар сарын 25-нд 185 дугаар “Аж үйлдвэрт шинэ нэр төрлийн бүтээгдэхүүн зохион бүтээх, үйлдвэрлэх журмын тухай” тогтоолд шинэ санаачилгын фонд, үйлдвэрийн газрын фонд, үйлдвэрлэл хөгжүүлэх фонд болон яамдын төвлөрсөн фондоос зарцуулсан хөрөнгийг шинэ нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж борлуулснаас олсон ашгаас нөхөн арвижуулж байхаар тогтоож өгсөн нь энэ ажлыг зах зээлийн харилцаанд шилжүүлэх ажлын эхлэл, шинэ нөөц боломж эрэлхийлсэн алсын хараатай шийдвэр байв. Шинэ бүтээлийн материалыг БНМАУ-ын Шинжлэх ухаан техникийн улсын хорооноос 1974 оны 10 дугаар сарын 14-ны өдөр баталсан шинэ бүтээлийн материал бүрдүүлэх зааврын дагуу үйлдэж, шинийг санаачлагчдын нийгэмлэгийн зөвлөл нь эрх хамгаалах материалыг бүрдүүлж өгөхөд тусалж, мэргэжлийн зөвлөгөө өгдөг байсан. Нам засаг болоод ард түмнээс шинийг санаачлагчдыг өндрөөс үнэлж, улс ардын аж ахуйн тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд оюун ухаан, хөдөлмөрөө зарцуулдаг шинжлэх ухаан, техник, нийгмийн хөгжил, дэвшилд амьдралаа зориулдаг хэмээн хүндэтгэн үзэх сайн хандлага төлөвшихөд чухал нөлөө үзүүлжээ. Монгол Улсын Үндсэн хуулийн хөгжлийг Б.Чимэд⁴¹ а/ социалист маягийн, б/ардчилсан маягийн гэж хуваах нь зүйтэй гэж үзсэн байх бөгөөд 1924, 1940, 1960 оны Үндсэн хуулийг социалист хэв маягт хамааруулжээ. Үндсэн хуульдаа улсын эдийн засгийн

⁴¹ Б.Чимид, Үндсэн хуулийн үзэл баримтлал, нийтлэг асуудал, нэгдүгээр дэвтэр, 2004, 208 дахь тал.

үндэс нь социалист өмч гэж заасан, төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн тогтолцоотой цаг үед патентын эрх зүйн тогтолцооны эхлэл тавигджээ. Хувийн өмч, оюуны өмчийг хөгжүүлэх талаар бодлогогүй байсан түүхэн цаг үед оюуны өмчийн олон улсын хөгжлийн чиг хандлагыг хүлээн зөвшөөрөх эхний алхмуудыг тавьж байв.

III. Патентын эрх зүйн зохицуулалт (1978–1992)

БНМАУ нь 1978 онд Дэлхийн оюуны өмчийн байгууллагыг байгуулах тухай конвенцыг⁴² соёрхон баталсан байх бөгөөд оюуны бүтээлд хандах хандлага дэлхий нийтийн хөгжлийн чиг хандлагын дагуу хөгжих суурь эхлэл тавигджээ. ДОӨБ-ын байгууллага байгуулагдсаныг олон улсын оюуны өмчийн хамгаалалт үүссэн түүхэн цаг үед⁴³ хамруулсан байх бөгөөд Аж үйлдвэрийн өмчийг хамгаалах тухай Парисын конвенц (1883) ба Утга зохиол, урлагийн бүтээлийг хамгаалах тухай Бернийн конвенцын (1886) гишүүн улсууд 1967 онд уг конвенцыг байгуулахаар гарын үсэг зурж, улмаар 1970 онд байгуулагдсан бөгөөд Дэлхийн оюуны өмчийн байгууллага нь 1974 онд НҮБ-ийн төрөлжсөн 16 байгууллагын нэг болж, оюуны өмчийн хөгжлийг олон улсын хэмжээнд чиглүүлэн удирдахаар зохион байгуулагдсан, шинийг сэдэх бүтээлч чадварыг дэмжих, оюуны бүтээлийн хамгаалалтын жишиг тогтолцоог бий болгох, эдийн засаг, соёл, нийгмийн болоод хүн төрөлхтний хөгжилд үзүүлэх оюуны

⁴² Дэлхийн оюуны өмчийн байгууллага байгуулах тухай конвенц, 1978, Төрийн мэдээлэл тусгай дугаар 3, 2005.

⁴³ WIPO, CNIPA, Intellectual Property basics: A Q&A for students, page 17.



өмчийн нөлөөг нэмэгдүүлэхэд чиглэсэн бодлого боловсруулж, олон улсын хэм хэмжээ, журмыг тогтоохоос гадна оюуны өмчийн мэдээллийг цуглуулах, оюуны өмчийн олон улсын эрхийн хамгаалалтыг хялбарчлахад чиглэсэн үйлчилгээг үзүүлэх зэрэг чиглэлээр үйл ажиллагаагаа явуулахаар зохицуулжээ. Конвенцын хувьд дэлхий дахинаа оюуны өмчийн эрхийг хамгаалах асуудлыг хариуцах байгууллагын зорилго, чиг үүрэг, ажлын алба, зохион байгуулалтын хэлбэрийг зохицуулаад зогсохгүй, оюуны өмчийг тодорхойлсон байна. Оюуны өмч гэдгийг утга зохиол, урлаг, шинжлэх ухааны бүтээл, тоглогчдын тоглолт, дуу авианы бичлэг болон радио телевизийн нэвтрүүлэг, хүний бүтээн туурвисан бүх шинэ бүтээл, шинжлэх ухааны нээлт, бүтээгдэхүүний загвар, бараа болон үйлчилгээний тэмдэг, хуулийн этгээдийн нэр болон илэрхийлэл, шударга бус өрсөлдөөний эсрэг хамгаалалтыг хамруулснаас гадна аж үйлдвэр, шинжлэх ухаан, утга зохиол, урлагийн салбарт гарч буй оюуны бүтээлээс үүдэн гарах бусад бүх эрх гэж тодорхойлжээ.

Оюуны өмчийн хөгжлийн чиг хандлага улс орон бүрийн хувьд ялгаатай он цагийн хэлхээнд үүссэн боловч 1880-аад оны дээрх Парисын болон Бернийн конвенцын гишүүн орнуудаас байгуулсан ДООБ-ын үйл ажиллагаа бүхэлдээ оюуны өмчийг бие даасан эрх зүйн салбарын хүрээнд, тухайлбал аж үйлдвэрийн өмч болон зохиогчийн эрхийн эрх зүйн салбарын ялгаатай байдалд тулгуурлан хөгжүүлсэн байх бөгөөд зохиогч нь патентын болон зохиогчийн эрхийн хувьд онцгой эрх эдэлдэг, өөрийн бүтээлээ захиран зарцуулах эрх олж авах

боломжтой тэр харилцаанд нэгэнт хөл тавьсан байгаа нь нийгмийн удирдан чиглүүлэх бодлогынхоо эсрэг оюуны өмчийн гэрээ хэлэлцээрт нэгдэж орсон гэж дүгнэх боломжтой байна. Агуулгын хувьд социалист өмчийг баримтлах нийгмийн бодлоготой зөрчилдсөн гэж тодорхойлж болох хэдий ч зүй тогтлын хувьд дэлхийн улс орнуудтай хамтран ажиллах, дэлхийн хөгжлийн нийтлэг чиг хандлагатай хөл нийлүүлэх том алхмыг хийжээ. Социалист бүтээн байгуулалтын хүрээнд гар хөдөлмөрийг механикжуулах, хөдөлмөрийн бүтээмжийг нэмэгдүүлэх, бүтээгдэхүүний чанарыг сайжруулах, хоёрдогч түүхий эдийг ашиглаж бүтээгдэхүүн үйлдвэрлэх, шинэ техник, технологи нэвтрүүлэх, үйлдвэржилтийг эрчимжүүлэх зэрэгт чиглэж, энэ үйл ажиллагаанд хөдөлмөрчдийн техникийн бүтээлч сэтгэлгээг хандуулахад төрийн бодлого чиглэсээр байжээ. Монголын ШСН-ийн III их хурлаас "Орчин үед шинжлэх ухаан, техник асар хурдан хөгжиж, хүний зохион бүтээх авьяас чадвар өндөр түвшинд хүрч, тэр нь социалист нийгмийн иж бүрэн дэвшлийг хангаж хурдасгах бодит хүчин зүйл боллоо. Иймд үед манай хөдөлмөрчдийн техникийн сэтгэлгээ, зохион бүтээх авьяасыг байнга хөгжүүлэх нь амьдралын хэрэгцээнээс үүсэн гарч байгаа шаардлага болж байна"⁴⁴ гэж төрийн бодлогыг тодорхойлж байв. МҮЭ-ийн Төв зөвлөлийн тэргүүлэгчдийн хурлын 1979 оны 7 дугаар сарын 19-ний өдрийн 105 дугаар "Монголын шинийг санаачлагчдын нийгэмлэгийн ажлыг

⁴⁴ Монголын шинийг санаачлагчдын нийгэмлэгийн зөвлөл, Монголын шинийг санаачлагчдын нийгэмлэгийн III их хурлын материал, 1988, 4 дэх тал.



сайжруулах зарим арга хэмжээний тухай” тогтоолд ШБОС гаргагчдын хөдөлгөөнийг зохион байгуулах ажлыг шинэ шатанд гаргахыг даалгаж, үйлдвэрлэлийн дамжлагыг механикжуулах тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл зохион бүтээх буюу боловсронгуй болгож хөдөлмөрийн бүтээмжийг нэмэгдүүлэх, үйлдвэрлэлийн зардлыг бууруулах, бүтээгдэхүүний нэр төрлийг бий болгох, хөдөлмөрлөх нөхцөлийг сайжруулах, байгалийн баялгийг зохистой ашиглахад шинэ санаачилгыг чиглүүлэхийг даалгажээ. Улмаар БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн Шинжлэх ухаан техникийн улсын хороо, Монголын үйлдвэрчний эвлэлийн төв зөвлөлийн тэргүүлэгчдийн хурлын 1979 оны 87/93 тогтоолоор “Үйлдвэрлэлийн тэргүүн туршлага судлах, нэгтгэн дүгнэх, нэвтрүүлэх журам”⁴⁵, МҮЭ-ийн Төв зөвлөл, Шинжлэх ухаан техникийн улсын хорооны 1979 оны 87/93 дугаар тогтоолоор “Үйлдвэрлэлийн тэргүүн туршлагын бүртгэл хөтлөх заавар”⁴⁶ зэрэг хэд хэдэн тогтоол шийдвэрийг баталжээ. Шинэ санаачилгыг өрнүүлэхэд шинийг санаачлагчдыг шинэ зүйл сэтгэхэд сургах, мэдлэгийг дээшлүүлэхэд бусад орнуудын туршлагаас суралцах боломжоор хангаж эхэлсэн байна. 1980 оноос эхлэн манай улсаас ДОӨБ-аас олон улсын түвшинд зохион байгуулагдах хавар, намрын ээлжит чуулган, хурал, сургалт семинарт тогтмол хамрагдаж болж, үндэсний семинар зохион байгуулагдах болжээ. Энэ олон улсын хамтын ажиллагаанд

⁴⁵ Монголын шинийг санаачлагчдын нийгэмлэгийн зөвлөл, Шинийг санаачлагчдын нийгэмлэгийн ажлын талаархи тогтоол дүрэм, зааврын эмхтгэл 1972-1979, 1980, 8-14 дэх тал.

⁴⁶ Монголын шинийг санаачлагчдын нийгэмлэгийн зөвлөл, Шинийг санаачлагчдын нийгэмлэгийн ажлын талаархи тогтоол дүрэм, зааврын эмхтгэл 1972-1979, 1980, 15-21 дэх тал.

ДОӨБ-ын Ерөнхий захирал Б.Богш 1886 онд Монгол улсад айлчлал тодорхой хувь нэмэр оруулсан тухай Монгол улсын оюуны өмчийн байгууллагын үүсэл хөгжил номд хамтын ажиллагааны хүрээнд оюуны өмчийн бие даасан байгууллага байгуулах, оюуны өмчийн бие даасан эрх зүйн зохицуулалтыг хөгжүүлэх, боловсон хүчнийг чадавхжуулах сургалт, семинарт оролцуулах, оюуны өмчийн бусад гэрээ, хэлэлцээрүүдэд элсэн орох, ЕПБ-тай хамтран ажиллах зэрэг асуудлуудыг төлөвлөсөн хугацаанд бодитой хэрэгжүүлэхэд түүхэн алхам болж, цаашдын олон талт хамтын ажиллагааг гүнзгийрүүлэх, хөгжүүлэх чиглэлээр хамтран ажиллах эх суурь тавигдсан.⁴⁷

ДОӨБ-д элсэн орсны дараагаар Монгол улс 1984 онд Аж үйлдвэрийн өмчийг хамгаалах тухай Парисын конвенцод⁴⁸ болон Барааны тэмдгийн олон улсын бүртгэлийн тухай Мадридын хэлэлцээрт⁴⁹ нэгдэн орсон байна. Парисын конвенцын хувьд аж үйлдвэрийн өмчийн эрхийг өргөн утгаар тодорхойлж, патент, барааны тэмдэг, бүтээгдэхүүний загвар, ашигтай загвар, худалдааны нэр, газар зүйн заалт болон шударга бус өрсөлдөөнийг хамгаалалтыг аж үйлдвэрийн өмчид хамааруулж, гишүүн улсуудаас баримтлах үндсэн зарчмыг тодорхойлж, зохицуулсан олон улсад аж үйлдвэрийн өмчийг хамгаалах үндсэн гэрээ юм. Үүнд үндэсний

⁴⁷ Оюуны өмчийн газар, Монгол улсын оюуны өмчийн байгууллагын үүсэл хөгжил, 2007, 42 дахь тал.

⁴⁸ Аж үйлдвэрийн өмчийг хамгаалах тухай Парисын конвенц, 1984, Төрийн мэдээлэл тусгай дугаар 3, 2005.

⁴⁹ Барааны тэмдгийн олон улсын бүртгэлийн тухай Мадридын хэлэлцээр, 1984, Төрийн мэдээлэл тусгай дугаар 3, 2005.



нөхцөлийн зарчим, давамгайлах эрхийн зарчим, бие даасан хамгаалалтын зарчим, албадан лиценз, аж үйлдвэрийн өмчийн эрхийг хүчинтэй байлгах ба төлбөрийн хугацааны хөнгөлөлт, онцгой эрхийг зөрчихгүй байх нөхцөлүүд гэх мэт хамаарна. Түүнээс гадна гишүүн улсууд аж үйлдвэрийн өмчийн асуудал хариуцсан байгууллага байгуулах, тусгай үйлчилгээ үзүүлэхээр зохицуулсан байх бөгөөд энэ тусгай үйлчилгээ нь аж үйлдвэрийн өмчийн албан ёсны хэвлэлд хамаарч байна. Энэхүү конвенцод элсэн орсны дүнд олон ажил эхлүүлсний нэг нь 1989 оноос улсын бүртгэлд авсан шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, барааны тэмдгийн ном зүйн мэдээллийг улиралд 1 удаа хэвлэн гаргадаг болжээ. 1992 оны 2 дахь хэвлэлд⁵⁰ Нээлт, шинэ бүтээл, оновчтой саналын дүрэм, 53-р зүйлийн дагуу шинэ бүтээл, Барааны тэмдгийн дүрмийн 48е зүйлийн дагуу барааны тэмдэг болон зохиогчийн гэрчилгээний дугаарт оноосон олон улсын ангиллын индекс тэй зэрэгцүүлэн, мөн зохиогчийн гэрчилгээ, патент ба мэдүүлгийн дугаарын заалтаар нэг бүрчлэн ангилаад зогсохгүй улсын бүртгэлд авсан олон улсын индекс бүрийг бүлэглэн монгол, орос, англи хэл дээр хэвлэж мэдээлсэн нь оюуны өмчийн мэдээллийг нээлттэй ил болгоод зогсохгүй, мэдээллийн багтаамжийн хувьд боловсронгуй хэлбэрийг хадгалсан, олон нийтийн сонирхлыг татахуйцаар шинжлэх ухаанч байдлаар бэлтгэн түгээдэг давуутай байжээ.

Улмаар программ хэрэгсэл болон дэвшилттэй техник технологийг зохион

⁵⁰ Патент, барааны тэмдгийн газар, Шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, барааны тэмдэг, 1992 (2), 1992

бүтээх асуудлыг шинээр зохицуулах болжээ. Үүний нэг илрэл нь БНМАУ-ын Сайд нарын зөвлөлийн 1990 оны 6 дугаар сарын 22-ны өдрийн 337 дугаар “Шинэ бүтээл, оновчтой санал зохиогч, нэвтрүүлэгчдийн шагналын тухай” тогтоолоор /1970 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 415 дугаар тогтоолын 2 дугаар зүйлийн “Нээлт, шинэ бүтээл, оновчтой санал гаргагчдыг шагнах тухай заавар” гэснийг хүчингүйд тооцож, /энэхүү тогтоолд шинэ бүтээл, оновчтой санал, бүтээгдэхүүний загвараас гадна программ хэрэгсэл зохиосон болон дэвшилттэй техник, технологи, зохион байгуулалтыг үйлдвэрлэл, үйлчилгээнд нэвтрүүлж хөдөлмөр, материал, түүхий эдийн нөөц хэмнэсэн, нийгмийн үйлдвэрлэлийн үр ашгийг дээшлүүлсэн хүмүүст үйлдвэрлэлийн жилийн бодит үр ашиг, хэмнэлтийн дүнгийн 30 хувиар нэг удаа шагнахаар, лицензээр гадаадад худалдсан бүтээлээс олсон ашиг, хэмнэлтийн 30 хувьтай тэнцэх шагналыг лиценз үйлчлэх хугацаанд гадаад валютаар буюу зохиогч хүсвэл үндэсний валютаар олгож байхаар тогтоосон байна. Энэхүү тогтоолоор “шинэ бүтээл, оновчтой саналын зохиогч, шинжлэх ухаан-техникийн ололт нэвтрүүлэгчдийг шагнах журам”-ыг баталж мөрдүүлэхийг Нийгэм, эдийн засгийн хөгжлийн улсын хороо, Техникийн дэвшил, стандартчиллын улсын хороонд даалгаж, тус хорооноос 1990 оны 8 дугаар сарын 3-ны өдрийн 71/90 дүгээр тогтоолоор⁵¹ тус журам батлагдаж, бэлэн дотоод, гадаадын шинжлэх ухаан-техникийн ололтыг нэвтрүүлж, үр ашгаа өгсөн эсэхийг тооцох

⁵¹ Монголын шинийг санаачлагчдын нийгэмлэгийн зөвлөл, Мэдээлэл №2, 1990, 3 дахь тал



аргачлалыг боловсруулжээ. Улмаар эдийн засгийн үр ашиг, хэмнэлтээс зохих шагнал олгохоор зохицуулсан нь эрх хамгаалагдсан бүтээлийг үйлдвэрлэлд нэвтрүүлж ашигласны дараах бодит үр дүнд түшиглэсэн оновчтой зохицуулалт гэж тодорхойлох үндэслэлтэй байна.

Монгол улсын өнцөг булан бүрд шинийг санаачлагчдын бүтээл ахуй амьдралд биеллээ олж үйлдвэрлэлд нэвтэрч үйлдвэр, орон нутаг, салбарын хэрэгцээг хангаж, улс ардын аж ахуйд тулгамдсан асуудлыг шийдвэрлэж байжээ. Энэ үйл явдал эрс эрчимжсэн он цагийн тухайд 1990 оны дунд үеийг нэрлэсэн байх бөгөөд 1991 онд хийсэн Нээлт, шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, оновчтой саналын тухай БНМАУ-ын хуулийн төсөлд холбогдуулах хийсэн зарим тайлбар, судалгаанд⁵² 1986-1990 онд шинэ бүтээлийг ашиглаж савхи, хиймэл савхи, үслэг эдлэл болон Говь-Алтайн Бигэр сумын төвд жимсний архины үйлдвэр зэрэг 4 үйлдвэр, давс боловсруулах, будаа ялгах ба боловсруулах, ганганы хандмал, чацаргана цэвэрлэх, боловсруулах, гаммаглобулин бэлтгэх арга зэрэг хүнс, хөдөө аж ахуйн шинэ бүтээл, хаягдал давс эргүүлж ашиглах төхөөрөмж, уурхайн өрмийн хошуу зэрэг тоног төхөөрөмж үйлдвэрлэх 18 цех байгуулагджээ. Энд дурдагдсан Говь-Алтайн Бигэр сумын төвд байгуулагдсан жимсний архины үйлдвэрийг П.Цэвэгмэд, О.Баянмөнх, Д.Бадгаа, Ч.Батжаргал, Ж.Дашням нарын хүмүүсийн бүтээсэн “Чацарганы жимснээс шингэн шүүс ялгах арга” нэртэй

⁵² БНМАУ-ын Үндэсний хөгжлийн яамны Патент, барааны тэмдгийн газар, Нээлт, шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, оновчтой саналын тухай БНМАУ-ын хуулийн төсөлд холбогдуулан хийсэн зарим тайлбар, судалгаа, 1991, 9 дэх тал

393 дугаар шинэ бүтээл⁵³ дээр үндэслэсэн байх бөгөөд уг аргыг Бигэр сумын “Эрх чөлөө” нэгдэл болон ШУА-ийн химийн хүрээлэнтэй хамтран боловсруулсан байх бөгөөд нэг тонн чацарганаар 8278 төгрөгийн товарын бүтээгдэхүүн хийж, 3900 төгрөгийн зардал гарган, 4378 төгрөгийн ашигтай ажилласан тухай мэдүүлэгт хавсаргасан баримт бичигт дурдагджээ. Судалгааны байгууллагатай хамтран өмнөх үйлдвэрлэлийн аргаас хэмнэлттэй эдийн засгийн ач холбогдолтой шинэ бүтээлийг зохион бүтээсэн нь урт хугацаагаар оршин тогтнох үйлдвэрлэлийн эхлэлийг тавьсан байх бөгөөд энэ үйлдвэр 1968 оноос чацарганын дарс, тос, оргилуун дарс зэргийг Монгол улсад анх үйлдвэрлэж байгаад 1993 оноос хувийн хэвшилд шилжиж хэрэглэгчийн таашаалд нийцсэн чанартай бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлж, орон нутгийн төсвийг бүрдүүлэхэд хувь нэмэр оруулан ажиллаж байна⁵⁴. Энд зөвхөн нэг жишээг дурдсан бөгөөд энэ цаг үед бүтээгдсэн олон шинэ бүтээл нухацтай сэтгэн бодож судалгаа шинжилгээний үр дүнд бүтээгдэж өнөөгийн үйлдвэрлэлийн суурийг тавьж, өргөжин тэлсээр байгаа нь улсын хөгжилд нөлөөлж байна. Статистикт харуулснаар 1971-1975 онд нийт 90 шинэ бүтээлд патент олгосон бол 1986-1990 онд 308 бүтээлд олгосон нь 10 гаруй жилийн хугацаанд 3 дахин өссөн, оновчтой саналын хувьд тус онуудад 1293-аас 10502 болж огцом нэмэгджээ.⁵⁵ ЗСБНУ-д 1979

⁵³ Оюуны өмчийн газрын аж үйлдвэрийн өмчийн сан, Патентын сан, 393 дугаар шинэ бүтээл

⁵⁴ Үйлдвэрлэл худалдааны Шимт Дээж ХХЗ, танилцуулга, <https://www.trademongolia.mn/mc/organisation/8774>.

⁵⁵ БНМАУ-ын Үндэсний хөгжлийн яамны Патент, барааны тэмдгийн газар, Нээлт, шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, оновчтой саналын



онд 150 мянга гаруй патентын мэдүүлэг (зохиогчийн гэрчилгээг оролцуулан) хүлээн авсан байна.⁵⁶ Адилхан улсын өмчид тулгуурласан социалист орнуудын хувьд шинжлэх ухаан, техникийн ололт амжилтыг бий болгож, өрсөлдөөнд суурилсан үйлдвэрлэл эрхэлж байсан нь манай улсын нийгмийн мөн чанараас ялгаатай байжээ. ШБОС нэвтрүүлснээс олсон ашгаас байгуулсан санд 1971-1975 онуудад 45,2 сая төгрөг, 1986-1990 онд 141,5 сая төгрөг хуримтлагджээ⁵⁷. Шинэ бүтээл, оновчтой саналын түвшинд сэтгэх асуудал яригдаж байсан нь бүтээлийн үр ашгийн тооцоо болон техникийн баримт бичгийг шинжлэх ухааны үндэслэлтэй боловсруулахад оршиж, эдгээр баримт бичиг дээр үндэслэн улс ардын аж ахуйд нэвтэрч ашиглагдах явдлыг улсын байгууллагууд шийддэг байжээ. Эндээс олон шат дамжлагаар шилэгдэж батлагдсан ШБОС-ыг үйлдвэрлэлд нэвтрүүлэхэд давуу талтай байсан нь энэ үед баримталж байсан тогтоол, заавруудаас дүгнэх боломжтой байна.

Монголын ШСН-ийн Зөвлөлийн ээлжит II бүгд хурлын 1990 оны 6 дугаар сарын 22-ны тогтоолд оюуны өмчийг шинжлэх ухаан, техникийн дэвшлийн эх сурвалж болохыг онцолж, нийгэмлэгийн бүх шатны үйл ажиллагааг нийгмийн өөрчлөлт шинэчлэлд нийцүүлэн шинэчлэх чиг баримтлалыг баталсан байх бөгөөд

тухай БНМАУ-ын хуулийн төсөлд холбогдуулан хийсэн зарим тайлбар, судалгаа, 1991, 7 дахь тал.

⁵⁶ Кодзирос Озу, Осуществление патентных операций в Японской промышленности, 1982. Приложение 5.

⁵⁷ БНМАУ-ын Үндэсний хөгжлийн яамны Патент, барааны тэмдгийн газар, Нээлт, шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, оновчтой саналын тухай БНМАУ-ын хуулийн төсөлд холбогдуулан хийсэн зарим тайлбар, судалгаа, 1991, 8 дахь тал.

хурлаас Патентын хуулийг боловсруулж мөрдүүлэх ажлыг ШСН-ийн зөвлөлийн тэргүүлэгчид даалгасан байна.⁵⁸ Түүнээс гадна ШСН-ийг шинэчлэх чиг баримжаанд⁵⁹ ШБОС, судалгаа шинжилгээний ажлыг боловсруулах, зураг төсөл зохион бүтээх товчоо, бүтээлч бригадыг зохион байгуулж, үйлдвэрлэлд нэвтрүүлэх, эрхийг нь хамгаалуулах үйл ажиллагааг багтаасан, мөн нийгэмлэгийн зөвлөлийн дэргэд патент судлалын олон нийтийн институтийг ажиллуулж, патент судлаач мэргэжил олгохоор заажээ. Улмаар эдгээр үйл ажиллагаа амьдралд бодитоор хэрэгжиж ШБОС нэвтрүүлэх бүтээлч бригад олноор байгуулагдсан, Политехникийн дээд сургуулийн дэргэд байгуулсан “Патент судлал”-ын оройн сургуулийг олон түвшний байгууллагын ШБОС-ын ажил хариуцсан мэргэжилтэн, эрдэмтэд, багш зэрэг 200 гаруй хүн төгссөн байна.⁶⁰ Төр засгийн тогтоол шийдвэрээр ШБОС хариуцсан олон нэгж, байгууллагуудыг тухайлбал бүтээлч бригад, зохион бүтээх товчоо, шинийг санаачлагчдын нийгэмлэг, зөвлөл, түүний орон нутгийн байгууллагууд, үйлдвэрчний эвлэлийн байгууллага, Шинжлэх ухаан, техникийн улсын хороо, Эдийн засгийн харилцан туслалцах зөвлөл зэрэг нэгж, байгууллагуудыг шат дараатай хөгжүүлж зохион байгуулсан нь зохиогчийн эрх, патентаар мэргэшсэн албан хаагчдыг бэлтгэж, оюуны өмчийн хүний нөөцийг бэлтгэснээс гадна патентын төрөлжсөн хууль гарах хүртэл

⁵⁸ Монголын шинийг санаачлагчдын нийгэмлэгийн зөвлөл, Мэдээлэл №2, 1990, 8-9 дэх тал.

⁵⁹ Монголын шинийг санаачлагчдын нийгэмлэгийн зөвлөл, Мэдээлэл №2, 1990, 12-13 дэх тал.

⁶⁰ Оюуны өмчийн газар, Монгол улсын оюуны өмчийн байгууллагын үүсэл хөгжил, 2007, 28 дахь тал.



ШБОС-ыг удирдан зохион байгуулах төр засгийн тогтоол шийдвэрүүд үр дүнтэй хэрэгжиж үүргээ амжилттай биелүүлжээ.

БНМАУ 1991 онд Патентын хамтын ажиллагааны олон улсын гэрээнд нэгдэн орсноор олон улсад патент мэдүүлэх, мэдүүлэг хүлээж авах, патентын мэдүүлэгт баримтлах стандарт дүрэм журмыг мөрдөх асуудлыг гэрээний хүрээнд нийцүүлэх Монгол улсад гадаадын улсын шинэ бүтээлийг бүртгэх ажил эрчимжсэн гэж дүгнэх боломжтой байна. Үүнээс өмнө БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 1972 оны 4 дүгээр сарын 14-ны 136 дугаар тогтоолоор гадаадын шинэ бүтээлд патент олгох асуудлыг зохицуулж, түүнд оноох хураамжийн хэмжээг тогтоосон байх бөгөөд гадаадын шинэ бүтээлд анх Япон улсын иргэн Сигэру Ивасова 1975 оны 01 дүгээр сарын 14-ны өдөр мэдүүлсэн 155 дугаар “Гэрийн бүрээсний материал ба түүнийг хийх арга” нэртэй шинэ бүтээлд анх патент олгосон байна.⁶¹ Түүнчлэн 1963-1990 онуудад нийт гадаад, дотоодын 538 шинэ бүтээл улсын бүртгэлд авснаас 20% орчим хувь буюу 109 шинэ бүтээлийг гадаад орноос мэдүүлж, үүнээс 23%-д нь патент олгож байжээ.⁶² ПХАГ бол олон улсад патентын мэдүүлэг гаргах, нэг зэрэг олон улс оронд патентын хамгаалалт эрэлхийлэх тогтолцоог бүрдүүлсэн олон улсын гэрээ бөгөөд уг гэрээгээр патентын мэдүүлэгт хамаарах техникийн өмнөх түшингийн хайлтын болон урьдчилсан шүүлтийн

тайланг бэлтгэж, зохион бүтээгч болон мэдүүлэг гаргагчдад зохион бүтээлтийн түвшингээ үнэлж цэгнэх, патентын газруудад патент олгох шийдвэр гаргахад тусалдаг байна. Улмаар энэ гэрээний дагуу патентын мэдүүлгийг хэвлэж нийтэд түгээдэг бөгөөд патентын мэдүүлгийн санг эрхлэн удирддаг. Монгол улс ДООБ-ын гишүүнээр элсэж, оюуны өмчийн олон улсын гэрээ, хэлэлцээрт нэгдсэн явдал нь оюуны өмчийн асуудлаар өөрийн улсын зохион бүтээгчдийн эрхийг гадаад улсад хамгаалах, гадаадын зохион бүтээгчдийн эрхийг Монгол улсад хамгаалах эрх зүйн харилцааны эхлэлийг тавьжээ. Улмаар оюуны бүтээлийг төр засаг өөртөө төвлөрүүлж ашигладаг байсан хандлагаа өөрчилж, олон улсын оюуны өмчийн тогтолцоотой нийцүүлэх үйл ажиллагаа явуулах болсон байх бөгөөд социалист өмчийг баримтлах нийгмийн бодлоготой зөрчилдсөн хувийн үйлдвэрийн оршин тогтнох эхлэлийг тавьж байжээ. 1991 оны судалгаанд⁶³ 12 шинэ бүтээлд тулгуурлан байгуулагдсан 4 хувийн үйлдвэр, пүүс 1990 онд Даланзадгад, Увс болон Улиастай аймагт байгуулагдсан талаар дурдсан нь өмчийн олон хэлбэрийг хүлээн зөвшөөрөх үзэл санааг илэрхийлж, нам засгийн эдийн засаг, нийгмийн бодлогод хувийн өмчийг хүлээн зөвшөөрөх практик алхмуудыг хийж эхэлсэн бодлогын нэн чухал илрэл болохыг тэмдэглэхэд таатай байна.

⁶¹ Оюуны өмчийн газар, Монгол улсын оюуны өмчийн байгууллагын үүсэл хөгжил, 2007, 17 дахь тал.

⁶² БНМАУ-ын Үндэсний хөгжлийн яамны Патент, барааны тэмдгийн газар, Нээлт, шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, оновчтой саналын тухай БНМАУ-ын хуулийн төсөлд холбогдуулан хийсэн зарим тайлбар, судалгаа, 1991, 6 дахь тал.

⁶³ БНМАУ-ын Үндэсний хөгжлийн яамны Патент, барааны тэмдгийн газар, Нээлт, шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, оновчтой саналын тухай БНМАУ-ын хуулийн төсөлд холбогдуулан хийсэн зарим тайлбар, судалгаа, 1991, 10 дахь тал.



IV. Дүгнэлт

Өрсөлдөөнгүй үйлдвэрлэл бол зах зээлийн хөгжлийг хангахад чиглэгддэггүй, материаллаг бараа бүтээгдэхүүнийг үйлдвэрлэж, улсын хэрэгцээг хангах зорилготой гэж дүгнэж болох бөгөөд социалист өмчтэй байсан нийгмийн тогтолцооны хувьд хэдэн зуун жилийн өмнө үүссэн дэлхий нийтийн буюу олон улсын патентын тогтолцооны үүсэл хөгжлөөс түүхэн хөгжлийн хувьд Монгол улсын патентын эрх зүйн зохицуулалт онцлогтой үүссэн гэж дүгнэх боломжтой байна. Адилхан социалист өмчтэй байсан улс орнуудын хувьд үйлдвэрлэл өндөр хөгжсөн байсан нь манай улсын нийгмийн мөн чанараас ялгаатай байжээ. Энэ түүхэн үед социалист хөдөлмөрийн хөдөлгөөнд шинийг санаачлах хөдөлгөөнийг өрнүүлэх, техникийн бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэхэд чиглэсэн төр засгийн тогтоол шийдвэрүүд голлож, оюуны бүтээл туурвигчдын бүтээл нь нийтийн өмч болж, зохиогч өөрийн бүтээлтэй холбоотой эрх эдэлдэггүй байжээ. Төр засгаас хөдөлмөрчин, ажилчин, инженер техникийн ажилтнууд, сэхээтэн гэж ялгалгүй ижил түвшинд шинийг санаачлах идэвхийг өрнүүлэх олон тооны тогтоол шийдвэр, зааврыг гаргаж, тэдгээрийг хэрэгжүүлэх шат дараалсан нэгж бүтцийг байгуулж, хүний нөөцийг бүрдүүлэхэд онцгойлон анхаарч, зохиогчийн гэрчилгээ, онцгой эрхийн бичиг авахад мэргэжлийн байгууллага зөвлөгөө өгч, чиглүүлэн удирддаг байсан нь оновчтой зохицуулалт гэж дүгнэх боломжтой байна.

Зохиогчийн эрхийн хууль тогтоомжийн зохицуулалтгүй учир

аж үйлдвэрийн бүтээлд зохиогчийн гэрчилгээ өгч байсныг БНМАУ-ын 1952 оны Иргэний хуульд “Зохиогчийн эрх”, “Зохион бүтээсэн зүйлийн эрх” хэмээн оюуны бүтээлийг төрөлжүүлэн хөгжүүлэх эхлэлийг тавьж, зохиогчийн эрхийн гэрчилгээ олгож байсан шинэ бүтээлийн зохицуулалтыг зохиогчийн эрхийн бүтээлээс салгасан шинэ зохицуулалтыг бий болгосон нь дэлхий нийтийн оюуны өмчийн хөгжлийн чиг хандлагад нийцүүлж журамласан гэж дүгнэх боломжтой байна. Улмаар аж үйлдвэрийн бүтээлд зохиогчийн гэрчилгээг БНМАУ-ын 1963 оны Иргэний хууль үйлчлэх хүртэл дангаар олгож байгаад хуулиар шинэ бүтээлд зохиогчийн гэрчилгээ олгохоос гадна онцгой эрхийн бичиг олгох шинэ зохицуулалтыг хуульчилжээ. Онцгой эрхийн бичиг эзэмшигч нь шинэ бүтээлээ бусдад түр ашиглуулах зөвшөөрөл өгөх буюу онцгой эрхийн бичгийг бүрмөсөн шилжүүлж болохоор хуульчилсан нь шинэ бүтээлээ өөрөө захиран зарцуулах эрхийг олгосон шинэлэг зохицуулалт байна. Түүнээс гадна онцгой эрхийн бичиг зохиогчийн гэрчилгээнээс илүү хууль зүйн хүчин чадалтай байсан гэх дүгнэлтэд хүрэх боломжтой байна.

БНМАУ нь Хүний эрхийн түгээмэл тунхаглалд нэгдэж, хүний эрх, эрх чөлөөг эрхэмлэсэн нийгмийг зохион бүтээх болсон төдийгүй, ДОӨБ-ын гишүүнээр элсэж олон улсын оюуны өмчийн гэрээ, хэлэлцээрт нэгдсэн явдал нь оюуны өмчийн асуудлаар өөрийн улсын иргэдийн эрхийг гадаад улс оронд хамгаалах, гадаад улсуудын эрхийг Монгол улсад хамгаалах үйл ажиллагааны эхлэлийг бүрдүүлжээ. Улмаар оюуны бүтээлийг төр засаг өөртөө



төвлөрүүлж ашигладаг байсан хандлагаа өөрчилж, олон улсын оюуны өмчийн тогтолцоотой нийцүүлэх үйл ажиллагаа явуулах болсон байх бөгөөд социалист өмчийг баримтлах нийгмийн бодлоготой зөрчилдсөн хувийн үйлдвэрийн оршин тогтнох эхлэлийг тавьж байжээ. Социалист чиг баримжаатай түүхэн цаг үед оюуны өмчийн ойлголт Үндсэн хуулийн түвшинд, бусад салбар хуулиудын хүрээнд тодорхойлогдоогүй байсан хэдий ч социализмын сүүлийн жилүүдэд хувийн аж ахуйн нэгж, пүүс байгуулагдаж байсан нь оюуны бүтээлийн асуудал оюуны өмч гэсэн ойлголт руу чиглэн хөгжих эхлэлийг тавьсан түүхэн он цаг гэж дүгнэх боломжтой байна.

V. НОМ ЗҮЙ

Монгол эх сурвалж:

1. Б.Чимид, *Үндсэн хуулийн үзэл баримтлал, нийтлэг асуудал, нэгдүгээр дэвтэр*, 2004
2. БНМАУ-ын Үндэсний хөгжлийн яамны Патент, барааны тэмдгийн газар, *Нээлт, шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, оновчтой саналын тухай БНМАУ-ын хуулийн төсөлд холбогдуулан хийсэн зарим тайлбар, судалгаа*, 1991.
3. БНМАУ-ын Үндэсний хөгжлийн яамны Патент, барааны тэмдгийн газар, *Шинэ бүтээл, оновчтой саналын талаарх хууль тогтоомжийн эмхэтгэл (1960-1975)*, 1980.
4. Б.Түвшинжаргал, Ж.Отгонбаяр, *Оюуны өмчийн эрх зүйн зарим*

- асуудал*, 1995.
5. Б.Буянхишиг, *Монголын өмчийн тогтолцооны шилжилт*, 2023.
 6. Д.Дэмбэрэл, Г.Гомбо, Ц.Батжаргал, *Шинэ бүтээлийн патент*, 2000.
 7. Д.Цолмон, *Оюуны өмч (Эрх зүйн асуудал)*, 2001.
 8. Ж.Амарсанаа, *Хүний эрх, Олон улсын ба үндэсний эрх зүйн асуудал*, 2000.
 9. З.Намжил, *Дэлхийн Оюуны Өмчийн Байгууллага, Оюуны өмчийн лавлах*, 2008.
 10. З.Намжил, *Патент-эрх зүйн оньс*, 2000.
 11. З.Сүхбаатар, Б.Батбаяр, П.Оюундэлгэр, *Монгол улсын иргэний хууль тогтоомж (Түүхэн эмхэтгэл) 1206-2012 он*, 2012.
 12. Л.Баасан, *Монгол Улсын Хөдөлмөрийн эрхзүй*, 2000
 13. Монголын шинийг санаачлагчдын нийгэмлэгийн зөвлөл, *Монголын шинийг санаачлагчдын нийгэмлэгийн III их хурлын материал*, 1988.
 14. Монголын шинийг санаачлагчдын нийгэмлэгийн зөвлөл, *Мэдээлэл №2*, 1990.
 15. Монголын шинийг санаачлагчдын нийгэмлэгийн зөвлөл, *Шинийг санаачлагчдын нийгэмлэгийн ажлын талаарх тогтоол дүрэм, зааврын эмхэтгэл*, 1972-1979.
 16. Монгол улсын их сургууль, Хууль зүйн дээд сургууль, Монгол улсын төр, эрх зүйн үндэс, 1998.



17. Н.Чинбат, *Иргэний эрх зүй лекцийн товчоон*, Ерөнхий анги, 2014.
18. Оюуны өмчийн газар, *Оюуны өмчийн үндсэн асуудал*, орч. Б.Одгэрэл, З.Гэрэлмаа, 2021.
19. Оюуны өмчийн газар, *Монгол улсын оюуны өмчийн байгууллагын үүсэл хөгжил*, 2007.
20. С.Нарангэрэл, Н.Тэмүүлэн, *Зохиогчийн эрхийн тулгуур асуудал*, 2008.
21. Т.Сэнгэдорж, *Монгол улсын төр, эрх зүйн үндэс*, 1998.
22. Техникийн дэвшил, стандартчиллын улсын хороо, *Шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, барааны тэмдэг*, 1990.
23. Ц.Гүрбадам, *БНМАУ-д шинжлэх ухаан-техникийн дэвшлийг хурдасгах асуудал*, 1974.
24. Хууль зүйн үндэсний хүрээлэн, *Хууль зүйн шинжлэх ухааны судалгааны арга зүй*, 2018.
25. Э.Мягмардорж, *Оюуны өмчийн эрх зүйн үндсэн асуудлууд*, Оюуны өмчийн газар, 2003.

Гадаад эх сурвалж:

1. Arpad Bogsh, *Brief history of the first 25 years of the World Intellectual Property Organization*, 1992.
2. Kamil Idris, WIPO, *Intellectual property power tool for economic growth*, 2003.
3. Кодзиро Озу, *Осуществление патентных операций в японской промышленности* (доклад), 1982
4. WIPO, *Inventing the Future*, 2006.

5. WIPO, CNIPA, *Intellectual Property basics: A Q&A for students*.
6. WIPO, *Intellectual property handbook*, 2012.

Эрх зүйн эх сурвалж

1. Аж үйлдвэрийн өмчийг хамгаалах тухай Парисын конвенц, Төрийн мэдээлэл тусгай дугаар 3, 2005.
2. Барааны тэмдгийн олон улсын бүртгэлийн тухай Мадридын хэлэлцээр, Төрийн мэдээлэл тусгай дугаар 3, 2005.
3. Дэлхийн оюуны өмчийн байгууллага байгуулах тухай конвенц, Төрийн мэдээлэл тусгай дугаар 3, 2005.
4. Төрийн мэдээлэл № 4-5, 1993.
5. Төрийн мэдээлэл тусгай дугаар, 1-р боть, 2004.
6. Патентын тухай хууль (1993, 2006)
7. Патентын газар, *Патентын тухай хууль тогтоомжийн эмхэтгэл*, 1994.

Цахим эх сурвалж:

1. Дэлхийн Оюуны Өмчийн Байгууллагын цахим хуудас: <https://www.wipo.int/>
2. Монгол Улсын эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем: <https://legalinfo.mn/>
3. Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн танхимын цахим хуудас: <https://www.mongolchamber.mn/>
4. Оюуны өмчийн газрын Аж үйлдвэрийн өмчийн мэдээллийн сан: <https://publish.ipom.mn/>



Abstract

HISTORICAL DEVELOPMENT OF PATENT LEGAL REGULATION IN MONGOLIA BEFORE THE RATIFICATION OF THE CONSTITUTION OF 1992

B.ODGEREL

Ph.D. candidate of the University of Internal Affairs

The development of the patent legal system around the world is considered to have started in the 1470s, it is emphasized that the newly created knowledge as it creates wealth when transformed knowledge into industrial production, and by protecting this knowledge, it gives the owner the right to exclude for their inventions, and to protect against unauthorized use or to protect the rights of innovators, and to prevent unfair competition. Generally, according to the patent legal system, a person who has invented something new is granted the right to use his work within the scope of the rights granted by a patent for a certain period, and to use it by other members of society with his permission. For our country, this social relationship began to be regulated during the centralized planned economy, i.e. in the 1940s, and it is believed that there is a need to study the historical development of the legal system in terms of theory and practice from the regulation when all material resources were public before moving to the system

of freely enjoying the benefits of works created and invented by the author under the recognition of private property by the Constitution of 1992.

In this article, the historical development of the legal regulation of patents in Mongolia is studied from the period when inventions and innovations were first registered and the author's certificate was issued, i.e. from 1944 to the ratification of the Constitution in 1992, and then periodically studied the years from 1944 to 1978 and from 1979 to 1992. Further, it is necessary to continue to study the historical development of the patent legal system after the recognition of private property by the Constitution of 1992 allowing the author to freely enjoy the benefits of his created and invented works.

Keywords

Invention, innovation, certificate of authorship, exclusive rights document, patent, legal regulations.

ШҮҮХИЙН ЦАХИМЖИЛТ: ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

Улсын дээд шүүхийн дэргэдэх
Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн академи¹

¹ Энэхүү судалгааг Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн академи (цаашид “Шүүхийн академи” гэх)-ийн Шүүхийн судалгааны төвийн дарга, хууль зүйн доктор Б.Дөлгөөн (Ph.D.) удирдаж, Захиргааны эрх зүйн секторын эрхлэгч С.Цэрэндолгор, секторын судлаач О.Тэнхлүүн, Н.Хулан, Б.Мөнгөншагай, Р.Ануурад, Иргэний эрх зүйн секторын судлаач О.Төрболд, С.Юмжирдулам, судлаач Р.Болор, Н.Ундрэм, Г.Амаржаргал нар хийж гүйцэтгэлээ.

ТОВЬЁГ

УДИРТГАЛ	91
Судалгааны зорилго:.....	91
Судалгааны хамрах хүрээ:	91
Судалгааны арга зүй:.....	91
Судалгааны бүтэц:.....	91
ҮНДСЭН ХЭСЭГ	91
НЭГ. ИХ БРИТАНИ, УМАРД ИРЛАНДЫН	
НЭГДСЭН ХААНТ УЛСЫН ЗОХИЦУУЛАЛТ	91
ХОЁР. БҮГД НАЙРАМДАХ ХЯТАД АРД УЛСЫН ЗОХИЦУУЛАЛТ	95
ГУРАВ. ЭСТОНИ УЛСЫН ЗОХИЦУУЛАЛТ	98
ДӨРӨВ. СИНГАПУР УЛСЫН ЗОХИЦУУЛАЛТ.....	99
ТАВ. АВСТРАЛИ УЛСЫН ЗОХИЦУУЛАЛТ	102
ЗУРГАА. БҮГД НАЙРАМДАХ СОЛОНГОС УЛСЫН ЗОХИЦУУЛАЛТ	107
ДОЛОО. КАНАД УЛСЫН ЗОХИЦУУЛАЛТ	109
НАЙМ. БРАЗИЛ УЛСЫН ЗОХИЦУУЛАЛТ	111
ЕС. АВСТРИ УЛСЫН ЗОХИЦУУЛАЛТ	113
АРАВ. ХОЛБООНЫ БҮГД НАЙРАМДАХ ГЕРМАН УЛСЫН ЗОХИЦУУЛАЛТ.....	116
ДҮГНЭЛТ, САНАЛ	118
НОМ ЗҮЙ	122

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

УДШ

ИБУИНХУ

БНХАУ

БНСУ

ХБНГУ

ИХШХШТХ

Улсын дээд шүүх

Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Хаант Улс

Бүгд Найрамдах Хятад Ард Улс

Бүгд Найрамдах Солонгос Улс

Холбооны Бүгд Найрамдах Герман Улс

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль



УДИРТГАЛ

Судалгааны зорилго:

Энэхүү судалгааны зорилго нь Монгол Улсын шүүхийн цахим систем боловсруулж, нэвтрүүлэх Ажлын хэсэгт дэмжлэг үзүүлэх судалгаагаар хангах үүднээс гадаадын тодорхой зарим улсын шүүхийн цахимжилтын эрх зүйн орчныг харьцуулан судлахад оршино.

Ингэхдээ холбогдох гадаад улс нь шүүхийн цахимжилтын талаар тусгайлан баталсан хууль тогтоомжтой эсэх, процессын хуульдаа зохицуулсан эсэхийг харьцуулан судална. Тодруулбал, шүүхийн цахимжилтын эрх зүйн орчныг 1) цахим шүүх хуралдаан (E-Court), 2) цахим хэргийн хөдөлгөөн (E-Case management), 3) цахим баримт бичиг (E-Filing) гэж ерөнхийд нь гурав ангилах буюу шүүх хуралдааныг цахим платформ эсхүл хиймэл оюун ухаанаар явуулах, нэхэмжлэл, хариу тайлбарыг цахимаар гаргах, хэргийн материалтай цахимаар танилцах талаар нарийвчлан зохицуулсан эсэхийг судалсны үндсэн дээр дүгнэлт боловсруулж, санал дэвшүүлнэ.

Судалгааны хамрах хүрээ:

Судалгааны объект нь гадаадын тодорхой зарим улс (ИБУИНХУ, БНХАУ, Эстони, Сингапур, Австрали, БНСУ, Канад, Бразил, Австри, ХБНГУ)-ын шүүхийн цахимжилттай холбоотой эрх зүйн зохицуулалт, шүүхийн практик болно.

Судалгааны арга зүй:

Судалгааг гүйцэтгэхдээ эрх зүйн социологийн судалгааны аргууд болох задлан шинжилж, нэгтгэн дүгнэх (анализ, синтез) арга зүйг ашиглав.

Судалгааны бүтэц:

Энэхүү судалгаа нь удиртгал, үндсэн хэсэг, дүгнэлт, хавсралт гэсэн хэсгээс бүрдэх харьцуулсан судалгаа болно.

ҮНДСЭН ХЭСЭГ

Шүүхийн цахимжилт нь үндсэндээ шүүхийн үйл ажиллагааны тодорхой хэсгийг бодит орон зайгаас цахим буюу дижитал орон зайд шилжүүлэхийг хэлнэ. Шүүхийн цахимжилт нь шүүхийн дотоод засаглал, шүүхийн үйл ажиллагааг хэвлэн нийтлэх, иргэдэд шүүхийн үйлчилгээг хүртээмжтэй, түргэн шуурхай хүргэх, иргэдийн цаг хугацаа, зардлыг хэмнэх, шүүхийн нэр хүндийг сайжруулах зэрэг ач холбогдолтой.¹ Судалгааны агуулгыг 1) цахим шүүх хуралдаан (E-Court), 2) цахим хэргийн хөдөлгөөн (E-Case management), 3) цахим баримт бичиг (E-Filing) гэсэн гурван асуудлын хүрээнд тодорхойлов.

Ингэхдээ захиалагчийн тухайлан дурдсан 10 улс буюу Их Британи Умард Ирландын Нэгдсэн Хаант Улс (цаашид “ИБУИНХУ” гэх), Бүгд Найрамдах Хятад Ард Улс (цаашид “БНХАУ” гэх), Эстони, Сингапур, Австрали, Бүгд Найрамдах Солонгос Улс (цаашид “БНСУ” гэх), Канад, Бразил, Австри, Холбооны Бүгд Найрамдах Герман Улс (цаашид “ХБНГУ” гэх)-ын холбогдох эрх зүйн зохицуулалтыг авч үзье.

НЭГ. ИХ БРИТАНИ, УМАРД ИРЛАНДЫН НЭГДСЭН ХААНТ УЛСЫН ЗОХИЦУУЛАЛТ

¹ Nguyen Hoa Binh, Building Digital Courts - an Important Task in the Judicial Reform Strategy, (2022), https://www.tapchicongsan.org.vn/web/english/mega-story/-/-/asset_publisher/lc29ulxCb05g/content/building-digital-courts-an-important-task-in-the-judicial-reform-strategy (Сүүлд үзсэн: 2024.02.27)



ИБУИНХУ-д өнөөдрийн байдлаар шүүхийн цахимжилтын талаар тухайлсан хууль батлаагүй байна.² Гэсэн хэдий ч Англи, Уэльсийн шүүхийн практикт 1 тэрбум гаруй фунтийн төсөвтэй, эрүү, иргэн, гэр бүлийн шүүх, трибуналыг хамарсан 50 гаруй төслөөс бүрдсэн том зорилго бүхий шинэтгэлийн хөтөлбөр хэрэгжиж байгаа ба төслийг Эзэн хааны шүүх, трибуналын үйлчилгээний алба (англ. *HM Courts & Tribunals Service*) удирдаж байна.³

1. Цахим шүүх хуралдаан (E-court):

ИБУИНХУ-д КОВИД-19 цар тахлын тархалттай холбогдуулан баталсан “Коронавирусийн тухай хууль 2020” (англ. *Coronavirus Act 2020*)-ийн 1 дүгээр бүлгийн 53-57 дугаар зүйлд “Шүүх, трибунал: видео, аудио технологи ашиглах” гэсэн хэсгийг хуульчилж, холбогдох технологи ашиглах орчин бүрдүүлэх зорилгоор дараах хуулиудад тодорхой хугацаагаар нэмэлт, өөрчлөлт оруулсан: (Тус 53-57 дугаар зүйлийн томьёолол нь дараах байдлаар хуульчлагдсан)

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны лайв холбоосын хүртээмжийг өргөтгөх хүрээнд:

- Эрүүгийн хэргийн тухай хууль (англ. *Criminal Justice Act 2003*);
- Эрүүгийн хэргийн давж заалдах тухай хууль (англ. *Criminal Appeal Act 1968*);

² ИБУИНХУ-ын хууль тогтоомжийн албан ёсны нэгдсэн сан (Англи, Уэльс, Шотланд, Умард Ирландын хууль тогтоомжийг багтаасан) болох <https://www.legislation.gov.uk/> цахим хуудсыг шүүж үзвэл тухайлсан хууль батлаагүй байх бөгөөд тус улсын бусад доктринал эх сурвалжид тухайлсан хуультай эсэхийг дурдаагүй байна.

³ Richard Susskind, *Online Courts and the Future of Justice* (New York: Oxford University Press, 2021), p.166.

- Эрүүгийн хэргийн тухай хууль (англ. *Criminal Justice Act 1988*)

Бусад эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны лайв холбоосын хүртээмжийг өргөтгөх хүрээнд:

- Гэмт хэрэг, хэв журмын тухай хууль (англ. *Crime and Disorder Act 1998*);
- Ялтан шилжүүлэх тухай хууль (англ. *Extradition Act 2003*);
- Цагдаа, эрүүгийн хэргийн нотлох баримтын тухай хууль (англ. *Police and Criminal Evidence Act 1984*);
- Зөрчлийг хянан шалгах тухай хууль (англ. *Prosecution of Offences Act 1985*);
- Зохион байгуулалттай хүнд гэмт хэрэг, цагдаагийн байгууллагын тухай хууль (англ. *Serious Organised Crime and Police Act 2005*)

Видео, аудиоогоор зохион байгуулсан хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд олон нийтийг оролцуулах хүрээнд:

- Шүүхийн тухай хууль (англ. *Courts Act 2003*);
- Трибунал, шүүх, шийдвэр гүйцэтгэлийн тухай хууль (англ. *Tribunals, Courts and Enforcement Act 2007*)

Халдварт өвчин туссан байж болзошгүй хүнд тавьсан шаардлага, хязгаарлалтыг эс зөвшөөрч магистратын шүүхэд давж заалдах лайв холболтын хүрээнд:

- Магистратын шүүхийн тухай хууль (англ. *Magistrates' Courts Act 1980*)



Хууль зүйн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд лайв холбоос ашиглах Умард Ирландын зохицуулалтын хүрээнд:

- Умард Ирландын шүүх, трибуналуудад хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд лайв холбоос ашиглах асуудал тус хуулийн хамрах хүрээнд

багтахаар зохицуулсан.

Хэдийгээр хуулийн 53-57 дугаар зүйлд дээрх байдлаар томьёолж хуульчилсан, өөр агуулгатай зохицуулалт байхгүй байх боловч мөн зүйлийн тайлбар хэсэг (англ. *explanatory notes*)-т дараах тайлбарыг баталжээ:⁴

96. КОВИД-19 цар тахлын улмаас шүүх, трибуналын хуралдааныг үр нөлөөтэй, цаг хугацаанд нь явуулах байдал алдагдана. Зорчих хөдөлгөөнд тогтоосон хязгаарлалтын улмаас талуудад шүүхэд очиход төвөгтэй байдал үүсэх тул олон тооны хуралдаан, шүүх хурал хойшлогдохоор байна. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд шүүхүүд хэргээ үр дүнтэй, түргэн шуурхай шийдвэрлэх үүрэгтэй бөгөөд **хуульд нийцүүлэн зохих ёсоор лайв видео холбоос, гар утас, цахим шуудан зэрэг технологи ашиглах** нь үүнд хамаарна. Улсын хэмжээнд нийт шүүхүүдэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд алсын зайнаас оролцох боломжийг ихэсгэж байх тул видео холболтын технологи ашиглах нь нэмэгдэж байна. Өнөөдрийн байдлаар шүүхүүд хуулиар болон эрх хэмжээнийхээ хүрээнд технологи ашиглах бүрэн эрхтэй юм.

97. Шүүх хуралдаанд нэг эсхүл хэд хэдэн оролцогч **лайв видео эсхүл аудио холбоосоор оролцох**, эсхүл танхимын шүүх хуралдаан явуулахгүйгээр **бүх оролцогч гар утас, видео хуралдаан явуулах хэрэгсэл ашиглаж оролцох** байдлаар бүрэн видео/аудио хуралдаан хийх боломжийг бүрдүүлэх нэмэлтийг энэ хуулиар хүчин төгөлдөр мөрдөж байгаа одоогийн хууль тогтоомжид оруулж байна.

98. Мөн хуулийн хүрээнд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг **олон нийт бүтнээр нь видео, аудио холбоосоор үзэж, сонсох боломжтой байхаар** зохицууллаа. Ингэснээр энэ хүрээнд явагдаж байгаа хуралдааныг **лайв стриймээр дамжуулах** боломжийг эрүү, гэр бүл, иргэний хэргийн шүүхүүдэд олгож байна.

99. Шүүх хуралдааны танхимд гэрэл зураг авах, дуу хураахтай холбоотой хязгаарлалт одоогийн хууль тогтоомжоор байгаа. 1925 оны Эрүүгийн хэргийн тухай хуулийн 41 дүгээр зүйлээр шүүхэд гэрэл зураг авахыг хориглосон. 1981 оны Шүүхийг үл хүндэтгэх тухай хууль (англ. *the Contempt of Court Act 1981*)-аар зөвшөөрөлгүй дуу хураахыг хориглосон. Шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогчийг хамгаалах зорилгоор ийнхүү хуульчилсан боловч энэ нь виртуал хуралдааны үзэл санаа бий болохоос бүр өмнөх зохицуулалт билээ. Иймд энэ хуулиар **оролцогчдыг хамгаалах** төстэй зохицуулалт бий болгож, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны **лайв стриймийг дамжуулах, бичих, виртуал хуралдаан, лайв-холболтын үеэр давхар зураг авах, дуу хураахыг хориглов**.

100. Энэ хуулиар халдвар өвчин туссан байж болзошгүй хүнд чиглэсэн хязгаарлалт тогтоохоор зохицуулж, холбогдох хязгаарлалтыг эс зөвшөөрвөл магистратын шүүхэд давж заалдах гомдол гаргаж болохоор зохицуулсан. Иймд мөн хуулиар хязгаарлалт тогтоолгосон хүний давж заалдах хурлыг танхимаар хийх тохиолдолд халдвар тархах эрсдэл байгаа гэж үзвэл шүүх өөрөөр шийдвэрлээгүй бол **холбогдох хуралдааныг дуустал нь видео холбоосоор явуулахаар** хуульчилсан.

⁴ Холбогдох зүйлийн тайлбар хэсэг, Coronavirus Act 2020, "Courts and tribunals: use of video and audio technology" (Explanatory Notes), <https://www.legislation.gov.uk/ukpga/2020/7/notes/division/24/index.htm>



Дээрхээс үзвэл шүүх хуралдааныг хэсэгчлэн болон бүтнээр нь цахимаар явуулах гэсэн хоёр төрлийн арга замыг шүүхүүд хэрэглэж болохоор байна. Ингэхдээ:

- Хэргийн оролцогчдын зарим нь танхимаар, зарим нь цахимаар (лайв видео эсхүл аудио холболтоор) оролцох;
- Хэргийн оролцогч, шүүгч бүгд цахимаар (гар утас, видео хуралдаан) оролцох гэсэн хоёр арга замаар шүүх хуралдааныг хийх боломжтой байна.

Дээрх 2020 оны Коронавирусийн тухай хуулийн холбогдох хэсгийн тайлбарын 98 дахь хэсэгт хуралдааныг лайв стриймээр дамжуулах боломжийг “эрүү, гэр бүл, иргэний хэргийн шүүхүүдэд” олгосноос үзвэл Эрүүгийн хэргийн шүүх, Гэр бүлийн шүүх, Иргэний хэргийн шүүхэд хянан шийдвэрлэх хэрэг маргаан хамаарахаар байна.

2. Цахим хэргийн хөдөлгөөн (E-case management):

Англи, Уэльсийн Цагдаагийн алба, Эзэн хааны прокурорын алба (англ. *Crown Prosecution Service*), дээр дурдсан Эзэн хааны шүүх, трибуналын үйлчилгээний алба хамтран эрүүгийн хэргийн хөдөлгөөнийг эхнээс нь дуустал цахимаар удирдах орчин бүрдүүлэх зорилготой “Нэгдсэн платформ” (англ. *Common Platform*) хөгжүүлж байна.⁵ Тус платформуор хөнгөн төрлийн, хөнгөрүүлэх нөхцөл байдалгүй, хорих ял оногдуулахааргүй гэмт хэрэгт холбогдсон сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийг цахимаар хэргээ шийдвэрлүүлэх

боломжийг олгож байгаа бөгөөд тус платформуор долоо хоног бүр 500 орчим торгуулийн хуудас төлөхөөс зайлсхийсэн зөрчлийг хянан шалгаж, шийдвэрлэж байна.⁶

Гэр бүлийн эрх зүйн маргааны хувьд эд хөрөнгийн маргаангүй, үл маргах журмаар шийдвэрлэх гэр бүлийн маргааныг цахимаар шийдвэрлэх платформуыг 2018 оны 4 дүгээр сард нээснээс хойш 5 сарын хугацаанд 14,000 цахим өргөдөл хүлээн авсан байна.⁷ Шүүхэд цаасан хэлбэрээр гаргасан өргөдлийн алдааг нь засуулж, дахин гаргуулахаар 40 хувийг нь буцаадаг байсан бол цахимаар өргөдөл хүлээн авснаас хойш ердөө 0.5 хувийг нь буцаадаг болжээ.⁸

Түүнчлэн, хуульд тухайлан заагаагүй боловч Англи, Уэльсийн шүүхийн практикт 2018 оны 3 дугаар сараас эхлэн “бага үнийн дүнтэй маргааныг цахимаар” шийдвэрлэж байх бөгөөд 10,000 фунтээс ихгүй хэмжээний мөнгөн дүнтэй холбогдох маргаанд хууль зүйн туслалцаа авалгүй оролцож байгаа хэргийн оролцогч цахимаар маргаанаа бүрэн шийдвэрлүүлэх боломжтой болжээ. 2021 оны байдлаар 25,000 маргааныг ийнхүү шийдвэрлэснээс хэрэглэгчдийн 90% нь үйлчилгээнд сэтгэл хангалуун буюу маш сэтгэл хангалуун байна гэжээ.⁹

3. Цахим баримт (E-filing):

Англи, Уэльсийн хэмжээнд замын хөдөлгөөний зөрчилд ногдуулсан торгуулийг эс зөвшөөрч давж заалдсан гомдлыг хянан шийдвэрлэх чиг үүрэгтэй

⁶ Ibid.

⁷ Ibid.

⁸ Ibid, p.167.

⁹ Ibid.

⁵ Richard Susskind, *supra* note 3, p.166.



Замын хөдөлгөөний торгуулийн давж заалдах трибунал (англ. *Traffic Penalty Appeal Tribunal - TPT*) нь 14 захиргааны ажилтантайгаар жилд дунджаар 25,000 хэрэг шийдвэрлэдэг бөгөөд 2006 оноос үйл ажиллагаагаа цахимжуулж, шийдвэрээ цахимаар гаргадаг болсон. Ингэхдээ 2016 онд FOAM систем (Давж заалдах гомдлын цахим, шуурхай менежмент – англ. *Fast Online Appeals Management*)-ийг хөгжүүлж, хэргийн хоёр тал цахимаар (англ. *a real-time basis*) холбогдож, хоорондоо болон шүүгчид үндэслэлээ танилцуулах боломжтой байхаар загварчилсан байна.¹⁰

Дээрх платформд интернэтэд холбогддог аливаа төхөөрөмж (ухаалаг гар утас, зөөврийн таблет)-өөр орж болох ба давж заалдах гомдлоо гаргах, нотлох баримтаа цахимаар оруулах (зураг, бичлэг, PDF өргөтгөлтэй файлууд), улмаар хэрэг шийдвэрлэх явцаа харах, хянах зэрэг бүх ажиллагааг цахимаар хийх боломжтой. Талууд хоорондоо зурвас явуулах, лайв чат ашиглах зэрэг аргуудаар холбогдож болохоос гадна шүүгч талуудаас тодруулга авах, нэмэлт баримт шаардах бол хэзээ ч, хаанаас ч холбогдож болох давуу талтай юм. Мөн нотлох баримт, хариу тайлбарыг платформд оруулсны дараа талууд хуралдаан хийхгүйгээр шийдвэр гаргуулах эсхүл утсаар хуралдаж шийдвэр гаргуулах гэсэн сонголтоос сонгож, “и-шийдвэр” гаргуулна. Аль ч тохиолдолд трибуналын шийдвэр FOAM системд байршина.¹¹

Замын хөдөлгөөний торгуулийг давж заалдах журмаар цахимаар

шийдвэрлэснээс хойш тус трибуналын бүх шийдвэрийн ердөө 10 хувь нь танхимын хуралдаанд үндэслэж гарч байгаа бөгөөд гомдол гаргасан өдөртөө нийт хэргийн 11 хувь нь хаагдаж, 25 хувь нь долоо хоногийн дотор, 45 хувь нь өдөртөө, 70 хувь нь дөрөв буюу түүнээс дээш долоо хоногийн дотор бүрэн шийдвэрлэгдэж байна. 2018 оны 7 дугаар сард хэргийн оролцогчоос авсан судалгаагаар 95 хувь нь FOAM системийг бусдад “заавал санал болгоно”, “санал болгоно” гэж хариулжээ.¹²

ИБУИНХУ-д өнөөдрийн байдлаар шүүхийн цахимжилтын талаар тухайлсан хууль байхгүй боловч КОВИД-ын үеийн цар тахлын тархалтыг бууруулах зорилгоор 2020 онд баталсан “Коронавирусийн тухай хууль”-д шүүх хуралдааныг цахимаар явуулж болох тухай заасан байна. Ингэхдээ шүүх хуралдааныг бүрэн болон хэсэгчлэн цахимаар явуулах гэж хоёр ангилсан байна.

ХОЁР. БҮГД НАЙРАМДАХ ХЯТАД АРД УЛСЫН ЗОХИЦУУЛАЛТ

БНХАУ 2012 онд Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль (1991)-даа цахим өгөгдлийг нотолгооны хэрэгслээр хүлээн зөвшөөрсөн зохицуулалт нэмэлтээр хуульчилснаар¹³ шүүхийн цахимжилт нэвтрүүлж эхэлжээ. Улмаар 2015 онд Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн хэрэглээний тайлбарт “Цахим өгөгдөл гэдэгт цахим шуудан, цахим зурвас, гар утасны зурвас, блог, микроблог, цахим гарын үсэг, домэйн, дуу, дүрсний бичлэг гэх мэт цахим

¹⁰ Ibid, p.170.

¹¹ Ibid.

¹² Ibid.

¹³ Zhuhao Wang, “China’s E-Justice Revolution”, *Judicature*, 105 №1, (2021), 37



хэрэгсэлд үүссэн буюу хадгалагдсан мэдээллийг хэлнэ”¹⁴ гэж заасан байна.

Шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг цахим технологийн тусламжтай явуулах, нэвтрүүлэх ажлыг тус улсын Ардын дээд шүүх (англ. *the Supreme People's Court of China*)-ээс идэвхтэй өрнүүлсэн. Түүнчлэн, 2017 онд “Ухаалаг шүүх” төслийг хэрэгжүүлж, шүүхэд хэрэг үүсгэхээс эхлээд шүүхийн шийдвэр биелүүлэх хүртэлх бүх ажиллагааг цахимжуулах, системийн бүтээн байгуулалтыг хурдасгах тухай санал гаргаж байсан байна.¹⁵ Үүний үр дүнд Бээжин, Гуанжоу, Ханжоу зэрэг хотод “Интернэт шүүх” байгуулагдаж, тус шүүхэд хандсан маргааны оролцогчдын 80% нь хувь хүн, 20% нь аж ахуйн нэгж байсан ба нийт шийдвэрийн 98% нь хүчин төгөлдөр болсон байна.¹⁶

1. Цахим шүүх хуралдаан (E-court):

БНХАУ-ын Ардын шүүхийн тухай хууль (2018)-ийн 58 дугаар зүйлд “Ардын шүүхүүд мэдээллийн технологийн бүтээн байгуулалтыг эрчимжүүлж, орчин үеийн мэдээллийн технологийг ашиглаж, шүүхийн ил тод байдлыг ахиулж, ажлын үр ашгийг дээшлүүлэх ёстой” гэж заасан байна. Шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг цахимжуулах талаар бие даасан хууль байхгүй боловч “Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хууль” (1991), “Интернэт шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх тухай журам” (2018), “Ардын

дээд шүүхийн онлайн шүүх хуралдааны дүрэм” (2021), “Ардын шүүхийн онлайн эвлэрүүлэн зуучлах ажиллагааны дүрэм” (2021), “Ардын шүүхийн онлайн үйл ажиллагааны дүрэм” (2022) зэрэг хэм хэмжээнүүдээр цахимаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг зохицуулсан байна.

2. Цахим хэргийн хөдөлгөөн (E-case management):

Ардын дээд шүүхийн онлайн шүүх хуралдааны дүрэм (2021)-ийн 1 дүгээр зүйлд Ардын шүүх болон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогч цахим мэдүүлгийн платформ (англ. *the electronic litigation platform*) ашиглан “хэрэг үүсгэх, эвлэрүүлэн зуучлал, нотлох баримт гаргах, лавлагаа (англ. *inquiry*), шүүх хурал болон бусад үйлчилгээг интернэт орчинд авах боломжийг бүрдүүлжээ. Мөн цахим хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь уламжлалт хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа (англ. *offline litigation*)-ны нэгэн адил хууль зүйн үр дагавартай байхаар заасан байна.

Дээрх дүрмийн 3 дугаар зүйлд талуудын хүсэл зориг, хэргийн нөхцөл байдал, техникийн боломж зэрэг холбогдох бүх хүчин зүйлсийг харгалзаж дараах төрлийн хэрэг маргааныг цахимаар шийдвэрлэхээр зохицуулсан байна:

- Иргэний болон захиргааны хэрэг;
- Хялбаршуулсан (англ. *expedited procedure*) хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хамаардаг гэмт хэрэг, тэнсэн харгалзах ял оногдуулах, хөнгөн гэмт хэрэг болон уламжлалт хэрэг

¹⁴ 最高人民法院，关于适用《中华人民共和国民事诉讼法》的解释（2015），第一百一十六条。

¹⁵ 最高人民法院关于加快建设智慧法院的意见。

¹⁶ “Robot justice: China’s use of Internet courts”, *The Lawyer’s Daily*, (Сүүлд үзсэн: 2024.02.19),

<https://www.lexisnexis.ca/en-ca/ihc/2020-02/robot-justice-chinas-use-of-internet-courts.page>



хянан шийдвэрлэх ажиллагаа тохиромжгүй гэмт хэргүүд;

- Онцгой төрлийн иргэний хэрэг маргаан, өр барагдуулах болон дампуурлын хэрэг;
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэл;
- Цахимаар шийдвэрлэхэд тохиромжтой бусад хэрэг.

Мөн тус улсын цахим шүүх нь худалдах, худалдан авах онлайн гэрээ, дуу хөгжим, видеог онлайнгаар худалдах, түгээлт, санхүүгийн зээл болон бага үнийн дүнтэй зээл, зохиогчийн эрх, домэйн нэр, өмчлөх эрх болон бусад хувийн эрх, бараа бүтээгдэхүүний доголдолтой холбоотой маргаан, прокурорын байгууллагаас гаргасан нийтийн ашиг сонирхолд холбогдох маргаан, онлайн худалдаа, үйлчилгээнд холбогдох захиргааны маргаан, Ардын дээд шүүхээс тодорхойлсон иргэний болон захиргааны бусад хэргийг тус тус шийдвэрлэдэг байна.¹⁷

Тус Ардын дээд шүүхийн тайлбарын 1 дүгээр зүйлд “цахим шүүхэд хэрэг хүлээн авах, нотлох баримт гаргах, шүүх хуралдааны бэлтгэл, шүүх хурал, шийдвэр гаргах зэрэг бүхий л үйл ажиллагааг нийтлэг байдлаар цахимаар явуулах ёстой” хэмээн заасан байна. Мөн Ардын дээд шүүхийн онлайн шүүх хуралдааны дүрэм (2021)-ийн 9 дүгээр зүйлд цахимаар нэхэмжлэл гаргасан тохиолдолд хэрхэн шийдвэрлэх талаар зохицуулсан байна.

¹⁷ 最高人民法院关于互联网法院审理案件若干问题的规定 (2018).

<http://gdfs.customs.gov.cn/customs/ztl86/302310/5366122/gjmylyflgf/5402808/5402830/index.html>

Тус улсад шүүхийн баримт бичгийг цахимжуулах хүрээнд Ардын дээд шүүхээс “Хятадын шүүхийн шийдвэрийн цахим сүлжээ” (англ. *China Judgments Online*) (<http://wenshu.court.gov.cn/>)-г хөгжүүлэн, сүлжээгээр дамжуулан шүүхийн бүхий л баримт бичигтэй (англ. *all court files*) танилцаж болохуйц нээлттэй цахим санг бий болгосон байна¹⁸.

3. Цахим баримт (E-filing):

Дээр дурдсанчлан тус улсын Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд цахим өгөгдлийг нотолгооны хэрэгсэл байхаар зохицуулсан байна.

Түүнчлэн нотлох баримтыг цахимжуулах хүрээнд блокчэйн систем ашиглах талаарх харилцааг журмаар зохицуулжээ.¹⁹ Нотлох баримтыг блокчэйд байршуулахын тулд Ардын дээд шүүх талуудад нотлох баримтыг танилцуулж, шалгаж, баталгаажуулах бөгөөд Ардын дээд шүүхээс баталгаажуулаагүй нотлох баримт нь хэргийн бодит байдлыг тогтоох үндэслэл болдоггүй байна. Харин нотлох баримтыг блокчэйд оруулсан хойно нотлох баримтын үнэн зөв эсэх талаарх гарсан маргааныг Ардын дээд шүүхийн онлайн шүүх хуралдааны дүрэм (2021)-ийн 17 дугаар зүйлд зохицуулсан байна.

Тус улсын шүүхийн цахимжилтын эрх зүйн орчны хувьд юун түрүүнд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуульд нотолгооны хэрэгслийн нэгэн төрөл нь “цахим өгөгдөл” байхаар зохицуулсан нь шүүхийн цахимжилтын суурийг тавьж, Ардын шүүхийн тухай хуульд заасан мэдээллийн технологийг

¹⁸ Zhu hao Wang, *supra* note 12. 37.

¹⁹ 最高人民法院关于互联网法院审理案件若干问题的规定 (2018), 第九条.



ашиглаж ажлын үр ашгийг дээшлүүлэх тухай зохицуулалтыг удирдлага болгосоор цахим шүүх, цахим шүүх хуралдааны талаарх дүрэм журмуудыг баталж, мөрдөж байна.

ГУРАВ. ЭСТОНИ УЛСЫН ЗОХИЦУУЛАЛТ

Эстони улсын шүүхийн цахимжилт нь Шүүхийн мэдээллийн систем (англ. *The court information system*), Цахим файл боловсруулах мэдээллийн систем (англ. *E-file proceedings information system*) болон Нийтийн цахим файлын портал (англ. *Public e-File portal*) зэргээс бүрддэг²⁰ байна. Шүүхийн цахимжилттай холбоотой харилцааг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль²¹ (англ. *Code of Civil Procedure*), Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль²² (англ. *Code of Criminal procedure*)-д хуульчилсан хэдий ч бие даасан хууль тогтоомж батлаагүй байна.²³

1. Цахим шүүх хуралдаан (E-court):

Шүүх хуралдааныг цахимаар явуулах болон маргааныг хиймэл оюун ухаанаар шийдвэрлэх тухай эрх зүйн зохицуулалт тус улсад байдаггүй. Гэвч хэргийн оролцогч гадаадад байгаа тохиолдолд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд

цахимаар оролцох боломжтой²⁴. Шүүх хурлыг цахимаар явуулахад тодорхой маргааны төрлийг заасан хязгаарлалт байхгүй.

2. Цахим хэргийн хөдөлгөөн (E-case management):

Цахим файл боловсруулах мэдээллийн систем (англ. *E-file proceedings information system*)-ээр дамжуулан нэхэмжлэл, хариу тайлбарыг цахимаар гаргах боломжтой. Энэхүү асуудлыг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 60¹ дүгээр зүйл болон Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 210 дугаар зүйлд тус тус зохицуулсан.

Эстонийн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль (2003)

210 дугаар зүйл.

Цахим файл боловсруулах мэдээллийн систем (англ. *E-File processing information system*);

(1) Цахим файл боловсруулах систем нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны мэдээлэл болон хувь хүний мэдээллийг боловсруулахад зориулагдсан төрийн мэдээллийн системд хамаарах бөгөөд дараах зорилготой :

1) Мөрдөн байцаах байгууллага, прокурор, шүүхээс хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулж байгаа эрүүгийн хэргийн талаарх тоймыг гаргах;

2) Эрүүгийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хийсэн үйлдлийн талаарх мэдээллийг тусгах;

3) Шүүхийн ажлыг зохион байгуулах;

4) Эрүүгийн бодлогын талаар шийдвэр гаргахад шаардлагатай гэмт хэргийн статистик мэдээлэл цуглуулах;

5) Мэдээлэл, баримт бичгийг цахимаар илгээх боломжийг бүрдүүлэх.

²⁰ E-Justice factsheet <https://e-estonia.com/wp-content/uploads/2019aug-facts-a4-v04-e-justice.pdf>

(Сүүлд үзсэн: 2024.02.15) .

²¹ Code of Civil Procedure (2005). <https://www.riigiteataja.ee/en/eli/513122013001/consolide> (Сүүлд үзсэн: 2024.02.16).

²² Code of Criminal Procedure (2003). <https://www.riigiteataja.ee/en/eli/530102013093/consolide> (Сүүлд үзсэн: 2024.02.16).

²³ Эстони улсын төрийн мэдээллийн эмхэтгэлийн цахим хуудаснаас бүх хуулиудыг нэг бүрчлэн шүүж үзэхэд (Эст. Riigi Teataja) тус харилцааг зохицуулсан бие даасан хууль байхгүй байна. <https://www.riigiteataja.ee/en/>

(Сүүлд үзсэн:2024.02.15).

²⁴ A step towards the digital future - how is justice administered in Estonia," 2023<https://rit.ee/en/news/step-towards-digital-future-how-justice-administered-estonia>,

(Сүүлд үзсэн:2024.02.15).



Эстониин Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль (2005)

60¹ дүгээр зүйл.

Цахим файл боловсруулах мэдээллийн систем (англ. *E-file proceedings information system*)

(1) Цахим файл боловсруулах мэдээллийн систем нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны мэдээлэл болон хувь хүний мэдээллийг боловсруулахад зориулагдсан төрийн мэдээллийн системд хамаарах бөгөөд дараах зорилготой:

- 1) Шүүхээр шийдвэрлэгдсэн иргэний хэргийн талаар тойм гаргах;
- 2) Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны баримт бичгийг байршуулах;
- 3) Шүүхийн ажлыг зохион байгуулах боломж бүрдүүлэх;
- 4) Хууль зүйн бодлогын шийдвэр гаргахад шаардлагатай статистик мэдээлэл цуглуулах;
- 5) Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны мэдээлэл, баримт бичгийг цахимаар илгээх боломж бүрдүүлэх.

Эстони улсын Шүүхийн тухай хуулийн 34-р зүйл, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 274 дүгээр зүйл,²⁵ 441 дүгээр зүйлд²⁶ заасны дагуу Нийтийн цахим файлын портал болон Шүүхийн мэдээллийн системээр дамжуулан хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гарсан тогтоол, захирамж болон хавтаст хэрэгтэй цахимаар танилцаж, мөн шүүхийн шийдвэрийг цахимаар байршуулах боломжтой.

²⁵ Code of Civil Procedure (2005) § 274 (1) “Цахим баримт бичгийг шүүхэд хэвлэсэн хэлбэрээр ирүүлэх эсвэл шүүхийн мэдээллийн системд зөвшөөрөгдөх форматаар шүүхийн мэдээллийн системээр илгээнэ.”

²⁶ Code of Civil Procedure (2005) § 441 (1) “Шүүх шүүхийн шийдвэрийг Эстони хэлээр цахим хэлбэрээр бэлтгэж, шийдвэр гаргасан шүүгчийн цахим гарын үсгээр гарын үсэг зурна. Шүүх шүүхийн мэдээллийн системд шүүхийн шийдвэрийг нэн даруй бүртгэнэ.”

3. Цахим баримт (E-filing):

Эстонид шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны баримт бичгийг Цахим файл боловсруулах мэдээллийн систем, Нийтийн цахим файлын порталаар дамжуулан гаргах боломжтой. Процессын хуульд цахимаар гаргаж болохгүй нотлох баримтыг хуульчилж заагаагүй. Өмгөөлөгч, нотариатч, шүүхийн шийдвэр гүйцэтгэгч, дампуурлын хэргийн итгэмжлэгдсэн төлөөлөгч, төрийн болон орон нутгийн захиргааны байгууллага нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны баримт бичгийг өөр хэлбэрээр гаргах хүндэтгэн үзэх шалтгаангүй бол хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулж буй байгууллагад өргөдөл, гомдол, бусад баримт бичгийг цахимаар гаргана.²⁷ Иргэний болон Эрүүгийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаанд шүүхүүд цаас ашигладаггүй буюу хавтаст хэрэг бүрэн цахимжсан²⁸.

ДӨРӨВ. СИНГАПУР УЛСЫН ЗОХИЦУУЛАЛТ

Сингапур улсад 2000 оноос “Цахим мэдүүлгийн систем” (англ. *Electronic Filing System*)-ийг шүүхийн баримт бичиг бүрдүүлэхэд ашиглаж эхэлснээр иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд томоохон дэвшил болсон. Цахим мэдүүлгийн системийг цаг үеийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэх үүднээс илүү үр өгөөжтэй болгох хэрэгтэйг шүүхийн байгууллагууд хүлээн зөвшөөрч *eLitigation* системийг хэрэгжүүлснээр

²⁷ Code of Criminal Procedure (2003) § 1602 (3). (Сүүлд үзсэн: 2024.02.16).

²⁸ A step towards the digital future - how is justice administered in Estonia,” 2023, <https://rit.ee/en/news/step-towards-digital-future-how-justice-administered-estonia>, (Сүүлд үзсэн:2024.02.15).



орчин үеийн технологи ашиглах, Цахим мэдүүлгийн системийн чадавхыг нэмэгдүүлэх дараагийн алхам болжээ. Улмаар *eLitigation*-ийн тусламжтай иргэд шүүхэд цахимаар өргөдөл, баримт бичиг гаргаж хянах боломжтой болсон. Системээр дамжуулан шүүхэд хэрэг маргаан хянан шийдвэрлэх явцад хэргийн материалтай бүхэлд нь танилцах, шүүх хуралдааны товыг харьцангуй чөлөөтэй сонгож болдог ороо ихээхэн ашиг тустай байдаг байна.²⁹

1. Цахим шүүх хуралдаан (E-court)

Сингапурт шүүхүүд цахим мэдүүлгийн иж бүрэн системтэй бөгөөд *eLitigation* платформ нь хэргийн оролцогч эсхүл өмгөөлөгчид бичиг баримт, хүсэлт гаргах, төлбөр хийх бололцоог цогц шийдсэн. Шүүхийн шатанд *eLitigation*-ийг заавал ашиглах бол бусад платформууд нь хэрэглэгчийн өөрийнх нь сонголтын асуудал байдаг байна.³⁰ Сингапур улс шүүхийн цахим харилцааг *Шүүхийн тухай дүрэм 2021* (англ. *Rules of Court 2021*)³¹-ийн 28 дугаар зүйл, *Сингапурын олон улсын арилжааны шүүхийн дүрэм 2021* (англ. *Singapore International Commercial Court*)³²-ийн 27 дугаар зүйл, *Нотлох баримтын тухай хууль 1893* (англ. *Evidence Act 1893*)³³.

²⁹ "About eLitigation," eLitigation, https://www.elitigation.sg/_layouts/IELS/HomePage/Pages/AboutElit.aspx (Сүүлд үзсэн: 2024.02.23)

³⁰ "CMS Expert Guide to Digital Litigation," CMS law firm, <https://cms.law/en/int/expert-guides/cms-expert-guide-to-digital-litigation/singapore>

³¹ Rules of Court (2021), Order 28. Rules of Court 2021 - Singapore Statutes Online (agc.gov.sg) (Сүүлд үзсэн: 2024.02.23)

³² Singapore International Commercial Court Rules (2021), Order 27. Singapore International Commercial Court Rules 2021 - Singapore Statutes Online (agc.gov.sg) (Сүүлд үзсэн: 2024.02.23)

³³ Evidence Act (1893), 62A. Evidence Act 1893 - Singapore Statutes Online (agc.gov.sg) (Сүүлд үзсэн: 2024.02.23)

ийн 62A дугаар зүйлд тус тус нарийвчлан зохицуулжээ. *Шүүхийн тухай дүрмийн 28* дугаар зүйлийг хэрэг маргааны төрлөөс үл хамааран бүх шүүхийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны цахим харилцаанд дагаж мөрддөг.

Шүүн таслах ажиллагаанд зарим харилцааг цахимаар явуулах боломжийг бусад хуульд буюу Сингапурын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль (англ. *Criminal Procedure Code*)³⁴-ийн 2 дугаар бүлгийн 226 дугаар зүйлд шүүгдэгч гэм буруугаа цахимаар хүлээхээр зохицуулсан байна.

Сингапурын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль (2010)

Гэм буруугаа цахимаар хүлээх

226. (1) Хуульд заасан гэмт хэрэгт буруутгагдаж буй этгээд энэ хэсгийн (7)(c)-д заасан торгууль, тогтоосон хураамжийг төлж гэм буруугаа (7)(b)-д зааснаар цахимаар хүлээж болно.

(2) Цахим хэлбэрээр гэм буруугаа хүлээхийн тулд яллагдагч нь:

(а) тогтоосон хугацаанд Улсын шүүхийн бүртгэлийн ажилтны хариуцаж буй цахим систем дээр гэм буруугаа хүлээн зөвшөөрөх тухай хүсэлт гаргах; болон

(б) тухайн гэмт хэрэгт гэм буруугаа цахимаар хүлээн зөвшөөрсөн яллагдагч нь шүүгчээс ялын төрлийг харгалзан тогтоосон торгуулийг урьдчилан төлөх.

Сингапурын Гэр бүлийн хэрэг маргаан хянан шийдвэрлэх тухай хууль (англ. *Family Justice Act 2014*)³⁵-ийн 11 дүгээр зүйлд гэр бүлийн маргааны шүүх хурлыг цахимаар хийж болохоор хуульчилсан.

Сингапурын Гэр бүлийн хэрэг маргаан хянан шийдвэрлэх тухай хууль (2014)

³⁴ Criminal Procedure Code 2010, 226. <https://sso.agc.gov.sg/Act/CPC2010?ProvlDs=P111-P22-#P111-P22> (Сүүлд үзсэн: 2024.02.23)

³⁵ Family Justice Act (2014), 11. <https://sso.agc.gov.sg/Act/FJA2014?ProvlDs=P12-#pr11> (Сүүлд үзсэн: 2024.02.23)



Шүүх хуралдааныг цахим харилцааны хэрэгслээр явуулж болно.

11. (1) Гэр бүлийн маргаан хянан шийдвэрлэх шүүх нь шүүх хуралдааныг (Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх журам эсвэл Гэр бүлийн шүүхийн дүрэмд заасан хэрэг, хянан шийдвэрлэх ажиллагаанаас бусад) шууд дамжуулан явуулж болно. Эдгээр нь шууд дамжуулалттай дүрс бичлэг, телевиз, аудионы цахим холбоос болон Ерөнхий шүүгчээс баталсан бусад цахим харилцаа холбооны хэрэгсэл болно. Энэ хэсэгт Гэр бүлийн хэрэг маргаан хянан шийдвэрлэх тухай хуулийн 10 дугаар зүйл үл хамаарна.

2. Цахим хэргийн хөдөлгөөн (E-case management):

Өдгөө Сингапур улсад шүүхийн үйлчилгээг хэд хэдэн цахим платформоос авах боломжтой бөгөөд эдгээрийн тусламжтай цахимаар шүүхэд нэхэмжлэл гаргах, хэргийн хөдөлгөөнийг хянах болон бусад үйлчилгээг авч болно. Тухайлбал:

1. **Authentic Court Orders (ACO)** – Шүүхийн шийдвэрийн батламжийг цахимаар үнэ төлбөргүй авахад;
2. **Community Justice and Tribunals System (CJTS)** – Хөдөлмөрийн маргааны шүүх, Олон нийтийн маргаан хянан шийдвэрлэх шүүх болон Зөрчлийн хэргийн зэрэг шүүхүүдээс цахим үйлчилгээ авахад;
3. **eLitigation** – Нийт улсын болон Дээд шүүхийн иргэний хэрэг маргаан, Гэр бүлийн шүүхийн маргаан болон Дээд шүүхийн эрүүгийн хэрэгт холбогдуулан баримт бичиг гаргахад;
4. **Integrated Case Management System (ICMS)** – Эрүүгийн хэргийн

шүүх болон Насанд хүрээгүй хүний эрүүгийн хэргийн шүүх, замын хөдөлгөөний дүрмийн зөрчлийн талаарх өргөдөл, баримт бичгийг цахимаар гаргахад;

5. **Integrated Family Management System (iFAMS)** – Гэр бүлийн шүүхийн зарим маргаанд асран хамгаалалт тогтоолгох, хялбаршуулсан журмаар шийдвэрлүүлэх зэрэг захирамжийг цахимаар гаргахад;
6. **Divorce eService** – Гэр бүлийн шүүхэд хялбаршуулсан журмаар гэрлэлт цуцлах өргөдөл гаргах эсвэл шүүхийн холбогдох баримт бичгийг бүрдүүлэхэд;
7. **Portable eService** – Нас барсан иргэний хөрөнгийг гэрээслэлийнх нь дагуу захиран зарцуулах зөвшөөрөл шүүхээс хүсэх зэргээр тус тус дээрх цахим платформуудыг ашигладаг байна.³⁶

Дээрх платформуудаар дамжуулан хэргийн хөдөлгөөнийг хянах буюу цахимаар хэрэг үүсгэхээс бусдаар шүүхийн шийдвэр гарах хүртэлх бүх үе шатыг хамруулсан тусдаа эрх зүйн зохицуулалт Сингапур улсад байхгүй байна.

Өмнө дурдсанчлан нийт шүүхийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явц дахь цахим харилцааг Шүүхийн тухай дүрмийн дагуу явуулдаг бөгөөд Шүүхийн бүртгэлийн ажилтан (*англ. The Registrar*) иргэдээс ирсэн цахим баримт бичгийг бүрдүүлэх, гүйцэтгэх, хүргүүлэх

³⁶ "E-Platforms," Сингапурын шүүхийн нэгдсэн цахим хуудас, <https://www.judiciary.gov.sg/services/e-platforms> (Сүүлд үзсэн: 2024.01.30)



болон цахим мэдүүлгийн системийг (цахим платформ) ашиглан дамжуулах нөхцөлийг бүрдүүлж ажилладаг³⁷. Ингэхдээ цахим мэдүүлгийн систем буюу цахим платформ ашиглах, платформын үйл ажиллагааг хянах захиргааны ажилтан, цахим баримт бичгийн бүрдүүлэлтэд туслуулах зорилгоор төлөөлөгчийг томилох, төлөөлөгчөөр дамжуулан товчоо байгуулах эрх хэмжээг уг дүрмийн 28 дугаар тушаалын 2, 3, 5 дугаар зүйлүүдэд тусгагджээ. Харин 6 дугаар зүйлд цахим үйлчилгээ авагчийн бүртгэл, эрх, үүргийг заасан байна.

Дээрх цахим платформ, хууль тогтоомжоос үзвэл хэргийн оролцогч шүүхэд баримт бичиг бүрдүүлж өгөх бүхий л ажиллагааг цахимаар явуулах боломжийг хангаж өгсний сацуу хариуцах шүүхийн эрх бүхий ажилтан, уг харилцаанд хөндлөнгийн туслалцаа үзүүлэх чиг үүрэг бүхий төлөөлөгч, төлөөлөгчөөр дамжуулан товчоо байгуулах боломжийг олгосноороо шүүхийн цахимжилтыг иргэдэд түргэн шуурхай, хүртээмжтэй болгосон гэж болохоор байна. Мөн Шүүхийн тухай дүрэмд хэрэглэгчийн бүртгэл, эрх, үүргийг тодруулснаас гадна 28 дугаар зүйлийн 7-д төлбөрийн хэмжээг нэг бүрчлэн заасан байгааг дурдах нь зүйтэй.

3. Цахим баримт (E-filing):

Нотлох баримтын тухай хуулийн 62А дугаар зүйлд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа, шүүхийг үл хүндэтгэх зөрчлөөс бусад аливаа хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд шүүхийн зөвшөөрөлтэйгөөр шууд дамжуулалттай дүрс бичлэгээр нотлох баримтыг өгч болно гэжээ. Ингэхдээ 18 насанд хүрээгүй

гэрч, Сингапурын нутаг дэвсгэрийн гадна байгаа гэрч, талууд нотлох баримтыг цахимаар гаргаж өгөх талаар харилцан тохиролцсон, шүүхээс зөвшөөрсөн байх зэрэг шаардлагыг хангасан байхыг заасан байна.

Шүүхийн тухай дүрмийн 28 дугаар зүйлийн 8-ын 3-т баримт бичгийг цахимаар мэдүүлэх, хүргэх, дамжуулах 2 төрлийн арга зам байгаагаас эхнийх нь цахимаар явуулах, хоёр дахь нь үйлчилгээ үзүүлэгч товчоогоор дамжуулах юм. Харин цахимаар мэдүүлэх үед бүртгэлтэй хэрэглэгч өөрийн таних кодыг ашиглах ба энэ нь бүртгэлийн ажилтан мэдүүлгийг баталгаажуулах гол түлхүүр болно. Шүүхийн тухай дүрмийн дагуу гарын үсэг зурсан байх шаардлагатай бүхий л бичиг баримтад баталгаажуулах кодыг хавсаргаснаар гарын үсэг зурсанд тооцогдоно.³⁸

ТАВ. АВСТРАЛИ УЛСЫН ЗОХИЦУУЛАЛТ

Австралийн Хамтын Нөхөрлөлийн Улс (англ. *Commonwealth of Australia*) нь Шинэ Өмнөд Уэльс (англ. *New South Wales*), Квийнслэнд (англ. *Queensland*), Өмнөд Австрали (англ. *South Australia*), Тасмани (англ. *Tasmania*), Викториа (англ. *Victoria*), Баруун Австрали (англ. *Western Australia*) гэсэн зургаан мужтай бөгөөд Австралийн нийслэл хотын бүс (англ. *Australian Capital Territory*), Хойд хэсгийн бүс (англ. *Northern Territory*) гэсэн хоёр тусгай засаг захиргааны нэгжтэй. Шүүхийн тогтолцооны хувьд Австралийн Хамтын Нөхөрлөлийн Улсын Дээд шүүх (англ. *High Court of Australia*) (цаашид "АХНУ-ын Дээд шүүх" гэх), Австралийн Холбооны шүүх (англ.

³⁷ Rules of Court (2021), Order 28, r.2.

³⁸ Rules of Court (2021), Order 28, r.8 (7).




Federal Court of Australia), Австралийн Холбооны тойргийн болон гэр бүлийн шүүх (англ. *Federal Circuit and Family Court of Australia*), Дээд шүүхүүд (англ. *Supreme Courts*), Дундын шүүхүүд (англ. *Intermediate Courts*), Доод шатны шүүхүүд (англ. *Lower Courts*)-ээс бүрддэг.

Австралийн хувьд 2020 оноос шүүхийн баримт бичгийг цаасан хэлбэрээс цахим хэлбэрт шилжүүлжээ.³⁹

Австралийн Хамтын Нөхөрлөлийн Улсын хуулиудаас гадна дээрх 8 засаг захиргааны нэгж бүр өөрийн гэсэн хууль тогтоомжтой, шүүхүүд нь мөн өөр өөрийн дүрмээр үйл ажиллагаагаа зохицуулдаг байх тул тус улсын шүүхийн цахимжилтын эрх зүйн орчныг АХНУ-ын Дээд шүүх, Австралийн Холбооны шүүх, Австралийн Холбооны тойргийн болон гэр бүлийн шүүхийн эрх зүйн зохицуулалтын хүрээнд судаллаа.

Схем 1. Австралийн Хамтын Нөхөрлөлийн Улсын шүүхийн тогтолцоо⁴⁰



³⁹ Австралийн Хамтын Нөхөрлөлийн Улсын Дээд шүүхийн албан ёсны цахим хуудас, <https://www.hcourt.gov.au/registry/filing-documents>

⁴⁰ Australian Court hierarchy, <https://www.ruleoflaw.org.au/crime/criminal-trial-processes/criminal-law-processes-court-jurisdiction/>



Австрали улсын шүүхийн тогтолцоонд цахим шүүх хуралдаан, цахим хэргийн хөдөлгөөн, цахим баримт бичгийн хэлбэрүүд нутагшсан байх бөгөөд АХНУ-ын Дээд шүүх нь [Digital Lodgment System Portal](#)⁴¹, Австралийн Холбооны шүүх, Австралийн Холбооны тойргийн болон гэр бүлийн шүүхүүд нь [eLodgment](#)⁴² системийг тус тус ашиглан цахим нотлох баримт гаргах, хэргийн үйл явцын талаар мэдээлэл авах, мэдэгдэл хүлээн авах зэрэг боломжтой байдаг байна.

Цахимаар шүүх хуралдаан явуулах, хэргийн хөдөлгөөнийг цахимжуулах болон цахим нотлох баримт зэрэг шүүхийг цахимжуулахтай холбоотой тухайлсан нэгдсэн хууль Австрали улсад байхгүй байна. Харин цахим нотлох баримтын тухай эрх зүйн зохицуулалтыг муж бүр өөр өөрийн Нотлох баримтын хууль (англ. *Evidence Act*)-даа зохицуулсан байх ба Австралийн Холбооны шүүх, Австралийн Холбооны тойргийн болон гэр бүлийн шүүхүүд нь мөн өөр өөрийн дүрэмд тусгажээ. Энэ талаар дэлгэрэнгүй авч үзье.

1. Цахим шүүх хуралдаан (E-court):

Австралийн Холбооны шүүх, Австралийн Холбооны тойргийн болон гэр бүлийн шүүхүүд нь [eCourtroom](#)⁴³ системийг ашиглан шүүх хуралдаанаа цахимаар явуулдаг байна. Цахимаар шүүх хуралдаан явуулахтай холбоотой зохицуулалтыг Австралийн холбооны шүүхийн хууль⁴⁴-ийн 47 дугаар зүйл,

⁴¹ Digital Lodgment System Portal <https://dls.hcourt.gov.au/static/>

⁴² eLodgment, <https://www.elodgment.fedcourt.gov.au/eLodgment/login.aspx?ReturnUrl=%2feLodgment%2fdefault.aspx/>

⁴³ eCourtroom, <https://www.ecourtroom.fedcourt.gov.au/ecourtroom/default.aspx>

⁴⁴ Federal Court of Australia Act 1976, <https://www.legislation.gov.au/C2004A01586/2018-08-25/text>

Австралийн Холбооны тойргийн болон гэр бүлийн шүүхийн тухай хууль⁴⁵-ийн 66-72 дугаар зүйлд тусгажээ.

Харин АХНУ-ын Дээд шүүх цахимаар шүүх хуралдаан явуулдаг тухай мэдээлэл тус шүүхийн цахим хуудас болоод бусад мэдээллийн санд байхгүй байх ба түүнтэй холбоотой эрх зүйн зохицуулалт мөн байгаагүйг дурдах нь зүйтэй.

Австралийн Холбооны шүүхийн хууль (1976)

47A Видео холбоос, аудио холбоос эсхүл бусад хэрэгслээр дамжуулан мэдүүлэг өгөх	
(1)	Шүүх эсхүл шүүгч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зорилгоор видео холбоос, аудио холбоос эсхүл бусад хэрэгслийг ашиглан мэдүүлэг өгөхийг зөвшөөрч болно.
47C Видео холбоос, аудио холбоос эсхүл бусад хэрэгслийг ашиглах нөхцөл	
Видео холбоос	
(1)	Шүүх эсхүл шүүгч дараах нөхцөлүүдийг хангасан гэж үзэхгүй байгаа бол видео холбоос, аудио холбоос эсхүл бусад хэрэгслээр дамжуулан мэдүүлэг өгөхийг зөвшөөрөхгүй байж болно.
(a)	Шүүх танхим эсхүл шүүхийн бусад танхим нь тухайн танхимд байгаа хүмүүст хүртээмжтэй (харж, сонсох боломжтой) тоног төхөөрөмжөөр тоноглогдсон байна.
(b)	Алслагдсан этгээд (шүүх хуралдаан видео холбоосоор дамжуулан оролцож буй этгээд)-ийн байрлаж буй газар нь тухайн шүүх хуралдааны оролцогчдыг харж, сонсох боломжтой тоног төхөөрөмжөөр тоноглогдсон байна.
(c)	Шүүхийн дүрэмд заасан бусад нөхцөл
(d)	Шүүх эсхүл шүүгчээс тогтоосон бусад нөхцөл

⁴⁵ Federal Circuit Court of Australia Act 1999, https://www.austlii.edu.au/cgi-bin/viewdb/au/legis/cth/repealed_act/fcccoa1999325/



Дээрхээс гадна Австралийн Холбооны шүүхийн албан ёсны цахим хуудас⁴⁶-т байгаа мэдээллээс үзвэл нууцтай холбоотой хэрэгт цахим шүүх хуралдааны хэлбэрийг ашиглахгүй бөгөөд бусад байдлаар цахимаар явуулж болох эсхүл явуулж болохгүй маргааны төрлийг тусгайлан зохицуулаагүй байна.

Түүнчлэн цахимаар шүүх хуралдаан явуулах эсэхийг шүүх/шүүгч шийдвэрлэх

ба ийнхүү шийдвэрлэхдээ тухайн маргааны мөн чанар, нарийн төвөгтэй байдал, хэргийн оролцогчдын тоо, хэргийн оролцогчид цахимаар оролцох боломжтой эсэх, тэдгээрийн хүсэлт, байр суурь, нотлох баримтын шинж чанар, цар хүрээ, тухайн маргааныг яаралтай шийдвэрлэх шаардлагатай эсэх зэргийг харгалзан үздэг байна.⁴⁷

Хүснэгт 1. Австрали улсын цахимаар шүүх хуралдаан явуулах болон цахим нотлох баримттай холбоотой эрх зүйн зохицуулалт⁴⁸

Австралийн Хамтын Нөхөрлөлийн Улс	Commonwealth of Australia
<ul style="list-style-type: none"> Австралийн Холбооны шүүхийн хууль (1976)-ийн 47A-47F, 59(2A) Гэр бүлийн хууль (1975)-ийн 102C-102K, 123(1)(ma) Гэр бүлийн хуулийн дүрэм (2004)-ийн 15.02(2)(a) Гэмт хэргийн хууль (1914)-ийн 15Y1-15YJ Австралийн Холбооны тойргийн болон гэр бүлийн шүүхийн хууль (1999)-ийн 66-72 	<ul style="list-style-type: none"> ss 47A-47F, 59(2A), Federal Court of Australia Act 1976 ss 102C-102K, 123(1)(ma), Family Law Act 1975 r 15.02(2)(a), Family Law Rules 2004 ss 15Y1-15YJ, Crimes Act 1914 ss 66-72, Federal Circuit Court of Australia Act 1999
Шинэ Өмнөд Вэльс	New South Wales
<ul style="list-style-type: none"> Эрүүгийн процессын хууль (1986)-ийн 6 дугаар хэсгийн 4 Нотлох баримтын хууль (дуу болон дүрс бичлэгийн холбоос) (1998)-ийн 5B, 5BAA, 5BA, 5BB 	<ul style="list-style-type: none"> Pt 6 Div 4, Criminal Procedure Act 1986 ss 5B, 5BAA, 5BA, 5BB, Evidence (Audio and Audio Visual Links) Act 1998
Викториа	Victoria
<ul style="list-style-type: none"> Эрүүгийн процессын хууль (2009)-ийн 360(a), 362, 363 Нотлох баримтын хууль (1958)-ийн 42E-42S 	<ul style="list-style-type: none"> ss 360(a), 362, 363, Criminal Procedure Act 2009 ss 42E-42S, Evidence (Miscellaneous Provisions) Act 1958
Квийнслэнд	Queensland

⁴⁶ Federal Court of Australia, <https://www.fedcourt.gov.au/online-services/ecourtroom>

⁴⁷ eCourtroom, section 2 <https://www.fedcourt.gov.au/online-services/ecourtroom>

⁴⁸ Audiovisual link technologies in Australian criminal courts: Practical and legal considerations, Australian Institute of Criminology research report 22, https://www.aic.gov.au/sites/default/files/2021-07/rr22_audiovisual_link_technologies_in_australian_criminal%20courts.pdf



<ul style="list-style-type: none"> • Нотлох баримтын хууль (1977)-ийн 21AB, 39E, 39R • Квийнслэнд мужийн Дүүргийн шүүхийн хууль (1967)-ийн 110C–110E • Шударга ёсны хууль (1886)-ийн 178C 	<ul style="list-style-type: none"> • ss 21AB, 39E, 39R, Evidence Act 1977 • s 110C–110E, District Court of Queensland Act 1967 • s 178C, Justices Act 1886
Баруун Австрали	Western Australia
<ul style="list-style-type: none"> • Нотлох баримтын хууль (1906)-ийн 106N, 121 • Гэр бүлийн шүүхийн хууль (1997)-ийн 219AB–AE • Эрүүгийн процессын хууль (2004)-ийн 77, 88(5), 140(2)–141 • Ял шийтгэлийн хууль (1995)-ийн 14(1) 	<ul style="list-style-type: none"> • ss 106N, 121, Evidence Act 1906 • ss 219AB–AE, Family Court Act 1997 • ss 77, 88(5), 140(2)–141, Criminal Procedure Act 2004 • s 66B(2), Bail Act 1982 • s 14(1) Sentencing Act 1995
Өмнөд Австрали	South Australia
<ul style="list-style-type: none"> • Нотлох баримтын хууль (1929)-ийн 13(2)(a), 59IE, 59IQ • Батлан даалтын хууль (1985)-ийн 13(5), 15(7) 	<ul style="list-style-type: none"> • ss 13(2)(a), 59IE, 59IQ, Evidence Act 1929 • ss 13(5), 15(7), Bail Act 1985
Тасмани	Tasmania
<ul style="list-style-type: none"> • Нотлох баримтын хууль (Хүүхэд болон тусгай гэрчүүд) (2001) -ийн 6B, 8(2)(b)(ii), 8(6) • Нотлох баримтын хууль (дуу болон дүрс бичлэгийн холбоос) (1999)-ийн 6, 7, 8 • Шударга ёсны дүрэм (2003)-ийн 67 	<ul style="list-style-type: none"> • ss 6B, 8(2)(b)(ii), 8(6), Evidence (Children and Special Witnesses) Act 2001 • ss 6, 7, 8, Evidence (Audio and Audio Visual Links) Act 1999 • s 67, Justices Rules 2003
Австралийн нийслэл хотын бүс нутаг	Australian Capital Territory
<ul style="list-style-type: none"> • Нотлох баримтын хууль (1991)-ийн 20(1), 32(1), 40Q, 40T(4), 40U, 43 	<ul style="list-style-type: none"> • ss 20(1), 32(1), 40Q, 40T(4), 40U, 43, Evidence (Miscellaneous Provisions) Act 1991
Хойд хэсгийн газар нутаг	Northern Territory
<ul style="list-style-type: none"> • Нотлох баримтын хууль (1939)-ийн 21A(2)(a), 49E–F 	<ul style="list-style-type: none"> • ss 21A(2)(a), 49E–F, Evidence Act 1939

2. Цахим хэргийн хөдөлгөөн (E-case management):

Дээр дурдсанчлан АХНУ-ын Дээд шүүх нь Digital Lodgment System Portal⁴⁹, Австралийн Холбооны шүүх, Австралийн Холбооны тойргийн болон гэр бүлийн шүүхүүд нь eLodgment⁵⁰ системийг тус

тус ашиглан нэхэмжлэл, хариу тайлбар, бусад мэдүүлгийг цахимаар гаргах, хэргийн үйл явцын талаар мэдээлэл авах, мэдэгдэл хүлээн авах зэрэг боломжтой байдаг байна.

Түүнчлэн DLS portal, eLodgment системүүдэд шүүгч, шүүхийн ажилтнууд, хэргийн оролцогч нараас гадна хуульч, судлаач нар бүртгэл үүсгэн ашиглах боломжтой байдгаараа онцлог байна.

⁴⁹ Digital Lodgment System Portal <https://dls.hcourt.gov.au/static/> (Сүүлд үзсэн: 2024.02.21)

⁵⁰ eLodgment, <https://www.elodgment.fedcourt.gov.au/eLodgment/login.aspx?ReturnUrl=%2feLodgment%2fdefault.aspx/> (Сүүлд үзсэн: 2024.02.21)



Тус системүүдийг ашиглан баримт бичиг илгээх, мэдүүлэг өгөх, мэдээлэлтэй танилцах зохицуулалтуудыг шүүхүүд дүрмээрээ зохицуулсан байна. (Хавсралт №1-ээс үзнэ үү.)

3. Цахим баримт (E-filing):

АХНУ-ын Дээд шүүх, Австралийн Холбооны шүүх, Австралийн Холбооны тойргийн болон гэр бүлийн шүүх болон бусад мужуудын шүүхийн эрх зүйн зохицуулалтаас үзэхэд цахим нотлох баримтыг дангаар нь зохицуулаагүй байх ба харин цахимаар шүүх хуралдаан явуулах явцад аудио болон видео бичлэг үзүүлэх, цахимаар баримт бичиг бүрдүүлэн шүүхийн цахим системд илгээх зэргээр цахим шүүх хуралдаан болон цахим хэргийн хөдөлгөөний зохицуулалтад шингээн зохицуулсан байна. (Хүснэгт 1-д үзүүлэв.)

Хамтын нөхөрлөлийн улс болон мужуудын эрх зүйн зохицуулалтаас харахад баримт бичиг, хэргийн хөдөлгөөнийг цахим хэлбэрээр явуулахыг нэн тэргүүнд авч үзэж байх ба шүүх, шүүгч, хэргийн материал (нэхэмжлэл, хариу тайлбар, мэдүүлэг, бусад бичиг баримт)-ыг хүлээн авч байгаа ажилтан цаасан хэлбэрээр шаардахаас бусад тохиолдолд цахимаар баримт бичиг бүрдүүлэхээр тогтоомждоо тусгасан нь онцлог байна.

ЗУРГАА. БҮГД НАЙРАМДАХ СОЛОНГОС УЛСЫН ЗОХИЦУУЛАЛТ

БНСУ-ын шүүхийн цахимжилт 2008 онд эхэлсэн бөгөөд Шүүхийн мэдээллийн нэгдсэн системийг ажиллуулах дэд бүтэц болох Дээд шүүхийн Компьютер мэдээллийн төвийг байгуулж, мэдээллийн системийг 24 цагийн турш

тогтвортой ажиллуулах үүднээс Дэжон, Пусан, Гванжу зэрэг хотод туслах дата төвийг барьж байгуулсан.⁵¹ Улмаар 2009 оны 12 дугаар сард Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулснаар цахим гарын үсэг, цахим баримт бичгийг хүлээн зөвшөөрч шүүхийн үйл ажиллагаа цахим болох үндэс бий болжээ.⁵²

1. Цахим шүүх хуралдаан (E-court)

БНСУ улсад 2010 онд Патентын шүүхэд цахим системийг туршилтын журмаар нэвтрүүлж⁵³ үүний дараагаар 2011 оны 5 дугаар сард иргэний хэрэгт, 2013 оны 1 дүгээр сард захиргааны болон гэр бүлийн хэрэгт, 2013 оны 9 дүгээр сард шийдвэр гүйцэтгэлийн хэрэгт, 2014 оны 4 дүгээр сард дампуурлын хэрэгт, 2015 оны 3 дугаар сард үл хөдлөх эд хөрөнгөтэй холбоотой шийдвэр гүйцэтгэлийн хэрэг болон онцгой ажиллагааны хэрэгт тус тус цахим шүүхийн үйл ажиллагааг нэвтрүүлсэн байна.⁵⁴

Тоон статистикийг авч үзвэл 2016 оны байдлаар 3 шүүгчийн бүрэлдэхүүнтэй хэрэгт 70%, шүүгч дангаар шийдвэрлэх хэрэгт 48%, бага үнийн дүнтэй хэрэгт 67% гэсэн дүн гарсан нь харьцангуй өндөр хувьтай байна.⁵⁵ Мөн Патентын шүүхийн

⁵¹ Promotion progress, Court of Korea, <https://www.scourt.go.kr/judiciary/information/progress/index.html> (Сүүлд үзсэн: 2024.02.21)

⁵² Hoshin Won, Measures to Realize Sustainable and Efficient Justice from the Perspective of Information and Communications Technology Focusing on the Korean Court, Journal of Korean Law | Vol. 16, 67-91, December 2016, p 75.

⁵³ Heike Gramckow and Omniah Ebeid, Leveraging technology to improve service

Delivery in the justice sector in south korea, 2016, p4.

⁵⁴ Supreme court of Korea, E-Trials, <https://eng.scourt.go.kr/eng/judiciary/eCourt/eTrials.jsp> (Сүүлд үзсэн: 2024.02.24)

⁵⁵ Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэн, "Цахим шүүхийн талаарх гадаадын зарим орны туршлага /Япон, БНСУ, Сингапур, Зүүн Карибын тэнгисийн улсуудын жишээн дээр/", Шүүх эрх мэдэл, 2020 №1, 127 дахь тал.



статистик мэдээллээс харахад цаасаар нэхэмжлэл гаргаж, цаасан суурьтай баримт бичигт тулгуурлан хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явагддаг байх үед нэхэмжлэл гаргасан өдрөөс хойш шүүх хуралдаан болох өдрийг хүртэл дунджаар 130 хоног зарцуулдаг байсан бол цахим системийг суурилуулсны дараа энэ хугацаа дунджаар 78 хоног болж буурсан. Энэ нь шүүх хуралдааны тов, хэргийн бүртгэл болон шүүх хуралтай холбоотой бусад бүх мэдээллийг онлайнгаар авах боломжийг оролцогчдоод олгодог болсонтой холбоотой гэж үзсэн байна.⁵⁶

2. Цахим хэргийн хөдөлгөөн (E-case management)

Иргэний хэргийн тухайд цахим шүүхтэй холбогдох гол харилцааг 2010 оны Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаанд цахим баримтыг хэрэглэх тухай хуулиар⁵⁷ зохицуулдаг (*Хавсралт №2-оос үзнэ үү*). Хуулийн хүрээнд Цахим мэдүүлгийн системийн ашиглалт, хяналт, цахим баримтад тулгуурласан иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг явуулах, цахим баримтыг хүлээн авах, шүүх хуралдааны тэмдэглэл зэргийг цахимжуулах, цахим баримтыг илгээх, мэдэгдэх, цахим баримтыг цаасан хэлбэрээр илгээх, гардуулах, нотлох баримтыг шинжлэн судлах, давж заалдах шатны шүүхэд гомдол мэдүүлэх, шүүхийн зардал, мөн тус хуулийн зохицуулаагүй

асуудлыг Улсын дээд шүүхийн журмаар зохицуулах тухай асуудлуудыг хуульчилжээ.⁵⁸ Тус хуулийн 3 дугаар зүйлд энэхүү хууль дараах хуулиудын хүрээнд мөрдөгдөхөөр⁵⁹ зохицуулсан. Үүнд:

- Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль
- Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль
- Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай
- Патентын тухай хууль
- Иргэний хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн тухай хууль
- Үүрэг гүйцэтгэгчийг дахин хөрөнгөжүүлэх болон дампуурлын тухай хууль
- Онцгой ажиллагааны хууль;
- Энэ хуулийн 1-7-д заасан хуулиудтай төсөөтэй хэрэглэгдэх бусад хууль

Харин Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд цахим баримт бичгийг ашиглах тухай хуулийг 2021 оны 10 дугаар сарын 19-ний өдөр баталсан байх бөгөөд 2024 оны 10 дугаар сарын 20-ны өдрөөс эхлэн хэрэгжүүлэх ажээ.⁶⁰

⁵⁶ Hoshin Won, "Measures to Realize Sustainable and Efficient Justice from the Perspective of Information and Communications Technology Focusing on the Korean Court", *Journal of Korean Law* | Vol. 16, 67-91, December 2016, pp.75-76.

⁵⁷ Act on the use of electronic documents in Civil litigations, (2010) https://elaw.klri.re.kr/eng_mobile/viewer.do?hseq=32734&type=part&key=4 (Сүүлд үзсэн: 2024.02.24)

⁵⁸ Ч.Болормаа "Цахимаар шүүх хуралдааныг зохион байгуулахтай холбогдох зарим асуудал." (2021), 12 дахь тал. <https://legaldata.mn/buteel/pdf?id=1153>, (Сүүлд үзсэн: 2024.02.23)

⁵⁹ Act on the use of electronic documents in Civil litigations, art. 3. (2010) https://elaw.klri.re.kr/eng_mobile/viewer.do?hseq=32734&type=part&key=4 (Сүүлд үзсэн: 2024.02.21)

⁶⁰ https://help.scourt.go.kr/nm/min_9/min_9_9/index.html (Сүүлд үзсэн: 2024.02.23)



3. Цахим баримт (E-Filing)

Цахим мэдүүлгийн систем бий болгох, түүний ашиглалтыг Шүүхийн захиргааны дээд байгууллага зохион байгуулна. Системийг ашиглах гэж буй этгээд нь Дээд шүүхийн журамд зааснаар хэрэглэгчийн бүртгэлд бүртгүүлсний дараа бичиг баримтыг цахимаар гаргах эрхтэй болох юм. Хуулийн зохицуулалтаас харахад шүүхэд цахимаар мэдүүлэх нь талуудын сайн дурын үндсэн дээр байна.

Мөн цахим шүүхээр үйлчлүүлэхэд хэрэглэгчийн бүртгэлээс гадна цахим гарын үсэг болон NPKI (national public key infrastructure) цахим баталгаажуулалтын системийг ашигладаг. Ингэснээр цахим шүүхээр үйлчлүүлэгчийн ID буюу хэрэглэгчийн хаягийг хулгайлах, жинхэнэ хэрэглэгч мөн бишийг ялгах ач холбогдолтой.⁶¹

ДОЛОО. КАНАД УЛСЫН ЗОХИЦУУЛАЛТ

Канад улс нь цахим шүүх хурлыг анх КОВИД-19 цар тахлын үед Zoom, Microsoft Teams, Cisco WebEx, JVN/WebRTC зэрэг цахим платформ ашиглаж⁶² явуулж байсан бөгөөд цахим шүүх хурлын ач холбогдлыг шүүхийн хүртээмж, үр ашгийг дээшлүүлэх хэмээн тодорхойлж цаашид ч нэвтрүүлэх шаардлагатайг тэмдэглэжээ.

1. Цахим шүүх хуралдаан (E-Court)

Цар тахлын үеэс хойш Канад улсын шүүхүүд цахим шүүх хуралдааныг зохион байгуулахдаа Zoom, WebEx, MS Teams зэрэг платформуудыг түгээмэл

ашиглаж байна⁶³. Канад улсын дээд шүүх нь цахим шүүх хурлыг шүүхээс өөрөөр зааварлаагүй тохиолдолд зөвхөн Zoom платформоор явуулдаг⁶⁴ ч хууль тогтоомждоо тусгаагүй байна. Гэсэн хэдий ч 2009 оноос эхэлж шүүх хуралдааныг өөрийн албан ёсны цахим хуудсаар дамжуулж ирсэн⁶⁵ бөгөөд шүүх хурлын дүрс бичлэгийг цахим хуудаст нийтэлж олон нийтийг үзэх боломжоор хангадаг.⁶⁶

Хоёр. Цахим хэргийн хөдөлгөөн (E-Case management)

Канад улсын дээд шүүх нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд **Цахим мэдүүлгийн портал**⁶⁷ (англ. *Electronic filing portal*) гэх платформ ашигладаг байна. Платформыг ашиглахад хэргийн оролцогчид өөрийн цахим шуудангийн хаягаар бүртгүүлж нэвтрэх бөгөөд нэг дор олон хуудас баримт байршуулж болох давуу талтай.

Цахим хэргийн хөдөлгөөн, баримт бичиг цахимаар мэдүүлэх журмыг **Дээд шүүхийн дүрэм** (цаашид “Дүрэм” гэх) болон **Канад Улсын дээд шүүхэд баримт бичиг мэдүүлэх удирдамж** (цаашид “Удирдамж” гэх)-д нарийвчлан зохицуулжээ.

⁶¹ Ч. Болормаа, *supra* note 58, 13 дахь тал.

⁶² Канадын Холбооны Шүүхийн асуудал эрхэлсэн Комиссын Тамгын газрын вэб сайт, <https://www.fja-cmf.gc.ca/COVID-19/Virtual-Hearings-and-Services-Audiences-et-services-virtuels-eng.html> (Сүүлд үзсэн: 2024.02.23)

⁶³ Канадын Холбооны Шүүхийн асуудал эрхэлсэн Комиссын Тамгын газрын вэб сайт, <https://www.fja.gc.ca/COVID-19/Virtual-Platform-Settings-Reglages-Plateformes-Virtuelles-eng.html>

⁶⁴ Канад улсын Дээд шүүхийн цахим хуудас, <https://www.scc-csc.ca/parties/before-avant-eng.aspx?pedisable=true>

⁶⁵ Канад улсын Дээд шүүхийн цахим хуудас, <https://www.scc-csc.ca/case-dossier/info/webcasts-webdiffusions-eng.aspx>

⁶⁶ Канад Улсын дээд шүүхийн цахим хуудас, <https://www.scc-csc.ca/media/document-eng.aspx>

⁶⁷ Цахим мэдүүлгийн портал, <https://portal-portail.scc-csc.ca/eng>



Цахим хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны уялдааг хангах гол субъект нь Бүртгэлийн ажилтан бөгөөд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны бүх үйл ажиллагааны цахим бүртгэлийг хадгалж⁶⁸, Дүрмийн 78 дугаар зүйлд заасны дагуу Бүртгэгчийн гаргасан тушаалыг шүүгчийн захирамжийн нэгэн адил холбогдох бүх талууд заавал дагаж мөрдөх үүрэгтэй байна.⁶⁹ Хэргийн оролцогчид шүүхэд аливаа хүсэлт, гомдлыг дээр дурдсанчлан цахимаар гаргахдаа Цахим мэдүүлгийн порталаар⁷⁰ дамжуулан гаргана. Нууцад хамаарах баримт бичгийг цахим хэлбэрээр нэг хувь (аливаа нууцад хамаарах баримт бичгийг шаардлагатай бол харлуулсан байна) (англ. *redacted version*), хэвлэмэл хувилбараар хоёр хувь хавсаргана.⁷¹ Бүртгэгч цахим баримтыг хүлээж авмагц хэргийн оролцогчид автоматаар мэдэгдэл очдог байна.⁷² Ийнхүү Бүртгэгч баримтыг хүлээн авснаас хойш Дүрмийн 32 дугаар зүйлд заасан хугацаанд шүүхэд хэлэлцүүлэхээр хүргүүлнэ.⁷³ Хэргийн оролцогчид цахимаар баримт бичиг мэдүүлэхдээ Дүрэм болон Удирдамжийн хавсралт дахь хамаарах маягтын дагуу илгээх боломжтой байна.⁷⁴

⁶⁸ Rules of the Supreme Court of Canada (2002), art. 10.2.b

⁶⁹ Rules of the Supreme Court of Canada (2002), art. 10.2.b 12

⁷⁰ Guidelines for Preparing Documents to be filed with the Supreme Court of Canada (Print and Electronic) (2021), Баримт бичиг мэдүүлэх бүлэг <https://www.scc-csc.ca/parties/gl-ld2021-01-27-eng.aspx>

⁷¹ Rules of the Supreme Court of Canada (2002), art.19.1.(2)

⁷² Канад улсын Дээд шүүхийн цахим хуудас, <https://www.scc-csc.ca/parties/gl-ld2021-01-27-eng.aspx#E>

⁷³ Rules of the Supreme Court of Canada (2002), art. 32(1) Бүртгэгч шүүхэд хэлэлцүүлэхээр өгнө.

⁷⁴ Guidelines for Preparing Documents to be filed with the Supreme Court of Canada (Print and Electronic), <https://www.scc-csc.ca/parties/gl->

Дүрэм болон Удирдамжид зааснаар Канад улсын Дээд шүүхэд хяналтын гомдлыг хэлэлцүүлэх тухай өргөдлийг мөн Бүртгэгчид гаргах⁷⁵ бөгөөд (Дүрмийн 25(1))-д заасан бүрдүүлбэр бүрийг Цахим мэдүүлгийн порталаар дамжуулан гаргаж, доод шатны шүүхийн шийдвэрийн холбоосыг хавсаргана. Хэрэв шүүхээс гомдлыг хэлэлцүүлэхийг зөвшөөрсөн тохиолдолд Дээд шүүхийн цахим хуудаст нийтэлнэ.⁷⁶

Шүүх хурлын тов мэдэгдэх баримтыг Дээд шүүхийн дүрмийн хавсралтад заасан маягтын дагуу цахимаар илгээнэ.⁷⁷ Бүртгэгч эсхүл шадар бүртгэгч нь Дээд шүүхийн тухай хуулийн 17 дугаар зүйлд зааснаар Ерөнхий шүүгчийн захирамжийн дагуу шүүхийн шийдвэрийг тайлагнаж нийтлэх⁷⁸ бөгөөд шүүхийн шийдвэрийг цахимаар албан ёсны хоёр хэлээр авах боломжтой байдаг.

3. Цахим баримт (E-filing):

Дүрмийн 10(3) дугаар зүйлд зааснаар шүүхэд аливаа баримт бичгийг мэдүүлэг гаргагч сонголтынхоо үндсэн дээр цахим болон хэвлэмэл хувилбарын алинаар нь ч гаргаж болох бөгөөд тухайн гаргасан хувилбар нь албан ёсных болно. Мөн Бүртгэгч өөрөөр шийдээгүй бол хэвлэмэл болон цахимаар давхар гаргасан баримтын хэвлэмэл хувилбар албан ёсны эх хувьд тооцохоор заасан. Цахим баримт

[ld2021-01-27-eng.aspx](#)

⁷⁵ Rules of the Supreme Court of Canada (2002), art.26 “Өргөдөл гаргагч нь Бүртгэгчид өргөдөл гаргана.”

⁷⁶ Guidelines for Preparing Documents to be filed with the Supreme Court of Canada (Print and Electronic), Applications for Leave to Appeal.

⁷⁷ Rules of the Supreme Court of Canada (2002), art. 69

⁷⁸ Supreme Court Act (1985), art. 17 “Бүртгэгч эсхүл шадар бүртгэгч нь Ерөнхий шүүгчийн захирамжийн дагуу шүүхийн шийдвэрийг тайлагнаж нийтэлнэ”.



бичгийг Удирдамжид хэвлэмэл баримт бичгийн илэрхийлэл буюу тамгалагдсан хэвлэмэл баримтыг сканердаж PDF өргөтгөлд буулгаснаар цахим баримт бичиг болно гэж тодорхойлжээ.⁷⁹

Түүнчлэн, Удирдамжид Цахим мэдүүлгийн порталыг дараах тохиолдолд ашиглахыг хориглохоор заажээ:

- Битүүмжилсэн, битүүмжлэхээр тогтоосон мэдээлэл бүхий баримт бичиг;
- Шүүхээс нууцад тооцсон болон нууцад хамааруулсан мэдээлэл бүхий баримт бичиг;
- Хууль тогтоомжоор нууцын зэрэглэлд хамааруулсан баримт бичиг;
- Ийм баримт бичгийг тусдаа CD/DVD-ROM дээр битүүмжилсэн дугтуйнд (хэвлэсэн хувилбарын шаардлагатай тооны хуулбарын хамт), захидал, маягыг хавсаргаж хийнэ. Баримт бичгийн хавтас (хэвлэмэл болон цахим хувилбарууд), мөн CD/DVD-ROM-ын гадна "Битүүмжилсэн" эсвэл "Нууц" гэсэн тэмдэглэл үйлдсэн байна.

НАЙМ. БРАЗИЛ УЛСЫН ЗОХИЦУУЛАЛТ

1. Цахим шүүх хуралдаан (E-court)

Бразил улс нь 2020 оны 10 дугаар сард "100% цахим шүүх" гэж шүүхийг бүрэн цахимжуулах зорилго тавьсан бөгөөд энэ зорилгын хүрээнд шүүхүүдийг цахим болгох арга хэмжээ авч байна. Хэдийгээр [Бразил улс нь "Шүүхийн](#)

⁷⁹ Guidelines for Preparing Documents to be filed with the Supreme Court of Canada (Print and Electronic), on Rule 19 of Rules of the Supreme Court of Canada (2002)

цахимжилтын тухай" бие даасан хууль байхгүй боловч шүүхийн ажиллагааг цахимжуулах эрх зүйн үндсийг Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан Шүүхийн үйл ажиллагааг цахимжуулах тухай 2006.12.19-ний өдрийн хуулиар баталсан. Тус хуульд үндэслэн Хууль зүйн үндэсний зөвлөл (порт. *Conselho Nacional de Justita*)-өөс холбогдох тогтоолууд гаргаж, зарим зүйлийг нэмэлтээр зохицуулжээ. (Хуулийг *Хавсралт №3-аас үзнэ үү.*)

Бразил улс нь 2006 оны Шүүхийн ажиллагааг цахимжуулах тухай хуульдаа шүүх хуралдааныг цахимаар явуулах талаар нарийвчлан зохицуулаагүй хэдий ч Хууль зүйн үндэсний зөвлөлөөс баталсан 2021.02.12-ны өдрийн 372 дугаар тогтоол⁸⁰-д шүүх хуралдааныг цахимаар явуулах арга хэрэгсэл болон түүнтэй холбогдох зарим нэмэлт зохицуулалтыг дараах байдлаар тусгажээ:

1-р зүйл. Дээд шүүхээс бусад шатны шүүх нь албан ёсны цахим хуудастаа дүрс бичлэгээр шууд холбогдох боломжтой холбоосыг байршуулсан байна.
2-р зүйл. Шүүх хуралдаан явуулах боломжтой цахим хэрэгслийг ашиглана.
4-р зүйл. Цахим шүүх хуралдааныг зохион байгуулах тусгай ажилтан нь хэргийн оролцогч талууд болон тэдгээрийн төлөөлөгчдөд эхний шатны мэдээллийг хүргэж хуралдааны тов гаргах үүрэгтэй. Ийнхүү шүүх хуралдааныг виртуал (англ. *virtual*) байдлаар явуулж байгаа нь Шүүхийн цахим системээс тусдаа ажиллагаа бөгөөд үүгээр нэхэмжлэлийг хүлээн авах зэргийг хориглоно.
5-р зүйл. Цахим шүүх хуралдаанд оролцох холбоосыг шүүхийн цахим хуудаст нийтэлнэ.

Дээрх зохицуулалтаас үзвэл 2006 онд батлагдсан Шүүхийн ажиллагааг цахимжуулах тухай хуулиас хойш буюу

⁸⁰ 2021.02.12-ны өдрийн 372 дугаар тогтоол <https://atos.cnj.jus.br/files/original15412620210219602fdc26a38d2.pdf>



2021 оноос эхлэн шүүх хуралдааныг цахимаар явуулах талаар нарийвчилсан зохицуулалтыг нэвтрүүлсэн байх ба шүүх хуралдааныг цахим платформ ашиглан явуулах зохицуулалттай байна. Шүүх хуралдаан зохион байгуулахдаа шүүх нь албан ёсны цахим хуудсаараа дамжуулан шүүх хуралдааны цахим холбоосыг байршуулах болон хэргийн оролцогчид илгээх боломжтой байгаагаараа онцлог байна.

Бразил улсын шүүхийн цахимжилттай холбоотой эрх зүйн зохицуулалтын хүрээнд ямар төрлийн хэргийг цахимаар явуулах талаар нарийвчлан зохицуулаагүй байна. Шүүхийн цахимжилттай холбоотой голлох зохицуулалтад тооцогдож буй 2006 оны Шүүхийн ажиллагааг цахимжуулах тухай хууль нь 1973 оны Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах зорилгоор батлагдсан тул иргэний хэргийг цахимаар явуулах талаар түлхүү зохицуулсан гэж үзэх боломжтой хэдий ч Шүүхийн ажиллагааг цахимжуулах тухай хуулийн 1-р зүйлд хэргийн харьяаллын талаар дараах байдлаар зохицуулсан байгаагаас үзэхэд зөвхөн иргэний хэргээр хязгаарлагдаагүйг харж болохоор байна:

1-р зүйл Энэхүү хуулиар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг явуулах болон ажиллагааны явцад үйлдэгдэх бүхий л төрлийн баримт бичгийг гаргах дамжуулахад цахим хэрэгсэл ашиглах харилцааг зохицуулна.

§1 Энэ хууль нь иргэний, эрүүгийн болон хөдөлмөрийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд, түүнчлэн бүх шатны тусгай шүүхүүдэд нэгэн адил үйлчилнэ.

2. Цахим хэргийн хөдөлгөөн (E-case management):

Бразил улсад хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг бүрэн цахим хэлбэрээр явуулах эсэх нь нэхэмжлэгчийн эрхийн асуудал буюу сонгох боломжтой байхаар зохицуулжээ⁸¹. Шүүхийн ажиллагааг цахимжуулах тухай хуулийн зохицуулалтын дийлэнх хэсэгт хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хэргийн хөдөлгөөнийг цахимжуулах талаар зохицуулсан байна. Ийнхүү цахимаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг явуулахын тулд хэргийн оролцогчид нь цахим гарын үсгээр баталгаажсан бүртгэл үүсгэн шүүхийн тусгай цахим системд нэвтрэх эрх нээлгэх ба уг платформыг ашиглан нэхэмжлэл, хариу тайлбар, гомдол гаргах мөн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад үйлдэгдэх бүхий л баримт бичгийг гаргах, тэдгээрийг холбогдох этгээдэд хүргүүлэх зэрэг ажиллагааг хийнэ.

Мөн Хууль зүйн үндэсний зөвлөлөөс гаргасан 2021.03.09-ний өдрийн 378 дугаар тогтоолын⁸² 1-р зүйлд: “100% цахим шүүх”-ийн хүрээнд хэрэг хянан шийдвэрлэх бүхий л ажиллагааг цахимаар явуулна” гэжээ. Энэ хүрээнд Бразил улсын Хууль зүйн үндэсний зөвлөлөөс шүүх, хуульчдын холбоо зэрэг байгууллагуудтай хамтран гаргасан цахим платформ болох PJE (Processo Judicial Electronico)-р дамжуулан хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг явуулдагаараа онцлогтой.⁸³

⁸¹ 2020.09.10-ны өдрийн 345 дугаар тогтоолын 3 дугаар зүйл, <https://atos.cnj.jus.br/files/original175500202010145f873b7482503.pdf>

⁸² 2021.03.09-ний өдрийн 378 дугаар тогтоолын 1 дүгээр зүйл, <https://atos.cnj.jus.br/files/original20261320210312604bce6592fac.pdf>

⁸³ Бразил улсын Шүүхийн үндэсний зөвлөлийн



3. Цахим баримт (E-filing):

Бразил улс нь Шүүхийн ажиллагааг цахимжуулах тухай хуульдаа нотлох баримтын талаар ерөнхий байдлаар зохицуулсан буюу хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны бүхий л нотлох баримт, материалыг хуульд заасны дагуу цахим хэлбэрээр боловсруулах, дамжуулах, хадгалах, түүнд гарын үсэг зурах боломжтой ба цахимаар нотлох баримт гаргах эрхийг хуулиар олгохын зэрэгцээ тухайн нотлох баримтын эх хувийг орлох хүчин чадалтай хэмээн тодотгожээ.

Цахим нотлох баримтыг тухайн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны тал, өмгөөлөгчид, мөн тухайн хэргийн оролцогч эсэхээс үл хамааран прокурор болон шүүгчдэд нээлттэй байлгана. Хэрэг шийдвэрлэхэд ач холбогдолтой гэж үзсэн нотлох баримтыг цахим хэлбэрээр гаргуулах болон илгээх шийдвэрийг шүүгч гаргана. Мөн эрүүгийн болон зөрчлийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хамаарахаас бусад тохиолдолд дуудан ирүүлэх хуудсыг холбогдох этгээдэд цахимаар хүргүүлж болохоор заажээ.

ЕС. АВСТРИ УЛСЫН ЗОХИЦУУЛАЛТ

1. Цахим шүүх хуралдаан (E-court)

Австри улс нь КОВИД-19 цар тахлын үед бусад улсын нэгэн адил шүүхийн үйл ажиллагаагаа тасралтгүй явуулах үүднээс шүүх хуралдааныг цахимаар явуулах арга хэмжээг хэрэгжүүлж эхэлсэн.⁸⁴ Тухайлбал, энэ үед “КОВИД-19

цахим хуудас, <https://www.cnj.jus.br/programas-e-acoes/processo-judicial-eletronico-pje/>

⁸⁴ Sharon Schmidt, Austria: Online Courts – COVID-19, Austria and the Recent Changes in the Practice of Using Video-Conferencing Technology, <https://oblin.at/newsletter/austria-online-courts-covid-19-austria-and-the-recent-changes-in-the->

цар тахлын үед шүүхийн тогтолцоонд авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай хууль”-ийг батлан мөрдүүлсэн бөгөөд тус хуулиар шүүх хуралдаанд видео технологи ашиглах зохицуулалтыг⁸⁵ тусгасан. Ингэснээр цахим харилцааны хэрэглүүрийг өргөжүүлэхийн зэрэгцээ шүүх хуралдаанд оролцогчдын хэрэгцээ шаардлагад нийцүүлэн шүүх ажиллагааг зохион байгуулах боломжийг бүрдүүлжээ.

Хэдийгээр дээрх цаг мөчөөс эхлэн цахим шүүх хуралдааныг нарийвчлан зохицуулсан эрх зүйн үндэс бий болсон гэж үзэх боломжтой ч үүнээс өмнө хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад тодорхой төрлийн цөөн тохиолдолд цахим хэлбэрээр шүүхийн үйл ажиллагаа явуулах боломжтой байсан. Тодруулбал, Иргэний хэргийн тухайд Австри улсын Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн §277-д “Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны нөхцөл байдал болон бусад шалтгааныг харгалзан үзсэний үндсэн дээр шүүгч нь нотлох баримт гаргуулахдаа дуу, дүрс дамжуулах хэрэгслийг ашиглаж болно”⁸⁶ гэж заасны дагуу нотлох баримт цуглуулах зорилгоор видео хурал хийж болохоор зохицуулсан байдаг бол эрүүгийн хэргийн тухайд Эрүүгийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн §165-д заасны дагуу гэрчээс мэдүүлэг авч байгаа тохиолдолд ашиглаж болохоор тус тус тусгасан байна.

Дээрхээс гадна цахим шүүх

[practice-of-using-video-conferencing-technology/](https://www.ris.bka.gv.at/GeltendeFassung.wxe?Abfrage=Bundesnormen&Gesetzesnumm er=10001699) (Сүүлд үзсэн: 2024.02.21)

⁸⁵ Ibid.

⁸⁶ Law of August 1, 1895, on judicial proceedings in civil legal disputes (Code of Civil Procedure - ZPO). <https://www.ris.bka.gv.at/GeltendeFassung.wxe?Abfrage=Bundesnormen&Gesetzesnumm er=10001699> (Сүүлд үзсэн: 2024.02.21)



хуралдаантай холбоотой гол эрх зүйн зохицуулалтын нэг нь шүүх болон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогчдын хоорондын цахим файл дамжуулахтай холбоотой харилцааг зохицуулсан **Хууль зүйн цахим үйл ажиллагааны тухай журам** (англ. *Electronic legal transactions*)⁸⁷ юм. Тус журмыг Австри улсын Шүүх байгуулах тухай хуулийн 89b дүгээр зүйлийг үндэслэн 2021 онд Хууль зүйн яамнаас баталсан⁸⁸ бөгөөд нийт 14 зүйлтэй.

Тодруулбал, 1 дүгээр зүйлд Хууль зүйн цахим үйл ажиллагааны хамрах хүрээ, 2, 3, 4, 5, 6 дугаар зүйлээр мэдээллийг хэрхэн дамжуулах, 7 дугаар зүйлд сүлжээний тайлбар, 8 дугаар зүйлд хаягийн код, 9 дүгээр зүйлд хууль зүйн цахим үйл ажиллагаатай холбоотой лавлагаа, мэдээлэл, 10 дугаар зүйлд өгөгдлийн аюулгүй байдал, 11 дүгээр зүйлд газрын бүртгэлтэй холбоотой тусгай зохицуулалт, 12 болон 13 дугаар зүйлд цахим мэдүүлэгтэй холбоотой тусгай зохицуулалт, баримт бичгийг эх хувиар нь ирүүлэх, газрын бүртгэлтэй холбоотой зохицуулалтыг тусгасан бол 14 дүгээр зүйлд хүчин төгөлдөр болох асуудлыг тус тус журамласан байна.⁸⁹

2. Цахим хэргийн хөдөлгөөн (E-case management)

Австри улс нь 21 дүгээр зууны 1980-аад оноос эхлэн мэдээллийн технологийн сүлжээг шүүхийн тогтолцоондоо ашиглах

⁸⁷ Elektronischer Rechtsverkehr,

<https://www.ris.bka.gv.at/NormDokument.wxe?Abfrage=Bundesnormen&Gesetzesnummer=20011774&Artikel=&Paragraf=1&Anlage=&Uebergangsrecht> (Сүүлд үзсэн: 2024.02.21)

⁸⁸ "Electronic Legal Transactions – ERV 2021 as well as amendments to the Document," Federal Law Gazette For The Republic Of Austria, RIS Document (bka.gv.at) (Сүүлд үзсэн: 2024.02.21)

⁸⁹ Ibid. (Сүүлд үзсэн: 2024.02.21)

болсон.⁹⁰ Улмаар Холбооны тооцоолох төв (англ. *Federal Computing Center*)-ийн сүлжээний тусламжтайгаар бүх шатны шүүх, прокурор, хорих анги, Холбооны Хууль зүйн яам хоорондоо хамтран ажиллах боломжтой болсон.⁹¹ Тус өөрчлөлт нь шүүхийн үйлчилгээний чанар, хурдыг нэмэгдүүлээд зогсохгүй шүүхийн ажилчдын сэтгэл ханамжид эерэгээр нөлөөлж байсан тул саяхнаас шүүхийн иж бүрэн үйлчилгээ бүхий цахим хэргийн хөдөлгөөний веб сайтыг ашиглалтад оруулжээ.⁹² Энэхүү **JusticeOnline**⁹³ интернет платформ нь шүүхийн үйл ажиллагааг хүнд сурталгүй, цаг хугацааны тодорхой хязгаарлалтгүйгээр харилцах боломжийг олгодог бөгөөд цахим баримт бичгийн бүрдлээс эхлээд газрын бүртгэлийн лавлагаа зэрэг өргөн хүрээний үйлчилгээг багтаасан утас болон компьютероос ашиглах боломжтой платформ юм.⁹⁴ Тодруулбал, JusticeOnline-аар дамжуулан дараах үйл ажиллагааг гүйцэтгэх боломжтой.⁹⁵ Үүнд:

- Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хяналт тавих: хэрэг

⁹⁰ Federal Ministry for Constitutional Affairs, Reforms, Deregulation and Justice, The Austrian Judicial system, Vienna 2018, 39. https://svrh.ch/wp-content/uploads/2019/04/UEMC-AT-Justicial_System-2009.pdf (Сүүлд үзсэн: 2024.02.21)

⁹¹ Federal Ministry of Justice, The austrian judicial system /Institutions – Agencies – Services/, 2009, 35. https://svrh.ch/wp-content/uploads/2019/04/UEMC-AT-Justicial_System-2009.pdf (Сүүлд үзсэн: 2024.02.21)

⁹² Dirk Hartung, Florian Brunnader, Christian Veith, Philipp Plog, and Tim Wolters, "The Future of digital Justice," 2022, 14. [https://legaltechcenter.de/pdf/Hartung%20et%20al%20\(2022\)%20Digital%20Justice.pdf](https://legaltechcenter.de/pdf/Hartung%20et%20al%20(2022)%20Digital%20Justice.pdf) (Сүүлд үзсэн: 2024.02.21)

⁹³ JusticeOnline, <https://justizonline.gv.at/jop/web/home> (Сүүлд үзсэн: 2024.02.21)

⁹⁴ The Austrian justice system, <https://www.justiz.gv.at/service/digitale-justiz/justizonline.9b8.de.html> (Сүүлд үзсэн: 2024.02.21)

⁹⁵ Ibid.



хянан шийдвэрлэх ажиллагааны нөхцөл байдал, зарлан дуудах хуудас, томилгоо, түүнчлэн баримт бичгийг олж авах.

- **Файл шалгах:** Файлуудыг хүссэн үедээ татаж авах боломжтой байхаас гадна цахим хэлбэрээр үзэх.
- **Загвар татах:** Шүүх, прокурорт хандах өргөдөл, гомдлын загвар татах
- **Компанийн бүртгэлийн лавлагаа:** Компанийн мэдээлэл, компанийн бүртгэлийн хуулбар, түүнчлэн баримт бичгийг татаж авах (төлбөртэй).
- **Газрын бүртгэлийн лавлагаа:** Газрын бүртгэлийн лавлагаа, газрын бүртгэлийн хуулбарыг татаж авах боломж (төлбөртэй).
- **Мэдээлэл, үйлчилгээ:** Justitia чатбот болон нэр томъёоны тайлбар толь ашиглан өдөр тутмын эрх зүйн асуудлын тайлбар, хариултыг хурдан хайж олох.

JusticeOnline-ыг ашиглахын тулд гар утсан дээрх гарын үсэг эсвэл иргэний үнэмлэх шаардлагатай. Гэсэн хэдий ч зарим хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны бүх хэсгийг JusticeOnline дээр үзэх боломжтой байхад заримынх нь хувьд зөвхөн зарим хэсгийг цахим хэлбэрээр үзэхээр байгаа зэрэг асуудал үүсэж байгааг анхаарч хөгжүүлсээр байна. Эдгээрээс гадна Австри улсын шүүхийн тогтолцоонд ашигладаг өөр нэг технологийн шийдэл нь Хууль зүйн цахим үйл ажиллагаа буюу Electronic legal transactions (ERV) юм. Энэ нь

хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогч талууд болон шүүх хоорондоо өгөгдлийг аюулгүй, цахимаар дамжуулах боломжийг олгодог бөгөөд цахим шуудан, факс ашиглан харилцахаас эрс ялгаатай.⁹⁶

2021 онд ERV ашиглан нийт 7,97 сая цахим баримт бичгийг дамжуулснаар зөвхөн шуудангийн төлбөрт 13 сая гаруй евро хэмнэсэн бөгөөд үүнтэй холбоотойгоор иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны 94%, шийдвэр гүйцэтгэх өргөдлийн 76% нь цахим хэлбэрээр хэрэгжиж байна.⁹⁷ Гэсэн хэдий ч уг сүлжээг JusticeOnline 2020 онд нээлтээ хиймэгц тус платформд нэгтгэсэн.

3. Цахим баримт (E-filing)

Австри улсын Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль (англ. *Civil Procedure Law*)⁹⁸-д цахим нотлох баримтыг тусад нь зохицуулаагүй байна. Гэсэн хэдий ч зураг, дуу чимээ хадгалах хэрэгсэлд байгаа баримтыг цахим нотлох баримттай адилтган авч үздэг бөгөөд цахим хэрэгсэлд бичмэл хэлбэрээр хадгалагдаж байгаа баримтыг бичмэл нотлох баримттай адил хэмээн үздэг.⁹⁹

Тодруулбал, Австри улсын Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 294 дүгээр зүйлд “Цаасан болон цахим

⁹⁶ The Austrian Justice System, <https://www.justiz.gv.at/service/digitale-justiz/justizonline.9b8.de.html> (Сүүлд үзсэн: 2024.02.21)

⁹⁷ Ibid.

⁹⁸ Law of August 1, 1895, on judicial proceedings in civil legal disputes (Code of Civil Procedure - ZPO). <https://www.ris.bka.gv.at/GeltendeFassung.wxe?Abfrage=Bundesnormen&Gesetzesnummer=10001699> (Сүүлд үзсэн: 2024.02.21)

⁹⁹ Nunner-Krautgasser, Bettina Anzenberger, Philipp, “Evidence in Civil Law – Austria,” 2015, 21

<https://library.oapen.org/viewer/web/viewer.html?file=/bitstream/handle/20.500.12657/32001/620430.pdf?sequence=1&isAllowed=y> (Сүүлд үзсэн: 2024.02.21)



хэлбэрээр ирүүлсэн баримт бичигт тухайн баримт бичгийг хүргүүлсэн тал гарын үсэг зурсан эсхүл шүүхээс болон нотариатаас баталгаажуулж тэдгээрийг хавсаргасан тохиолдолд тухайн баримтыг нотлох баримтын бүрдүүлбэр хангасан гэж үзнэ” хэмээн зохицуулжээ. Энэ ч үүднээс баримт бичгийн цахим хувилбар нь аналог баримт бичигтэй ижил нотлох чиг үүрэгтэй хэмээн үзэж шүүх цахим баримтыг үнэлэн хэргийг шийдвэрлэдэг байна.

АРАВ. ХОЛБООНЫ БҮГД НАЙРАМДАХ ГЕРМАН УЛСЫН ЗОХИЦУУЛАЛТ

1. Цахим шүүх хуралдаан (E-court)

Европын Холбооны хууль тогтоомжид хууль зүйн технологи, хиймэл оюун ухааныг ашиглах талаар тодорхой зохицуулалт байхгүй байх бөгөөд холбогдох бусад хууль тогтоомжид ч энэ талаар хараахан нарийвчлан зохицуулаагүй байна¹⁰⁰. Өөрөөр хэлбэл, ХБНГУ-д шүүхийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг цахим платформ ашиглан явуулж болох хэдий ч хиймэл оюун ухааныг ашиглан явуулах хэлбэр хараахан нэвтрээгүй байна.

ХБНГУ-ын ИХШХШТХ (ZPO)-ийн 128 дугаар зүйлийн 128а хэсэгт зааснаар цахим шүүх хуралдааныг дуу, дүрсний бичлэг хэлбэрээр дамжуулан явуулдаг байна. Шүүх хуралдааныг шүүхийн тусгай өрөөнд дуу, дүрсний бичлэгээр олон нийтэд шууд дамжуулах ёстой байдаг бөгөөд цахим шүүх хуралдааныг

¹⁰⁰ European Justice: Europäisches Justizportal - Elektronischer Rechtsverkehr und elektronische Kommunikation mit Gerichten, in Deutschland, 2021, European e-Justice Portal - e-legal transactions and e-communication with courts (europa.eu) (Сүүлд үзсэн: 2024.02.22)

үндэсний хэмжээнд төдийгүй Европын түвшинд (маргааны үнийн дүнгээс үл хамааран) хийх боломжтой байх шаардлагатай хэмээн үздэг. Энэ нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны процедурыг илүү үр дүнтэй болгож, талуудын цагийг хэмнэж, хурлын товыг өөрчлөх буюу хойшлуулах эрсдэлийг бууруулж, асуудлыг илүү хурдан шуурхай тодруулж, маргааныг шийдвэрлэх боломжтой болох юм.

2. Цахим хэргийн хөдөлгөөн (E-case management)

ХБНГУ-ын Цахим хэргийн хөдөлгөөний дүрэм (герм. *Elektronischer Rechtsverkehr-ERVV*)¹⁰¹ нь иргэн, хуулийн этгээд, аж ахуйн нэгж, холбоо, нөхөрлөл, түүнчлэн хуульч, нотариатч, татварын байцаагч, шүүхийн шийдвэр гүйцэтгэгч зэрэгт цахим баримт бичгийг шүүхийн байгууллагатай аюулгүй, хууль ёсны дагуу солилцох боломж олгожээ¹⁰².

Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны бүх шатанд шүүхэд нэхэмжлэл, өргөдөл, гомдлыг цахим хэлбэрээр гаргах боломжтой. Эдгээр үйлчилгээнд цагийн хязгаарлалт гэж байхгүй буюу хүссэн цагтаа цахим платформоор дамжуулан материалаа илгээх боломжтой¹⁰³ байна. Үүний урьдчилсан нөхцөл нь нэхэмжлэл нь холбогдох этгээдийн мэргэшсэн цахим гарын үсэгтэй байх эсхүл хариуцагч этгээд гарын үсэг зурсан байх бөгөөд аюулгүй дамжуулах платформ (Sichere

¹⁰¹ Цахим хэргийн хөдөлгөөний дүрэм, 2017 он, ERVV.pdf (Сүүлд үзсэн: 2024.02.22)

¹⁰² Цахим хэргийн хөдөлгөөний дүрмийг тайлбарласан гарын авлага, 2022 он, 5 дахь тал, leitfaden_erv_pdf.pdf (justiz.de) (Сүүлд үзсэн: 2024.02.22)

¹⁰³ European Justice: Europäisches Justizportal, supra note 99.



bbermittlungswege)¹⁰⁴-оор ирүүлсэн байх явдал болно. Аюулгүй дамжуулах платформуудыг ИХШХШТХ-ийн 130а хэсгийн 4 дэх хэсэгт зохицуулсан төдийгүй “Цахим хандалтын тухай хууль” (герм. *Onlinezugangsgesetz-OZG*)¹⁰⁵-д тодорхойлсон.

Түүнчлэн цахимаар шүүхэд нэхэмжлэл гаргасан тохиолдолд нэхэмжлэгч нэхэмжлэлээ ямар хэлбэрээр шүүхэд гаргасан эсэхээс үл хамааран хариуцагч хариу тайлбараа шүүхэд цахимаар гаргах үүрэгтэй байдаг төдийгүй цахимаар үүсгэсэн нэхэмжлэлийг эргүүлэн татах боломжтой байдаг гэдгээрээ онцлогтой. Нөгөөтээгүүр, аливаа маргаанд иргэн, хуулийн этгээд, эрх бүхий байгууллага, тухайн маргааны оролцогч талууд цахим хэлбэрээр баримт бичиг, холбогдох материалуудаа чөлөөтэй илгээх боломжтой байдаг. Гэвч одоогийн байдлаар тусгайлсан цахим хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа гэж байхгүй¹⁰⁶ байна.

Мөн ИХШХШТХ-ийн 829 болон 835 дугаар зүйлд тус тус зааснаар шүүхийн шийдвэр гүйцэтгэгчийн ажиллагаа, гүйцэтгэх ажиллагаа явуулах тухай өргөдлийг цахим хэлбэрээр илгээж болдог. (ИХШХШТХ-ийн 753-р зүйлийн 5 дахь хэсэгт заасны дагуу 130d¹⁰⁷ дугаар

¹⁰⁴ Justizportal, <https://justiz.de/index.php> (Сүүлд үзсэн: 2024.02.22)

¹⁰⁵ Тус хууль нь нийт 11 зүйлээс бүрдэх бөгөөд хэрхэн цахимаар аюулгүй мэдээлэл, баримт бичиг дамжуулах тухай нарийвчлан заасан.

¹⁰⁶ European Justice: Europäisches Justizportal, supra note 99.

¹⁰⁷ ИХШХШТХ (ZPO)-ийн 130d дугаар зүйл. “Хуульч, эрх бүхий байгууллага, хуулийн этгээд, түүний дотор нийтийн даалгавраа биелүүлэхийн тулд тэдгээрийн үүсгэн байгуулсан холбоодоос бичгээр гаргаж өгөх бэлтгэл бичгийн баримт бичиг, түүний хавсралт, түүнчлэн мэдүүлэг, мэдүүлгийг цахим баримт бичиг болгон илгээх ёстой.”

зүйлийг баримталж цахимаар ирүүлнэ). Хэрэв нэхэмжлэлийн хэмжээ нь 5,000 еврогоос хэтрээгүй тохиолдолд гүйцэтгэх захирамжийг тодорхой нөхцөлөөр онцгой тохиолдолд цахим хэлбэрээр илгээж болох ба энэ нь нэг талаасаа эд хөрөнгийг хураах, шилжүүлэхдээ албадан гүйцэтгэх тухай цахим өргөдөл гаргах зэрэгт хамаарах заалт юм.

3. Цахим баримт (E-filing)

Шүүх хуралдааны явцад бичмэл болон цахим нотлох баримтыг шинжлэхэд нарийн төвөгтэй байдаг бөгөөд нэг талаас хөндлөнгийн гэрч оролцоогүй цахим нотлох баримтын хувьд **“нотлогдох байдал”**-ыг дутуу үнэлдэг, нөгөө талаас (техникийн хувьд) илүү үр дүнтэй байх нь ч бий. Тиймээс цахим баримтын хэлбэр болох цахим шуудан эсхүл дуу, дүрс бичлэг зэргийг шүүх хуралдаанд нотлох баримт болгон нэвтрүүлэх нь улам бүр чухалд тооцогдсоор байна¹⁰⁸.

Дээр дурдсанчлан баримт бичгийг тодорхой нөхцөлд цахим хэлбэрээр шүүхэд илгээж болох бөгөөд цахим баримт бичиг хэлбэрээр гаргасан нэхэмжлэл, өргөдөлд хариуцагч этгээдийн мэргэшсэн цахим гарын үсэг байх ёстой юм. ХБНГУ-д цахим баримтыг ИХШХШТХ (ZPO)-д зохицуулсан төдийгүй Цахим хэргийн хөдөлгөөний дүрэмд мөн нарийвчлан зохицуулж өгчээ. Тухайлбал, Хэргийн хөдөлгөөний дүрмийн хоёрдугаар бүлэгт Цахим баримт бичигт тавигдах шаардлагуудыг нэг бүрчлэн зааж өгсөн байна.

Цахим нотлох баримтыг нэг ангилалд хамааруулж болохгүй бөгөөд талууд

¹⁰⁸ Müllers, Frederik, Simone Salemi, and Natascha Schliwinski: "Digitale Beweise im Straf- und Zivilprozess.", 2022, S. 169.



нийгмийн сүлжээнд бичсэн сэтгэгдлийн зургийг цаасан хэлбэрээр гаргаад нотлох баримт болгон өгч болохоор хуульчилжээ. Цахим болон бичмэл нотлох баримтыг шүүх шинжээчээр шинжлүүлэх ба энэ нь тухайн баримтыг олон янзын аргаар, тал бүрээс нь шинжлүүлж, нотлох баримт мөн эсэхийг нь үнэлэх, дүгнэх шүүхийн нэг арга хэлбэр гэж ойлгож болох юм.¹⁰⁹

Мөн тус улсын Гарын үсгийн тухай хууль (герм. *Signaturgesetz*)-ийн дагуу цахим шууданд үзлэг хийсний дараа тэмдэглэгээ хийн, гарын үсэг зурснаар нотлох баримтад тооцох, тооцохгүйг баталгаажуулдаг байна. (Монгол Улсын зохицуулалттай харьцуулсныг Хавсралт №4-өөс үзнэ үү)

ДҮГНЭЛТ, САНАЛ

Судалгааны хүрээнд шүүх хуралдааныг цахим платформ эсхүл хиймэл оюун ухаанаар явуулах, цахимаар шийдвэрлэх хэрэг маргааны төрөл, нэхэмжлэл, хариу тайлбарыг цахимаар гаргах, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гарч байгаа тогтоол, захирамжтай цахимаар танилцах, нотлох баримт, бусад баримт бичгийг цахимаар гаргаж болох эсэх, цахимаар гаргаж болохгүй нотлох баримтыг тухайлан заасан эсэх талаар тухайлан хуульчилсан эсэхэд хариулт өгөх замаар харьцуулан судаллаа. Судалгааны үр дүнд дараах дүгнэлтийг хийж байна.

- Судалгааны багийн зүгээс захиалагчийн тухайлан дурдсан ИБУИНХУ, БНХАУ, Эстони, Сингапур, Австрали, БНСУ, Канад, Бразил, Австри, ХБНГУ-ын цахим шүүхийн эрх зүйн зохицуулалтыг

харьцуулан судалж, дээрх асуултад хариулт өгөхийг зорьсон бөгөөд судалгаанд хамруулсан 10 улсын 8 улсын хувьд шүүхийн цахимжилтын талаар тухайлсан хуульгүй, харин цахимжилттай холбоотой харилцааг холбогдох процессын хуулиуддаа эсхүл шүүхийн тухай хууль, дүрэм болонцаг үеийн байдлаас улбаалан баталж байсан Коронавирусийн тухай хууль зэрэгт тусгалаа олжээ. Харин БНСУ болон Бразил улсад иргэний процессын хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах замаар шүүхийн цахимжилтыг тусгайлан зохицуулсан хууль баталсан байна.

- *ИБУИНХУ-ын хувьд* өнөөдрийн байдлаар шүүхийн цахимжилтын талаар тухайлсан хууль байхгүй боловч КОВИД-ын үеийн цар тахлын тархалтыг бууруулах зорилгоор 2020 онд баталсан “Коронавирусийн тухай хууль”-д “Шүүх, трибунал: видео, аудио технологи ашиглах” гэж тухайлан хуульчилж, КОВИД-ын үеэр шүүх хуралдааныг цахимаар явуулж болох тухай заасан байна. Ингэхдээ шүүх хуралдааныг бүрэн болон хэсэгчлэн цахимаар явуулах гэж ерөнхий байдлаар хоёр ангилсан. Мөн, Иргэний хэргийн 10,000 фунтээс ихгүй үнийн дүнтэй маргаан; Эрүүгийн хэргийн хорих ял оногдуулахааргүй хөнгөн төрлийн гэмт хэрэг; Гэрлэгсэд эд хөрөнгийн болон аливаа маргаангүй, үл маргах журмаар гэрлэлт цуцлуулах маргаан болон Замын хөдөлгөөний торгуулийг давж заалдах журмаар шийдвэрлэх маргааныг бүрэн цахимжуулсан байна. Бүрэн цахимжуулсан гэдэгт

¹⁰⁹ Мцллэрс 2022, S. 173.



гомдол, нэхэмжлэл гаргахаас авхуулаад нотлох баримт, хариу тайлбарыг цахимаар оруулах, талууд хоорондоо платформд байгаа сонголтыг ашиглан холбогдох, шүүгчтэйгээ холбогдох, хэргийн явцаа хянах, хуралдааны хэлбэр сонгох, шийдвэрээ цахимаар гардах зэрэг бүх ажиллагааг хамруулан ойлгохоор байгаа нь онцлог байна.

- *БНХАУ-ын хувьд* 2012 онд “цахим өгөгдөл”-ийг нотолгооны хэрэгсэл гэж хүлээн зөвшөөрсөнөөр шүүхийн цахимжилтын суурь тавигдсан байна. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогч нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны “Цахим мэдүүлгийн платформ”-ыг ашиглаж “хэрэг үүсгэх, эвлэрүүлэн зуучлал, нотлох баримт гаргах, лавлагаа, шүүх хурал болон бусад үйлчилгээ” гэх ажиллагаануудыг интернэт сүлжээгээр дамжуулан явуулах боломжтой болсон. Шүүхийн баримт бичгийг цахимжуулах хүрээнд Ардын дээд шүүхээс “Хятадын шүүхийн баримт бичгийн цахим сүлжээ”-г хөгжүүлэн, сүлжээгээр дамжуулан шүүхийн бүхий л баримт бичигтэй танилцаж болохуйц нээлттэй цахим санг бий болгожээ. Шүүхийн цахимжилтын талаарх бие даасан хууль байхгүй боловч “Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хууль” (1991), “Интернэт шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх тухай журам” (2018), “Ардын дээд шүүхийн онлайн шүүх хуралдааны дүрэм” (2021), “Ардын шүүхийн онлайн эвлэрүүлэн зуучлах ажиллагааны дүрэм” (2021), “Ардын шүүхийн онлайн үйл ажиллагааны дүрэм” (2022) зэрэг хэм хэмжээнүүдээр цахим харилцааг зохицуулсан байна.
- *Эстони улсын хувьд* шүүхийн цахимжилттай холбоотой эрх зүйн зохицуулалт болон тус улсын шүүхийн цахимжилтыг бүрдүүлж буй Шүүхийн мэдээллийн систем, Цахим файл боловсруулах мэдээллийн систем, Нийтийн цахим файлын порталын танилцуулгуудаас үзэхэд шүүхэд нэхэмжлэл, хариу тайлбарыг цахимаар гаргах, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гарч буй захирамж, тогтоол, шийдвэртэй цахимаар танилцах боломжийг бүрдүүлжээ. Түүнчлэн иргэний хэрэг шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа, эрүүгийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаанд цаас ашигладаггүй буюу хавтаст хэрэг бүрэн цахимжсан. Харин шүүх хуралдааныг цахимаар явуулах болон маргааныг хиймэл оюун ухаанаар шийдвэрлэх тухай эрх зүйн зохицуулалт тус улсад байдаггүй. Мөн шүүх хуралдааныг цахимаар явуулах тухай бие даасан хууль байхгүй хэдий ч Шүүхийн тухай хууль, Эрүү болон Иргэний процессын хуулиудад холбогдох зохицуулалтуудыг тусгажээ.
- *Сингапур улсын хувьд* шүүхүүд цахим мэдүүлгийн иж бүрэн системтэй байхаас eLitigation платформ нь хэргийн оролцогч талууд эсхүл өмгөөлөгчид бичиг баримт, хүсэлт гаргах, төлбөр хийх бололцоог цогц шийдсэн. Шүүхийн цахим харилцааг Шүүхийн тухай дүрэм 2021 (*англ.* Rules of Court 2021)-ийн 28 дугаар



зүйлд нарийвчлан зохицуулсан ба хэрэг, маргааны төрлөөс үл хамааран бүх шүүхийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны цахим харилцаанд мөрдөгддөг, харин бие даасан хууль байхгүй. Мөн хиймэл оюун ухаанаар хэрэг маргааныг шийдвэрлэхтэй холбоотой зохицуулалт байхгүй байна. Сингапур улсад шүүхийн үйлчилгээг цахимаар 7 гаруй цахим платформуос авах боломжтой бөгөөд eLitigation-ыг хуульчилжээ. Эдгээр платформын тусламжтай цахимаар шүүхэд нэхэмжлэл гаргах, хэргийн хөдөлгөөнийг хянах болон бусад цахим үйлчилгээг авч болно.

- *Австрали улсын хувьд* шүүхийн цахимжилт нь харьцангуй дэвшилттэй байх боловч эрх зүйн зохицуулалтын хувьд тухайн улсын засаг захиргааны нэгжийн онцлогоос шалтгаалж нэгдсэн нэг шүүхийн цахимжилтын тухай хууль байхгүй байна. Түүнчлэн хамтын нөхөрлөлийн улсын хэмжээнд үйлчилдэг болон мужуудын эрүү, иргэний процессын (захиргааны процессын хууль байдаггүй) хуулиуддаа шүүхийн цахимжилтын талаар ижил байдлаар зохицуулсан зохицуулалт байхгүй (ихэнхдээ тийм зохицуулалт байхгүй) байна. Харин шүүхийн хууль болон шүүхийн дүрмүүдээр, мөн муж тус бүр Нотлох баримтын тухай хуулиараа цахим шүүх хуралдаан, цахим хэргийн хөдөлгөөн, цахим баримт бичиг (нотлох баримт)-ийг зохицуулжээ. Тус хамтын нөхөрлөлийн улс болон мужуудын эрх зүйн зохицуулалтуудаас харахад баримт бичиг, хэргийн хөдөлгөөнийг

цахим хэлбэрээр явуулахыг нэн тэргүүнд авч үзэж байх ба шүүх, шүүгч, хэргийн материал (нэхэмжлэл, хариу тайлбар, мэдүүлэг, бусад бичиг баримт)-ыг хүлээн авч байгаа ажилтан цаасан хэлбэрээр шаардахаас бусад тохиолдолд цахимаар баримт бичиг бүрдүүлэхээр хууль, дүрэмдээ тусгасан нь онцлог байна.

- *БНСУ-ын хувьд* 2010 оны Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаанд цахим баримтыг хэрэглэх тухай хуулийг баталснаар иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаанд цахим мэдүүлгийн систем ашиглах, цахимаар шүүхтэй харилцах боломжийг бий болгосон. Уг хуулийн үйлчлэл Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай, Патентын тухай хууль, Иргэний хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн тухай хууль, Үүрэг гүйцэтгэгчийг дахин хөрөнгөжүүлэх болон дампуурлын тухай хууль, Онцгой ажиллагааны хуулиудад мөрдөгдөхөөр хуульчлагджээ. Харин Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд цахим баримт бичгийг ашиглах тухай хуулийг 2021 оны 10 дугаар сарын 19-ний өдөр баталсан байх бөгөөд 2024 оны 10 дугаар сарын 20-ны өдрөөс эхлэн хэрэгжихээр байна.
- *Канад улсын хувьд* шүүхийн цахимжилт анх КОВИД-19 цар тахлын үеэр Zoom платформ ашиглан шүүх



хурлыг явуулсан үеэс эхэлжээ. Канад улсын Дээд шүүхэд хуралдааныг цахимаар явуулах талаар тусгайлан зохицуулсан хууль, дүрэм байхгүй. Харин хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг цахимаар хэрэгжүүлэх Цахим мэдүүлгийн портал гэх платформтой байх бөгөөд ашиглах журмыг Дээд шүүхийн дүрэм болон Дээд шүүхэд баримт бичиг мэдүүлэх удирдамжаар нарийвчлан зохицуулсан байна.

- *Бразил улсын хувьд* шүүхийн цахимжилтын талаарх хуулийг 2006 онд Шүүхийн ажиллагааг цахимжуулах гэх нэртэйгээр баталжээ. Тухайн хуулиар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг явуулах болон ажиллагааны явцад үйлдэгдэх бүхий л төрлийн баримт бичиг, нотлох баримт зэргийг гаргах болон дамжуулахад цахим хэрэгсэл ашиглах харилцааг зохицуулахаар заасан байдаг. Түүнчлэн Бразил улс нь шүүхэд нэхэмжлэл гаргахаас эхлэн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа болон шүүх хуралдааныг явуулахад цахим хэрэгсэл болох шүүхийн систем болон PJE гэх платформыг ашиглаж байх ба мөн нэхэмжлэл гаргах, зохих этгээдэд шүүхээс мэдэгдэх хуудас илгээх, нотлох баримтыг гаргах болон түүнтэй танилцах, шүүх хуралдааныг цахимаар явуулахад цахим арга хэрэгслийг ашиглахаар зохицуулсан байгааг харж болохоор байна.
- *Австри улсын хувьд* шүүхийн цахимжилттай холбоотойгоор тусгайлсан хууль байхгүй ч дээрх

харилцааг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хуулийн цөөн хэдэн зохицуулалт мөн журмаар зохицуулж шүүхийн үйл ажиллагаанд цахим технологи хэрэглэж буй туршлагаараа Европын хэмжээнд тэргүүлэгч улсын нэг байна. Үүний нэг шалтгаан нь цахим баримт бичгийн бүрдлээс эхлээд газрын бүртгэлийн лавлагаа гэх мэт өргөн хүрээний үйлчилгээг багтаасан Justiceonline платформыг үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн явдал юм. Тус платформоор дамжуулан Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хяналт тавих, - Файл шалгах, Загвар татах, Компанийн бүртгэлийн лавлагаа, газрын бүртгэлийн лавлагааны мэдээллийг харах боломжтойгоос гадна чатботоор дамжуулан эрх зүйн эргэлзээтэй асуудлууддаа хариулт авах боломжтой.

- *ХБНГУ-ын хувьд* шүүхийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг цахим платформ (Justizportal) ашиглан явуулж болох хэдий ч хиймэл оюун ухааныг ашиглан явуулах хэлбэр хараахан нэвтрээгүй байна. Түүнчлэн ХБНГУ-д цахим баримтыг ИХШХШТХ (ZPO)-д зохицуулсан төдийгүй Цахим хэргийн хөдөлгөөний дүрэмдээ нарийвчлан зохицуулсан байх бөгөөд тус дүрэм нь иргэн, хуулийн этгээд, аж ахуйн нэгж, холбоо, нөхөрлөл, түүнчлэн хуульч, нотариатч, татварын байцаагч, шүүхийн шийдвэр гүйцэтгэгч зэрэгт цахим баримт бичгийг шүүх байгууллагатай аюулгүй, хууль ёсны дагуу солилцох боломжийг олгожээ. Цахимаар шаардлагатай



баримт бичигтэй танилцах тухайд, талууд эсхүл тэдгээрийн хууль ёсны төлөөлөгч нь холбогдох бүхий л баримт бичиг, мэдээллийг цахимаар авах боломжгүй хэдий ч зарим тохиолдолд иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны бүртгэлийн асуудал, шүүгчийн томилгооны талаарх мэдээллийг цахим хэлбэрээр үзэж танилцах боломжтой байдаг байна.

Судалгааны дүгнэлтэд үндэслэн судалгааны багийн зүгээс дараах саналуудыг дэвшүүлээ:

- Судалгааны явцад улсууд шүүхийн цахимжилтыг тухайлан зохицуулсан бие даасан хуулийг батлахыг яаран зорихгүй байгаа нь ажиглагдаж байна. Иймд цахим шүүх хуралдааны хэлбэр, явуулах арга замыг тусгайлсан хуулиар зохицуулахаас илүүтэйгээр, иргэн, эрүү, захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиудад тусгаж өгөх, эсхүл журмаар зохицуулах;
- Хөнгөн төрлийн гэмт хэрэг, зарим зөрчлийн хэрэг, иргэний хэргийн бага үнийн дүн бүхий маргааныг шүүхийн ачааллыг бууруулах үүднээс цахимаар бүрэн шийдвэрлэх боломжийг бүрдүүлэх;
- Шүүхээс тухайлан шаардаагүй бол шүүхийн цахим системээр дамжуулан иргэд, хуулийн этгээдийг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны бүх шатанд шүүхэд цагийн хязгаарлалтгүйгээр нэхэмжлэл, өргөдөл, гомдлыг гаргах боломжоор хангах. Ингэхдээ мэдээллийн аюулгүй байдлыг хангасан платформ бий болгох;
- Цахимаар үүсгэсэн нэхэмжлэлийг

эгүүлэн татах боломжтой ХБНГУ-ын туршлага онцлог байх бөгөөд ингэснээр бүрдүүлбэр дутуу, үг үсэг, агуулгын алдаатай илгээсэн, өөр материалтай андуурч явуулсан зэргийг оролцогч өөрөө засах боломжтой байх учир цахимаар ирүүлж буй баримт, материалыг тодорхой хугацаанд эгүүлэн татах боломжтой байхаар тохируулах;

- Шүүхийн цахим үйлчилгээг авах нөөц бололцоогүй болон тусгай хэрэгцээт иргэдэд шүүхийн цахим мэдүүлгийн үйлчилгээг тэгш хүртээмжтэй хүргэх үүднээс хөндлөнгийн төлөөлөгч, үйлчилгээний товчоо байгуулах эрх зүйн орчин бүрдүүлэх;
- Цахим мэдүүлгийн системд нэвтрэх болон хандах эрхийн хувьд шатлалтай байх. Олон нийт нээлттэй хандах боломжтой мэдээлэл авахад зориулагдсан хэсэг байхын сацуу зөвхөн хэргийн оролцогч өөрийнхөө бүртгэлээр нэвтрэн орох зэргийг ялгаатай тохируулах;
- Хэргийн оролцогч шүүхэд цахим баримт мэдүүлэхдээ цахим/тоон гарын үсгийг ашиглан улмаар үнэн зөв, бодитой байдлыг хангах боломж бүхий практик орчин бий болгох, цахимаар гаргах боломжгүй гэж үзсэн баримт, үйл ажиллагааг тодорхой заах.

НОМ ЗҮЙ

Гадаад эх сурвалж:

1. Australian Court hierarchy, <https://www.ruleoflaw.org.au/crime/criminal-trial-processes/criminal-law-processes-court-jurisdiction/>



2. A step towards the digital future - how is justice administered in Estonia," 2023, <https://rit.ee/en/news/step-towards-digital-future-how-justice-administered-estonia>
3. "About eLitigation," eLitigation, https://www.elitigation.sg/_layouts/IELS/HomePage/Pages/AboutElit.aspx
4. "CMS Expert Guide to Digital Litigation," CMS law firm, <https://cms.law/en/int/expert-guides/cms-expert-guide-to-digital-litigation/singapore>
5. Coronavirus Act 2020, "Courts and tribunals: use of video and audio technology" (Explanatory Notes), <https://www.legislation.gov.uk/ukpga/2020/7/notes/division/24/index.htm>
6. Digital Lodgment System Portal, <https://dls.hcourt.gov.au/static/>
7. Dirk Hartung, Florian Brunnader, Christian Veith, Philipp Plog, and Tim Wolters, "The Future of digital Justice," 2022, 14. [https://legaltechcenter.de/pdf/Hartung%20et%20al%20\(2022\)%20Digital%20Justice.pdf](https://legaltechcenter.de/pdf/Hartung%20et%20al%20(2022)%20Digital%20Justice.pdf)
8. eLodgment, <https://www.elodgment.fedcourt.gov.au/eLodgment/login.aspx?ReturnUrl=%2feLodgment%2fdefault.aspx/>
9. eCourtroom, <https://www.ecourtroom.fedcourt.gov.au/ecourtroom/default.aspx>
10. E-Justice factsheet, <https://e-estonia.com/wp-content/uploads/2019aug-facts-a4-v04-e-justice.pdf>
11. Electronic filing portal, <https://portal-portail.scc-csc.ca/eng>
12. "Electronic Legal Transactions – ERV 2021 as well as amendments to the Document," *Federal Law Gazette For The Republic Of Austria*, [RIS Document \(bka.gv.at\)](https://www.ris.bka.gv.at)
13. European Justice: Europäisches Justizportal - Elektronischer Rechtsverkehr und elektronische Kommunikation mit Gerichten, in Deutschland, 2021, [European e-Justice Portal - e-legal transactions and e-communication with courts \(europa.eu\)](https://www.e-justice.europa.eu)
14. Elektronischer Rechtsverkehr,
15. <https://www.ris.bka.gv.at/NormDokument.wxe?Abfrage=Bundesnormen&Gesetzesnummer=20011774&Artikel=&Paragraf=1&Anlage=&Uebergangsrecht>
16. Federal Ministry for Constitutional Affairs, "Reforms, Deregulation and Justice, The Austrian Judicial system," Vienna 2018, 39. https://svrh.ch/wp-content/uploads/2019/04/UEMC-AT-Justicial_System-2009.pdf
17. Federal Ministry of Justice, "The austrian judicial system /Institutions – Agencies – Services/," 2009, 35. https://svrh.ch/wp-content/uploads/2019/04/UEMC-AT-Justicial_System-2009.pdf
18. Hoshin Won, "Measures to Realize Sustainable and Efficient Justice from the Perspective of Information and Communications Technology



- Focusing on the Korean Court”, *Journal of Korean Law* | Vol. 16, 67-91, December 2016, p 75.
19. Heike Gramckow and Omniah Ebeid, “Leveraging technology to improve service Delivery in the justice sector in South Korea”, 2016, p4.
 20. JusticeOnline, <https://justizonline.gv.at/jop/web/home>
 21. Müllers, Frederik, Simone Salemi, and Natascha Schliwinski: "Digitale Beweise im Straf-und Zivilprozess.", 2022, S. 169.
 22. Nunner-Krautgasser, Bettina Anzenberger, Philipp, “Evidence in Civil Law – Austria,” 2015, 21. <https://library.oapen.org/viewer/web/viewer.html?file=/bitstream/handle/20.500.12657/32001/620430.pdf?sequence=1&isAllowed=y>
 23. Preview of criminal electronic litigation, https://help.scourt.go.kr/nm/min_9/min_9_9/index.html
 24. “Robot justice: China’s use of Internet courts”, *The Lawyer’s Daily*.
 25. Richard Susskind, “Online Courts and the Future of Justice” (New York: Oxford University Press, 2021)
 26. Sharon Schmidt, Austria: Online courts – covid-19, austria and the recent changes in the practice of using video-conferencing technology, [https://oblin.at/newsletter/austria-online-courts-](https://oblin.at/newsletter/austria-online-courts-covid-19-austria-and-the-recent-changes-in-the-practice-of-using-video-conferencing-technology/)
 27. “Promotion progress,” Court of Korea, <https://www.scourt.go.kr/judiciary/information/progress/index.html>
 28. Zhuhao Wang, “China’s E-Justice Revolution”, *Judicature*, 105 №1, (2021)
 29. 最高人民法院关于加快建设智慧法院的意见.
- Эрх зүйн эх сурвалж:**
1. Австралийн Холбооны шүүхийн тухай хууль (1976)
 2. Австралийн Холбооны тойргийн шүүхийн тухай хууль (1999)
 3. Австри улсын Хууль, эрх зүйн цахим үйл ажиллагааны тухай журам (2021)
 4. Австри улсын Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль (1895)
 5. БНХАУ-ын Ардын дээд шүүх, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийг хэрэглэх тухай тайлбар (2015)
 6. БНХАУ-ын Цахим шүүхээр хэрэг хянан шийдвэрлэх тухай хэд хэдэн асуудлаарх Ардын дээд шүүхийн журам (2018)
 7. БНХАУ-ын Ардын шүүхийн тухай хууль (2018)
 8. БНХАУ-ын Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хууль (1991)
 9. БНХАУ-ын Ардын дээд шүүхийн онлайн шүүх хуралдааны дүрэм



- (2021)
10. Бразил улсын Хууль зүйн үндэсний зөвлөлөөс баталсан 2021.03.09-ны өдрийн 378 дугаар тогтоол
 11. Бразил улсын Хууль зүйн үндэсний зөвлөлөөс баталсан 2021.02.12-ны өдрийн 372 дугаар тогтоол
 12. Бразил улсын Хууль зүйн үндэсний зөвлөлөөс баталсан 2020.09.10-ны өдрийн 345 дугаар тогтоол
 13. Канадын Дээд шүүхийн дүрэм (2002)
 14. Канад улсын Дээд шүүхэд баримт бичиг мэдүүлэх удирдамж (2021)
 15. Канадын Дээд шүүхийн хууль (1985)
 16. Сингапур улсын Шүүхийн тухайн дүрэм (2021)
 17. Сингапур улсын Олон улсын арилжааны шүүхийн тухай дүрэм (2021)
 18. Сингапур улсын Нотлох баримтын тухай хууль (1893)
 19. Сингапур улсын Эрүүгийн хэрэг хянаг шийдвэрлэх тухай хууль (2010)
 20. Сингапур улсын Гэр бүлийн хэрэг маргаан хянан шийдвэрлэх тухай хууль (2014)
 21. БНСУ улсын Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаанд цахим баримт ашиглах тухай хууль (2010)
 22. ХБНГУ-ын Цахим хэргийн хөдөлгөөний дүрэм (Elektronischer

- Rechtsverkehr- ERVV) (2017)
23. Эстони улсын Иргэний хэрэг шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль (2005)
 24. Эстони улсын Эрүүгийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль (2003)

Цахим эх сурвалж:

1. Австрали улсын Холбооны шүүхийн албан ёсны цахим хуудас: <https://www.fedcourt.gov.au/online-services/ecourtroom>
2. Австрали улсын Хамтын Нөхөрлөлийн Улсын Дээд шүүхийн албан ёсны цахим хуудас: <https://www.hcourt.gov.au/registry/filing-documents>
3. Австри улсын шүүхийн албан ёсны цахим хуудас: <https://www.justiz.gv.at/service/digitale-justiz/justizonline.9b8.de.html>
4. Бразил улсын Засгийн газрын албан ёсны цахим хуудас: <https://www.planalto.gov.br>
5. Бразил улсын Хууль зүйн үндэсний зөвлөлийн албан ёсны цахим хуудас: <https://atos.cnj.jus.br>
6. ИБУИНХУ-ын хууль тогтоомжийн албан ёсны нэгдсэн сан: <https://www.legislation.gov.uk/>
7. Канад улсын Холбооны Шүүхийн асуудал эрхэлсэн Комиссын Тамгын газрын албан ёсны цахим хуудас: <https://www.fja-cmf.gc.ca/COVID-19/Virtual-Hearings-and-Services-Audiences-et-services-virtuels-eng.html>
8. Канад улсын Дээд шүүхийн албан

- ёсны цахим хуудас: <https://www.scc-csc.ca/parties/before-avant-eng.aspx?pedisable=true>
9. Сингапур улсын шүүхийн нэгдсэн цахим хуудас: <https://www.judiciary.gov.sg/services/e-platforms>
10. БНСУ улсын Дээд шүүхийн цахим хуудас: <https://eng.scourt.go.kr/eng/judiciary/eCourt/eTrials.jsp>
11. Ч.Болормаа “Цахимаар шүүх хуралдааныг зохион байгуулахтай холбогдох зарим асуудал.” (2021), 12 дахь тал. <https://legaldata.mn/buteel/pdf?id=1153>
12. Эстони улсын төрийн мэдээллийн эмхэтгэлийн цахим хуудас: <https://www.riigiteataja.ee/en/>
13. Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэн, “Цахим шүүхийн талаарх гадаадын зарим орны туршлага /Япон, БНСУ, Сингапур, Зүүн Карибын тэнгисийн улсуудын жишээн дээр/,” *Шүүх эрх мэдэл сэтгүүл*, 2020 №1, 127 дахь тал
14. Цахим хэргийн хөдөлгөөний дүрмийг тайлбарласан гарын авлага, 2022 он, 5 дахь тал, [leitfaden_erv_pdf.pdf](#) (justiz.de)